

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

UIH.MN
СҮДАЛГААНЫ САН

“Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр,
эрхийнхээ хувьд адил тэгш байна...”

(10 дахь жилдээ)

2011/02

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл
2011/02 (38)
Улсын бүртгэлийн дугаар 244
Жилд 2 удаа хэвлэгдэнэ.
10 дахь жилдээ

Сэтгүүлийн редакцийн зөвлөл

Ж.Бямбадорж Ерөнхий редактор /ХЭҮК-ын дарга/
З.Бадмаараг Хариуцлагатай нарийн бичгийн дарга /ХЭҮК-ын ахлах мэргэжилтэн/

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн Үндэсний
Комиссын бодлогыг илэрхийлэхгүй, зөвхөн зохиогчийн
үзэл бодол болно.

АГУУЛГА

1. ӨМНӨХ ҮГ	5
2. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ	
➤ П. Оюунчимэг “Хүний эрхийг хангах, хамгаалах орчин үеийн үзэл баримтлал”	6
➤ Б. Дэлгэрмаа, Ж.Хулан “Хөдөлмөрийн харилцаанд насаар ялгаварлан гадуурхах нь”	25
➤ Ц. Алтанцэцэг “Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагуудад шилжүүлэх харилцааны Үндэсний эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”	31
➤ М. Ариунаа “Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагуудад шилжүүлэх харилцааны Олон улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”	46
➤ Ш. Сүхбаатар “Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалтын онол практикийн зарим асуудал”	55
➤ Б. Болорсайхан “Уул уурхайн салбар дахь хүний эрхийн асуудал”	66
➤ Д. Баянбилэг “Хүний хөгжил, хүний аюулгүй байдлын харилцан хамаарал”	85
➤ Н. Чинчулуун “Ажлын байран дахь бэлгийн дарамтлалыг зохицуулах эрх зүйн орчин шаардлагатай байна”	93
➤ “Монгол Улс дахь уул уурхай ба хүний эрх” сэдэвт үндэстний хэлэлцүүлгийн баримт бичиг	97
3. МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА	
➤ Макау Мутуа “Хүний эрхийн салбарт гарч буй хувьсал өөрчлөлт” орчуулсан Г.Золжаргал	117
4. ЗОЧНЫ ЯРИА	
➤ “Бидний зорьж яваа цэг хол, шийдвэрлэхийг хүсч байгаа асуудал том” /Хүчирхийллийн эсрэг Үндэсний төвийн захирал Д. Энхжаргалтай хийсэн ярилцлага/	120

TABLE OF CONTENTS

FOREWORD 5

ARTICLES

- “Current issues in fulfilling and protecting human rights”, Dr. Oyunchimeg Purev 6
- “Age Discrimination in Employment”, Prof. Delgermaa Boldbaatar,
Ms.Khulan Jamiyansuren 25
- Comparative analysis on international and Mongolian laws concerning rights of
abandoned children Dr.Altantsetseg Tserenjav, Ms.Ariunaa Munkhdalai 31
- Theoretical and practical issues on the legal protection of honor and reputation
of individuals Dr. Sukhbaatar Shirchin 55
- Human rights and mining: in the context of Mongolia,
Mr.Bolorsaikhan Badamsambuu 65
- “Correlation between human rights and freedoms, human development,
and human safety” Mr.Bayanbileg Danikhuu 85
- “There is a need of policy and legislation to solve sexual harassments
in work places”, Ms.Chinchuluun Naidandorj 93
- Discussion paper for the national dialogue
“Mining and human rights in Mongolia” 97

WORLD DISCUSSION ON HUMAN RIGHTS:

- Makau Mutua “Change in the Human Rights Universe”
translated by Ms.Zoljargal Gantumur 117

MEET AND GREET: INTERVIEW WITH LEADING HUMAN RIGHTS EXPERTS AND PRACTITIONERS

- Target we heading is far beyond and a problem we endeavor solving is
immense,Ms.Enkhjargal Davaasuren, Executive Director of National
Center against Violence of Mongolia, by Ms.Badmaarag Zagdaa 120

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос эрхлэн гаргадаг “Хүний эрх” сэтгүүлийн шинэ дугаарыг эрхэм уншигч танаа толилуулж байна. Арван нас хүрч буй сэтгүүл маань нийтлэлийн бодлогодоо шинэ өнгө аяс оруулж байгааг энэхүү дугаараас Та анзаарах буй за.

Хүний эрхийн салбарт тулгамдаж буй асуудал, эрдэм шинжилгээний өгүүлэл, хүний эрхтэй холбоотой бүхнийг нийтэлдэг байсан сэтгүүл маань хүний эрхийн онолын судалгааг Монголд хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгыг өмнөө тавилаа.

Сэтгүүл маань цаашид хүний эрхийн асуудлаарх Монгол эрдэмтэн, судлаачдын бүтээлийг танилцуулдаг уламжлалаа хадгалахын сацуу дэлхий нийтийн анхаарал татсан эрдэм шинжилгээний бүтээлийг эх хэлнээ хөрвүүлэн эрхэм уншигч танаа хүргэж байх болно.

Түүнчлэн хүний сайн сайхан амьдралын төлөө сэтгэл оюунаа чилээж, үр дүнтэй ажиллаж буй хүний эрхийн зүтгэлтний манай сэтгүүлд өгсөн ярилцлагаас Та “хүний эрхийн онол Монгол хөрсөнд хэрхэн ургаж байгаа” тухай бодролтой үлдэж, хүний эрхийн төлөөх ажлын хөшигний ар талыг харах биз ээ.

Мөн хүний эрхийн онолыг ухан тунгааж, оюунаа нэрж туурвисан таны бүтээлийг нийтийн хүртээл болгохдоо бид үргэлж таатай байх болно. Монгол Улсад хүний эрхийн онолын судалгааг хөгжүүлэхэд эрхэм уншигч таны шүүмж, санал, хамтын ажиллагааг хүсэн хүлээж байна.

Сэтгүүлийн редакци

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ, ХАМГААЛАХ ОРЧИН ҮЕИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



ХЭҮК-ын гишүүн, хууль зүйн ухааны доктор
Пүрэвийн Оюунчимэг

Хүний эрхийг хангах, хамгаалах талаар өнөө цагт үндэсний болон олон улсын түвшинд хэрхэн ойлгож, ямархуу үзэл баримтлалаар хандаж байгааг дэлгэрэнгүйгээр нарийвчлан өгүүлсэн байна. Харьцуулсан судалгааг бодит амьдралын жишээнд тулгуурлан ул суурьтайгаар гаргаж ирснээрээ сонирхолтой бүтээл. Зохиогч эл өгүүлээрээ дамжуулан Монгол Улсын хүний эрхийн салбарт дараахь зүйлсийг ажил хэрэг болгох шаардлагатай байгааг сануулжээ. Үүнд:

- Төрөөс хүний эрхийг хангах хамгаалах ажлыг цаасан дээр биш бодит үр дүнд хүргэх тодорхой бүтээмжтэй ажлуудыг нарийвчилсан төлөвлөгөө болон дэмжлэгийн дагуу хэрэгжүүлэх;
- Хүний эрхийг хангах үндэсний хотолбор болон бодлогыг бодитойгоор хэрэгжүүлэхэд санхүүгийн болон боловсон хүчний шаардлагатай нөөцийг бий болгон эрчимтэй ажиллуулах;

- Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд субъектийн хязгаарлалтгүйгээр бүх нийтэд тэгшээр хуваарилан хүргэх үйл ажиллагааг төрийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;

- Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулан эрх зүйн шинэтгэлийн ажлыг хуулийн бүх байгууллагуудыг хамруулан хийхээс гадна, хуулийн байгууллагуудын ажилтнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах;

- НҮБ-аас Монгол Улсын Засгийн газарт огссон зөвлөмжийг бодитойгоор хэрэгжүүлэхэд төрийн бүх байгууллагуудын анхаарлыг хандуулан бодит үр дүнд хүрэхүйцээр хэрэгжүүлэх;

- Олон улсын нэгдэн орсон гэрээний заалттай дотоодын хууль тогтоомжуудын зорчилдсон болон зохицуулагдаагүй заалтуудыг эргэн нэг харж шүүхийн практикт аль болох өргөн хурээгээр хэрэглэж хэвших;

- Хүний эрхэд суурилсан хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зайлиггүй шаардлагатай байна.

**CURRENT ISSUES IN FULFILLING
AND
PROTECTING HUMAN RIGHTS**

Commissioner Ms. P. Oyunchimeg of
NHRC, PhD in Law

For further planning, the state must take the following steps:

- *To implement certain and efficient actions to achieve practical results in protecting human rights according to detail plans,*
- *To develop and operate financial and personnel resources for factual implementation of National Programmes and policy on human rights,*
- *To organize activities to distribute human rights education in public equally without regardless of subjects with participation of government organization,*
- *To pay attention to implementation of Millennium Development Goals, to involve all legal organizations in legal reform work, and to emphasize on improving education and concept on human rights of workers in legal organization,*
- *To concentrate attention of every government organizations for factual fulfillment of the recommendation to the Mongolian Government by the UN,*
- *To reconsider the articles of domestic laws which contradict with international treaties of Mongolia and which has not been regulated and to use the articles of the international treaties in the judicial and legal practice, and*
- *To fulfill development strategy based on human rights.*

Хүний эрхийг хангах, хамгаалах талаар аливаа асуудлыг хөндөн ярихын тулд хүний эрхийн мөн чанар, зарчмуудыг дурдах шаардлагатай. Юуны өмнө хүний эрхийн зарчмууд, түүний төрийн үйл ажиллагаа, аливаа төлөвлөлтөд үзүүлэх нөлөөг авч үзэх хэрэгтэй юм.

Хүний эрхийн зарчмуудад:

- Түгээмэл болон салшгүй байдал;
- Хуваагдашгүй байдал;
- Харилцан хамааралт болон харилцан уялдаат байдал;
- Тэгш эрх болон үл ялгаварлал;
- Оролцох, татан оролцуулах;
- Хариуцлага болон эрх зүйд захирагдах ёс (rule of law) багтдаг.

Эдгээр хүний эрхийн үндсэн зарчмуудад нэгэн зэрэг анхаарал хандуулсан үед хүний эрхийн биелэлтэд таатай орчныг бий болгоход чиглэсэн үйл явцыг баталгаажуулдаг. Эдгээр зарчмуудыг тодорхойлон, төлөвлөлтөд ямар утга илэрхийлэхийг дор тайлбарлавал:

Түгээмэл болон салшгүй байдал:

Энэ дэлхийн аль ч өнцөгт байгаа аливаа эмэгтэй, эрэгтэй хүн, хүүхэд нь хүний төрлийг олж төрсний хувьд хүний эрхийг тээгч/эдлэгч юм.

Хөтөлбөрийн загвар гаргаж буй хэн нэгэнд туслах үедээ та бусад ямар нэгэн бүлэгт (шилжин суурьшигч, дотооддоо шилжсэн хүмүүс, хүүхдүүд, уугуул хүмүүс, ядууралд өртсөн эмэгтэйчүүд зэрэг) хамаарах эрхийг санамсаргүй үгүйсгэсэн эсэхийг нягтална. Түгээмэл байдал гэдэгт нөөц баялгийн хязгаарын улмаас дараалал тогтоосон ч гэсэн хүн бүр хүний эрхтэй байхыг ойлгоно.

Гэхдээ үүнийг хүн бүрийн бүх асуудлыг нэгэн зэрэг шийднэ гэсэн үг биш. Жишээлбэл, НҮБ-ын Хүн амын сан нь өмнөө тавьсан зорилгуудад ахиц гаргахын тулд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд бүх нийтээр хамрагдах явдлыг баталгаажуулахыг зорьдог бол Засгийн газар хамгийн гадуурхагдсан бүлгүүдэд үйлчилгээ үзүүлж эхлэхийг эн тэргүүнд зорих боломжтой.

Хуваагдашгүй байдал:

Хэн ч бусад хүний аливаа эрхийг сайн дураар дамжуулах боломжгүй. Нэг эрхийг үгүйсгэх нь ямагт өөр нэгэн эрхийг эдлэхэд нөлөөлдөг.

Энэ зарчмыг хэрэглэх үед тодорхой улсад зарим эрхийг бусад эрхийг эдлэхэд саад болох байсан ч тухайн эрхээс илүү чухалд үзэж болох эсэх асуулттай тулгардаг. Жишээлбэл, иргэний болон улс төрийн эрхийг эдийн засаг, нийгэм, соёлын эрхтэй адил түвшинд хүндэтгэж, ашиглаж болох уу? ЭАБХУТК¹, АҮАҮБХУТОУК²-д заасан тэгш эрх, аливаа олон улсын гэрээнд тусгасан эрхүүд нь ИБУТЭТОУП³, ЭЗНСЭТОУП⁴-аар баталгаажсан эрхүүдтэй адил эрэмбэтэй байх уу?

Харилцан хамааралт болон харилцан уялдаат байдал:

Нэг эрхийн биелэлт нь бүхлээр, эсвэл дангаар бусад эрхийн биелэлтээс хамаардаг. Жишээлбэл, эрүүл мэндээ

¹ Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц

² Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц

³ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

⁴ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт

хамгаалуулах эрхийн биелэлт нь сурч боловсрох, цэвэр усаар хангагдах эрх, үл ялгаварлал зэрэг эрхээс хамаарч болно.

Салбаруудын хооронд түншлэлийг бий болгосон бол үндэсний хөтөлбөрүүд илүү амжилттай байх болно. Жишээлбэл, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний цогц хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн яам нь боловсрол, орон сууц, эмэгтэйчүүдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагууд болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтрах боломжтой. Хүний эрхийн хүрээ нь асуудал шийдвэрлэх болон хөгжилд хүрэхийн тулд олон салбарын дэмжлэгийг авдаг.

Тэгш эрх болон үл ялгаварлал:

Хүн бүр хүний төрлийг олсны хувьд болон нэр төрийн хувьд адил тэгш байх бөгөөд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой.⁵

Төлөвлөлт нь орон нутгийн гэхээс илүү хотын хүн ам зэрэг хүрэхэд хялбар хүмүүст дангаар чиглэх ёсгүй. Учир нь оршин буй эрх мэдлийн тэнцвэргүй байдал улам хурцдах болно. Санаатай бус ялгаварлан гадуурхалтаас зайлсхийсэн байх ёстой. Жишээлбэл, ямар нэгэн хөтөлбөр боловсруулах үед оролцуулахаар олон тооны хүнийг урьсан ч тодорхой бүлгүүд алслагдмал газар амьдардаг учраас уулзалтад оролцож чадалгүй үлддэг. Ялангуяа, төлөвлөлтөнд дараахь зүйл хэрэгтэй байх боломжтой. Үүнд:

⁵ ХЭТТ-ын 1, 2 дугаар зүйл; ЭЗНСЭТОУП-ын 2(2); ИБУТЭТОУП-ын 2(1), 3 дугаар зүйл.

- Ялгаварлан гадуурхагдаж, сул дорой байдлынхаа улмаас зовж шаналж буй хүмүүст, ялангуяа маш ядуу амьдарч байгаа хүмүүст эн тэргүүнд анхаарах;
- Мэдээлэл цуглуулах чадавхийг бэхжүүлэх, гарал үүсэл, хүйс, газар зүйн байрлал зэргээс шалтгаалан боломжийн хэрээр нийлүүлсэн мэдээллийг батлахаар задлан шинжлэх;
- “Тоглоомын талбайг тэгшлэхийн” тулд эмэгтэйчүүдийг дэмжсэн үйлдэл, оролцоонд зориулсан тусгай чуулган зэрэг түр хугацааны тусгай арга хэмжээг дэмжих;
- Төслийн мэдээллийг хүртээмжтэй хэлбэр, цөөнхийн хэлээр авах боломжтой болгох;
- Үл ялгаварласан хандлага, зан үйлд өөрчлөлт гаргахын тулд иргэний боловсрол, эрх зүйн шинэчлэлийг дэмжих.

Оролцох, татан оролцуулах:

Хүн бүр, бүх хүмүүс хүний эрх, суурь эрх чөлөө биелэх боломжтой иргэний, эдийн засгийн, нийгмийн, соёлын, улс төрийн хөгжлийг эдлэх, түүнд хувь нэмэр оруулах идэвхтэй, чөлөөтэй, бүрэн дүүрэн оролцоотой байна.

Үнэлгээ, задлан шинжилгээ, загвар, хэрэгжилт, мониторинг зэрэг төлөвлөлтийн хугацааны бүх шат дахь хөгжлийн үйл явцуудад үндэсний сонирхлын бүлгүүд хууль ёсны өмчлөх эрхтэй байхыг баталгаажуулах.

Үйл явцын хувьд жинхэнэ оролцооны шинжтэй байхдаа тэд “идэвхтэй, чөлөөтэй, бүрэн дүүрэн” байх ёстой. Оролцоо нь идэвхтэй тухайн иргэний шүүмжлэлт ухамсар, шийдвэр гаргах явдлыг дэмжиж буй эсэхийг тооцоход анхаарч үздэг.

Хөгжлийн стратегиуд нь иргэдийг, ялангуяа хамгийн гадуурхагдсан иргэдийг эрх мэдэлжүүлэх, тэдний горьдлого найдлагыг Төр болон бусад үүрэг хүлээгчдэд тодорхой илэрхийлэх, тэдний өөрийн хөгжлийг хариуцуулах болно.

Хариуцлага болон эрх зүйд захирагдах ёс:

Төр болон бусад үүрэг хүлээгчид хүний эрхийн олон улсын гэрээнд заасан эрх зүйн хэм хэмжээ, стандартыг сахин биелүүлэх ёстой.

Үүрэг хүлээгчид дээрхийг биелүүлж чадаагүй тохиолдолд хохирсон эрх эдлэгчид нь хуульд заасан дүрэм, журамд заасны дагуу зохих ёсны шүүх, бусад шүүгчээс өмнө зохистой байдлаар хохирол барагдуулах шүүхийн үйл явцыг эхлэх эрхтэй.

Хариуцлага гэдэгт хүй элгэнд юуг, хэрхэн хийсэн тухай мэдээлэл хангахыг ойлгоно. Үүнд ил тод болон нээлттэй байдал шаардагддаг.

Хариуцлагын тогтолцоо нь:

- Тодорхой үүрэг, хариуцлага;
- Ил тод шийдвэр гаргах үйл явц, шийдвэрт тавигдах шаардлага;
- Мэдээлэлд нэвтрэх боломж;
- Хариуцлага шаардах үр нөлөөтэй механизмуудыг шаарддаг.

Хариуцлагыг төлөвлөлтийн харилцан адилгүй түвшинд тогтоосон байна. Энэ нь үүргийг заагаагүй үед бэрхшээлээс гарахад зориулсан албадлага, боломж шаарддаг. Мөн үүрэг хүлээгчдийн (жишээлбэл төр) чадавхийг бий болгосноор хариуцлагын болон нөхөн төлөх тогтолцоо орших ба өөрийн үйлчилж буй ард түмэн,

Засгийн газрын өмнө та болон танай байгууллага хариуцлага хүлээх явдлыг баталгаажуулахыг шаарддаг.

Гэхдээ хариуцлагыг үр нөлөөтэй болгохын тулд шаардсан байх ёстой. Үүнээс уламжлан хүний эрхэд суурилсан хандлага нь эрх эдлэгчдэд, ялангуяа хамгийн сул дорой хүмүүст шаардлагатай өөрсдийн эрхийг үр нөлөөтэй шаардах чадавхийн задлан шинжилгээг шаарддаг.

Дээр дурдсан хүний эрхийн зарчмууд дээр нэмж өгүүлэхэд, олон улсын хүний эрхийн стандартыг мөн удирдлага болгосон байна.

Хүний эрхийн стандарт

Олон улсын хүний эрхийн гэрээ конвенц нь нийгмийн бүх түвшин дэх үүрэг хүлээгчид, ялангуяа Төрийн байгууллагууд хариуцлагатай байх наад захын эрх, шаардлага, үүргийг бүрэлдүүлэх хүний эрхийн стандартыг агуулдаг.

Наад захын стандарт бол эрх эдлэгдэж буйг батлах боломжтой төлөвлөлтийн / бодлогын түвшний үйл ажиллагааны наад захын шаардлагатай түвшин юм. Наад захын түвшин юу болохыг тодорхойлохдоо тодорхой эрх, эсвэл бүлгийн эрхтэй холбоотой Төрийн үүргийг ойлгоход ямагт гэрээний байгууллагуудын “Ерөнхий зөвлөмжүүдийг” үздэг.

Жишээлбэл, ЭЗНСЭТОУП-ын хэрэгжилтэд хяналт тавих хөрооноос ЭЗНСЭТОУП-ын эрүүл мэнд дээд түвшинд хүрсэн байх 12 дугаар зүйлд хүлээн зөвшөөрсөн хамгийн наад захын үндсэн үүргийг тайлбарласан Ерөнхий зөвлөмжийг гаргасан. Хамгийн наад захын үндсэн үүрэгт:

- Эрүүл мэндийн тоног төхөөрөмж,

бүтээгдэхүүн, үйлчилгээ нь боломжтой, хүртээмжтэй, тохиромжтой, сайн чанарын байна;

- Нөхөн үржихүйн, эхийн (төрөхийн өмнөх, төрсний дараах) болон хүүхдийн эрүүл мэндийн асаргаа халамж;
- Эрүүл мэндийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, үйлчилгээ нь боломжтой, хүртээмжтэй, тохиромжтой, сайн чанарын байх явдлыг баталгаажуулах;
- Эрүүл мэндийн асуудал, урьдчилан сэргийлэх, хянах аргуудын талаарх боловсрол, мэдээллээр хангах;
- Цэвэр ус, хоол хүнс, орон байр болон бусад зүйл хэрэглэх зэрэг “эрүүл мэндийн үндсэн тодорхойлогчдыг” баталгаажуулах.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн наад захын стандарт

Дээр дурдсаны дагуу эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн хувьд олон улсын хүний эрхийн стандартууд нь Улсууд олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ, эм тариа, эрүүл мэндийн халамжийн боловсон хүчинг дараахь байдлаар баталгаажуулах үүрэг хүлээснийг илтгэдэг. Үүнд:

- Газар зүйн байрлал, эсвэл эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалахгүй хүн бүрт боломжтой байх;
- Соёл, хүйс, нас зэрэг зүйлд хамаарахгүйгээр бүх хүмүүст хүртээмжтэй байх;
- Залуус, дүрвэгсэд, ядууралд ортсон эмэгтэйчүүд гэх мэт бүх бүлэгт тохиромжтой байх, хувь хүн бүрийн хувийн нууцыг хүндэтгэх.
- Түүнчлэн эрүүл мэндийн боловсон хүчин болон боломжит эм тариа,

ашигласан тоног төхөөрөмжийн чанар, ур чадвар нь аливаа хүй элгэн, тухайн хүй элгэний доторх бүх хувь хүмүүст зориулан тогтоосон стандарттай байна.

Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн эдгээр наад захын стандартуудыг (боломжтой (availability), хүртээмжтэй (accessibility), тохиромжтой (acceptability), чанар (quality)) гол төлөв “ЗАQ” гэх нь бий. “ЗАQ” нь үүрэг хүлээгч эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн шаардлагатай наад захын стандартыг дэс дарааллын дагуу хангахад шаардлагатай.

Жишээлбэл, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ нь тухайн хот дахь эмэгтэйчүүдэд боломжтой, хүртээмжтэй, тохиромжтой байхаас гадна сайн чанарын байх боломжтой. Гэхдээ эрүүл мэндийн үйлчилгээ нь соёлын хувьд тохиромжтой бус бол (тодруулбал, эмнэлэг дан ганц эрэгтэй эмчтэй, соёлын хувьд эмэгтэйчүүдэд эрчүүд үзлэг хийхийг хүлээн зөвшөөрдөггүй бол) эрүүл мэндээ хамгаалуулах эрхийг бүрэн эдлэгдсэн гэж үзэхгүй.

Хүний эрхэд суурилсан хөгжлийн бодлого, хандлага

Үүний зэрэгцээ 1990-ээд оноос хөгжил, хүний эрхийг салган авч үзэх шаардлагагүй хэмээн тодорхойлж, хөгжлийн төлөөх хүний эрхэд суурилсан бодлого, хандлага хэмээх ойлголтыг боловсруулан, 2000 оны эхээр НҮБ-ын цөөнгүй агентлагууд хэдийнэ үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн ч тус ойлголтыг ялгаатай ойлгож байсан.

НҮБ-ын агентлаг хоорондын хамтын ажиллагааны явцад НҮБ-ын агентлагууд, туншүүдийн үйл хэрэгт (ялангуяа Улс орны нийтлэг үнэлгээ (ССА), НҮБ-ын Хөгжлийн туслалцааны хүрээнд (UNDAF)

хамаарах орон нутгийн түвшин дэх үйл ажиллагаа) хүний эрхэд суурилсан хандлага гэж юу болох талаар “нийтлэг ойлголттой” болох нь чухал юм гэдэг илэрхий болсон. Үүний үр дүнд НҮБ-ын олон агентлагууд хүний эрхэд суурилсан хандлагын гол бүрэлдэхүүний талаарх нэгдсэн ойлголттой болсон. Энэхүү нэгдсэн ойлголтыг “НҮБ-ын нийтлэг ойлголт” гэдэг.⁶

Хүний эрхэд суурилсан хөгжлийн хандлагын тухай нийтлэг ойлголтын талаарх НҮБ-ын мэдэгдэл

1. Аливаа хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүд, бодлого, техник туслалцаа нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, бусад хүний эрхийн олон улсын бусад гэрээнд заасан хүний эрхийн биелэлтэд ахиц гаргана.
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, бусад хүний эрхийн олон улсын бусад гэрээнд заасан хүний эрхийн стандартууд, дээрх баримт бичгээс үүдэлтэй зарчмууд нь бүх салбарын аливаа хөгжлийн хамтын ажиллагаа, төлөвлөлт болон төлөвлөлтийн үйл явцын бүх түвшинд удирдлага болно.
3. Хөгжлийн хамтын ажиллагаа “үүрэг хүлээгч” нарын өөрийн үүргийг биелүүлэх, “эрх эдлэгч” нарын өөрийн эрхийг шаардах чадавхийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Үүний дагуу “үүрэг хүлээгч” гэдэгт:

- Юуны өмнө Төрийн этгээд (state actors) буюу Засгийн газрын төрөл бүрийн түвшний байгууллагууд

⁶ United Nations. The Human Rights-Based Approach to Development Cooperation: Towards a Common Understanding Among the UN Agencies. Available at: www.hreoc.gov.au/social_justice/conference/engaging_communities/un_common_understanding_rba.pdf.

- Бусад этгээд, эсвэл өөрийн эрхийг эдлэхэд хариу нөлөөлөх үүрэг бүхий тодорхой Төрийн бус этгээдийг (non-state actors) ойлгоно.

Төрийн этгээд нь ХЭСХ бүх түвшинд (төрийн бүх харьяа газар, Засгийн газрын, үндэсний, орон нутгийн, нутгийн захиргааны түвшний бүх салбар) хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүргийг биелүүлэх төрийн чадавхид анхаардаг.

Төрийн бус этгээд нь хүний эрхтэй холбоотой хариуцлагыг хувь хүн, олон улсын байгууллага, иргэний нийгмийн байгууллага (тэдний дунд) зэрэг Төрийн бус этгээдүүдэд тусгайлан хариуцуулж болно.

Жишээлбэл, Хүүхдийн эрхийн тухайн конвенцийн дагуу эцэг эх тодорхой үүрэг хүлээдэг. Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчид өөрийн эмчлүүлэгчийн хувийн нууцаа хамгаалуулах эрхийг сахин хамгаалах хариуцлага хүлээж, тэдний алдаа мадаггүй мэдээлэл авах эрхийг баталгаажуулах үүрэгтэй.

Шашны удирдагчид, эсвэл ахмад настныг тодорхой тохиолдолд үүрэг хүлээгч хэмээн үзэж болно. Жишээлбэл, тэд хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн гэрлэлтийн эсрэг зоримог дуугарах хариуцлага хүлээнэ гэж харах боломжтой.⁷

Хүний эрхийн боловсролыг бүх шатанд түгээн дэлгэрүүлэх

Хүний эрхийн боловсрол бол хүсч байгаа нийгмийн-улс төрийн өөрчлөлтөд хүргэх тухайн улс эсвэл нутаг дахь

⁷ UNFPA A Human Rights-Based Approach to Programming P.79

одоогийн хүний эрхийн нөхцөл байдалд чиглэх боломжит арга хэмжээний нэг юм. Үүнтэй уялдан НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас 2004 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 59/113 тогтоолоор Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийг баталж, нийгмийн бүх салбарт хүний эрхийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх явдлыг эрчимжүүлэхэд анхаарсан юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн арван жилийн хугацаанд буюу 1995-2004 оны хооронд олж авсан туршлага, дэвшилд тулгуурлан, хүний эрхийн боловсрол олгох нийтлэг үндсэн зарчим, арга зүйг тодорхойлох, олон улсын түвшнээс үндэсний хамгийн анхан шатны нэгжид хамтын ажиллагаа, түншлэлийг бэхжүүлэх зорилготой байсан.

Тус хөтөлбөрийн эхний шатанд (2005-2009 он) ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоон дахь хүний эрхийн боловсролд анхаарал хандуулсан бол хоёр дахь шатанд (2010-2014 он) дээд боловсролын тогтолцоон дахь хүний эрхийн боловсрол болон багш, сурган хүмүүжүүлэгч, төрийн албан хаагч, хууль хяналтын байгууллагын ажилтнууд, цэргийн бие бүрэлдэхүүнд чиглэсэн хүний эрхийн боловсролын хөтөлбөрт ач холбогдол өгч байна.

Мөн НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 2007 онд өөрийн Зөвлөх хорооноос хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын төсөл бэлтгэхийг хүсчээ. Зөвлөл энэ баримт бичгийг эцэслэхдээ Зөвлөх хороог Гишүүн Улсууд, холбогдох олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн

дээд комиссарын газар, хүний эрхийн үндэсний байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудын байр суурь, санааг тухайн тунхаглалын агуулга дахь боломжит элементүүдэд суулгахыг мөн хүсчээ.

Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын төсөл нь удирдлага болгох зарчмууд, үндэсний болон олон улсын түвшинд хүний эрхийн боловсролыг хэрэгжүүлэхэд зориулсан зөвлөмжүүдийг агуулдаг. Хорооноос 2011 оны 1 дүгээр сард тунхаглалын хамгийн сүүлийн төслийг Зөвлөлд өргөн барьжээ.

НҮБ-ын Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын төсөлд:

I. тодорхойлолт, зарчим

Хүний эрхийн боловсрол, сургалт нь:

- Хүний эрхийн түгээмэл соёлыг хөхиүлэн дэмжихэд чиглэдэг. Энэ нь суурь эрх бөгөөд хүн бүрийн сурч боловсрох эрхийн салшгүй хэсэг юм.
- Тэгш эрх, ялангуяа охид хөвгүүд, эрчүүд эмэгтэйчүүдийн хооронд дахь тэгш эрх болон ХЭТГ, холбогдох олон улсын гэрээнд заасан бусад зарчмуудад тулгуурлана.
- Эмзэг бүлэг, уугуул хүмүүс болон үндэсний, угсаатны, шашны, хэлний цөөнхөд хамаарах хүмүүсийн тусгай хэрэгцээг бүрэн анхаарна.
- Боловсрол, сургалт, сурах бүх түвшин, аливаа хэлбэрт анхаардаг одоо үргэлжилж байгаа үйл явц юм.
- Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хувь нэмэр оруулж, гэр бүлийн хүчирхийлэл, ялангуяа охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг арилгахад чиглэдэг.

II. Улс орны түвшин дэх хэрэгжилтийн хэмжүүр

- Тухайн улс нь хүний эрхийн боловсрол, сургалтад хамрагдах эрхийг хүндэтгэх, дэвшилттэйгээр биелэл болоход гол хариуцлагыг хүлээнэ. Тухайн улс нь үйл ажиллагааны эрх зүйн хүрээг тогтоох, түүний үр нөлөөг байдлын үнэлгээг хийх, хүн бүр эдлэх явдлыг баталгаажуулах ёстой.
- Хүний эрхийн боловсрол, сургалт нь хүчтэй улс төрийн хүсэл зориг, хүний болон санхүүгийн нөөцийн хуваарилалт, яамд хоорондын зохицуулалт, хүний эрхийн үндэсний байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн зүгээс дэмжигдсэн байна.
- Хүний эрхийн боловсрол, сургалт нь харилцан адилгүй улс орнуудын соёлын болон уламжлалын баялагт анхаарч, шинэ технологийг ашиглана.
- Сургагч, бэлтгэгч нарыг хамгаалах, эрх чөлөөг баталгаажуулахын тулд тусгай анхаарал тавих ёстой.

III. Олон улсын түвшин дэх хэрэгжилтийн хэмжүүр

- Олон улсын, бүс нутгийн, үндэсний, орон нутгийн хичээл зүтгэлүүдийн хооронд хамтын ажиллагааг шаарддаг.
- НҮБ, олон улсын болон бүс нутгийн байгууллагууд:
- Иргэний болон цэргийн бие бүрэлдэхүүний хүний эрхийн боловсрол, сургалтыг хөхиүлэн дэмжинэ.
- Олон улсын гэрээг соёрхон батлах, гэрээний биелэлтэд хяналт тавих байгууллагыг хүлээн зөвшөөрөх, Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн

төлөв байдлын ээлжит хэлэлцүүлэгт оролцуулах замаар дараагийн арга хэмжээг авна.

- Сайн дурын шинжтэй олон улсын сан, хүний эрхийн боловсрол, сургалтын зохицуулалт, мониторингийн олон улсын төвийг байгуулна гэж тусгайлан заажээ.⁸

Хүний эрхийг хамгаалах, хангахад төрийн оролцоо болон механизм

Аливаа улсад хүний эрхийг хангах, хамгаалах нь төр, түүний биелүүлэх үүрэгтэй салшгүй холбоотой бөгөөд суурь эрхүүдийг үр нөлөөтэй эдлэх явдлыг баталгаажуулах, хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох гэж томъёолж ирсэн. Хүний эрхийн олон улсын эрх зүйн хүрээнд улс бүрийн засаг төр олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө үүрэг хүлээснийг ангилан авч үзвэл:

- Хүний эрхийг хүндэтгэх – тухайн эрхийг эдлэхэд саад болох аливаа зүйлийг тэвчих
- Хүний эрхийг хамгаалах – төрийн эрх мэдэлтэн, эсвэл төрийн бус этгээдийн зүгээс тухайн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх механизм бий болгох хууль тогтоомжийг батлах. Төр нь хүний эрхэд халдсан төрийн бус этгээдийн зүй бус үйлдлээс хүн бүрийг хамгаалах үүрэгтэй.
- Хүний эрхийг хангах – тухайн эрхийг эдлэх боломжийг хүмүүст олгосон хөрөнгө нөөцийг хуваарилах зэрэг асуудлыг агуулсан идэвхтэй арга хэмжээг байгууллагуудад болон журмуудад суулгах. Нэг талаас үүрэг

хүлээж буй этгээдийн үүргээ биелүүлэх чадавхийг нэмэгдүүлэх, нөгөө талаас эрх эдэлж буй этгээдийн эрхээ шаардахыг нь дэмжиж урамшуулах асуудлыг давхар анхаарч үздэг. Хангах нь хялбаршуулах (хүртээмжийг амар хялбар болгох), хөхиүлэн дэмжих (мэдээлэх), хангах (хамгийн эмзэг бүлгийг эн тэргүүнд анхаарах, тэгш эрхэд чиглэх) гэж хуваах боломжтой. Тодруулбал улсууд хүн бүр өөрийн эрхийг эдэлж чадавхийг баталгаажуулах эерэг үйлдлийг хийх ёстой – улсууд хууль, бодлогыг баталж, эрхүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах ёстой.

Монгол Улсын Их Хурал НҮБ-ын Мянганы дээд хэмжээний Чуулга уулзалтаас баталсан “Мянганы тунхаглал” баримт бичгийг сайшаан, Монгол Улсын Мянганы Хөгжлийн 2015 он хүртэлх зорилтыг тодорхойлж, 2005 оны 4 дүгээр сард “Монгол Улсын Мянганы Хөгжлийн зорилт”-ыг баталсан. Энэхүү баримт бичиг нь есөн зорилго, 2002 зорилтыг дэвшүүлэн тавьсан. Улсын Их Хурал 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр 13 дугаар тогтоол гаргаж, Мянганы Хөгжлийн зорилтуудын үзүүлэлтүүд дээр 2 заалт нэмж одоо 24 заалттай болсон байна.

Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэл 2004 онд, хоёрдугаар илтгэл 2007 онд гарсан билээ. Энэ оны эхээр Улсын Их Хурал “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого” хэмээх 2021 он хүртэл баримтлах том хэмжээний бодлого, хөтөлбөрийн баримт бичгийг баталсан.

Эдгээр баримт бичгийн гол агуулга, зорилго нь Монгол хүнийг хөгжүүлэх тулгуур зорилтуудын 2015 ба 2021 гэхэд

⁸ НҮБХЭЗ Зөвлөх хороо – Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглалын төсөл (2010) http://www.ohchr.org/english/bodies/hrcouncil/advvisorycommittee/HR_education_training.htm

хүрэх түвшин, чиглэлийг гаргаж тавьсан ба хүний хөгжлийн асуудал нь Мянганы хөгжлийн зорилтууд ба цогц бодлогын гол амин сүнс, зангилгаа нь болж, хүний хөгжил, хүний эрх, аюулгүй байдлыг хангах нь цаашид төрийн бодлогын улаан шугам байхыг энэхүү баримт бичгүүдээс харахаар зохицуулжээ.

Хүний хөгжлийн гол хоёр багана тулгуур гэж зүй ёсоор тооцогддог эрүүл, энх аж төрөх, боловсрол эзэмшихтэй холбоотой тодорхой зорилтууд Мянганы хөгжлийн зорилтуудад тусгагдсан. 24 зорилтын 10-ыг нь энэ хоёр асуудалтай шууд холбоотой гэж үзэж болохоор байна.

Хүний эрхийн онол, үндсэн зарчим, суурь асуудлын хүрээнд авч үзвэл Мянганы хөгжлийн зорилтууд нь бүхэлдээ хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулах, хамгаалахад чиглэгдсэн ба зорилго, зорилт нэг бүр нь хүний эрхийн тодорхой салбар, хүрээг хамаарч, өөр хоорондоо гинжин холбоосоор уягдсан. Мянганы хөгжлийн зорилт нь мөн чанартаа хүний хөгжил-хүний эрхийн дэвшлийн ойрын ирээдүйн чиг баримжаа юм. Хүн өөрөө хөгжлийн гол төв, гол ашиг хүртэгч нь байх ёстой гэдэг үзэл баримтлалтай нийцсэн байна.

Мянганы хөгжлийн зорилтын 9 дэх зорилгод “Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахих” гэсэн том зорилт дэвшигдсэн. Энэ онд Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 60 жилийн ой тохиож байна. Өнөөдөр дэлхийн 100 гаруй улс орны Үндсэн хуульд энэхүү тунхаглалыг бүхлээр нь эсхүл гол гол заалтуудыг нь оруулсан гэж үздэг. Түгээмэл тунхаглалыг 30 зүйлтэй, тэдгээрийг олон улсын бусад баримт бичгүүдэд дэлгэрүүлэн тусгасан.

Мянганы хөгжлийн зорилгын “Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахих” гэсэн зорилгын шалгуур үзүүлэлтийг боловсруулахад олон саналууд гарч байсан ба эдгээрээс дараах гурван шалгуур үзүүлэлтийг сонгож авсан. Үүнд:

1. Монгол Улсын хууль тогтоомж олон улсын эрхийн гэрээ, конвенцид нийцэж буй эсэх
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт
3. Төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй өмгөөлөгчдийн тоо

Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын хүрээнд дотоодын хууль тогтоомжийг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, хэрэг маргааныг шийдвэрлэхэд тэдгээрийг ишилж, үндэслэж байх, эрх зүйн эх сурвалж болгож занших талаар, шүүх хуулийн байгууллагын практикт хэрэглэхтэй холбоотой гарын авлага сургалт, семинарыг цаашид зохион байгуулах шаардлагатай. Улсын Дээд шүүх 2008 онд “Монгол Улсын олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг шүүхийн практикт хэрэглэх тухай” томоохон тогтоол гаргасан.

Энэ нь олон улсын гэрээг практикт хэрэглэхэд чухал түлхэц болох нь дамжиггүй ч үүнийг хэрэг маргааныг шийдвэрлэхдээ шүүх, харгалзан үзэж байгаа практик хэрэглээ маш дутмаг байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Гэрээ, конвенцийн биелэлтийн талаарх илтгэлийг хугацаанд нь чанартай бодит баримтын үндсэн дээр боловсруулж НҮБ-ын зохих хороодод хүргүүлэн, хэлэлцүүлснээр Монгол Улс Дэлхийн

хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа, хүний эрхийг хамгаалах үйлсэд тухайн улс орон ямар ололт амжилтад хүрсэн, ямар хүндрэл бэрхшээл байгаа, цаашид олон улсын тусламж дэмжлэгийг чухам ямар чиглэлээр авч болох, хамтын ажиллагааны хүрээ, түвшинг тодорхойлох, улмаар Монгол Улс дахь хүний эрхийн нөхцөл байдлыг дээшлүүлэх хөшүүрэг, түлхэц болгон ашиглах нь үр өгөөжтэй юм.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахижтай холбоотой хоёр дахь шалгуур үзүүлэлт бол шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт /хувь/ юм.

Шүүхийн шийдвэр бүр бодитойгоор биелэгдэж байх ёстой. Гэтэл манай улсад шүүхийн шийдвэр биелэлт туйлын хангалтгүй /40%, 50%/, иргэд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын хүнд суртал, буруутай ажиллагаанаас болж хохирсоор байна. Бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулахад шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлтийн байдал шийдвэрлэх үүрэгтэй. Гэтэл бодит амьдрал дээр шүүхийн шийдвэр ямар байгааг “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” Үндэсний чуулганы индэр дээрээс Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлэхдээ:

“Өнөөдөр манайд шүүхийн шийдвэр хамгийн өндөр биелж байгаа нь хорьдог хэсэг дээрээ 90 гаруй хувийн биелэлттэй байна, хамгийн бага биелж байгаа нь юун дээр байна гэж та бүхэн үзэж байна? Алимент гэж сонссон уу? Хүүхдийн тэтгэмж. Тэрэн дээр очихоор 9 хувийн биелэлттэй явж байх юм. Одоо та нар эндээс нэг дүгнэлт хий дээ. Бид ер нь яаж ажиллаж байна.

Алиментийг биелүүлдэггүй улс байх нь байна шүү дээ, бид. Хүүхдийн тэтгэмж бол жаахан юм. Тэгэхээр өнөөдөр манай хуулийн байгууллага, шүүхийн шийдвэр, тэр та нар 9 хувь, 90 хувийг хооронд нь нэмээд 2-т хуваа даа, хэдэн хувийн биелэлттэй гарч байна, шүүхийн шийдвэр”⁹ гэжээ.

Энэ хэсгийн гурав дахь шалгуур үзүүлэлт нь төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчилгээ үзүүлж буй өмгөөлөгчдийн тоо, үйл ажиллагаа юм.

Манай улсад эрүүгийн хэрэгт холбогдож ял эдэлж байгаа хүмүүсийн 80 орчим хувь нь нэн ядуу, ядуу, ажилгүй хүмүүс байна. Шүүхийн тухай болон Өмгөөллийн тухай хуульд зааснаар “Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасан байдаг боловч ердөө 15 сая төгрөг төлөвлөдөг. 2006 онд Монгол Улсын Засгийн газар “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан.

Уг хөтөлбөрт төлбөрийн чадваргүй иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх төвүүдийг байгуулах, орон тооны улсын өмгөөлөгчийг ажиллуулах талаар заасан.

Энэхүү үндэсний хөтөлбөрийг 2012 он хүртэл хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Туршилтын журмаар зарим аймаг, дүүрэгт төвийг ажиллуулж байсан бол одоо бүх аймаг, нийслэлийн дүүргүүдэд төвүүдийг идэвхтэй ажиллуулж байна. Энэ ажилд НҮБХХ-өөс хэрэгжүүлж буй “Хууль зүйн хүртээмж ба хүний эрх” төслийн үйл ажиллагаа маш их нөлөөлөл үзүүлж буйг хэлэх хэрэгтэй.

⁹ Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Шүүх эрх мэдлийн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганыг нээж хэлсэн үг, 2011.04.14, Төрийн ордон

Төлбөрийн чадваргүй, ядуу иргэдийн хувьд хууль зүйн чанартай, хүртээмжтэй үйлчилгээ нь шударга шүүхээр шүүлгэх, эрүү шүүлтээс ангид байх, бусдын гэм буруутай үйлдлээс өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, халдашгүй чөлөөтэй байх зэрэг олон эрхээ эдлэхтэй салшгүй холбоотой юм.

Мөн ядууралтай тэмцэх, бууруулахад нөлөөлөх арга хэмжээг улс орнууд сүүлийн жилүүдэд идэвхтэй судалсны дүнд ядуу иргэдийг эрх мэдэлжүүлэх, тэдгээрийн хүний эрхийн боловсрол ойлголт болон хууль эрх зүйн мэдлэг, мэдээллийг олгон чадавхжуулахгүйгээр ядууралтай тэмцэх нь үр нөлөөгүй хоосон арга хэмжээ гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Иймээс НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс дэлхийн улс орнуудад ядуу иргэдийн эрх зүйн ойлголт, чадавхийг нэмэгдүүлэх энгийнээр өөрийн эрхийг мэдэж шаарддаг болгоход анхаарч эхэлжээ. Тодруулбал, орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг тухай бүр хийлгэх, өөрийг нь тодорхойлох баримт бичгийг (төрсний гэрчилгээ, иргэний үнэмлэх, эрүүл мэндийн даатгал гэх мэт) албан ёсоор бүртгүүлэн авах, иргэний хувиар төрөөс үзүүлэх халамж үйлчилгээнд бүрэн дүүрэн хамрагдах, үүнд тулгуурлан өөрийн өмчлөх эрхийг хуулийн дагуу баталгаатай эдлэх нөхцөлийг бүрдүүлэхэд түлхүү анхаарч байгааг цохон тэмдэглэх нь зүйтэй.


Монгол Улсын Их Хурлаас 2003 онд “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг батлан гаргасан. Энэхүү хөтөлбөр нь Монгол Улсад ойрын ирээдүйд хүний эрхийг хангах, хамгаалах

төрийн бодлого, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлсон онцгой ач холбогдол бүхий цогц баримт бичиг мөн. Иймээс энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн иргэний ардчилсан нийгэм байгуулах Үндсэн хуулийн үзэл баримтлалын тулгуур асуудал юм. Монголын төрөөс явуулж буй бодлого, үйл ажиллагаа нь энэхүү хөтөлбөрт заасан бодлого, чиглэлд нийцэж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдэх ёстой. Гадаад улсын хувьд:

- Кыргыз Улсын Ерөнхийлөгч 2002 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр 2002-2010 он хүртэл хэрэгжих “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр (Үндсэн чиглэл)” (National Human Rights Action Plan) –ийг баталжээ. Тус улсын Хүний эрхийн омбудсман 2009 онд “Хүний болон иргэний эрх, эрх чөлөөний төлөв байдал” гэсэн тайлан илтгэл гаргасан байна.
- БНХАУ 2009 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр нэг жилийн хугацаатай хэрэгжих “Хүний эрхийн үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Энэ нь үйл ажиллагааны төлөвлөгөөний шинжтэй баримт бичиг ажээ.
- Казакстан Улсын Ерөнхийлөгч 2009-2012 онд хэрэгжих “Хүний эрхийн салбарын үндэсний төлөвлөгөө”-г баталсан ба энэ нь хүний эрхийн хамгаалалтыг боловсронгуй болгох тухай дэлгэрэнгүй хөтөлбөр юм.¹⁰

Орчин үед хүний эрхэд суурилсан хандлагын үүднээс эрх эдлэгч,

¹⁰ Эрх зүйн судалгааны төв ТББ “Монгол Улсад Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийх аргачлал тодорхойлох ажлын тайлан, УБ, 2011. 4 тал.



үүрэг хүлээгч нарыг тодорхойлж, нийгмийн харилцаанд хэрхэн оролцох явдлыг тодорхойлох болсон тул үүрэг хүлээгчээр дан ганц төрийг бус, харин иргэний нийгэм, хувийн хэвшил, хүй элгэн, хамт олныг авч үзэх байдал илрэлээ олж байна. Тодруулбал, нийгмийн хариуцлагын хүрээнд яригдах болсон нэг асуудал бизнес болно.

НҮБ-ээс гаргасан санаачлагын нэг нь дэлхий дахинд бизнесийн салбарт тогтвортой, нийгмийн хариуцлагатай бодлого баримтлах, түүний хэрэгжилтийг илтгэх явдыг дэмжсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Даян дэлхийн гэрээ (United Nations Global Compact) юм. Энэ санаачлагаар хүний эрх, хөдөлмөр, байгаль орчин, авлигад анхаарал хандуулж, НҮБ-ын агентлагууд, хөдөлмөрчид, иргэний нийгмийн байгууллагуудтай компаниуд мөр зэрэгцэн орж ирсэн онцлогтой. Дэлхийн хамгийн том сайн дурын, корпорациудыг хамааруулсан санаачлага хоёр зорилтыг өмнөө тавьсан. Үүнд:

1. Дэлхий дахин дахь бизнесийн үйл ажиллагаанд тус арван зарчмыг удирдлага болгох;
2. Мянганы Хөгжлийн Зорилт зэрэг өргөн хүрээг хамарсан НҮБ-ын зорилтуудыг дэмжих арга хэмжээг хурдасгах.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалаас иш татсан, НҮБ-ын Даян дэлхийн гэрээний арван зарчмын эхний хоёр зарчим нь:

1. Бизнес нь олон улсын түвшинд хүлээн зөвшөөрсөн хүний эрхийг дэмжиж, хүндэтгэнэ.
- Эрх зүйд захирагдах ёсыг хөхиүлэн дэмжих
 - Хэрэглэгчийн асуудалд анхаарал хандуулах

- Ажилтны бүтээмж, хариуцлагыг нэмэгдүүлэх
 - Хүй элгэний сайн харилцааг тогтоох гэх мэт
2. Бизнес нь хүний эрхийн зөрчилд оролцохгүй байхыг баталгаажуулна.¹¹

Компаниуд өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрхэн хүний эрхийг дэмжих, хүндэтгэх талаар жишээ дурдвал:

Ажлын байранд:

- Аюулгүй, эрүүл ажиллах нөхцөлөөр хангах
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг баталгаажуулах
- Ажилтнуудын дунд ялгаварлан гадуурхах байдлыг гаргахгүй байх
- Албадан эсвэл хүүхдийн хөдөлмөрийг шууд болон шууд бус байдлаар ашиглахгүй байх
- Ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүд эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, орон сууцаар хангагдаагүй бол хангагдах боломжийг олгох
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон хүнийг ажилд авах замаар дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх
- Бүх ажилтнуудын шашны итгэл үнэмшилд хүндэтгэлтэй хандах гэх мэт.

Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд, 2011 оны 11 дүгээр сарын байдлаар тус санаачлагыг дэмжин, Улаанбаатар хот болон нэр бүхий 22 компани, ТББ, эвлэл, холбоо багтаж байна.¹²

¹¹ http://www.unglobalcompact.org/Issues/huan_rights

¹² http://www.unglobalcompact.org/participants/search?business_type=all&commit=Search&cop_status=all&country%5B%5D=128&joined_after=&joined_before=&keyword=&listing_status_id=all&organization_type_id=&page=1&per_page=50§or_id=all

Иймээс хүний эрхийг хангах, хамгаалах үүргийг төрд хамааруулж, олон улсын эрх зүйн талаас харж байсан өнцөг өөрчлөгдөж, тус асуудалд дэлхий дахины хүрээнд илүү олон этгээдийг хамруулах байдлаар төлөв байдлыг сайжруулахад анхаарч байна гэж дүгнэх боломжтой ажээ.

Шинэлэг үзэл баримтлал

Орчин үед эрх зүйд захирагдах ёсны ойлголтыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэмд суулгаж өгсөн. Оршил хэсэгт НҮБ-ын нэгэн зорилгодоо “шударга ёсыг сахих, гэрээ болон олон улсын эрх зүйн бусад эх сурвалжаас үүдэн гарах аливаа үүргийг хүндэтгэн мөрдөх нөхцлийг бүрэлдүүлэх” гэж оруулсан байна. Энэхүү байгууллагын тэргүүний зорилго бол “Олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах, энэ зорилгын үүднээс энх тайванд учрах аюул заналыг сэрэмжлэн зайлуулах, түрэмгийлэл буюу энх тайвныг бусниулах бусад явуулгыг дарахын тулд үр нөлөөтэй хамтарсан арга хэмжээ авах, олон улсын маргаан буюу энх тайвныг бусниулахад хүргэж болзошгүй байдлыг шударга ёс, олон улсын эрх зүйн зарчмын дагуу эв зүйгээр зохицуулах буюу шийдвэрлэж байх” юм.

Эрх зүйд захирагдах ёсны зарчмыг үндэсний болон олон улсын түвшинд хэрэгжүүлж байна. Үндэсний түвшинд НҮБ нь Үндсэн хууль буюу түүнтэй ижил хүчин чадалт хэм хэмжээ, ил тод болон тохирохуйц эрх зүйн хүрээ, түүний хэрэгжилтэд анхаарах, шударга ёс, засаг төр, хүний эрхийн байгууллагууд нь сайтар зохион байгуулагдсан бүтэцтэй, санхүүжилттэй, бэлтгэгдсэн боловсон хүчинтэй, хэрэгцээт тоног төхөөрөмжөөр хангагдсан байх, үр нөлөөтэй шүүх үйл явц,

механизмуудыг агуулсан, хариуцлагатай төрийн албан хаагч, байгууллагуудтай, иргэний нийгмийн зүгээс эрх зүйд захирагдах ёсыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулдаг зэрэг эрх зүйд захирагдах ёсны хүрээг дэмжиж ажилладаг. Дээрх хэм хэмжээ, бодлого, институтууд, үйл явц нь нийгмийн гол цөм болж, хувь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан эрх зүйн хамгаалалтын дор өөрийгөө аюулгүй, тайван байдлаар мэдрэх, маргааныг тайван замаар үр нөлөөтэй шийдэх боломжийг хохирогчид олгох, хуулийг зөрчсөн хэн ч, Төр ч гэсэн хариуцлага хүлээх нөхцөлийг илэрхийлж байна.

Олон улсын түвшинд НҮБ-ын Дүрэмд эрх зүйд захирагдах ёсны зарчим нь Улсуудын хоорондын харилцааг зохицуулах чухал элементүүдэд илрэлээ олдог. 1970 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2625 (XXV) тогтоолоор баталсан НҮБ-ын Дүрэмд заасны дагуу Улсуудын хооронд дахь нөхөрсөг харилцаа, хамтын ажиллагааны талаарх олон улсын эрх зүйн зарчмуудын тунхаглалд НҮБ болон эрх зүйд захирагдах ёсны хоорондын холбоосыг хүлээн зөвшөөрсөн байна. Энэхүү тунхаглалын оршил хэсэгт “үндэстнүүдийн дунд эрх зүйд захирагдах ёсыг хөхиүлэн дэмжихэд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрмийн чухал ач холбогдол”-ыг цохон тэмдэглэжээ.

Олон улсын эрх зүйд хийсэн хичээл зүтгэлийг нэгтгэн, НҮБ-ын үнэт зүйлс, зарчмуудал:

- НҮБ-ын дүрэм, олон улсын эрх зүйг хүндэтгэх;
- Улсуудын тусгаар тогтносон байдал болон хүч хэрэглэх, аюул заналхийлэлгүй байх зарчмыг хүндэтгэх;
- Олон улсын үүргээ бүрэн дүүрэн биелүүлэх;
- Тайван замаар маргааныг шийдвэрлэх;
- Хүний эрх, суурь эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах;
- Геноцид, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг, угсаатны цэвэрлэгээ, дайны гэмт хэргээс хамгаалах нь дан ганц улсын өөрийн хүн амын өмнө хүлээх үүрэг бус, харин олон улсын хамтын нийгэмлэгийн үүрэг болохыг хүлээн зөвшөөрөх;
- Энх тайван, аюулгүй байдал, хөгжил, хүний эрх, эрх зүйд захирагдах ёс, ардчилал хоорондоо зайлшгүй уялдаа холбоотойг хүлээн зөвшөөрөх зэрэг болно.

Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих асуудал чухал боловч энэ үзэл санаа буруугаар ашиглагдах буюу түүний нөхцөл байдалд тохируулан хэрэглэх явдал дутагдалтай байдаг нь бидний сэтгэлийг зовоодог билээ. Эн тэргүүнд энэхүү үзэл санаанд бүхий л хэрэгцээ, хүсэл эрмэлзлэлийг хамааруулан ойлгох ёсгүй. Хүний эрх гэдэг тусгайлан авч үзэх ёстой маш үнэ цэнэтэй зүйл билээ. Түүнээс гадна хүний эрхийг хөхиүлэн дэмжихдээ янз бүрийн соёл, түүх, нөхцөл байдлыг харгалзан үзэх учиртай. Эдгээр эрхийг хүндлэх арга хэлбэр нь нийгэм бүрт өөр өөр байдаг бөгөөд Америк, Швед, Германд тохирч байгаа зүйлийг Беларусь, Эстони, Аргентин, Нигерт шууд хуулбарлаж болно гэж ойлгож болохгүй.

Хүний эрхийн тухай үзэл баримтлалын талаар тодорхой ойлголттой байх нь ялангуяа өдөр тутамд хүний эрх нь зөрчигдөж байдаг хүмүүсийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд амин чухал ач холбогдолтой юм. Хүсч болох бүхэн эрх байж чадахгүй бөгөөд бүх эрхийг хүний эрхэд хамааруулах нь өрөөсгөл гэж болно. Хүний эмзэг эрхтэнийг цахилгаанаар цохиулж, эрүүдэн шүүх явдлыг цалинтай амралт эдлэх эрхтэй адилтган үзэх нь учир дутагдалтай. Хүний эрхийг зөрчсөн аливаа асуудлаар засаг төр нь хариуцлага хүлээх ёстойг дурдах нь зүйтэй.¹³

Тэгвэл төр хариуцлага хүлээх, хүний эрхийг хангах, хамгаалахын тулд ямар идеологийг удирдлага болгож, нийгмийн харилцааг зохицуулах вэ гэдэг асуулт урган гарч ирнэ.

Монгол Улсын хувьд бид бүхэн Азийн цээжинд амьдарч байгаагийн хувьд соёл иргэншлийн нөлөөг эн тэргүүнд харгалзах ёстой. Ази тив бол соёлын маш олон үзэгдэл, хэлбэрийг өөртөө агуулсан онцлогтой ба тухайн бүс нутагт дахь хүмүүсийн улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал ч харилцан адилгүй. Соёлын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөхийн тулд хүний эрх нь уламжлалт эх сурвалжид тулгуурлахаа больсныг дурдах шаардлагатай. Эрдэмтэн судлаачдын хувьд дөрвөн эх сурвалж байгааг онцолдог. Үүнд:

- Бурханлиг эрх мэдэлтэн
- Жам ёсны эрх
- Зон совин
- Олон улсын гэрээг соёрхон батлах явдал¹⁴

¹³ Найжель Ашфорд Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. УБ, 2011, 63-64 дэх тал.

¹⁴ <http://www.hurights.or.jp/archives/database/hr-cultural-values.html>

Эхний хоёр эх сурвалж нэг их дэлгэрээгүй, гурав дахь эх сурвалжийн талаар маргаан их өрнөдөг. Хэдийгээр нийгэм дэх элитүүд олон улсын хүний эрхийн гэрээг соёрхон баталсан ч түүний түгээмэл байдлыг эргэн харах шаардлагатай гэсэн байр суурийг илэрхийлэх нь бий. Зарим тохиолдолд улс төрийн хүчин зүйлсээс шалтгаалан шийдвэр гаргадаг. Хүний эрхийн Үндэсний Комисс, Авлигатай тэмцэх газар байгуулахыг олон улсын хамтын нийгэмлэгээс шахсан гэх мэт. Учир нь элитүүдийн үнэт зүйлсийг уламжлалт үнэт зүйлсээс салган авч үзэх боломжгүй гэдэг. “Азийн үнэт зүйлс” буюу Ази тив дэх нийтлэг үнэт зүйлсийг тодорхойлвол Барууны үзэлтэй зөрчилдсөн, бүх хүмүүст хамаарах түгээмэл, нийтлэг биш үнэт зүйлсийг дэмждэг.

Үүнд:

- Өөрийнхөө дээр нийгмийг тавьж, гэр бүлийг нийгмийг барих “тоосго” гэж үздэг
- Асуудлыг маргаанаас илүүтэйгээр зөвшилцлөөр шийддэг
- Эрхтэй эсрэгцүүлэн үүргийн ач холбогдлыг чухалчилдаг
- Өөрийн сул дорой гишүүдийн араас халамж анхаарал тавих хүй элгэний (community) үүргийг онцолдог.¹⁵

Нөгөө талаас Азийн хувьд, аминч үзлээс илүүтэйгээр хамтач үзэл хүчтэй нөлөөлдөг, хэлэлцэж шийдвэр гаргахаас илүүтэйгээр удирдагчийн байр суурийг хардаг, үзэл бодлоо чөлөөтэй

илэрхийлэхээс дуугүй байх нь зүй зохистой гэдэг үзэл бодол газар авсан ч гэлээ, барууны соёл иргэншлийн нөлөөгөөр эрх зүйг нутагшуулах, өөрийн болгох үзэгдэл ХХ зуунаас эрчимтэй явагдсан билээ.

Улс төрийн болон эрх зүйн онолын үзэл баримтлалаас нийтлэг олж харах боломжтой, дэлхийн улс орнуудад түгээмэл байдлаар төрийн үйл ажиллагааг тодорхойлох, эрх зүйн хэм хэмжээ боловсруулах үйл явцыг илэрхийлэх, нийгмийн зүй ёсны үзэгдлийг хэмжих хэмжүүрээр эрх зүйд захирагдах ёсыг (rule of law) авч үзэх боломжтой. Эрх зүйд захирагдах ёс нь төгс төгөлдөр шинжтэй, бүрэн утгаар хэрэгжсэн, нэг хэвийн зүйл биш, харин улс төр, эрх зүйн идеологи буюу эрмэлзэл бөгөөд хүний болон нийгмийн хөгжлийг даган хөгжиж, тавигдах хэм хэмжээ, шалгуур нь улам нарийсч байдаг онцлогтой билээ.

Эрх зүйд захирагдах ёсны талаар өгүүлэхийн тулд Английн хуульч Альберт Дайсийг дурдах нь зүйтэй. Тэрээр эрх зүйд захирагдах ёсыг:

1. Шүүхийн тогтоосон хуулийг зөрчиж, хэнийг ч шийтгэж болохгүй.
2. Нийгэмд эзэлсэн байр сууриас үл хамааран хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байна.
3. Хууль тогтоох үйл ажиллагаа нь хувь хүний эрхээр ямагт хязгаарлагдаж байх ёстой гэж анх үзсэн¹⁶. Альберт Дайси ийнхүү эрх зүйд захирагдах ёсыг өргөн утгаар агуулга, мөн чанарын талаас тодорхойлсон. Харин тэрээр эрх

¹⁵ Ghai, Yash (1994) “Human Rights and Governance: The Asia Debate,” in Center for Asian and Pacific Affairs, occasional papers, The Asia Foundation, San Francisco, November.

¹⁶ Dicey, Albert. An Introduction to the Study of the Law of the Constitution (1885). Palekar, S. Comparative Politics and Government p. 64–65 (PHI Learning 2009)

зүйд захирагдах ёсны хэлбэрийн буюу процедурын талыг онцлоогүй.¹⁷

Харин Л.Фуллер эрх зүйд захирагдах ёсыг дан ганц хэлбэрийн буюу процедурын талаас авч үзэж, түүний бүрдэл хэсэгт дараахь элементүүдийг оруулжээ. Үүнд:

Хуулиуд нь:

1. Нэн түгээмэл байх
2. Нийтэд зарлаж мэдээлсэн байх
3. Үйлчлэх ирээдүйтэй байх
4. Тодорхой бөгөөд ухаалаг байх
5. Зөрчилгүй байх
6. Тогтвортой байх
7. Боломжгүй зүйлийг шаардахгүй байх
8. Үг хэллэг нь ойлгомжтой, хоорондоо нийцэл зохицолтой шатлан захирсан байх ёстой гэж үзсэн байна.¹⁸

Иймээс “эрх зүйд захирагдах ёс” буюу rule of law гэсэн ойлголт нь хууль тогтоогчдийн дур зорго, үнэлэмж, үзэл суртал, байр суурийг эрх зүйн үнэт зүйл, зарчим, хүний салшгүй эрх, зүй ёс, шударга процедурыг шингээсэн хууль зүйн техникээр хязгаарлаж, хуулиар бий болж болзошгүй аюулыг зайлуулж, хуулийг цэвэр ариун байлгах тухай үзэл санааг илэрхийлжээ.

Эрх зүйд захирагдах ёсны индексийг World Justice Project-аас боловсруулан гаргаж, дэлхийн улсуудын төлөв байдалд үнэлгээ өгдөг. Тэрхүү үнэлгээний шалгуур үзүүлэлт нь 10 бүлэг, 49 үзүүлэлтээс бүрэлддэг. Үүний тавдугаар хүчин зүйлд багтсан суурь эрхийг хэр үр нөлөөтэй баталгаажуулснаар үнэлэх нь хүний эрхийг хангахад тухайн улс ямар ач холбогдол өгч тодорхойлох хүчин зүйл гэж болно.

¹⁷ Н.Лүндэндорж, Jurisprudence, Эрх зүй судлал: Философи, онол, УБ, 2011, 141–142 дэх тал.

¹⁸ Мөн тэнд

Мөн олон улсын түвшинд шинээр гарч ирсэн механизм бол Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг буюу UPR-Universal Periodic Review юм. Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг нь НҮБ-ын гишүүн 192 орны хүний эрхийн төлөв байдлыг 4 жил тутам дүгнэн хэлэлцэх цоо шинэ механизм юм.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2006 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 60/251 тоот тогтоолоор НҮБ-ын Хүний эрхийн Комиссыг Хүний эрхийн зөвлөл болгон өөрчлөн байгуулж, “гишүүн бүх улсынхаа хүний эрхийн үүрэг, амлалтынх нь биелэлтийн талаар үнэн бодит мэдээлэлд үндэслэн, тэдэнд шударга бөгөөд бүхий л хүрээний асуудлыг хамруулан дүгнэлт хэлэлцүүлэг хийх” эрхийг Хүний эрхийн зөвлөлд олгосон.

2007 оны 6 дугаар сарын 18-нд Хүний Эрхийн Зөвлөлийн шинэ гишүүд баталсан зөвлөлийн ирээдүйн ажлын удирдамжийг агуулсан зохион байгуулалтын баримт бичиг (А/ХЭЗ/шийдвэр/5/1)-ийн нэг үндсэн хэсэг нь Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR) -ийн тухай байсан юм.

Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR) бий болсноор аль нэгэн гэрээгээр хязгаарлагдахгүй хүний эрхийн бүхий л асуудлыг нэг дор авч хэлэлцэх боломж олгосноос гадна НҮБ-ын гишүүн бүх улсыг хамрах болсноороо илүү ач холбогдолтой юм. НҮБ-ын гэрээний хороод нь зөвхөн тухайн гэрээний гишүүн орнуудад хамааралтай бөгөөд зөвхөн тухайн гэрээнийхээ хэрэгжилтийг хянан хэлэлцдэг

тул олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрт нэгдэн ороогүй олон улс орон гэрээний хороодын хяналтаас гадуур үлддэг байв.

UPR нь бүх улс оронд ялгаваргүй, тэгш хандах, хэлэлцүүлэгт орж байгаа улстай хамтран ажиллах зарчимд үндэслэдэг ба улс орнууд дахь хүний эрхийн нөхцөл байдлыг сайжруулах, хүний эрхийг хангахад тулгарч буй бэрхшээлүүдийг даван туулахад төр засагт туслах, техникийн туслалцааны асуудлыг ч мөн авч үздэг нэгэн онцлогтой юм.

UPR-ийн эцсийн зорилго нь дэлхийн бүх хүний тусын тулд улс орнуудын хүний эрхийн нөхцөл байдлыг газар дээр нь сайжруулахад оршино. Энэ зорилгодоо хүрэхийн тулд улс орнууд дахь хүний эрхийн төлөв байдлыг үнэлэх, хүний эрх зөрчигдөх тохиолдол бүрт анхаарлаа хандуулах боломжийг эрэлхийлэх бөгөөд улс орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, хүний эрхийн салбар дахь сайн туршлагаа хуваалцах, бие биенээсээ суралцах боломжийг олгох, хүний эрхийн асуудлаа сайнаар шийдвэрлэх чадавхийг бэхжүүлэх зорилготой.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 159 тогтоолоор “НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө” баталжээ. Уг тогтоолд эрхлэх ажлынхаа хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн 2014 онд биелэлтийг нь гаргахыг төсвийн

ерөнхийлөн захирагч нарт, зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хэрэгжилтэд нь ерөнхий хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны сайдад даалгасан байна.

Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Гадаад харилцааны яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссарын газар, Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин төлөөлөгчийн газартай хамтран Монгол Улсын Засгийн газраас баталсан “Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн Зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2011-2014 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г танилцуулах семинарыг 2011 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулж, семинарт яамд, тамгын газар, төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид оролцож, санал бодлоо солилцсон байна. Семинарт оролцогчид Зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, мөн яамдын үйл ажиллагааны уялдааг сайжруулах нь зүйтэй гэж тэмдэглэснийг дурдах нь зүйтэй.

Цаашид:

- Төрөөс хүний эрхийг хангах хамгаалах ажлыг цаасан дээр биш бодит үр дүнд хүргэх тодорхой бүтээмжтэй ажлуудыг нарийвчилсан төлөвлөгөө болон дэмжлэгийн дагуу хэрэгжүүлэх;

- Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр болон бодлогыг бодитойгоор хэрэгжүүлэхэд санхүүгийн болон боловсон хүчний шаардлагатай нөөцийг бий болгон эрчимтэй ажиллуулах;

- Хүний эрхийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд субъектийн хязгаарлалтгүйгээр бүх нийтэд тэгшээр хуваарилан хүргэх үйл ажиллагааг төрийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;

- Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулан эрх зүйн шинэтгэлийн ажлыг хуулийн бүх байгууллагуудыг хамруулан хийхээс гадна, хуулийн байгууллагуудын ажилтнуудын хүний эрхийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах;

- НҮБ-аас Монгол улсын Засгийн газарт өгсөн зөвлөмжийг бодитойгоор хэрэгжүүлэхэд төрийн бүх байгууллагуудын анхаарлыг хандуулан бодит үр дүнд хүрэхүйцээр хэрэгжүүлэх;

- Олон улсын нэгдэн орсон гэрээний заалттай дотоодын хууль тогтоомжуудын зөрчилдсөн болон зохицуулагдаагүй заалтуудыг эргэн нэг харж шүүхийн практикт аль болох өргөн хүрээгээр хэрэглэж хэвших;

- Хүний эрхэд суурилсан хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦААНД НАСААР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ НЬ



Санхүү, Эдийн Засгийн Дээд сургуулийн бизнесийн удирдлагын тэнхимийн багш, дэд профессор
Болдбаатарын Дэлгэрмаа



Санхүү, Эдийн Засгийн Дээд сургуулийн бизнесийн удирдлагын тэнхимийн багш, дэд профессор
Жамъянсүрэнгийн Хулан

Энэхүү эрдэм шинжилгээний огуулалд хөдөлмөрийн харилцаанд насаар ялгаварлан гадуурхах асуудал болон түүний эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн.

Уг асуудлын хүрээнд “насаар ялгаварлан гадуурхах” хэмээх ойлголтын талаар бусад улс орнуудын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан шинжилжээ. Тухайлбал, “Хөдөлмөр эрхлэхэд насаар ялгаварлан гадуурхахгүй байх тухай” / ADEA/ АНУ-ын хууль, шүүхийн шийдвэр, жишиг тохиолдлуудаар баяжуулан тайлбарлах аргаар асуудлыг танилцуулж, зөвлөмж гаргасан байна. Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-ийг шинэчлэн найруулж батлахад дээрх ойлголтыг илүү нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэж үзжээ.

AGE DISCRIMINATION IN EMPLOYMENT

Delgermaa.B, Khulan.J

This paper concerns age discrimination and its legal regulation. I have presented a comparison of legal regulation of age discrimination in different countries. I have taken the example of non-discrimination in employment based on age in various court decisions from the United States and enriched it with examples and cases from other countries. Based on my findings, I present some recommendations. It is important to define the above mentioned issue in detail for discussion and approval of the amendment to the Law on Employment of Mongolia.

Бид өдөр тутмын сонин эргүүлж суухдаа ажлын заруудыг уншина. "...ажлын дадлага туршлагатай, мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан...", "...30-аас дээш насны...", "...мэргэжлээрээ таваас дээш жил ажилласан, 40 хүртэл насны..." гэх шаардлагуудыг тавьж байгууллагууд ажилтанг сонгож авах болжээ. Хэрвээ шууд ба шууд бус утгаар хүний насыг заасан ажлын зарыг АНУ, Европын Холбооны улсуудад гаргах юм бол тухайн байгууллага хуулиар өндөр торгууль төлөх болно. Учир нь эдгээр орнуудад насаар алагчлахыг хориглосон хуультай.

Гэтэл манайд бол энэ нь ердийн зүйл болоод удаж байна. Тэр тусмаа 40-өөс дээш насны хүмүүс эрэгтэй, эмэгтэй үл хамааран ажилд орох ямар ч найдваргүй болжээ. Ийм гаж сэтгэл зүй монголын нийгэмд тогтоод удаж байна. 40-өөс дээш насныхан хуучинсаг, удаан, социализмын үед олж авсан мэдлэг нь хуучирсан гэх мэт олон шалтгаануудыг тоочно. Гэтэл 40 нас гэдэг бол жинхэнэ хийж бүтээхийн оргил нас хэмээн үздэг. Англи хэлнээ "age discrimination", орос хэлнээ "дискриминация по возрасту-эйджизм" гэж томъёолжээ. Эйджизм нь зөвхөн 40 насныханд хамаатай бус дөнгөж сургууль төгссөн залуучууд ч энэ алагчлалд өртөнө.

Барууны орнуудад бол эйджизмд 25-аас доош, 50-аас дээш насныхан илүү өртдөг байна. Гэтэл манайд 40-50 нас буюу хувийн амьдрал нь тэгширсэн, ажлын арвин их дадлага туршлагатай, энэ насанд хүн карьер гэхээс илүү өөрийн сонирхолтой, дуртай, гол нь тогтвортой ажлын байранд байхыг хүсдэг гээд тоочвол олон давуу талыг харуулсан нас байх юм. Ажлын заруудаас ажвал

"мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан, ажлын дадлага туршлагатай" гээд зачих юм бол яаж дөнгөж сургууль төгссөн хүн энэ шалгуурын дагуу ажил олох юм бэ?

Монгол Улсын Үндсэн Хуулийн 2 дугаар бүлгийн 14.2-д "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно"; 10.4-т "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй" гэж заажээ. Мөн Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд "Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох" тухай заасан байдаг. Үүнд 7.2-т "Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно".

Мөн 7.3-т "Ажил олгогч нь иргэнийг ажилд авахад болон хөдөлмөрийн харилцааны явцад ажил, үүргийн онцлог шаардлагын улмаас ажилтны эрх, эрх чөлөөг хязгаарласан бол энэ тухай үндэслэлээ нотлох үүрэгтэй" гэжээ.

Мөн түүнчлэн "Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай" Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын III дүгээр конвенцийн I дүгээр зүйлд "алагчлах" гэсэн нэр томъёо хоёр утгыг илэрхийлсэн. Үүнд:

а/Арьс үндэс, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол,

үндэс угсаа буюу нийгмийн гаралд үндэслэн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш боломж, хандлагыг үгүйсгэх буюу зөрчихөд хүргэж байгаа аливаа ялгаварлах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үйлдэл;

б/Ажил олгогч, ажилчдыг төлөөлөх байгууллага буй тохиолдолд тус байгууллагууд болон холбогдох бусад байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр гишүүн улсад тогтоосон ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш боломж, хандлагыг үгүйсгэх буюу зөрчихөд хүргэж байгаа аливаа ялгаварлах, үгүйсгэн гадуурхах, эсхүл давуу байдал олгох бусад үйлдэл гэж заажээ.

Энэхүү зөвлөмжид /11.2/ “Гишүүн улс бүр ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтэд алагчлахаас урьдчилан сэргийлэх үндэсний бодлого боловсруулна. Энэхүү бодлого нь хууль тогтоомж болон ажил олгогч, ажилчдыг төлөөлөх байгууллагын хооронд байгуулсан хамтын хэлэлцээр, эсхүл үндэсний нөхцөл, практикт тохирох бусад аргаар хэрэгжих бөгөөд түүнд дараах зарчмыг тусгасан байвал зохино” гээд 12 зарчмыг заажээ. Түүнчлэн I.1.(2)-д “Тодорхой ажлын онцлогтой холбоотой тавигдах шаардлагад үндэслэсэн ялгаварлах, хавчин гадуурхах, эсхүл давуу байдал олгох үйлдлийг “алагчлах” хэмээх ойлголтод хамааруулахгүй” гэж заасан.

Энэ бүх хууль тогтоомж, конвенциуд Монгол улсад үйлчилж байхад амьдрал дээр насаар ялгаварлан гадуурхах явдал улам нэмэгдсээр байна.

Насаар ялгаварлан гадуурхах дараах төрлүүд байна. Үүнд:

- **Шууд ялгаварлан гадуурхалт**

/прямая дискриминация/: Энэ нь ажилтанг шууд настай нь холбогдуулж ялгаварлан гадуурхахыг хэлнэ. Жишээ нь тухайн ажлын байранд тавигдах бүх шаардлагуудыг хангаж байгаа боловч 46 настай учир ажилд авахгүй байх, нэгэн компани 50-с дээш насны ажилчдаа өөрийгөө хөгжүүлэх тал дээр дэмжлэг үзүүлдэггүй, ингэснээрээ карьер осөх боломжгүй болгодог байна.

- **Шууд бус ялгаварлан гадуурхалт / косвенная дискриминация/:** Энэ нь ажил олгогч ажилтнаа эсвэл ажилд орох хүсэлтэй байгаа хүмүүсийг насаар нь бүлэгт хувааж, бусадтай харьцуулахад ашиггүй байх нөхцөл байдалд оруулдаг. Жишээ нь Federal Express Corporation хууль бусаар ажлаас халсан case юм. Тус компани шуудан зөөгч /зарлага-куррьер/ ажилтнууддаа тодорхой хугацааны дотор тодорхой тооны илгээмжийг хүргэж өгөх үүрэг өгчээ. Зорилго нь бага хугацаанд олон илгээмж хүргэх явдал. Гэтэл мэдээж 40 ба түүнээс дээш насныхан залуу шууданчдыг яаж гүйцэх вэ дээ. Компани анхнаасаа л 40-өөс дээш насныхныг халах зорилготой ийм үүрэг өгчээ. Шүүхээс хууль бусаар ажлаас халсан гэж ажилчдын талд шийдвэр гаргажээ.

- **Хавчих /преследованис/. Энэ нь насны талаар шоглох, элдэв үгээр хэлэх, доромжлох ойлголт юм.**

- **Виктимизация /victim/. Энэ нь насаар ялгаварлан гадуурхсаны үндсэн дээр эрхээ хамгаалуулахаар хандсан ч өөр бусад эрх нь зөрчигдсөн ажилтнуудын талаар мэдүүлэг өгөхийг хэлнэ.**

Насаар ялгаварлах нь ажилд орох, хөдөлмөрлөх явцад тохиолдоно.

Дийлэнх компаниуд мэргэжлийн өндөр мэргэшилтэй, ажлын арвин туршлагатай, тавигдаж буй шаардлагад бүрэн нийцэж байгаа боловч насны хувьд тохирохгүй гэж үзэж ажилд авдаггүй. Ахимаг настай хэмээн үзэж, тэдгээрийг удаан, ойр ойрхон өвдөж чөлөө авах магадлалтай, сүүлийн үеийн чиг хандлага, үйл явдлуудтай танилцаагүй хэмээн үздэг байна. Харин залуучуудыг давтан сургаж авснаар компаниуд тэдэнд зарцуулсан зардлаа үр бүтээлтэй ажиллуулснаар амархан нөхөж авна хэмээн тооцдог байна. Түүнчлэн залуучууд дунд шатны албан тушаалд ажилд ороход хүндрэлтэй байдаг байна. Учир нь хэт залуу учир бусад ажилтнууд хүлээн зөвшөөрөхгүй байх, ахмад ажилтнууд үл тоомсорлох асуудал тулгардаг учир ийм албан тушаалд ороход хэцүү байна. Залуу эмэгтэйчүүдийн тухайд төрөх насны, хүүхэд төрүүлэх чөлөө аваад алга болно хэмээн ажилд авах дургүй байх талтай.

Насаар ялгаварлах нь дийлэнхдээ ахимаг насныханд тохиолдох ба энэ нь ажилд орох, албан тушаал ахих, цалин хөлсөө нэмэгдүүлэх, шагнал урамшуулал авах, мэргэжил дээшлүүлэх, бүтцийн өөрчлөлт хийхэд цомхотголд өртөх зэргээр илэрнэ. АНУ-ын шүүхийн практикт 40 ба түүнээс дээш насны хүмүүсийг цомхотгож, олноор нь халсан жишээд олон байдаг байна.

АНУ-ын Конгресс насаар ялгаварлах явдлыг халах зорилгоор 1967 онд “Хөдөлмөр эрхлэхэд насаар ялгаварлан гадуурхахгүй байх тухай” /ADEA/ хуулийг баталжээ. Энэ хууль нь 40 ба түүнээс дээш насны хүмүүсийг хамгаалах ба 40-өөс доош насныханд үйлчлэхгүй юм байна. Мөн 20 ба түүнээс дээш ажилтантай компаниудад хамааралтай хууль юм.

Энэ хуулиар хэрэв ажилтан нь мэдлэг, мэргэжил, ур чадвар, бүтээмж зэрэг ажил олгогчийн зүгээс тавигдаж буй бүх шаардлагыг хангаж байгаа боловч шууд ба шууд бусаар насаар ялгаварлан гадуурхаж ажлаас нь халсан бол шүүхэд гомдол гаргах эрхтэй байна. Хуулиар ажилтан дараах хохирлыг нэхэмжлэх эрхтэй. Үүнд:

- Ажилгүй байсан хугацааны цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн шимтгэлийг ажил олгогчоос гаргуулах;
- Цалин хөлсийг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль буюу мөнгөн төлөөс /компенсация / ажил олгогч төлөх;
- Өмгөөлөгчийн туслалцаа авсны хөлс болон бусад зардлууд зэрэг байна. Энэхүү хуулийн дагуу шийдвэрлэсэн АНУ-ын шүүхийн шийдвэрийг авч үзье.

Parrish v. Immanuel Medical Center 92 F.3d 727 (8th Cir.1996)

Мэри Руф Парриш нь Иммануэлийн эмнэлэгт 1979 оноос буюу 57 наснаасаа эхлэн бүртгэлийн албанд ажилласан юм. Удалгүй түүний ажилладаг ажлын байр компьютержсэн боловч тэрээр ажилласаар л байв. Түүнд шинэ техник, технологийг ашиглахад ямар ч хүндрэл гараагүй ба ахлах ажилтнаасаа хангалттай эерэг үнэлгээ авдаг төдийгүй сөрөг үнэлгээ сонсож байгаагүй ажээ. Тэрчлэн хамт ажиллагсад болох багийнхнаа анхааруулга, шүүмжлэлээс хэд хэдэн удаа аварч байв. Хэдийгээр Парриш бусад бүртгэлийн ажилтнуудтай харьцуулахад удаан ч, тэрээр багийнхаа хамгийн нямбай ажилтан юм.

Компьютерийн систем өндөр түвшинд

гарч нэмэлт сургалтуудыг шаардаж эхлэв. Мери хоёр өдрийн үргэлжилсэн сургалтад оролцох ёстой байсан боловч хоёр дахь өдрийн хичээлийг тасалсан байна. Учир нь тухайн үед эмнэлэг ачаалал ихтэй ажиллаж байсан тул тэрээр нэг өдрийн сургалтад сууж чадсангүй. Түүгээр ч барахгүй тэрээр ядаргаанд орж эмнэлэгт хэвтжээ.

Энэхүү үйл явдлын дараа Меригийн ахлах болох бүртгэлийн залуу ажилтан компьютер дээр асуудалтай байгаа учраас түүнд шинэ ажилд орох санал тавьжээ. Сарын дараа ажилдаа эргэн орсон бөгөөд тэрээр шинэ ажилд, шинэ цагийн хуваарийн дагуу ажиллах болсон байна. Түүнд санал болгосон ажил нь нэг бол бүтэн өдөржин ажиллах эсвэл юу ч хийхгүй байх ажил байсан ба тэрээр энэхүү саналыг хүлээж авахаас татгалзжээ.

Дараагийн өдөр нь тэрээр ажиллаагүй бөгөөд ахлах руугаа утасдан шилжүүлгээ анхааран дахин нягтлан үзэхийг хүссэн байна. Ахлах нь зүгээр л Мерид татгалзсан бөгөөд түүнийг 66 настай хэмээн ажлаас халсан юм.

Мери Иммануэл эмнэлгийн эсрэг нэхэмжлэл гаргасан ба түүний нас ба чадварыг нь халах шалтгаан болгосныг баталж чадсан юм.

Иммануэл эмнэлэг нь Меригийн хувьд шинэ компьютерийн систем, хүнд байснаас тэрээр үр бүтээлгүй ажиллаж байгаа учраас шилжүүлэг хийх нь зүй ёсны хууль ёсны зүйл хэмээн мэтгэлзсэн. Гэвч шүүх эмнэлгийн захиргааны тайлбарыг хүлээж аваагүй бөгөөд Иммануэл нь Мери насаар нь ялгаварласан хэмээн үзсэн

байна.

Хөдөлмөрийн харилцаанд насаар алагчлах нь хөдөлмөрчин хүнд бүх талаар сөргөөр нөлөөлнө. Хүн сэтгэл зүйн дарамт буюу стресст орох, өөрийгөө арчаагүй дорой байдалтай байгаагаар мэдрэх, санхүүгийн хувьд хүнд байдалд орсноор амьдралын хэв маягаа өөрчлөх шаардлага гарна. Олон жил их хүч хөдөлмөр гаргаж ажилласны эцэст насны үзүүлэлтээр гадуурхагдах болсон нь өөрийгөө үнэ цэнэгүй болсон мэдрэмж төрүүлдэг байна. Ажиллаж байгаа ч ажил албан тушаал ахих, шагнал урамшуулал авах зэрэгт гадуурхагдаж байгаа нь ажилтны хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлөх, тухайн байгууллагад эзлэж буй байр суурь нь ирээдүйгүй мэт санагдана.

Насаар алагчлах жишээнүүд:

1. Компани нэлээд хэдэн ажилтанг орон тооны цомхотголоор халах болжээ. Ингээд 40-өөд хүнийг халсан байна. Хэсэг хугацааны дараа судлаад үзэхэд халагдсан хүмүүсийн зөвхөн нэг нь л 40-өөс доош насны бусад нь 40-өөс дээш насныхан байжээ. Мөн эдгээр хүмүүс нь мэргэжлийн ур чадвартай, ажлын туршлагатай, гэрээгээр хүлээсэн үүргээ ягштал биелүүлдэг сайн ажилтнууд байжээ. Энэ бол насаар ялгаварлан гадуурхах үйлдэл болсон. Учир нь цомхотгох үндэслэл нь зөвхөн "нас"-ны шалгуураар явагдсан.
2. 20 гаруй насны гэрлэсэн эмэгтэй ажилд орох ярилцлагад оржээ. Ажлын зард тавигдаж буй бүх шаардлагыг хангаж, бусад ярилцлагад орж буй хүмүүсээс бүхий л үзүүлэлтээр илүү байгаа боловч компани эмэгтэйд авсангүй. Учир нь

залуухан, гэрлэсэн болохоор нэг их удалгүй хүүхэд төрүүлэх чөлөө аваад явна гэж үзжээ. Энэ бол бас л насаар алагчилсан гэж үзэх жишээ юм.

3. Дээр дурдсан жишээ. Зарлага буюу шуудан зөөгч нарт тодорхой тооны илгээмжийн тодорхой хугацааны дотор хүргэж өгөх үүрэг өгчээ. Гэхдээ эдгээр илгээмжийн хүргэх хугацаа нь даалгаварт өгөгдсөн хугацаанаас тавиу байжээ. Компани 50-55 насны, 13-14 жил ажилласан хүмүүсээ халах зорилготой ийм ажиллагаа явуулжээ. Энэ бол насаар шууд бус ялгаварлан гадуурхах үйлдэл, учир нь ажил үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байсан ажилтнуудыг халсан.

Насаар ялгаварлан гадуурхах хууль бус үйлдлийг гаргахгүйн тулд компаниуд юуны өмнө дээд, доод шатны бүх ажилчид хөдөлмөрийн харилцааны хууль, эрх зүйн актуудыг сайн мэдэж, ойлгож авсан байх ёстой. Мөн тухайн компани хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын дотооддоо мөрдөгдөх бүх дүрэм, журмаа илт тод, ойлгомжтой, шударга ёсны зарчимд нийцүүлэн гаргасан байх ёстой. Ялангуяа, шинээр ажилтан авах, ажил албан тушаал ахих, албан тушаал бууруулах буюу сахилгын арга хэмжээ авах, ямар нэгэн хөнгөлөлт, урамшуулал хүртэх, ажлаас халагдах үндэслэл гэх мэт асуудлуудыг ойлгомжтой байдлаар томъёолсон байх ёстой.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮҮХДИЙГ АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ШИЛЖҮҮЛЭХ ХАРИЛЦААНЫ ҮНДЭСНИЙ ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн
сургуулийн захирал, доктор, профессор
Цэрэнжавын Алтанцэцэг

Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх асуудлын хүрээнд одоогийн дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн үр нөлөөг судаллаа. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүл, эцэг эхээс нь авах, буцаах, тэднийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх, асран хүмүүжүүлэх, түүнтэй холбогдон гарах хууль зүйн үр дагаврыг зохицуулсан нэгдмэл хууль гаргаж, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх ашгийн төлөө хүлээх хариуцлагын болон мэдээлэл, хяналтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна. Энэ үүднээс харин хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг шинэчлэн найруулж, дээрх асуудлыг цогц байдлаар тусгасан бие даасан хуулийг боловсруулах шаардлагатай юм.

Comparative research on international law and Mongolian domestic law regarding the rights of abandoned children

Mrs. AltantsetsegTs. /Prof./, Director,
School of Law, Otgontenger University

Within the framework moving vulnerable children to state or private care facilities, we have researched the effects of current laws and rules. Current law is insufficient to protect the rights of vulnerable children when relocating them to care facilities for their care, protection, and education, and to create general system of responsibility, education, and protection of child rights.

Therefore, it is necessary to adopt an amended version of the Law on Temporary Detention of Homeless Children.

Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага:

Монгол Улсын Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн 2 дугаар бүлэг нь иргэний нийгмийн ардчилсан шинжийн гол шалгуур болсон хүний эрх, эрх чөлөөг хангах зарчмын үндсэн асуудлуудыг тодорхойлсон. Энэ нь нийгмийн бүхий л орчинд зайлшгүй дагаж мөрдөх иргэний үндсэн эрх, эрх чөлөөний нийтлэг зарчим, хууль зүйн шаардлага болох тул тусгайлсан зохицуулалтаар хангагдах эрх зүйн үндэс нь болно.

Үндсэн хуулийн дээрх зохицуулалтад тулгуурлан авч үзвэл хараа хяналтгүй, хүнд нөхцөлд байгаа хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг Хүүхдийн эрхийг хамгаалах гэсэн ерөнхий асуудлын хүрээнд тусгайлан зохицуулсан хууль үйлчлэх шаардлага бий болсныг харуулж байна. Иймээс Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль нь 1996 онд батлагдсан.

Энэхүү хуулиар хүүхдийн эрх, түүнийг хамгаалах үндсэн зарчим, төр, олон нийтийн оролцоо, хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж болон хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт, хүлээлгэх хариуцлагыг зохицуулж өгснөөрөө нийгмийн бүхий л хүрээнд хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний стандартыг тогтоож, улмаар уг хуультай уялдуулан бусад холбогдох хууль тогтоомжийг батлан гаргаснаараа үндэсний хэмжээнд “Хүүхэд хамгааллын тогтолцоо”-г бүрдүүлэх эрх зүйн үндсийг гавьсан.

Хүүхдийг асрамж, халамжийн байгууллалагад байршуулан асрамжлах үйл ажиллагааны үндэсний эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгож, боловсонгүй болгох шаардлага байгааг илэрхийлж байна.

Мөн Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлогод тулгуурлан I дүгээр тэргүүлэх чиглэл болох “Хүний хөгжлийн бодлого”-д нийцүүлэн хүүхэд хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай юм.

Тэр дундаа дээрх бодлогод тусгагдсан “бүтэн өнчин, хаягдмал, гэр бүлээсээ дайжсан, хараа хяналтгүй хүүхдийг гэр бүлд эсхүл гэр бүлтэй нь дүйцэхүйц халамжийн таатай орчинд өсгөж хүмүүжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, төрөөс онцгой анхаарч, халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх үүднээс түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

Дээрх нөхцөл байдалд тулгуурлан хараа хяналтгүй, хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөөг судалж, судалгааны үндэслэл бүхий мэдээллээр хангах шаардлагын үүднээс энэхүү судалгааг хийсэн болно.

Судалгааны ажлын зорилго, зорилт: Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх

асуудлын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, үндэсний хууль тогтоомж болон хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагуудаас хийсэн хяналт, шалгалтын ажлын тайлан, мэдээ, судалгааны материал болон статистик тоон мэдээлэл дээр тулгуурлан тухайн харилцааг зохицуулж буй одоогийн дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн үр нөлөөг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

Судалгаанд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулалт, баримт бичиг судлах, ярилцлага хийх, хууль зүйн аналитик шинжилгээ хийх зэрэг аргуудыг хэрэглэн хүүхдийг асрамж, халамжийн байгууллагуудад шилжүүлэх асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хүүхэд хамгааллын тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн санал, дүгнэлтийг боловсруулах явдал болно.

Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/: Үндсэн хуулийн “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн 2 дугаар бүлэг нь иргэний нийгмийн ардчилсан шинжийн гол шалгуур болсон хүний эрх, эрх чөлөөг хангах зарчмын үндсэн асуудлуудыг тодорхойлсон. Хүний эрх, тэр дундаа хүүхдийн эрхийн асуудал нь Үндсэн хуулийн энэхүү хэсгийн агуулгын хүрээнд тодорхой тусгагдсан болно. Тухайлбал: Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөө,

Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүний эрх, эрх чөлөөг хангах талаар төрийн хүлээх үүрэг зэрэг заалтуудын дагуу судалгаа хийж дараах дүгнэлтийг хийсэн.

- Дүгнэлт: Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтууд нь хүний үндсэн эрх, эрх чөлөөний нийтлэг зарчим, хууль зүйн шаардлагыг илэрхийлэх бөгөөд энэ нь бусад хуулиар тогтоосон тусгайлсан зохицуулалтаар хангагдах буюу тухайлбал, нийгмийн тодорхой харилцааны эрх зүйн зохицуулалтын онцлогтой нь холбоотойгоор хүний эдлэх эрхийн эрх зүйн үндэс нь болно.

Иймээс Үндсэн хуулийн дээрх зохицуулалтаар хараа, хяналтгүй, хүнд нөхцөлд байгаа хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, түүний хүрээнд асрамж, халамжийн байгууллагад хүүхдийг шилжүүлэх ажиллагаатай холбогдсон асуудлыг тусгайлан зохицуулах хууль зүйн үндэслэлтэй болохыг харуулж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай Монгол улсын хууль /1996 он/: Энэхүү хуулиар хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдож үүссэн харилцааг зохицуулна. Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон хуулийн зохицуулалт нь нийгмийн бүхий л хүрээнд хүүхдийн эрх, ашиг сонирхолтой холбоотой асуудалд хамааралтай тул хүүхдийн үндсэн эрхийг баталгаажуулсны зэрэгцээ хүүхдийн эрхийг хамгаалахад төр, олон нийтийн болон эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоог тодорхойлж өгсөн

болно. Тухайлбал: хуулийн 2 дугаар бүлэгт: “Хүүхдийн эрх, журамт үүрэг”, 7 дугаар зүйлд: “Хүүхдийн хамгаалуулах эрх” 10 дугаар зүйлд: “Хүүхдийн эрхийг хамгаалах талаар Засгийн газрын хэрэгжүүлэх бүрэн эрх, 11 дүгээр зүйлд: “Хүүхдийн эрхийг хамгаалах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хэрэгжүүлэх бүрэн эрх”, 14 дүгээр зүйлд: “Хүүхдийг нийгмийн халамжийн арга хэмжээнд хамруулах”, 15 дугаар зүйлд “Онцгой ба хүнд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж, тусламж” зэрэг Хүүхдийг асрамж, халалламжийн байгууллагад шилжүүлэх харилцааг зохицуулалсан хууль зүйн хэм хэмжээнүүд байна.

- Дүгнэлт: Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхдийн үндсэн эрх, түүнийг хамгаалах үндсэн зарчим, төр, олон нийтийн оролцоо, хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж, хууль тогтоомжийн биелэлтэнд тавих хяналт болон хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан.

Дээрх хуулийн зохицуулалтын хүрээнд авч үзвэл нийгмийн бүхий л орчинд хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой үндсэн асуудлыг хуульчлан зохицуулж байгаагийн хувьд энэхүү хууль нь үндэсний хэмжээнд хүүхдийн эрх, түүнийг хамгаалах стандартыг тогтоосон юм.

Иймээс энэхүү хууль нь хүүхдийн эрх, эрх чөлөөний нийтлэг зарчим хууль зүйн ерөнхий шаардлагыг илэрхийлэх бөгөөд тусгайлсан бусад хуулийн зохицуулалтаар хангагдах түүний эрх зүйн үндэс нь болно.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар гэр бүлийн орчноос гадна “Гэр

бүлийг орлох бусад хувилбарт орчин” –г хүлээн зөвшөөрч энэхүү орчинд хүүхдийг асран халамжилж болох эрх зүйн механизмыг хүлээн зөвшөөрч энэ орчинд хүүхдийг асран халамжилж болох эрхзүйн зохицуулалтын механизмыг бүрдүүлсэн гэж үзэх үндэслэл байна. Энэ хуулийн зохицуулалтын хүрээнд авч үзэхэд “Гэр бүлийг орлох хувилбарт орчин” гэдэгт дараах механизмыг хамруулсан байна.

Үүнд:

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн гэр бүлд амьдрах үрчлэлт;
- Хүсэлт гаргасан иргэний гэр бүлд амьдрах;
- Халамжлан хүмүүжүүлэх, асран сувилах үүрэг бүхий түр саатуулах байгууллагад шилжүүлэх;
- Хүүхдийг төрийн асрамжинд авах;
- Асрамж халамжийн байгууллагад асран хүмүүжүүлэхээр шилжүүлэх зэргийг хамруулсан.

Мөн онцгой болон хүнд нөхцөлд байгаа хүүхдэд гэдгийг хуульчлан томьёолсон. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн зохицуулалтаас харахад хүүхдийн талаарх төрийн бодлого нь хүн ам зүйн болон гэр бүлийн хүрээн дэх бодлогын дагавар салбар, илүү бие даасан шинжтэй болохыг харуулж байна. Иймээс бие даасан салбарын хүрээнд хүүхдийн эрх, ашиг сонирхолтой холбогдсон асуудлыг цогц шийдвэрлэх үүднээс төрийн эрх зүйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай юм.

Тухайн асуудлын эрх зүйн зохицуулалт хангалтгүй байх нь хүний эрх, эрх чөлөөг нийтээр хүлээн зөвшөөрсөн

жишгээс дордуулах, эрх зүйн хийдэл гаргах, хуулийн заалтуудаар хоорондоо зөрчилдөх, улмаар хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлыг хохироох, хууль бус үйлдэлд хүргэх зэргээр нийгэм болон хувь хүнд сөрөг нөлөөлөл үзүүлэх нөхцлийг бүрдүүлдэг талтай. Иймд олон улсын болон үндэсний хууль тогтоомжид хүлээн зөвшөөрсөн эрхийг хангах, хэрэгжүүлэхэд шаардлагатай, үр нөлөө бүхий эрхзүйн хамгаалалтын болон зохицуулалтын арга, механизмыг бүрдүүлэх нь нэн ач холбогдолтой болно.

Үүний тулд:

- Үндэсний хууль тогтоомжийг Олон улсын гэрээ конвенцтой нийцүүлэх, түүний хэрэгжилтийг хангах;
- Үндэсний хууль тогтоомжийн заалтуудын уялдааг хангах, гарч буй зөрчлийг арилгах, амьдрал практикт үүссэн тулгамдсан, шийдвэрлэвэл зохих асуудлыг зохицуулах эрх зүйн механизм бүрдүүлэх;
- Хүүхэд нь эрх зүйн харилцааны бие даасан субъект хэдий ч тухайн субъектын онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Хүүхдийг асран халамжилж, хүмүүжүүлэх нэн тэргүүний “эхний хувилбарт” орчин бол “гэр бүлийн орчин” бөгөөд харин халамж, асрамжийн төвд байршуулах нь “эцсийн хувилбар” болох талаар олон улсын конвенцид заасан заалтад анхаарлаа хандуулах, энэ зохицуулалт нь хүүхэд хамгааллын талаар төрөөс баримтлах эрх зүйн бодлогын гол цөм болох ёстой.
- Асрамж, халамжийн байгууллагад хүүхдийг шилжүүлэн байршуулах нь “гэр бүлийг орлох” онцгой

хэлбэрийн зохицуулалт болох тул хуулиар журамлагдан зохицуулагдах харилцаа гэдгийг илэрхийлж байна. Иймээс хүүхдийг асрамж халамжийн байгууллагад шилжүүлэхтэй холбогдсон асуудлыг хүүхэд хамгааллын хүрээнд тусгайлан зохицуулсан эрх зүйн орчинг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага бий болсныг харуулж байна.

Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль /1994 он/: Энэхүү хууль нь 5 зүйлтэй. Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай асуудлыг зохицуулсан ба уг хуулийн үйлчлэх субъектын бүтцийн хувьд “хараа хяналтгүйгээс амь нас, эрүүл мэнд нь хохирч болзошгүй 16 хүртэлх насны, хаяг, эцэг эх, харгалзан дэмжигч нь тодорхойгүй хүүхэд” гэж тодорхойлсон. Ийм хүүхдийг хамгаалах эрх зүйн хамгаалалтын механизм нь: “түр саатуулах байр байна” гээд “Цагдаагийн байгууллага уг хуулийн хэрэгжилтийг хангахаар заасан байна.

- Дүгнэлт: Хүүхдийг асран хүмүүжүүлэх, хамгаалах хувилбарт орчны нэг хэлбэрийг хүлээн зөвшөөрч тогтоосон боловч хүүхдийн эрхийг баталгаажуулаагүй байна.

Өөрөөр хэлбэл, энэ нөхцөлд хүүхэд ямар эрхтэй байх, түүний эрхийг эрхийг хэрхэн хамгаалах тухай асуудал хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын болон үндэсний хуулиар тогтоосон стандартад нийцээгүй байх тул “хүүхдийн дээд эрх ашигт нийцүүлнэ” гэсэн хүүхдийн эрх хамгааллын үндсэн зарчимд тулгуурлан болон тодорхой нарийвчилсан заалтуудыг тусгаж боловсронгуй болгохын зэрэгцээ гэр бүлийн орчноос бусад “гэр бүлийн

орчинг орлох хэлбэр”-ийн орчинд хараа хяналтгүй, хүнд нөхцөлд байгаа хүүхдийг шилжүүлэх, асран хүмүүжүүлэхтэй холбоотой харилцааг цогц байдлаар хүүхдийн эрхэд суурилсан агуулгаар тусгаж энэ хуулийг шинэчлэн, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Гэр бүлийн тухай хууль /1999 он/: Монгол Улсын гэр бүлийн тухай хуулийн үйлчлэлийн нэг хэсэг нь хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих үйл ажиллагаатай холбогдсон харилцаа” бөгөөд хуулийн

- 25 дугаар зүйлд. “Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах;
- 31 дүгээр зүйлд. “Эцэг, эх байх эрх хассанаас үүсэх үр дагавар;
- 39 дүгээр зүйлд “Хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад байгаа хүүхдэд олгох тэтгэлэг;
- 56 дугаар зүйлд “Хүнд нөхцөлд байгаа үрчлүүлэх хүүхдийн бүртгэл, хяналт;
- 62 дугаар зүйлд “Үрчлэлтийг хүчингүйд тооцсоноос үүсэх үр дагавар;
- 66 дугаар зүйлд “Асран хамгаалах, харгалзан дэмжих байгууллага;
- 67 дугаар зүйлд “Асран хамгаалах, харгалзан дэмжих;
- 69 дүгээр зүйлд “Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг;
- 70 дугаар зүйлд “Асран хамгаалагч, харгалзан дэмжигчид хориглох зүйл;
- 71 дүгээр зүйлд “Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагааны талаар Засаг даргын эдлэх эрх;
- 72 дугаар зүйлд “Асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үйл ажиллагаанд хяналт тавих;

- 73 дугаар зүйлд Асран хамгаалах, харгалзан дэмжих эрх, үүрэг дуусгавар болох үндэслэл;
- 74 дүгээр зүйлд “Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа”-ны талаарх зохицуулалтууд тус тус тусгагдсан.
- Дүгнэлт: Монгол Улсын гэр бүлийн тухай хуулийн дээрх зохицуулалтуудад дүн шинжилгээ хийхэд юуны өмнө хүүхдийг асран халамжлах эрх зүйн механизмыг хуульчилж өгснөөр ач холбогдолтой юм.

Энэхүү эрх зүйн механизмын хүрээнд авч үзвэл хүүхдийг нэн түрүүнд өөрийн гэр бүлдээ эсхүл ойрын төрөл, садангийн хүмүүстэйгээ хамт амьдрах эрх зүйн орчинг бүрдүүлэх тал руу чиглүүлсэн нь олон улсын гэрээ конвенцид “хүүхдийн амьдрах, хөгжих, хамгийн шилдэг арга буюу эхний хувилбар болох “гэр бүлийн орчин” байна гэсэн заалтыг хүлээн зөвшөөрсөн тодийгүй “Хүүхдийн хүмүүжил болон хөгжилд эцэг, эх буюу тодорхой тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчид гол хариуцлагыг хүлээнэ” гэсэн зохицуулалтын агуулгад нийцүүлсэн заалт тусгагдсан гэж үзэж байна.

Мөн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асран халамжлан хүмүүжүүлэх гэр бүлийг орлох бусад халамжийн хувилбарт системийг хүлээн зөвшөөрч хуульчилж өгсөн. Гэвч энэхүү зохицуулалт нь хүүхдийн эрхэд суурилсан байх, “хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд хангах” гэсэн олон улсын гэрээ конвенцийн заалттай бүрэн нийцээгүй байх тул, түүний зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Тухайлбал: Асрамж, халамжийн байгууллагад хүүхдийг шилжүүлэн асран

халамжлах хэлбэрийг хүлээн зөвшөөрсөн боловч эрх зүйн хангалттай орчинг бүрдүүлээгүй, процессын шинжтэй хэм хэмжээг тогтоогоогүй, Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх эрх зүйн зохицуулалт нь гэр бүлийг орлох эцсийн хувилбар болох тул энэхүү харилцаа нь харин журмаар биш хуулиар зохицуулагдах зайлшгүй шаардлагатай харилцаа гэдгийг онцгойлон анхаарах ёстой.

Иймээс энэ талаарх зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлэхдээ дараах нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай байна. Үүнд:

- Олон улсын гэрээ, конвенцийн холбогдох заалттай нийцүүлэх;
- Хүүхдийн эрхэд суурилсан гэр бүлд түшиглэсэн бусад хэлбэрийн халамжийн үйлчилгээг субъектын онцлог, хүнд нөхцөлд байгаа хүүхдийн нөхцөл байдлыг харгалзсан зохицуулалтыг хуульчлах;
- Холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтыг уялдуулах;
- Олон улсын гэрээ, конвенцид заасан хүүхдийн эрх, эрх чөлөөг нийтээр хүлээн зөвшөөрсөн жишигт нийцүүлэх;
- Хүүхдийн талаарх төрийн бодлого нь бие даасан шинжтэй бодлого болохын хувьд төрийн эрх зүйн бодлогыг “хууль тогтоох”, “хөтөлбөрийн”, “удирдлагын” “гүйцэтгэх”, “боловсролын” гэсэн 5 түвшинд хүүхэд хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, эрх зүйн үр ашигтай арга хэрэгслийг хуульчлах замаар тодорхойлох;

Эрх зүйн үр ашигтай арга хэрэгсэл:
Энэхүү томъёоллыг хүний эрхийн талаарх олон улсын ихэнх гэрээ конвенцид тусгагдсан бөгөөд түүнийг улс орон бүр үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга хэрэгслийг бий болгох тухай хуулийн заалттай холбоотой хэрэглэдэг. Гэхдээ эдгээр арга хэрэгсэл нь үр ашигтай байх шаардлагатай. Энэ нь хүн бүхэнд бодитойгоор хэрэгждэг байх гэсэн хэмжүүрээр илэрдэг тул энэхүү зохицуулалтын онцлогийг харгалзаж үзэж тусгайлсан хуулийн зохицуулалтыг бий болгох нь илүү үр нөлөөтэй болно.

Нийгмийн халамжийн тухай хууль /2005 он: Энэхүү хууль нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоож, нийгмийн халамжийн санг бүрдүүлэх, зарцуулах журам, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

- 3 дугаар зүйлд Хуулийн нэр томъёоны тайлбарыг хуульчилсан байгаа.
- 6 дугаар зүйлд “Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, хяналт”
- 7 дугаар зүйлд “Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх”
- 8 дугаар зүйлд: “Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний зохион байгуулалт”
- 9 дүгээр зүйлд: “Амьжиргааг дэмжих зөвлөл”-ийн эрх, үүрэг,
- 10 дугаар зүйлд: “Нийгмийн ажилтан”-ы эрх, үүргийн зохицуулалт
- 26 дугаар зүйлд: “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн

үйлчилгээний төрөл, хамрах хүрээ"-г тодорхойлж

- 28 дугаар зүйлд: “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээ”-г тодорхойлж, тус тус хуульчлан заасан байна.

Дүгнэлт: Нийгмийн халамжийн тухай хуулийн дээрх заалтуудын хүрээнд авч үзэхэд “байнгын асаргаа шаардлагатай иргэн”, “асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, асаргаа, эмчилгээ шаардагдах иргэн” хэмээх ойлголтын хууль зүйн агуулгыг тодорхойлж, түүнд хүнд нөхцөлд хүүхдийг хамруулсан бөгөөд тэдгээрийн эрх, ашгийг хамгаалах үүднээс халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хэлбэрийг хуульчилсан.

Мөн дээрх үйлчилгээг үзүүлэх эрх бүхий байгууллага, тэдгээрийн бүрэн эрх, зохион байгуулалт, үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тодорхойлсон байна.

Гэвч “Хүнд нөхцөлд байгаа хүүхэд”-ийн хувьд тухайн субъектын онцлог болон хүнд нөхцөл байдалд нь тулгуурласан хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хангах, хамгаалах түвшинд зохицуулагдаагүй, ялангуяа Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр бүлэгт тусгагдсан “Хүүхдэд үзүүлэх нийгмийн халамж” гэсэн зохицуулалттай уялдуулж, асрамж, халамжийн үйлчилгээний талаарх зохицуулалтад тодорхой тусгах шаардлагатай.

Мөн Гэр бүлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтын хүрээнд халамж, асрамжийн үйлчилгээний талаарх заалтыг

тусгах замаар хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд “Түр байрлуулах, асрамжлах, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төрөлд хамруулсан боловч түүнийг хэрхэн яаж зохицуулах талаарх заалт тусгагдаагүй байна.

Түүнчлэн нэгдсэн мэдээллийн сан, хариуцлагын тогтолцооны талаарх зохицуулалтыг ч боловсронгуй болгох нь нэн чухал юм. Салбар хоорондын зохицуулалтын нэгдмэл байдлыг хангахад ашиглах мэдээллийн эх үүсвэрийг дэлгэрэнгүй харилцан уялдаатай болгох үүднээс холбогдох хуулийн зохицуулалтын хүрээнд нэмэлт оруулах хэрэгтэй байна.

“Мэдээллийн нэгдмэл тогтолцоо” түүний эрх зүйн орчин бүрдээгүй тул салбаруудын хоорондох мэдээлэл, тоон баримтууд зөрүүтэй байх, дэлгэрэнгүй бус байх, мэдээллийн эх сурвалжийн чанар хангахгүй байх улмаар төрийн бодлогын үр нөлөөг бууруулах зэрэг сөрөг нөхцөл байдлуудыг бий болгож байна.

Нийгмийн халамжийн тухай хууль болон холбогдох бусад хуулийн “Хүүхдийн асрамж, халамж”-тай холбоотой эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийхэд:

- Хууль зүйн нэр, томьёо, ойлголтыг нэг мөр болгох;
- Холбогдох хууль тогтоомжийн заалтууд хоорондын зөрчилдөөнийг арилгах;
- Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг хамруулах нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний төрлийг хууль тогтоомжид нэг мөр болгох зохицуулалтыг тус бүрт нь тодорхой

хуульчлах, халамж, асрамжийн байгууллагад хүүхдийг асран хүмүүжүүлэх талаар шийдвэр гаргах байгууллагын талаарх заалтуудыг нэг мөр болгон тусгах;

- Гэр бүлийн болон нийгмийн халамжийн тухай хууль, хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиудад тусгагдсан асрамж, халамжийн үйлчилгээний төрөл, хэлбэр, түүний зохицуулалтыг нэг мөр болгож, хооронд нь уялдуулах, тухайлбал: “Түр байрлуулан асрамжлах”, “гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ”, “олон нийтийн оролцоонд түшиглэсэн асрамжийн үйлчилгээ”, “төрөлжсөн асрамжийн үйлчилгээ” гэх зэрэг хувилбарт үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг холбогдох хуулиудад нэг мөр тусгах, хүүхдийн эрх, түүний хамгааллын хүрээнд ямар нөхцөлд аль зохицуулалтыг хэрэглэх, түүнээс үүсэх хууль зүйн үр дагавар, мэдээлэл, хариуцлагын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх байдлаар энэ асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Бидний хийсэн судалгааны нэг хэсэг нь “Хүүхдийн асрамж, халамжийн үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам заавруудад хийсэн дүн шинжилгээ”-ний ажил байсан.

Энэ судалгааны ажлын хүрээнд НХХ-ийн сайдын 2005 оны 29 тоот тушаалаар баталсан “Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын мөрдөх үлгэрчилсэн дүрэм”-ээр асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагад зөвшөөрөл олгох, цуцлах, үйл ажиллагааны хэм хэмжээг тогтоох, хяналт тавих харилцааг зохицуулдаг. Энэхүү дүрмийн хувьд дараах дүгнэлтийг судлаачийн хувьд хийлээ.

Дүгнэлт: Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт заасны дагуу “Хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх журам, асрамжийн байгууллагын жишиг дүрмийг нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн заалтын дагуу “Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын мөрдөх үлгэрчилсэн дүрмийг баталсан байна. Энэ зохицуулалтыг 2003 оны 5 дугаар сарын 22-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон байна.

Дүрмийн зохицуулалтын хамрах хүрээг авч үзэхэд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад байнгын болон түр байрлаж буй хүүхдэд үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон асуудлыг зохицуулж байна. Харин хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэхтэй холбогдсон зохицуулалт тусгагдаагүй байна.

Энэхүү үлгэрчилсэн дүрэм нь Хүүхдийн асрамж, халамжийн нийт байгууллагуудад нийтлэг мөрдөгдөх эрх зүйн баримт бичиг болох тул тухайн байгууллага, дүрмээ боловсруулахдаа уг загварыг хэрэглэх бөгөөд өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлог нөхцөл байдлыг тусгаж болно. Гэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай гэдгийг анхаарах хэрэгтэй.

Үлгэрчилсэн дүрэм нь 2005 онд батлагдсан байх тул түүнээс хойш батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хуулиудын холбогдох заалтуудтай нийцүүлэн түүний зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Тухайлбал,

- Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт /2003 он/,
- Нийгмийн халамжийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт / 2008 он/
- Хүүхдийн асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага /2008 он/

Хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудын мөрдөх үлгэрчилсэн дүрэм тухайн байгууллагын хэмжээнд зайлшгүй мөрдөгдөх эрхзүйн баримт бичиг хэдий ч “хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хангах, хамгаалах нь” төрийн эрх зүйн бодлогын нэн тэргүүний зорилго байх тул хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад зөвшөөрөл олгох, татан буулгах, зөвшөөрлийг цуцлах, түүний бүтэц зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчмыг нэг мөр болгох үүднээс хуулиар зохицуулах шаардлагатай.

Одоогийн дагаж мөрдөж буй хуулийн хүрээнд “Хүүхдийн асрамж, халамжийн үйл ажиллагааны талаарх зохицуулалт хэт бүрхэг, бараг зохицуулалтгүй байна. Түүний дотор Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хэрхэн хангах, хамгаалах талын зохицуулалт байхгүй байна. Дээрх үлгэрчилсэн дүрэм нь энэ харилцааны нэг тал болох Хүүхдийн асрамж, халамжийн төв, нөгөө тал болох асрамж, халамжинд байгаа хүүхэд түүнийг төлөөлж эрх ашгийг хамгаалах төр, эцэг эхийн хоорондын харилцааг зохицуулна. Гэтэл зарим субъектын тухайлбал, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хангах, хамгаалах талаарх зохицуулалт байхгүй байна.

Мэдээлэл, хариуцлагын тогтолцооны эрх зүйн орчин бүрдээгүй тул энэхүү дүрэмд

холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ гэсэн ерөнхий заалт тусгасан байгааг анхаарах хэрэгтэй.

Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх, авах эцэг эхэд нь буцаах, эрх бүхий байгууллагын шийдвэр, маргааныг хэрхэн шийдвэрлэх зэрэг асуудал зохицуулалтгүй байгаа ба энэхүү асуудлыг дүрэм, журмаар зохицуулах боломжгүй юм. Бие даасан хуулиар нэг мөр зохицуулах нь хууль хоорондын зөрчилдөөн, хийдэл, давхардлыг арилгах хүүхэд хамгааллын тогтолцоог бүрдүүлэхэд нэн ач холбогдолтой.

Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор баталсан “Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах байрны дэглэм, журам”-ын хэрэгжилтэд судалгаа хийгээд дараах дүгнэлтийг гаргалаа.

Дүгнэлт: Энэхүү журам нь 1996 онд батлагдсан бөгөөд үүнээс хойш шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хуулиудтай нийцүүлэн шинэчлэн найруулах шаардлагатай байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Хүүхдийг асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлэх журам”-ыг Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсэн заалттай нийцээгүй байна. Харин энэ асуудлыг дээрх журмаар зохицуулах боломжгүй. Энэ зохицуулалт нь хараа хяналтгүй байгаа хүүхдийг түр саатуулах байрнаас халамжийн байгууллагад

шилжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах асуудал тусгагдсан байгааг анхаарах хэрэгтэй.

- Дээрх журмын 1.3 дахь хэсэгт “Түр саатуулах байрны үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль, бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно” гэж заасан атал журмын 1.1 дэх хэсэгт тусгагдсан “түр байрлуулах хугацааг 48 цаг хүртэл” гэж заасан нь Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан “7 хоног хүртэл хугацаагаар түр саатуулж болно” гэсэн заалтай зөрчилдөж байгааг анхаарах
- Хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэхтэй холбогдсон хууль, хуульчилсан актуудад тусгагдсан зохицуулалтын давхардал, зөрчил, хийдлийг арилгах замаар түүний зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.
- Гэр бүлийг орлох эцсийн хувилбарт үйлчилгээ нь “Үрчлэлт болон асрамж, халамжийн байгууллагад хүүхдийг шилжүүлэн асран хүмүүжүүлэх хэлбэр” байдаг. Иймээс энэ асуудлын талаарх хуулийн зохицуулалт дутмаг “зөвхөн шилжүүлнэ” гэсэн агуулгаар зохицуулагдаж түүнтэй холбоотой шилжүүлж авах, байршуулах, хүмүүжүүлэх, шилжүүлэх зэрэг процессын ажиллагааны эрх зүйн орчин бүрдээгүй байна. Хүүхдийн эрх хамгааллын хүрээнд энэ асуудал нь хуулиар нэг мөр цогц байдлаар зохицуулагдах онцлог харилцаа болно. Өөрөөр хэлбэл, хүүхдийн асрамж, халамжийн байгууллагын мөрдөх үлгэрчилсэн журам болон стандарт,

мөн хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах байрны дэглэм, журмаар зохицуулагдах боломжгүй харилцаа юм. Иймээс хүүхдийн асрамж, халамжийн байгууллагад хүүхдийг шилжүүлэхтэй холбоотой хууль, хуульчилсан актуудын зохицуулалтын уялдааг хангах, боловсронгуй болгох, хүүхэд хамгааллын эрхзүйн орчинг бүрдүүлэх үүднээс энэ төрлийн харилцааг цогц байдлаар нэгдмэл зохицуулсан хуулийг шинээр бий болгох хэрэгцээ шаардлага байна.

- Дээрх дүрэм, журмуудад хүүхдийн эрх хамгааллын зохицуулалт тусгагдаагүй байгаа нь Хүүхдийн эрхийн тухай конвенци, Монгол Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиар тогтоосон хүүхдийн эрхийн талаарх олон улсын болон үндэсний стандарттай нийцээгүй, түүнтэй зөрчилдөж байна. Тиймд дээрх стандартад нийцүүлэн хүүхдийн эрхэд суурилсан, хүүхдийн эрхийн хамгаалалтыг баталгаажуулах хүрээнд уг зохицуулалт заавал хуульчлагдан тусгагдах учиртай.
- Хүүхдийн талаарх мэдээлэл, бүртгэл судалгааны талын нэгдсэн эрх зүйн зохицуулалтгүй байна. Мэдээлэл, үнэлгээ, хяналтын нэгдсэн тогтолцоо байхгүйгээс энэ талаарх мэдээ, тайлан, судалгаа нэг хэв загварт ороогүй, хагас дутуу, зарим чухал шаардлагатай мэдээллийг орхигдуулсан, өөр хоорондоо уялдаагүй байгаагаас холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийхэд бэрхшээлтэй байгаа төдийгүй цаашдаа хүүхдийн талаарх төрийн эрх зүйн бодлогын үр нөлөөг дээшлүүлэхэд сөргөөр нөлөөлөх нэгэн хүчин зүйл болж байна.

Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2009 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр баталсан 503 тоот тушаалаар баталсан “Эцэг эх нь хэн болох нь тогтоогдоогүй олдмол хүүхдийг бүртгэх журам”-ын хэрэгжилтэд судалгаа хийлээ.

Дүгнэлт: Журмын “Олдмол хүүхэд” гэсэн нэр томъёоны тайлбар нь гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиудтай зөрчилдөж байна. Хүүхэд гэдэг нь хууль зүйн утгаараа 18 насанд хүрээгүй бүх хүнийг хэлнэ. Харин энэ журамд хүүхдийн насны дээд хязгаарыг 16 нас байхаар заасан байна.

Гэр бүлийн тухай хууль болон Иргэний хуульд заасан асран хамгаалах, харгалзан дэмжих ажиллагаа нь хоорондоо ялгаатай ойлголт болохыг энэ журамд харгалзан үзээгүй байна.

Олдмол болон эцэг эх нь тогтоогдоогүй хүүхдийн бүртгэл, мэдээллийг эрх бүхий бусад байгууллагаас хүүхдийн асрамж, халамжтай холбоотой гаргадаг мэдээллүүдтэй уялдуулаагүй байгаа нь энэ тухай мэдээллийг цагдаагийн байгууллагаас цааш нь ямар байгууллагад мэдээлэх тухай зохицуулалт тусгагдаагүй байна.

Журмын 615.4-ийн в-д заасан зохицуулалт нь сум, дүүргийн Засаг даргын захирамжаар шийдвэрлэгдэх.

Мөн 615.4-ийн г заалт нь бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай уялдуулсан зохицуулалт дутуу байна.

Олдмол хүүхдийн хувьд эрх ашгийг нь хамгаалах, хангах талаар журамд заасан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлээгүй төрийн албан хаагчид ногдуулах хууль зүйн хариуцлагын механизм тусгагдаагүй байна.

Стандартчилал, хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар батлагдсан “Хүүхдийн асрамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” стандарт нь 2009 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж ирсэн бөгөөд гол зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүүхдэд үзүүлж буй асрамж, халамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагыг тогтоож мөрдүүлэхэд оршино.

Стандартыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүүхдэд асрамж, халамж, хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллага, үйл ажиллагаагаа төлөвлөх, хэрэгжүүлэх, зохицуулах, үйлчилгээний чанарыг сайжруулах болон холбогдох байгууллагаас энэ төрлийн үйлчилгээний зөвшөөрөл олгох, хяналт тавихад ашиглана.

Хүүхдийн асрамж, хамгааллын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага буюу стандарт нь Монгол Улсын хэмжээнд баримталж буй стандартад тусгасан норматив тогтоосон 12 бодлогын баримт бичгүүдэд суурилсан байна.

Дүгнэлт: Энэхүү стандарт тогтоосноор Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тусгасан “Оролцогч улсууд хүүхдийг халамжлах, хамгаалах үүрэг бүхий газар, алба, байгууллагыг аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарт, ялангуяа ажилчдын орон тоо, чадавхид хяналт тавих үүднээс эрх бүхий байгууллагаас тогтоосон жишигт нийцсэн нөхцлөөр хангана” гэсэн заалттай нийцүүлсэн байна.

Стандарт бол тухайн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, нормативыг тогтоодог. Иймээс хүүхдэд асрамж, халамж хамгааллын үйлчилгээг үзүүлэхтэй холбогдуулан хүүхдийн эрх түүний хамгааллын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад энэхүү стандарт нэн чухал ач холбогдолтой юм.

Харин хүнд нөхцөлд байгаа болон хараа хяналтгүй хүүхдийг асрамж халамжийн байгууллагад шилжүүлэх, тэднийг асран хүмүүжүүлэх процесс, эцэг эхээс нь хүүхдийг авах, тэдэнд буцаан өгөх, түүнтэй холбогдон гарах хууль зүйн үр дагаврууд, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хөндсөн, гэр бүлтэй дүйцэхүйц орчинд буюу хувилбарт бусад үйлчилгээнд хүүхдийг хамруулах, асуудал нь дан ганц стандартаар зохицуулагдах боломжгүй юм.

Харин хараа хяналтгүй хүүхдийг асрамж халамжийн байгууллагад шилжүүлэх, тэднийг асран хүмүүжүүлэх процесс, эцэг эхээс нь хүүхдийг авах, тэдэнд буцаан өгөх, түүнтэй холбогдон гарах хууль зүйн үр дагаврууд нь тусгай хуулиар журамлагдан зохицуулагдах онцлог харилцаа болох тул дараах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай. Үүнд:

1. Хүний эрхийн асуудал болох тул;
2. Гэр бүлийг орлох түүнтэй дүйцэхүйц орчинд хүүхдийг асран халамжилж, хүмүүжүүлэх тул онцгой харилцаа болох тул;
3. “Хүүхэд” гэх эрхзүйн харилцааны субъектын онцлогийг харгалзах үүднээс;

4. Хүүхдийн анхдагч орчин болох гэр бүл, түүний эцэг, эх нэн тэргүүнд гол үүрэг хариуцлага хүлээнэ гэсэн зарчмыг хангах, хэрэгжүүлэх үр дагаврыг оновчтой тодорхойлох зохицуулах шаардлага бий болж байгаа;

5. Хүүхдийн эрх хамгааллын эрх зүйн механизмыг бүрдүүлэх үүднээс уг асуудлыг хуулиар зохицуулах нь илүү үр нөлөөтэй болно.

Хүүхдийг асрамж, хамгааллын үйлчилгээнд хамруулахтай холбогдсон асуудлын эрх зүйн зохицуулалтыг /Гэр бүлийн тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль,/ авч үзвэл “Гэр бүлийг орлох, түүнтэй дүйцэхүйц орчинд хүүхдийг асран хүмүүжүүлэх, үйлчилгээнд хамруулах хувилбарт зарим нэг хэлбэрийг хүлээн зөвшөөрч хуульчилсан хэдий ч хүүхдийг асрамж халамжийн байгууллагад шилжүүлэх, авах, буцаах, түүнээс үүдэлтэй хууль зүйн үр дагавруудын талаарх зохицуулалт байхгүй байна.

Иймээс холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтын уялдааг хангах, хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийн хүрээнд тэдгээрийг асран халамжлах, хувилбарт орчны талаарх эрхзүйн зохицуулалтыг цогц тусгаж шинэчлэн өөрчлөх нь зүйтэй.

Төрийн эрх зүйн бодлогын баримт бичгийн хүрээнд хийсэн дүн шинжилгээ

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний 12 дугаар тогтоолоор батлагдсан “ Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний

хөгжлийн цогц бодлого” нь хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм дэх монгол хүний хөгжлийг хангах, тус улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологи, соёл, иргэншлийг эрчимтэй хөгжүүлэхэд чиглэсэн ирэх 14 жилийн бодлогыг дэлхий нийт, бүс нутгийн хөгжилтэй нягт уялдуулан цогцоор тодорхойлсон.

Дүгнэлт: Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлогод тулгуурлан I дүгээр тэргүүлэх чиглэл болох “Хүний хөгжлийн бодлого”-д уялдуулан хүүхэд хамгааллын тогтолцооны эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Тэр дундаа дээр дурьдсан бодлогын 4.3 дахь хэсгийн стратегийн зорилтын 1.4-т заасан “бүтэн өнчин, хаягдмал, гэр бүлээсээ дайжсан, хараа хяналтгүй хүүхдийг гэр бүлд, эсхүл гэр бүлтэй нь дүйцэхүйц халамжийн таатай орчинд өсгөж хүмүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, “төрөөс онцгой анхаарна”, халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэн хөгжүүлнэ гэсэн заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд “гэр бүлтэй дүйцэхүйц орчин” гэдэгт хамаарах асрамж, халамжийн олон хувилбаруудыг хуульчлан эрхзүйн орчинг нь бүрдүүлэх нь зүйтэй юм.

Одоогийн дагаж мөрдөгдөж буй хууль тогтоомжуудад “хүнд нөхцөлд байгаа хүүхэд” гэсэн ерөнхий ойлголтыг илүү тодорхой тусгаж түүний агуулга нэг бүрийн онцлогт тохирсон эрхзүйн механизмын оновчтой арга хэрэгслийг тусгах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2004

оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийг талаар баримтлах бодлого” баримт бичгийн 2 дахь хэсэгт: гэр бүл, хүн амын бүлгийн хөгжлийг хангах талаар тусгасан.

Дүгнэлт: Хүнд нөхцөлд байгаа хүүхдэд онцгой анхаарна гэсэн дээрх заалтын хүрээнд хүүхэд хамгааллын эрхзүйн орчин цогц бүрдүүлэх үүднээс “хүнд нөхцөлд байгаа хүүхдийн хамгааллын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай. Энэ нь хүүхдэд “ээлтэй” байхад чиглэгдсэн байх нь чухал юм.

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах Үндэсний хөтөлбөр”-ийн эрхэм зорилго нь Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд өөрийгөө хөгжүүлэх, ажиллаж амьдрахад шаардлагатай боловсрол, мэргэжил, эзэмших орчин, нөхцлийг бүрдүүлж, тэдний аж байдлыг улам сайжруулахад оршино. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацааг 3 үе шаттайгаар 9 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр заасан. Эхний үе шат 2002-2004 он, 2 дахь үе шат 2005-2007 он, 3 дахь үе шат 2008-2010 он байгаа.

Дүгнэлт: Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд тулгуурлан авч үзвэл: “Хүүхдэд нийгмийн үйлчилгээ үзүүлэх халамж, асрамжийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг 2008 онд батлуулсан нь ач холбогдолтой болсон.

Гэвч “хүүхдийг дээдлэх” зарчимд нийцүүлэн хүүхдийн эрхийн хууль тогтоомжийг шинэчлэх гэсэн зорилт хэрэгжээгүй, тэр дундаа хүнд нөхцөлд байгаа хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний эрх зүйн орчин бүрдээгүй, эрх зүйн шаардлагатай шинэтгэлүүд хийгдээгүй байна.

Дэвшүүлж буй саналууд:

1. Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүл, эцэг эхээс нь авах, буцаах, тэднийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх, асран хүмүүжүүлэх, түүнтэй холбогдон гарах хууль зүйн үр дагаврыг зохицуулсан нэгдмэл хууль гаргаж, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрх ашгийн төлөө хүлээх хариуцлагын болон мэдээлэл, хяналтын нэгдмэл тогтолцоог бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалтыг хуульчлах шаардлагатай байна. Энэ үүднээс харин хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хуулийг шинэчлэн найруулж, дээрх асуудлыг цогц байдлаар тусгасан бие даасан хуулийг боловсруулах
2. Хүүхэд хамгааллын стандартыг

сахиулах, бодлого хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагуудын зохистой тогтолцоог бүрдүүлэх

3. Хүүхдийн эрхийг хамгаалах талаарх хууль, УИХ, Засгийн газрын тогтоол, яам, агентлагийн болон бүх шатны Засаг дарга нарын холбогдох шийдвэр Үндсэн хуульд тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах зарчимд хэрхэн нийцэж байгаад дүн шинжилгээ хийх ажлыг тогтмол зохиох
4. Холбогдох хууль тогтоомжид энэ судалгаа болон холбогдох бусад судалгаануудын дүгнэлт, саналд тулгуурлан нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хүүхдийн эрхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох
5. “Мянганы хөгжлийн зорилтууд”-д тулгуурласан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”- той уялдуулан эрх зүйн шинэтгэл хийх ажлыг хэрэгжүүлэх
6. Хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хяналт-үнэлгээний болон мэдээллийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх ажлуудыг хэрэгжүүлэх санал дүгнэлтийг дэвшүүлж байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮҮХДИЙГ АСРАМЖ, ХАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ШИЛЖҮҮЛЭХ
ХАРИЛЦААНЫ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН
СУДАЛГАА



Отгонтэнгэр Их сургуулийн Хууль зүйн
сургуулийн ахлах багш
Мөнхдалайгийн Ариунаа

Судлаач энэ өгүүлэлдээ хүүхдийг асрамж, халамжийн байгууллагуудад шилжүүлэх, түүний эрхийг хангаж, хамгаалахтай холбоотой зохицуулалтын онцлогийг тодорхойлох зорилгоор НҮБ-аас баталсан тунхаглал болон Монгол улсын нэгдэн орсон олон улсын зарим гэрээ, конвенцийг судалж, дүн шинжилгээ хийв. Энэ хүрээнд хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн үр нөлөө бүхий зохих хамгаалалт, аргууд шаардлагатайг онцгой анхаарах, хүүхэд хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхэд нь эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчид зохих тусламж үзүүлэх, хүүхэд асран хамгаалах байгууллага, ажил үйлчилгээг хөгжүүлэх, хүүхдүүд өөрсдөд нь зориулсан асрамжийн алба, газрын үйлчилгээг ашиглах эрхээ эдлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлуудыг хэрэгжүүлэх санал дүгнэлтийг дэвшүүлж байна.

Comparative analysis is on international and Mongolian laws concerning rights of abandoned children

Mrs. Ariunaa M Senior Professor
School of Law, Otgontenger University

Researchers have undertaken analysis of international legal instruments to which Mongolia is a party, in order to determine how children's rights are to be protected in cases in which their parents are unable or unwilling to continue caring for them.

The researchers have pointed out the necessity of having clear legal regulations and protection mechanisms in place. Parents and parents-to-be should be educated as to their legal responsibilities so as to reduce the number of abandoned children in Mongolia.

The services provided by state-owned and private facilities caring for abandoned children should be improved and developed. All of these actions are necessary to ensure that children's rights are protected as much as possible.

Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага:

Хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний стандарт, тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох шаардлагатай асуудлууд байна. Энэ бол хараа хяналтгүй, хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх, түүний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал юм.

Хүүхдийн эрхийн тухай конвенцид заасан “Гэр бүлийн орчноосоо түр буюу бүрэн хагацсан, эсхүл ийм орчинд байх нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэхгүй бол хүүхдэд улсаас онцгой хамгаалалт, туслалцаа үзүүлнэ”, “Оролцогч улсууд үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу ийм хүүхдийг өөр орчинд асран халамжлах бололцоог бүрдүүлнэ” гэсэн заалтууд нь хүүхдийг асран халамжилж, хүмүүжүүлэх нэн тэргүүний шилдэг арга буюу эхний хувилбарт орчин бол “гэр бүлийн орчин” байх бөгөөд харин халамж, асрамжийн төвд хүүхдийг байршуулах нь эцсийн хувилбар бөгөөд энэ нь нэг талаас гэр бүлийг орлох, түүнтэй дүйцэхүйц түвшинд байх, нөгөө талаас хүүхдийн эрхэд суурилсан, түүний дээд ашиг сонирхолд нийцсэн байх гэсэн шаардлага, зарчмын хүрээнд зохицуулагдах ёстойг тодорхойлсон.

Энэ үүднээс авч үзвэл хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад байршуулан асрамжлах үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой болгож, боловсронгуй болгох шаардлагатайг илэрхийлж байна.

Хүүхэд хамгааллын талаар төрийн эрхзүйн бодлогод тусгасан “бүтэн өнчин, хаягдмал, гэр бүлээсээ дайжсан, хараа хяналтгүй хүүхдийг гэр бүлд эсхүл гэр бүлтэй нь дүйцэхүйц халамжийн таатай орчинд өсгөж хүмүүжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, төрөөс онцгой анхаарч, халамжийн тогтолцоог төлөвшүүлж, халамжийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэж хөгжүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх үүднээс түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

Дээрх нөхцөл байдалд тулгуурлан хараа хяналтгүй, хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх олон улсын эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, түүний үр нөлөөг судалж, судалгааны үндэслэл бүхий мэдээллээр хангах шаардлагын үүднээс энэхүү судалгааг хийсэн болно.

Судалгааны ажлын зорилго, зорилт: Хүнд нөхцөлд байгаа хүүхдийг асрамж, халамжийн байгууллагад шилжүүлэх асуудлын олон улсын эрх зүйн холбогдох гэрээ, конвенцийн зохицуулалтын өнөөгийн байдал, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, үндэсний хууль тогтоомж болон хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагуудын одоогийн дагаж мөрдөж буй хууль тогтоомжийн үр нөлөөг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

Судалгаанд задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулалт, баримт бичиг судлах, ярилцлага хийх, хууль зүйн аналитик шинжилгээ хийх зэрэг аргуудыг хэрэглэн хүүхдийг асрамж, халамжийн байгууллагуудад шилжүүлэх асуудлын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хүүхэд хамгааллын тогтолцооны эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэгдсэн санал, дүгнэлтийг боловсруулах явдал болно.

**Олон улсын эрх зүйн зохицуулалт,
үндэслэл, стандартад хийсэн
харьцуулсан судалгаа**

Монгол улс нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаарх эрхзүйн үндсийг тодорхойлсон олон улсын цөөнгүй гэрээнд нэгдэн орсон бөгөөд асрамж, халамжийн байгууллагуудад хүүхдийг шилжүүлэх, түүний эрхийг хангаж, хамгаалахтай холбоотой зохицуулалтын онцлогийг тодорхойлох зорилгоор уг асуудалтай холбоотой зохицуулалтын хүрээнд НҮБ-аас баталсан тунхаглал болон Монгол улсын нэгдэн орсон олон улсын зарим гэрээ, конвенцийг судалж, дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1946 он/

2 Дугаар зүйл. “Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстой. Мөн түүнчлэн тухайн хүнийг харьяалдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа

гэсэн, тухайлбал, тусгаар тогтносон буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй” гэж

3 дугаар зүйл. “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй” гэж

6 дугаар зүйл. “Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй” гэж

7 дугаар зүйл. “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй” гэж

25 дугаар зүйл. “1. Хүн бүр хоол хүнс, хувцас хунар, орон байр, эмчилгээ сувилгаа, нийгэм ахуйн зайлшгүй шаардлагатай үйлчилгээг оролцуулаад өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй. Ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхтэй” гэж

“2. Эх нялхас онцгой асрамж, туслалцаа авах эрхтэй. Баталгаатай гэр бүлээс гарсан буюу бутач гэдгээс үл хамаглан бүх хүүхэд нийгмээс адилхан хамгаалалт эдлэх ёстой” гэж

2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт /1966, 1976 он/

2 дугаар зүйл.

1. Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьяалалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.

2. Хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээ аваагүй байгаа бол энэхүү Пактад оролцогч улс бүр үндсэн хуулийнхаа журам болон энэ Пактын заалтад нийцүүлэн түүнд хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох хууль тогтоомжийн буюу бусад арга хэмжээг авах үүрэгтэй” гэж

“3. Энэхүү Пактад оролцогч улс бүр дараахь үүрэг хүлээнэ:

- (a) энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зорчигдсон аливаа хүнийг, ийм зөрчлийг албаны үүргээ гүйцэтгэж байсан этгээд үйлдсэн байсан ч үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангах;
- (b) эрх зүйн хамгаалалт хүссэн аливаа этгээдийн тийм эрхийг эрх бүхий шүүх, захиргаа, хууль тогтоох байгууллага, эсхүл тухайн улсын эрх зүйн тогтолцоонд заасан эрх бүхий бусад байгууллагаас тогтоож байх явдлыг хангах, түүнчлэн шүүхээр хамгаалуулах боломжийг нь хөгжүүлэх;
- (c) эрх зүйн хамгаалалт олгож байгаа бол түүнийг эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх явдлыг хангах” гэж

24 дүгээр зүйл. “1. Аливаа хүүхэд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ болон төрсөн байдлаар алагчлагдахгүйгээр өөрийн гэр бүл, нийгэм, төрийн зүгээс насанд хүрээгүйнхээ хувьд шаардлага бүхий хамгаалалт эдлэх эрхтэй.

2. Хүүхэд төрсөн даруй бүртгэгдэж, нэртэй болох ёстой.

3. Хүүхэд бүр иргэний харьяалалтай болох эрхтэй” гэж

26 дугаар зүйл. “Бүх хүн хуулийн өмнө тэгш байх бөгөөд аливаа алагчлалгүйгээр хуулиар тэгш хамгаалуулах эрхтэй. Энэ үүднээс аливаа байдлаар алагчилах явдлыг хуулиар хориглох бөгөөд хууль нь арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн байдал буюу бусад байдлаар алагчилахаас бүх хүнийг адил тэгш үр нөлөөтэй хамгаалах баталгааг бүрдүүлэх ёстой” гэж.

3. Хүүхдийн эрхийн тухай конвенци
//1989/1990 он//

Удиртгал хэсэгт:

“Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатай”-г Хүүхдийн эрхийн тунхаглалд заасныг анхааралдаа авч;

Дэлхийн улс бүрт хүнд нөхцөлд амьдарч буй хүүхэд байгаа бөгөөд тэдэнд онцгой анхаарал шаардлагатайг хүлээн зөвшөөрч энэхүү конвенцид заасан зүйлийг хэлэлцэн тохиролцож баталсан.

Үүнд:

2 дугаар зүйл. “1. Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчилахгүй энэхүү Конвенцид заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана” гэж

3 дугаар зүйл. “1. Нийгмийн хамгааллын улсын буюу хувийн байгууллага, шүүх, захиргааны болон хууль тогтоох байгууллагаас хүүхдийн талаар явуулах аливаа үйл ажиллагаанд юуны өмнө хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад анхаарлаа хандуулна.

2. Оролцогч улсууд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч буюу түүний төлөө хуулийн дагуу хариуцлага хүлээх бусад этгээдийн эрх, үүргийг харгалзан, хүүхдийг хамгаалах, халамжлах зорилгоор хууль тогтоох болон захиргааны бүхий л зохистой арга хэмжээг авна.

3. Оролцогч улсууд хүүхдийг халамжлах, хамгаалах үүрэг бүхий газар, алба, байгууллагыг аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарт, ялангуяа ажилчдын орон тоо, чадавхид хяналт тавих үүднээс эрх бүхий байгууллагаас тогтоосон жишигт нийцсэн нөхцлөөр хангана” гэж

6 дугаар зүйл. “2. Оролцогч улсууд хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлэн хангана” гэж

18 дугаар зүйл. “1... Хүүхдийн хүмүүжил болон хөгжилд эцэг, эх буюу тодорхой тохиолдолд хууль ёсны асран

хамгаалагчид гол хариуцлагыг хүлээнэ. Хүүхдийн дээд ашиг сонирхол нь тэдний анхаарал чиглэх гол зүйл мөн.

2. Энэхүү Конвенцид заасан эрхийг дэмжин хэрэгжүүлэх, баталгаажуулахын тулд оролцогч улсууд хүүхэд хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхэд нь эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчид зохих тусламж үзүүлэх бөгөөд хүүхэд асран хамгаалах байгууллага, ажил үйлчилгээг хөгжүүлэх явдлыг хангана” гэж

19 дүгээр зүйл. “1. Оролцогч улсууд эцэг эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна.

2. Хамгаалалтын ийм арга хэмжээ нь хүүхэд, тэднийг асран халамжилдаг хүмүүст шаардлагатай тусламжийг үзүүлэх зорилгоор нийгмийн хөтөлбөр боловсруулах, түүнчлэн хүүхдэд хэрцгийгээр хандахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, авч хэлэлцэхээр шилжүүлэх, мөрдөн байцаалт явуулах, эмчлэх, цаардлагатай тохиолдолд шүүх ажиллагаа явуулах болон бусад арга хэмжээг тусгасан журмыг агуулна.

20 дугаар зүйл. “1. Гэр бүлийн орчноосоо түр буюу бүрэн хагацсан, эсхүл ийм орчинд байх нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцэхгүй бол хүүхдэд улсаас онцгой хамгаалалт, туслалцаа үзүүлнэ.

2. Оролцогч улсууд үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу ийм хүүхдийг өөр орчинд асран халамжлах бололцоог бүрдүүлнэ.

3. Хүүхдийг ийнхүү асран халамжлах нь асрамж хамгаалалтад түр шилжүүлэх, лалын шашинтны хууль ёсны дагуу “кафала” хэрэглэх, үрчлүүлэх буюу шаардлагатай тохиолдолд хүүхдийг асран хүмүүжүүлэх зохих байгууллагад өгөх зэрэг хувилбартай байж болно. Эдгээр хувилбарыг авч үзэхдээ хүүхдийн хүмүүжлийн залгамж чанарыг эрхэмлэхийн дээр түүний гарал угсаа, шашин болон соёлын хамаарал, төрөлх хэлийг зохих ёсоор харгалзан үзэх ёстой” гэж

25 дугаар зүйл. “Оролцогч улсууд асран хамгаалах, биеийн болон сэтгэл зүйн эмчилгээ хийх зорилгоор эрх бүхий байгууллагын шийдвэрээр асрамжинд авсан хүүхдийн эмчилгээ, сувилгаа, асран хамгаалахтай холбогдсон бусад бүх нөхцлийг тогтсон хугацаанд үнэлж дүгнүүлэх хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрнө” гэж

26 дугаар зүйл. “1. Оролцогч улсууд хүүхэд бүр нийгмийн халамж, түүний дотор нийгмийн даатгалд хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг үндэснийхээ хууль тогтоомжийн дагуу авна” гэж

27 дугаар зүйл. “1. Оролцогч улсууд бие бялдар, оюун ухаан, оюун санааны болон нийгмийн хөгжлийг хангах түвшинд аж төрөх хүүхэд бүрийн эрхийг хүлээн зөвшөөрнө.

2. Эцэг эх буюу хүүхдийн төлөө үүрэг хариуцлага хүлээж байгаа бусад

хүн хүүхдийг хөгжүүлэхэд шаардагдах амьдралын нөхцлийг өөрсдийн чадавхи, санхүүгийн боломжийн хэрээр хангах үндсэн үүрэг хүлээнэ.

3. Оролцогч улсууд энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд үндэсний нөхцөл, хөрөнгө бололцоондоо нийцүүлэн эцэг эх, хүүхдийн төлөө хариуцлага хүлээж буй бусад хүнд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд материаллаг тусламж, ялангуяа хувцас, орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан.

Дүгнэлт: Монгол Улс нь хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах талаарх дэлхийн улс орнуудын хэмжээнд баримтлах эрх зүйн үндсийг тодорхойлсон олон улсын цөөнгүй тооны гэрээ, конвенцид нэгдэн орсон бөгөөд хүүхдийн асрамж, халамжийн байгууллагуудад хүүхдийг шилжүүлэх харилцаа, хүүхдийн эрхийг хангаж, хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын онцлогийг тодорхойлох зорилгоор НҮБ-аас батлан гаргасан “Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал”, болон Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын хүний эрхийн эрх зүйн гол гол баримт бичгүүд болох “Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт”, “Хүүхдийн эрхийн тухай конвенци” зэрэгт дүн шинжилгээ хийлээ.

Үүнд:

Хүний эрхийн стандартыг тогтоосон үндсэн баримт бичиг нь 1948 оны НҮБ-ын Хүний эрхийн Түгээмэл тунхаглал юм. Иймээс дэлхийн бүх ард түмэн, бүх улс гүрэн хүний эрх, эрх чөлөөг нийтээр нэг мөр ойлгох, хүлээн зөвшөөрөх, хамгаалах, хэрэгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой стандарт болохын хувьд НҮБ-ын гишүүн

улсууд НҮБ-тай хамтран хүний эрх, үндсэн эрх чөлөөг нийтээр хүндлэн сахихад тус дөхөм үзүүлэх үүрэг хүлээнэ гэж хүний эрхийг хангах талаарх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Энэхүү үүрэгтэй уялдаж, дээрх баримт бичгээр тогтоосон стандартын дагуу хүний эрхийг хамгаалах асуудлаар тухайн улс гүрэн ямар түвшинд байгааг тодорхойлодог болсон.

НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалд “хүүхэд онцгой халамж, туслалцаа авах эрхтэй” гэж тунхагласан. Энэхүү тунхаглалын заалттай уялдуулж Хүүхдийн эрхийн тухай конвенцийг 1989 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Иймээс уг конвенц нь хүүхдийн эрхийг хангаж, хамгаалах олон улсын стандартыг тогтоосон үндсэн баримт бичиг болно. Энэхүү конвенцид оролцогч улсууд “гэр бүл, түүний гишүүдийн, ялангуяа хүүхдийн өсөж бойжих, аж төрөх жам ёсны орчин, нийгмийн үндсэн нэгж болохын хувьд нийгэмд хүлээх хариуцлагыг бүрэн хэмжээгээр үүрүүлэхэд шаардлагатай хамгаалалт, туслалцаа хүртэх ёстой”-г ойлгож, аз жаргал, хайр, ойлголцол бүхий гэр бүлийн орчинд өсөж бойжих нь хүүхдийн бүрэн өв тэгш хөгжлийг хангах нөхцөл болохыг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Хүүхдэд ийм онцгой халамж тавих шаардлага байгааг Хүүхдийн эрхийн тухай 1924 оны Женевын Тунхаглал,

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталсан Хүүхдийн эрхийн Тунхаглал болон “Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын Пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон улсын пакт” түүнчлэн Хүүхдийн аж байдал эрхэлсэн олон улсын болон төрөлжсөн байгууллагуудын холбогдох баримт бичиг, дүрэмд тусгаж хүлээн зөвшөөрснийг улс орон бүр нэн түрүүнд анхааралдаа авахыг чухалчлан заасан байна.

Дээрх олон улсын баримт бичигт заасан стандарт хэм хэмжээг нэгтгэн авч үзвэл, хүүхдийн эрхийг хамгаалах талаархи олон улсын хамтын нийгэмлэг дараах жишгийг тогтоосон байна. Үүнд:

- Хүүхдийн эрхийг хамгаалах төрний бодлогыг боловсруулах
- Хүүхдийн эрхийг хамгаалах үндсэн зарчмыг боловсруулах
- Хүүхдийн эрхийг хангаж, хамгаалах талаарх хууль тогтоомжийг гаргах
- Хүүхдийг хамгаалах, халамжлах зорилгоор хууль тогтоох болон захиргааны бүхий л зохистой арга хэмжээ авах
- Хүүхдийг халамжлах, хамгаалах үүрэг бүхий газар, албан байгууллагын аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарт ялангуяа ажилчдын орон тоо чадавхид хяналт тавих үүднээс эрх бүхий байгууллагаас тогтоосон жишигт нийцүүлэх нөхцлөөр хангах
- Хүүхдийн бие бялдар, оюун ухаан гүйцэд төлөвшөөгүйн улмаас түүнийг төрөхөөс өмнө болон төрсний дараа онцгой халамж, хамгаалалт, түүний

- дотор эрх зүйн зохих хамгаалалт шаардлагатайг онцгой анхаарах
- Хүүхдийн амьдрах, эсэн мэнд хөгжих бололцоог дээд зэргээр бүрдүүлж хангах
 - Хүүхэд хүмүүжүүлэх үүргээ биелүүлэхэд нь эцэг эх, хууль ёсны асран хамгаалагчид зохих тусламж үзүүлэх, хүүхэд асран хамгаалах байгууллага, ажил үйлчилгээг хөгжүүлэх
 - Хүүхдүүд өөрсдөд нь зориулсан асрамжийн алба, газрын үйлчилгээг ашиглах эрхээ эдлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах
 - Асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийн бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй харьцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийллээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захиргааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авах
 - Хүүхэд, тэднийг асран халамжилдаг хүмүүст шаардлагатай тусламжийг үзүүлэх зорилгоор нийгмийн хөтөлбөр боловсруулах, түүнчлэн хүүхдэд хэрцгийгээр хандахаас сэргийлэх, ийм байдлыг илрүүлэх, мэдээлэх, шилжүүлэх, эмчлэх, мөрдөн байцаалт явуулах, шаардлагатай тохиолдолд шүүх ажиллагаа явуулах болон бусад арга хэмжээг тусгасан журмыг мөрдүүлэх
 - Гэр бүлийн орчноосоо түр буюу бүрэн хагацсан, эсхүл тийм орчинд байх нь хүүхдийн дээд эрх ашиг сонирхолд нийцэхгүй бол хүүхдэд улсаас онцгой хамгаалалт, туслалцаа үзүүлэх
 - Үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу хүнд нөхцөлд байгаа хүүхдийг өөр орчинд асран халамжлах бололцоог бүрдүүлэх
 - Шаардлагатай нөхцөлд хүүхдийг асран хүмүүжүүлэх зохих байгууллагад өгөх зэрэг асран халамжлах хувилбарт үйлчилгээг хүлээн зөвшөөрч,
 - Эдгээр хувилбарт орчинд хүүхдийн хүмүүжлийн залгамж чанарыг эрхэмлэхийн дээр түүний гарал, угсаа, шашин болон соёлын хамаарал, төрөлх хэлийг зохих ёсоор харгалзан үздэг байх
 - Хүүхдийн эрх, ашиг сонирхолтой холбоотой аливаа үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцүүлэн түүнийг хангах,
 - Хүүхдийн аж байдлыг аливаа байдлаар хохироох, аливаа бусад хэлбэрийн мөлжлөгөөс хамгаалсан байх: гэсэн агуулгын хүрээнд хүүхдийн эрх, ашиг сонирхолтой холбоотой аливаа асуудал, үйл ажиллагаанд зайлшгүй дагаж мөрдөх “жишиг”-ийг тогтоосон байна.
- Монгол Улс нь эрх зүйн тогтолцоогоо өөрөө тодорхойлж, төлөвшүүлэх бүрэн эрхтэй ч хүний эрхийг дээдэлсэн ардчилсан зарчмыг эрхэмлэх үүднээс 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулинд :
- Хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
 - Хүн төрөлхтний соёл, иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж
 - Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгон тунхагласан.

Монгол улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд:

- Монгол улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн бодлого явуулна.
- Монгол улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

- Монгол улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ гэж заасан.

Иймээс дээрх олон улсын стандартад үндэслэн үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх нь нэг талаасаа зүй ёсны асуудал, нөгөө талаасаа зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг харуулж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХҮНИЙ НЭР ТӨР, АЛДАР ХҮНДИЙН ЭРХ ЗҮЙН ХАМГААЛАЛТЫН ОНОЛ ПРАКТИКИЙН ЗАРИМ АСУУДАЛ



Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч, доктор
Ширчингийн Сүхбаатар

Хүний нэр төр, алдар хүндийг эрх зүйгээр хамгаалах асуудал нь ихээхэн өргөн цар хүрээг хамардаг, маргаан мэтгэлцээнтэй, нарийвчлан судалбал зохих зүйлийн нэг юм. Уг ойлголтыг тодотгохын тулд түүний үндсэн шинжсийг гадаад буюу объектив, дотоод буюу субъектив талаас нь судалжээ. Хүний нэр төр, алдар хүндийн үндсэн шинжүүдийг тодотгохын тулд уг ойлголтуудыг нэг мөр болгох нь чухал юм. Хүний нэр төр, алдар хүнд нь түүний юугаар ч үнэлиггүй хамгийн үнэ цэнэтэй зүйл бөгөөд хүнийг хүн гэж нэрлэхийн утга учир түүнд оршдог ажээ. Судлаач нь энэхүү бүтээлдээ 1991-2010 оныг хүртэлх нэр төр алдар хүндээ сэргээлгэхээр шүүхэд хандсан тохиолдол, тоо баримтуудыг ашигласан байна. Тэрбээр “Бусдыг доромжлох, гүтгэх гэмт хэргийн субъект нь гол төлөв хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан сэтгүүлчид байгаа нь энэ гэмт хэргийн хүндрүүлэх шинжтэй шууд холбоотой. Хэрэв энэ асуудалд анхаарал тавихгүй цаг алгуурлавал хэвлэл мэдээллийн эрх чөлөөг боомлох байдал хүргэж болзошгүй. Түүнчлэн одоогийн эрүүгийн хуулиас доромжлох гэсэн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг гэмт хэрэг биш болгож иргэний эрх зүйгээр шийдвэрлэдэг болох нь зохистой байна” гэж үзжээ.

THEORETICAL AND PRACTICAL ISSUES ON THE LEGAL PROTECTION OF HONOR AND REPUTATION OF INDIVIDUALS

Sh.Sukhbaatar PhD in law

The following concepts are addressed in the article with the theme of “Certain theoretical and practical aspects of the legal protection of an individual’s image and reputation”:

The article underscores that the legal protection of an individual’s image and reputation is a broad and disputed topic of law, which should be comprehensively studied. In order to clarify the topic, main feature was examined objectively and subjectively.

The article also evaluates the effect of criminal defamation and insult in today’s prosecution process. The strict criminal penalties such as imprisonment and heavy fines adversely affect freedom of expression.

Moreover, the article has studied and concluded on the prosecution of cases that were initiated by claims of criminal defamation and insult of image, reputation and dignity from 1991 to 2010.

Нэг. Хүний нэр төр, алдар хүндийн үндсэн шинж

Хүний нэр төр, алдар хүндийг эрх зүйгээр хамгаалах асуудал ихээхэн өргөн цар хүрээ, маргаан мэтгэлцээнтэй, хууль зүйн шинжлэх ухааны нарийвчлан судалбал зохих зүйлийн нэг юм. Энэ ойлголтыг тодотгохын тулд түүний үндсэн шинжийг гадаад буюу объектив, дотоод буюу субъектив талаас нь авч үзэв. Нэр төрийн гадаад тал нь тодорхой хүний үнэлгээнээс үл шалтгаалах тул агуулгын хувьд объектив бөгөөд нийгэм, түүний бүлгийн үнэлгээ, үнэт зүйлийн нэгдсэн ойлголтыг тусгадаг.

Түүнчлэн энэ нь бусад хүн, нийгмээс хувь хүний зан үйл, үйл ажиллагаанд өгсөн улс төр, ёс суртахууны үнэлгээ бөгөөд тэр нь тогтвортой шинж чанартай байдаг. Тодруулбал, тухайн хувь хүний бүх талыг эсхүл түүний зарим хэсгийг хамаарсан байхыг хэлнэ. Хүний нэр төрийн гадаад үнэлгээ нь “нэр алдар”, “нэр хүнд”, “сайн нэр” гэсэн ойлголттой салшгүй холбоотой. Хэрэв нэр алдар нь тодорхой хүмүүсийн нэгдэл дунд зонхилж буй хувь хүн болон түүний үйл ажиллагааны үнэлгээний тухай ерөнхий тогтсон үзэл санаа байдаг бол, нэр төр нь илүү бага хүрээгээр хязгаарлагддаг.

Иймээс нэр төрийн объектив тал нь өөрийн агуулгын хувьд тодорхой түүхэн шинж чанартай. Нийгмийн харилцаан дахь хүний чиг үүрэг, байр суурь, түүнд тавих шаардлага, үйл ажиллагааны үнэлгээ, ёс суртахууны үзэл бодлыг тусгаж өгдөг онцлогтой.

Нэр төрийн гадаад буюу объектив тал нь хувь хүний гавьяа зүтгэлийг нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрч хүндэтгэх, хүмүүсийн үзэл санаагаар илэрхийлэгддэг. Үүгээрээ хүний нэр алдар, сайн нэр, ёс

суртахууны ач холбогдол бий болдог. Үүнээс гадна нэр хүнд нь нийгмийн зүгээс эерэг үнэлгээ олж авахад хувь хүний үйл ажиллагааг чиглүүлж түүнд ёс суртахууны ханамж олгодог ёс зүйн баялаг юм.

Нэр төрийн дотоод тал нь хэлбэрийн хувьд субъектив байна. Хүн өөрийн нэр төр, алдар хүндийг ухаарч, тодорхой нийгмийн хүрээнд өөрийнхөө талаар ямар үзэл санаа тогтсоныг харгалзан өөрөө өөрийгөө үнэлэх чадварыг бий болгодог.

Нэр төрийн ухамсар, мэдрэмж нь хувь хүний чухал шинж чанар бөгөөд түүний хөгжлөөс тухайн нийгмийн үзэл бодол, ёс суртахууны төлөвшил шалтгаалдаг. Иймд нь объектив, гадаад талаасаа хувь хүний зан үйл, үйл ажиллагааны дотоод сэдэлт болж өгдөг.

Хүний алдар хүндийн үзэл санааны шалгуур нь хүн төрөлхтөний дээд үнэт зүйл болон дундад зууны эцэст гуманистуудын тусламжтайгаар бий болсон гэж үздэг. Алдар хүнд нь хүмүүнлэгийн онолын үндсэн ойлголт бөгөөд энэхүү шалгуурын боловсруулалт нь хувь хүний эрх зүйн байдлыг тодорхойлох судалгааны ач холбогдолтой юм.

Хууль зүй, гүн ухаан, ёс зүйн ном зохиолд ихэнх тохиолдолд хувийн алдар хүндэд тухайн хүний бие бялдрын шинж чаиарыг хамааруулдаг алдаатай үзэл санаа зонхилж иржээ. Энэ бол буруу ойлголт юм.

Алдар хүндийн төрөл зүйн ойлголт нь амин хувийн шинж чанар, нийгмийн гарал үүсэл, хүйс, үндэс угсаанаас үл шалтгаалсан хувь хүн тус бүрийн үнэ цэнийг тодорхойлсон цогц ойлголт юм.

Алдар хүндийн тухай ойлголтонд нэр хүндийн тухай ойлголттой адил гадаад

буюу объектив, дотоод буюу субъектив талыг хамааруулдаг. Объектив тал нь тухайн хүнийг дээд үнэт зүйл болохыг хүлээн зөвшөөрдөгт оршино. Алдар хүндийн дотоод талын шалгавар нь тухайн хүний дотоод ертөнц, дэлхий ертөнцийг үзэх үзэл, уг нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахууны шаардлага, хэм хэмжээнд нийцүүлэн ямарваа үйлдэл хийх чадвартай холбоотой. Өөрөөр хэлбэл, нийгэмд өөрийн эзлэх байр суурь, хэрэгцээ, ёс суртахууны үнэ цэнийг ухамсарлаж мэдэрсэн байх явдал юм.

Нэр төр, алдар хүнд нь ёс суртахууны шалгавар мөн боловч нийтийн эрх зүйн шинж чанарыг агуулдаг. Ёс суртахууны шалгавар нь нэг талаас тухайн хүний нийгэм, бусад хүн, өөрөө өөртөө хандах харилцааг илэрхийлдэг. Нөгөө талаас тодорхой этгээд болох хувь хүнд төр, нийгэм, ялгавар бүхий нийгмийн бүлгүүд яаж хандах харилцаагаар илэрхийлэгдсэн бодит амьдралаар тодорхойлогдсон ерөнхий ойлголт гэж үзэж болно.

Ёс суртахууны үндсэн гол шалгавар нь шударга ёс, энэрэнгүй ариун нандин харамгүй сэтгэл, нэр төр, алдар хүндээ хамгаалах үүрэг хариуцлага гэх мэт байдаг бол, тэдгээрийн эсрэг нь хорон санаа, шударга бус явдал, хүний нэр тор, алдар хүндийг гутаан доромжлох зүй бус шунал юм. Эдгээр нь хоорондоо харилцан холбоотой ба ёс зүй, эрх зүйд салшгүй уялдаа бүхий нэгдсэн хос шалгавар гэж тооцогддог. Уг шалгаврын бодит байдлыг илэрхийлсэн нягт харилцаа холбоо нь тэдгээрийн тусгай шинж тэмдэг, ялгааг үгүйсгэдэггүй.

Эдгээр ойлголтын үндсэн ялгаа нь дараахь байдалд оршино. Хэрэв нэр төр нь тухайн хувь хүн нийтээр хүлээн

зөвшөөрсөн ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээг биелүүлсний үр дүнд нийгмийн зүгээс түүнийг хүндлэх, хүлээн зөвшөөрөх хэмжээг тодорхойлдог бол, алдар хүнд нь аливаа хүн бүр энэхүү хүлээн зөвшөөрөлт, хүндлэлийг олж авах тэгш боломжийг хэлдэг.

Үүнээс гадна нэр төрийн утга агуулга нь алдар хүндийн ойлголтоос илүү нарийн явцуу хүрээнд хамаардаг. Алдар хүнд нийтийн, тусгай, ганцаарчилсан шалгаварын нэгдэл болж хүмүүнлэгийн онолын үндсэн ойлголт гэж тооцогддог бол нэр хүнд нь эдгээр ойлголтын хэлэлцүүлэгт ордоггүй.

Хүний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн тухай ойлголт нь ёс суртахууны салбарт хамаардаг. Тэдгээр нь хоорондоо хил залгаа, утга агуулгын хувьд ойр дотно, заримдаа ижил, нэг нь нөгөөгөө тодорхойлдог онцлогтой. Нэр алдрын тухай ойлголт нь нэр хүндийн тухай ойлголттой нийлдэг. Нэр алдар нь хүний алдар хүнд, дутагдлын талаархи ерөнхий үзэл санааны илэрхийлэл юм.

Эцэст нь хувь хүний нэр төр нь хүлээн зөвшөөрөх гадаад илэрхийллийг шаарддаггүй бол алдар хүнд нь ихэнх тохиолдолд хүлээн зөвшөөрөх гадаад хэлбэрээр шагнал, зэрэг, цол зэргээр илэрхийлэгддэг.

Хүн өөрөө өөрийгөө болон бусад нь түүнийг юу гэж бодож, үнэлж байгаагаас үл шалтгаалан түүнийг “эрхэм дээд үнэт зүйл” гэж хүлээн зөвшөөрдөг нь алдар хүнд юм.

Алдар хүндийн тухай ойлголт нь хувь хүний өөрийн үнэлэмж, дүгнэлтээс өргөн хүрээтэй. Учир нь тэр өөрийн хувийн алдар хүндийн мэдрэмжээс гадна аливаа

хувь хүний үнэлэмжийг түүний оөрийн болон бусад этгээдийн үнэлэмж, хувийн шинж чанараас үл хамааран үнэлдэг. Тухайлбал, бага насны хүүхэд, сэтгэл санаа, бие эрхтний хувьд өөрөө өөрийгөө үнэлж чаддаггүй хэн ч бай бүх хүний нэр төр, алдар хүндийг төр хуулийн хамгаалалтандаа байлгадаг. Үүгээрээ хүн бүрийн эрхэм нэр төр, алдар хүнд нь дээд үнэт зүйлд зүй ёсоор тооцогддог.

Хүний нэр төр, алдар хүндийн үндсэн шинжүүдийг тодотгохын тулд уг ойлголтуудыг нэг мөр болгох нь чухал юм. Өнөөг хүртэл эдгээр ойлголтын агуулгын талаар янз бүрийн эргэцүүлэл байдаг ч нэгдмэл нэг тодорхойлолт алга байна. Ялангуяа хүний нэр төр, алдар хүндийн ухагдахууны талаар нэг мөр ойлголт хуульч эрдэмтдийн дунд тогтоогүйгээс түүнийг эрх зүйн талаас нь янз бүрээр тодорхойлох иржээ. Тухайлбал судлаач эрдэмтдийн нэг хэсэг нь алдар хүндийг эрхийн чадварын элемент гэж байхад нөгөө хэсэг нь нийгмийн үнэт зүйл, гуравдахь хэсэг нь онцгой субъектив эрх гэж үздэг.

Манай улсын хувьд 1999 оныг хүртэл хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбогдсон хэрэг маргааныг шийдвэрлэх талаар шүүхийн практикт нэгдмэл ойлголт тогтоогүй, ялангуяа нэр томъёоны хувьд эргэлзээтэй байдал ноёлсон хэвээр ирсэн юм.

Мөн нэр төр, алдар хүнд гэсэн нэр томъёонуудын утга санааг бус харин тэдгээрийг хамгаалах талаар шинжлэх ухааны үзэл баримтлалууд боловсруулахад арга зүйн ач холбогдлыг иш үндэс болговоос нэр төр, алдар хүндийн агуулгын талаархи маргаан улам бүр бодитой сонирхолтой болж ирэх нь дамжиггүй.

Нөгөө утгаар нь авч үзвэл нэр төр, алдар хүнд гэсэн ойлголтуудын агуулгын талаархи мэтгэлцээн нь үг зүйн талаас нь төдийгүй тэдгээрийн арга зүйн ач холбогдол, шинжлэх ухаан ч талаас нь авч үзвэл илүү барьцтай, тодорхой болно.

Нэр хүнд гэдэг нь тухайн хүний талаар нийгэмд байгаа мэдээллийн үндсэн дээр үүсдэг, орчин тойрныхонд нь тодорхой болсон шинж чанарууд, нэр алдар, дутагдлын тухай сайн, муу мэдээнүүдийн харьцаа, түүний үр дүнд тухайн нийгмийн зан суртахууны үүднээс нийгмийн ухамсарт туссан хувь хүний тухай санал сэтгэгдэл гэж ч тодорхойлж болох юм.

Түүнчлэн “Нэр төр”, “алдар хүнд” хэмээх ухагдахуунууд, тэдгээрийн харьцааг тодорхойлох талаарх бүх үзэл бодлуудыг “алдар хүнд” гэдгийг явцуу, эсвэл өргөн утгаар ойлгож байгаагаас хамааруулж ялгаж үзэж болно.

Түүнчлэн амьд хүний хувьд түүний сайн муу чанарын хамгийн хүлээн авууштай тодорхойлолт нь нэр хүнд байдаг бол нас барсан хүний хувьд алдар нэр байдаг. Нас барсны хойно иргэний нэр төр, алдар хүндийг хамгаалах нь эцсийн бүлэгт түүний алдар нэрийг сэргээх асуудал гэж үзүүштэй.

Ажил хэргийн нэр хүндийн тухай ойлголтыг нийгмийн ухамсарт байгаа тухайн этгээдийн ажил хэргийн шинж чанарыг тусгасан эерэг үнэлгээ гэж тодорхойлох нь зүйтэй. Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн бизнесийн үйл ажиллагааны нэг гол баталгаа нь энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх чухал нөхцлүүдийн нэг ажил хэргийн нэр хүндийг хамгаалах эрхийг хууль тогтоомжид улам болгосон гуй болгох явдал юм.


Хоёр. Гүтгэх доромжлох хэргийн хууль зүйн практикийн судалгаа

Өнөөгийн шүүхийн практикаас харахад бусдад гүтгүүлсэн доромжлуулсан гэх этгээд гомдлоо эрүү, иргэний хэргийн алинаар нь гаргахаа өөрөө шийдвэрлэдэг байна. Энэ нь иргэдийн дунд “Мууг нь үзвэл эрүүгээр яв, мөнгө хүсвэл иргэнээр яв” гэсэн хэлц үг ч үүсэхэд хүргэжээ.

Монгол Улсын хэмжээнд 2006-2010 онд бусдын нэр төр, алдар хүндийн эсрэг доромжлох гэмт хэрэгт 28, гүтгэх гэмт хэрэгт 74 нийт 102 хэрэгт эрүү үүсгэн шалгасан байна. Эдгээр хэргийн өсөлт бууралтыг цаг хугацааны дараалалаар авч үзвэл 2006 онд 12, 2007 онд 21, 2008 онд 19, 2009 онд 14, 2010 онд 36 хэрэг тус тус гарчээ.

Доромжлох, гүтгэх гэмт хэргийн гаралт 2006-2008 он хүртэл жил дараалан өсч, 2009 онд 14 болж огцом буурснаа 2010 онд хурдтай өсч 36 болжээ. Хэргийн гаралтын байдлыг тархацаар нь буюу нийслэл, орон нутгаар ангилж үзвэл энэ төрлийн хэргийн 69.7 хувийг нийслэл, 30.3 хувь нь орон нутагт гарчээ. Хэргийн нэг онцлог шинж нь энэ төрлийн хэргийн шүүгдэгч, хохирогчдын дийлэнх нь нийслэл Улаанбаатарт түүн дундаа Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт оршин үйл ажиллагаа явуулдгаас хамааралтай байна.

Хэргийн тархацыг диаграммаар үзүүлбэл:



Улсын хэмжээнд 2006-2010 онд эрүү үүсгэсэн 102 гүтгэх, доромжлох гэмт хэргээс 13 хэргийг шүүхээр эцэслэн таслан шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, эрүү үүсгэсэн нийт хэргийн 12.7 хувь нь шүүхээр шийдвэрлэгджээ. 2006 онд эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлээр 2 хэрэгт 2 хүн, 2007 онд 1 хэрэгт 1 хүн нийслэлд, 2008 онд Баянхонгор аймагт эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлээр 1 хэрэгт 1 хүн торгох ялаар, нийслэлд мөн зүйлийн 1 дэх хэсгээр 1 хэрэгт 1 хүн 2.160.000 төгрөгийн торгох ялаар, мөн зүйлийн 2 дахь хэсгээр 3 хэрэгт 4 хүн 9.640.000 төгрөгийн торгох, мөн зүйлийн 3 дахь хэсгээр 2 хүн хорих ялаар шийтгэгдсэн боловч бүгдийг тэнссэн байна. 2009 онд Нийслэлд мөн зүйлийн 2 дахь хэсгээр 1 хэрэгт 1 хүн баривчлах ялаар, 2010 онд Архангай аймагт эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлээр 1 хэрэгт 1 хүн 2.160.000 төгрөгөөр торгох, нийслэлд эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлээр 1 хэрэгт 1 хүн 5.580.000 төгрөгөөр торгох ялаар тус тус шийтгүүлсэн байна.

Ардчилсан нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө баталгаажсан байх ёстой ч хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хамгаалах үүднээс шаардлагатай хязгаарлалтуудыг нарийвчлан тусгаж өгөх нь 2000 онд Лондон хотноо зохиогдсон “Гүтгэлгийн эсрэг хууль”-ийн талаарх семинарын гол зарчим байсан байна. Гүтгэлгийн эсрэг хуулийн гол зорилго нь нэр хүндээ бууруулуулж хохирсон иргэн нэхэмжлэл гаргах эрхтэй ч албан хаагчийн буруутай үйл ажиллагааг шүүмжилсэн, хээл хахуулийг ил гаргасан тохиолдолд гүтгэлгийн эсрэг хуулийг хэрэглэхийг хоригложээ. Түүнчлэн зарчмын хувьд

Эрүүгийн хуулиас гүтгэлгийн эсрэг заалтыг хасч, Иргэний хуулиар зохицуулах хэрэгтэйг гүтгэлгийн эсрэг заалтууд эрүүгийн хуулиндаа хэрэглэж байгаа орнуудад зориуд анхааруулсан байна.

Европын орнуудаас гүтгэлгийн гэмт хэргээр 1992 оноос хойш нэг ч хүнийг хорих ялаар шийтгээгүй байхад манай улс 2002 оноос мөрдөж эхэлсэн Эрүүгийн хуулиараа цөөнгүй тооны хүнд ял шийтгэл оногдуулжээ. Судалгаанаас үзэхэд зөвхөн 2006-2010 оны хооронд гүтгэх, доромжлох гэмт хэргээр 102 хэрэгт 151 хүнд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж, прокурорын хяналт дор хянан шалгаж, 13 хэрэгт 18 хүнийг шүүхээс хорих, баривчлах, торгох ялаар шийтгэсэн байна. Тухайлбал 2008 онд Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлээр 2 хүнд хорих ял оногдуулж, тэнсэн харгалзахаар шийдвэрлэжээ.

Сэтгүүлчдийн дунд “Нэр төр нь гутаагдсан гэх үндэслэлээр ихэвчлэн ямар этгээд гомдол гаргаж шалгуулдаг вэ?” гэсэн асуултанд нийслэлд шалгагдсан эрүүгийн хэргийн нийт хохирогч нарын 96 хувь нь төрийн өндөр албан тушаалтан, олны танил хүмүүс байсан бол хөдөө орон нутагт улс төрчид дангаараа 66.7 хувь эзэлж байна. Эндээс дүгнэлт хийхэд эрүүгийн хуулийн гүтгэх доромжлох гэмт хэрэг нь төрийн өндөр алба хашиж байгаа эрх мэдэл бүхий хүмүүсийн хувьд өөрсдийг нь шүүмжилсэн, ажил хэргийн шударга бус хандлагыг нь илчлэн гаргаж тавьсан сэтгүүлчдийн итгэл үнэмшлийг мохоох тааламжтай нөхцөл бүрдүүлсэн, зөвхөн тэдэнд үйлчилдэг хуулийн заалт болон хувирах магадлал өндөр байна.

Эрүүгийн хуулийн хатуу чанга хариуцлага, тухайлбал хорих, хэт их

торгуулийн ял нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд нь сөрөг муу нөлөө үзүүлж болзошгүй. Шүүхийн практикаас харахад гүтгэх, доромжлох гэмт хэрэгт холбогдогчдын 81,4 хувийг хэвлэл мэдээллийн байгууллага буюу сэтгүүлч эзлэж байна.

Гүтгэх, доромжлох гэмт хэрэгт холбогдогчийг ангилвал:

Он	Хэвлэл мэдээллийн байгууллага	Бусад	Нийт
2006	9	3	12
2007	17	4	21
2008	15	4	19
2009	11	3	14
2010	31	5	36
Нийт	83	19	102
Хувь	81.4%	19.6%	100%


Олон нийтэд хамааралтай асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь бусад орнуудад хуулиар баталгааждаг. Чөлөөтэй мэтгэлцэж байх үед алдаатай мэдээлэл нийтлэгдэх магадлал өндөр байдаг. Хэрэв энэ эрх нь оршин байх ёстой юм бол түүнд хамгаалалт байх ёстой. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэх тал хэдий өндөр байр суурьтай, өөрөөр хэлбэл төр засгийн эрх мэдэл бүхий албан тушаалтан байсан ч тэдний өмнөөс нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэх хэрэг үүсгүүлэхээр хэн нэгэн санаачлага гаргасан бол шүүх түүнийг хүлээж авдаггүй жишиг АНУ зэрэг олон оронд байна. Бүр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлч нийгмийн тодорхой зүтгэлтнүүдтэй холбоотой баримтыг алдаатай нийтэлснийхээ төлөө шийтгэл хүлээх ёсгүй ч гэж үздэг. Учир нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдээр хохирлыг нөхөн төлүүлэх нь тэдний дунд айж болгоомжилсон уур амьсгалыг бий

болгож шударга шүүмжлэл, эрүүл сэтгүүл зүйг хохироож ардчиллын мөн чанарыг алдагдуулах талтай. Хэвлэл мэдээллийн байгууллагын хувьд сайн санааны үүднээс хийсэн “алдаа” байж болохыг хуулиар хүлээн зөвшөөрдөг эрх зүйн зохицуулалтыг манай улс хууль тогтоомждоо хэрэгжүүлэх цаг нэгэнт болжээ.

Гурав. Иргэний хэргийн шүүхийн практикт хийсэн судалгаа

Хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас үүссэн иргэний нэхэмжлэлтэй хэргийг шүүхээр шийдвэрлэж буй байдлыг 1991-2010 оны байдлаар судлаж үзвэл доорх байдал ажиглагдаж байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар улсын хэмжээнд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутааснаас үүссэн иргэний 917 хэрэг, маргаан гарснаас Улаанбаатар хотод 465 буюу нийт хэрэг маргааны 50.7 хувь нь, орон нутагт 452 буюу 49.3 хувийг шүүхээр хэлэлцэн шийдвэрлэсэн байна.



Судалгаанаас үзэхэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсанаас үүссэн хэргүүд 1991-1996 оны хооронд бага гарсан боловч 1997-2010 он хүртэл хурдтай өссөн байна. Энэ нь 1994 оны Иргэний хуулийн шинэчилсэн найруулга, 2002 оны Иргэний хуулиар хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаагдсанаас үүсэх эдийн бус гэм хорын хохирлыг арилгахаар хуульчилсантай холбоотой гэж үзэж болно.

Дээрх хэрэг маргааны шийдвэрлэлтийн байдлаас авч үзвэл:

- Нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан -186 буюу 20.2 хувь,
- Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгосон -146 буюу 15.9 хувь
- Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон – 180 буюу 19.6 хувь,
- Нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан

-252 буюу 27.5 хувь,

- Зохигчид эвлэрсэн -101 буюу 11.0 хувь,
- Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн - 48 буюу 5.2 хувь,
- Хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон - 4 буюу 0.4 хувийг тус тус эзэлж байна.

Эндээс дүгнэлт хийхэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбогдон шүүхээр шийдвэрлэгдэж буй хэрэг, маргааны 55,0 хувь нь хангагдаж, 43.6 хувь нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэж, үлдсэн 1.4 хувь нь шүүхээс нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Улсын хэмжээнд сүүлийн 10 жил гарсан нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас үүссэн дээрх хэргүүдийн өсөлт, бууралтын байдлыг харвал дараах байдалтай байна.

Үүнээс үзэхэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас үүссэн хэрэг маргаан орон нутагт 2005-2006 оны хамгийн бага байсан ба Улаанбаатарын хэмжээнд тогтмол өссөн байна. Мөн дээрх судалгаанаас харахад хэрэг маргааны гаралт улс төрийн сонгуулийн жилүүдэд тогтмол өндөр үзүүлэлтэй гарчээ.

Энэ нь улс төрчдийн сонгуулийн PR бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд ямар нэг хэмжээгээр халдаж байсан гэсэн дүгнэлт хийхэд хүргэв.

Анхан шатны шүүхийн шийдвэрүүдэд судалгаа хийж үзэхэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбогдсон иргэний хэрэг, маргааны хариуцагчийг хэвлэл мэдээллийн байгууллага, бусад гэж үндсэн 2 бүлэгт ангилж болохоор байна.

Хариуцагчийг ангилбал:				
Нийт хэргийн тоо	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	Эзлэх хувь	Бусад субъект	Эзлэх хувь
206	178	86,4	28	13,6%

Энэхүү 206 иргэний хэргийн 178 хэрэгт шүүх хариуцагчаар татагдан орсон хэвлэл мэдээллийн хэрэгслийг бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэвлэлээр дамжуулан гутаасан гэм буруутай гэж тогтоожээ. Энэ нь нийт хэргийн 86,4 хувийг эзэлж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд харшлах мэдээ, сэлт нийгэмд тараах, хууль зөрчих нь

Монголын нийгэмд өнөө үед гарч буй хэрэг, зөрчлийн дотор ялимгүй хувийг эзэлдэг ч шударга бус үнэнд харш, хууль бус үйлдэл, ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан хэрэг, маргаан буурахгүй байгаа нь чөлөөт хэвлэлийн үүрэг, ач холбогдлыг бууруулж, дөрөв дэх засаглалын эрх мэдлийн нийгмийн хүч, нолоог сулруулахад хүргэж болзошгүй ноцтой үр дагавартайг анхаарч үзүүштэй.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг судалбал нэхэмжлэлийн 37 нь буюу 18 хувь нь нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангасан, 66 буюу 32 хувь нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг нь хэрэгсэхгүй болгосон байна. Эндээс шүүхэд нэр төрөө сэргээлгэхээр хандсан нэхэмжлэлийн 50 гаруй хувь нь хангагдаж байгааг харж болно. Мөн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 26 хэрэг буюу 12,6 хувь байна. Нийт хэрэг маргааны 36,4 хувийг хялбаршуулсан журмаар, үлдсэн 63,6 хувийг ердийн журмаар шийдвэрлэжээ.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан гэж үзэж, гэм хорын хохирлыг мөнгөн хэлбэрээр гаргуулахыг хүссэн нэхэмжлэл 95 хувь, үлдсэн 5 хувь нь нэр төрөө сэргээлгэх, залруулга хийлгэх, уучлалт гуйхыг тус тус шаардсан нэхэмжлэл байна.

Нэр төр гутаасан, алдар хүнд буурсны улмаас учирсан хохирлыг төлүүлэх тохиолдолд бодит тооцоо гаргах боломжгүй бөгөөд хохирогч этгээд өөрөө ямар хэмжээгээр яаж хохирсоноо нотлох хэрэгтэй болдог. Нэхэмжлэгчийн шаардсан мөнгөний хэмжээ шүүхийн тогтоосон хэмжээнээс ямагт өндөр байдаг нь хохирлыг бодитой тооцох арга зайлшгүй чухлыг харуулж байна. 2004-2009 оны шүүхийн судалгаанаас харахад нэр төр, алдар хүндээ сэргээлгэхээр нэхэмжлэгчид дунджаар 3-15 сая төгрөг, дээд хэмжээ нь 200 сая төгрөг нэхэмжилсэн ба шүүх нэхэмжлэгчдийн эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг дунджаар 500.000-1.500.000 сая төгрөгөөр шийдвэрлэсэн байна.

Мөн зарим тохиолдолд (10 орчим хэрэг) нэхэмжлэгчээс “...миний нэр төрийг мөнгөөр үнэлэх аргагүй” эсхүл “...хариуцагчийн санхүүгийн боломжийг харгалзан” гэх мэтээр эд хөрөнгийн бус гэм хорын хэмжээг мөнгөөр үнэлэлгүйгээр нэр төрөө өөр аргаар сэргээлгэхээр шүүхэд хандсан тохиолдол ч байна. Мөн нийт иргэний хэргийн 9,7 хувь буюу 20 хэрэгт нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзжээ. Иргэний хэрэг, маргааныг тархацаар нь буюу нийслэлийн дүүрэг тус бүрээр судалж үзвэл Сүхбаатар дүүрэгт 112 хэрэг буюу 54,3 хувь, Чингэлтэй дүүрэгт 49 хэрэг буюу 23,8 хувь нь гарсан байна. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн олонхи

тус хоёр дүүрэгт оршин үйл ажиллагаа явуулдгаас хамаарч байна.

Судалгаанд нас барсан хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг сэргээлгэж, гэм хорын хохиролд хоёр сая төгрөг нэхэмжилсэн хэрэг Сүхбаатар дүүрэгт нэг гарсан ба түүнийг шүүх хуулийн дээрх заалтын дагуу нэр төр сэргээж, нэхэмжлэлийн шаардлагаас гэм хор нэхэмжилсэн хэсгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Анхан болон давж заалдах шатны шүүхүүд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсантай холбогдох хэргийг шийдвэрлэхдээ гаргаж буй нийтлэг дутагдлууд:

- Нэхэмжлэгчийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсан эсэх нь тодорхойгүй буюу бодитоор тогтоогдохгүй байхад сэргээхээр шийдвэрлэж байна.
- Олон нэхэмжлэгчтэй хэрэгт нэхэмжлэгч нарын хэнийх нь нэр төр, хэнийх нь ажил хэргийн нэр хүнд гутаагдсан эсэхийг зааглаж тогтоохгүй байна.
- Байгууллагын ажил хэргийн нэр хүнд гутаагдсантай холбоотой нэхэмжлэлийг иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсанаар шийдвэрлэсэн байна.
- Гэм хорын хохирлын хэмжээг иарийвчлан бодитоор тогтоогоогүй, хуулийг хэт явцууруулан тайлбарласан.
- Гутаасан мэдээг тараасан хэлбэр хэрэгслээр няцаалтыг хийх нь ач холбогдолгүй гэж үзвэл хэргийн онцлогоос шалтгаалан өөр хэлбэр хэрэгслээр няцаалт хийх үүргийг шүүх оногдуулж болохыг Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгээр

зөвшөөрсөн байгааг шүүхүүд шийдвэр гаргахдаа харгалзан үзээгүй зэрэг дутагдал ажиглагдаж байна.

Дөрөв. Судалгааны үр дүн, дүгнэлт

Манай улсад хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалж ирсэн хууль тогтоомж, шүүхийн практик, судлаачдын бүтээлийг судалсны үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Хүний нэр төр алдар хүнд нь олон шинжлэх ухааны уулзварт оршдог нарийн төвөгтэй асуудал юм. Хууль зүйн шинжлэх ухаан эдгээр шинжлэх ухааны ололт, мэдлэгт суурилан аливаа хүний хүн болж төрсөн заяамлыг нь нэр төр, төлөвших явцдаа олж авсныг нь алдар хүнд хэмээн тодорхойлох явдал дийлэнх судлаачдын хувьд хүлээн зөвшөөрөгдсөн байна.

2. Хүний нэр төр, алдар хүнд нь түүний юугаар ч үнэлшгүй хамгийн үнэ цэнэтэй зүйл бөгөөд хүнийг хүн гэж нэрлэхийн утга учир түүнд оршдог ажээ. Шинжлэх ухааны үүднээс авч үзвэл нэр төрийн асуудал нь философи, сэтгэл судлал, түүх зэрэг олон шинжлэх ухааны уулзварт агуулгыг нь судалдаг ба харин эрх зүйн хувьд түүнийг хамгаалдаг байна.

3. Хүний нэр төр, алдар хүнд нь Үндсэн хуулийн эрх зүй, иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй зэрэг олон салбар эрх зүйн зохицуулалтын объект болно. Тэгэхдээ зарим үед энэ нь хүний амьд явах эрхээс дутахааргүй эрх зүйн хамгаалалтын нэн чухал объект юм.

4. Монголчууд эрт дээр үеэс эхлэн хүний нэр төр, алдар хүндийг юуны өмнө заншлын хэм хэмжээгээр сайтар хамгаалж ирсэн түүхэн уламжлалтай ард түмэн юм. Дундад зууны үеэс эхлээд онөө цагт Монгол Улсын хууль тогтоомжид хүний

нэр төр, алдар хүнд хамгаалалтын нэн чухал объект болж иржээ.

5. Манай Улс удаа дараагийн эрүүгийн хууль тогтоомждоо хүний нэр төр, алдар хүндийг хүний амь нас, эрүүл мэндийн дараах ач холбогдол бүхий гэмт хэргийн объект болгон хамгаалж ирсэн бөгөөд хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалтын нэг чухал хэсэг нь эрүүгийн эрх зүйн хамгаалалт болж байна. Шүүхийн практикийг судалж үзэхэд бусдыг доромжлох, гүтгэх гэмт хэргийн субъект нь гол төлөв хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан сэтгүүлчид байгаа нь энэ гэмт хэргийн хүндрүүлэх шинжтэй шууд холбоотой байна. Тиймээс цаашид хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр гутаасан гэсэн хүндрүүлэх нөхцөл байдлыг хууль тогтоох болон хууль тайлбарлах үйл ажиллагаагаар нилээд явцуу хүрээнд авч үзэх бодит шаардлага нэгэнт бүрэлджээ. Хэрэв энэ асуудалд анхаарал тавихгүй цаг алгуурлавал хэвлэл мэдээллийн эрх чөлөөг боомилох байдалд хүргэж болзошгүй. Түүнчлэн одоогийн эрүүгийн хуулиас доромжлох гэсэн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг гэмт хэрэг биш болгож иргэний эрх зүйгээр шийдвэрлэдэг болох нь зохистой байна.

6. Судалгааны явцад хүний нэр төр, алдар хүндийн суурь хамгаалалт нь эрүүгийн эрх зүй бус харин иргэний эрх зүй мөн байна гэсэн дүгнэлтэд хүрэв. Иргэний эрх зүйд байгаа няцаалт хийлгэх, уучлалт хүсэх, мөнгө: төлбөр тогтоох зэрэг өргөн хүрээтэй бусад арга хэрэглүүр нь хүний нэр төр, алдар хүндийг жинхэнэ ёсоор хамгаалах үр нөлөөтэй арга болно.

7. Хүний нэр төр, алдар хүндийн эсрэг гэмт хэргийг эрх зүйн бусад зөрчил

тухайлбал Иргэний эрх зүйн зөрчил, захиргааны эрх зүйн зөрчил зэргээс зааглан ялгах онолын болон практикийн үндэслэлийг нарийвчлан тодорхойлох явдал нэн чухал байна. Эрх зүйн бусад зөрчлөөс зааглан ялгахад юуны өмнө чухам ямар хууль тогтоомжинд тухайн үйлийг заасан эсэх, тухайн хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээ, бий болсон хор уршиг, түүнчлэн холбогдогч болон хохирогчийн ажил, албан тушаал, гутаалтын хэр хэмжээ зэрэг обьектив болон субъектив хүчин зүйлийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай байна. Шүүхийн практикт жишиг тогтоохын тулд шүүхийн тайлбарыг зөв гаргахаас эхлээд шүүхийн шийдвэрлэсэн хэргийг нийтэд ил тод болгох, дагнан мэргэшсэн хуульчдыг төлөвшүүлэх, хууль зүйн сургалтыг сайжруулах зэрэг олон асуудлыг нэн даруй шийдвэрлэх цаг аль хэдүйн болсон байна. Хүний нэр төр, алдар хүндэд халдсан хэрэг зөрчил цаашдаа өсөх чиг хандлагатай байна. Энэ нь хууль тогтоомж тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг шинэ төвшинд гаргаж энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг өргөжүүлэх бодит шаардлагыг бий болжээ.

Нэр төр, алдар хүндийг эрх зүйгээр хамгаалах харилцааг ийнхүү илүү нарийвчлан, тодорхой болгох, олон улсын нийтлэг жишиг, дэлхийн улс орнуудын хууль зүйн практиктай ойртуулж уялдуулах зорилгоор Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид дараах өөрчлөлтийг даруй хийх саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг иргэний эрх зүйгээр хамгаалахад чухал нөлөөтэй “Няцаалтын тухай” 1952 оны олон улсын конвенцид

манай улс нэгдэн орох,

2. Хүний нэр төр, алдар хүндэд халдсан эдийн бус хохирлын хэмжээг хүний биед учирсан гэмтлийн зэрэг тогтоодог журмын адилаар зэрэглэн тогтоох.

3. Хүний нэр төр, алдар хүндэд учирсан сэтгэл зүйн хохирлыг нөхөн сэргээх эмчилгээгээр засах арга замыг судалж нэвтрүүлэх. Тухайлбал, уг гүтгэлэг доромжлолын улмаас тухайн хохирогчид болон түүний ар гэрийнхэний сэтгэл зүйд гэмтэл учирдаг. Энэхүү гэмтлийг ганцхан мөнгөн хэлбэрээр бүрэн засах боломжгүй тул сэтгэл зүйн эмчилгээ хийж уг эмчилгээний зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулж байх.

4. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “... нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд санаатай болон хэт хайхрамжгүй гэм буруутай нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцох...” гэсэн заалтыг нэмэх.

5. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг зэрэгцүүлэн адилтаж болохгүй бөгөөд тэднийг хамгаалах явдлыг ангид ялган хуульчлах буюу Иргэний хуулийн 21 дүгээр зүйлд дээрх ухагдахуунуудын ойлголтыг нэг бүрчлэн тайлбарлаж хуульчлах.

6. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг “Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан уг хэлбэр болон уучлалт хүсэх, хүлцэл өчих, бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан эсэх асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг нийтэд мэдээлэх зэрэг аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно” гэж оорчлон найруулах нь зүйтэй байна.

УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын Хүний эрхийн боловсрол хариуцсан референт, докторант Бадамсамбуугийн Болорсайхан

Энэхүү нийтлэлээр хүрээлэн буй орчинтой холбоотой асуудал, бизнесий үйл ажиллагааны талаарх дэлхий дахины чиг хандлагыг нэгтгэхийг зорьсон. Зохиогч нийгмийн олон түвшинд, ялангуяа хүрээлэн буй орчинтой холбоотой эрх, хөдөлмөрлөх эрх, иргэдийн оролцоо, шилжих хөдөлгөөн зэрэгт хүчтэй нөлөөлж байгаа “уул уурхайн тэсрэлт”-ийг онцлон үзсэн. Үүнтэй уялдан хэрхэн хүний зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжийг тодруулах зорилгоор эрхэд суурилсан хандлага ба хөгжил; нийгмийн хариуцлагыг хөхиүлэн дэмжих гэсэн хоёр чиглэлээр санал боловсруулжээ.

Хүрээлэн буй орчны эрх

Анх 1981 онд баталсан Хүний болон ард түмний эрхийн тухай Африкийн хартид заасан хүрээлэн буй орчны эрхийг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрч эхэлж байна. Хүрээлэн буй орчинд орчин цагийн нийгмийн үзүүлэх нөлөө улам тод болохын хэрээр хүрээлэн буй орчны эрх чухал ач холбогдолтойд тооцогдож байна.

Уг эрхийг олон улсын гэрээгээр баталгаажуулаагүй боловч Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25 зүйлд

HUMAN RIGHTS AND MINING: IN THE CONTEXT OF MONGOLIA

officer Mr. Bolorsaikhan.B of NHRC

This article aims to summarize the global tendencies to related environmental issues, and business activities. The author addressed the “mining boom” which makes great impacts to many societal levels in Mongolia, especially environmental rights, labor rights, civil participation and migration etc. Herewith, the paper proposed two suggestions aiming to clarify the possibilities of prevention from human rights violation: rights-based approach and development; promotion of social responsibility.

хүн бүр “өөрийн болон ам бүлийнхээ эрүүл мэнд, аж амьдралыг тэтгэхэд хүрэлцэхүйц амьжиргаатай байх эрхтэй”-г тунхагласантай уялдан олон жилийн турш хөгжин ирсэн зүглийн нэг олон улсын (болон бүс нутгийн шилжтэй) хүрээлэн буй орчны эрх зүй билээ¹⁹. Аюултай болон хорт хаягдал, бохирдолд тавих хяналт, байгалийн нөөц баялгийг (ургамал, амьтны аймаг, эрдэс) ашиглах явдлыг зохицуулсан

¹⁹ НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, <http://legalinfo.mn/insys/lawmain.php?Vsea=true&vlawid=3756&vtype=7>

олон тооны эрх зүйн эх сурвалжийг боловсруулсан нь хүрээлэн буй орчныг сайжруулах зорилготой. Гэхдээ хүрээлэн буй орчны эрх байдаг эсэх, түүнийг олон улсын стандартыг соёрхон батлах явдлыг түргэтгэхэд ашиглах талаар маргаан өрнөсөөр байна.

НҮБ-ын Хүний хүрээлэн буй орчны талаарх хурлаас баталсан 1972 оны Стокольмын тунхаглалд “Хүн бол эрх чөлөө, тэгш эрхтэйгээр нэр төртэй амьдрах, аж төрөх боломж олгосон чанартай орчинд тохиромжтой нөхцөлд амьдрах үндсэн эрхтэй бөгөөд одоогийн болон ирээдүйн үедээ зориулан хүрээлэн буй орчныг хамгаалах, сайжруулах хариуцлага хүлээдэг” гэж заасан²⁰. Энэ тунхаглалыг заавал биелүүлэх шинжгүй боловч Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25 дугаар зүйлтэй төстэй байна. Үүнтэй адил санааг 1989 онд баталсан НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид хойч ирээдүйд зориулсан хүрээлэн буй орчныг сайжруулах гэсэн байдлаар давтсан ажээ. Хүрээлэн буй орчин, хөгжлийн талаарх 1992 оны хурлаар тухайн эрхийн талаар ахиц гарч, Риогийн тунхаглалын 1 дүгээр зарчимд “Хүн төрөлхтөн тогтвортой хөгжлийн төвд байна. Тэд байгаль орчинтой зохицон эрүүл, үр ашигтай байдлаар амьдрах эрхтэй” гэжээ²¹. Дараагийн хурлаар тогтвортой хөгжлийн ойлголтыг

хөгжүүлэн, улс төрийн хүсэл эрмэлзлэлийг бодит үйл хэрэг болгохтой холбогдуулан Хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2002 онд Йоханнесбург дэх хурлаар шийдвэрлэсэн²². Үүний зэрэгцээ 1992 онд баталсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенц, түүний нэмэлт болох 1997 онд баталсан Киотогийн протоколоор хүрээлэн буй орчинд нөлөөлөх хийн гаралтыг зохицуулах санаачлагыг дурдаж болно. Мөн байгаль орчинд шууд нөлөөлж байгаа нь илэрхий болсон биологийн болон химийн зэвсэг, цөмийн үйл ажиллагаа, хорт хаягдлын талаарх олон гэрээ гарсан. Харин төрд хүрээлэн буй орчныг хамгаалах, хадгалах, сайжруулах явдлыг хөхиүлэн дэмжих үүрэг хүлээлгэсэн байдаг онцлогтой.

Хэрэв хүрээлэн буй орчны эрхийг тодорхойлбол хамтын эрхэд хамааруулах боломжтой. Хүрээлэн буй орчны мөн чанар нь үүнээс зайлшгүйг илтгэн харуулж байна. Гэхдээ хамтын эрхийн талаарх эрдэмтэд судлаачдын байр суурь нэгдээгүй байгааг онцлох нь зүйтэй²³.

Хүрээлэн буй орчны эрх нь одоо байгаа эрхүүдэд тулгуурлах замаар тодорхой нөхцөлд баталгаажих боломжтойгоор хөгжих эрхээс ялгаатай. Уугуул хүмүүсийн эрхийн тухайд, байгалийн нөөц баялагтай холбоотой зарим асуудлаар хүрээлэн буй орчны эрх нь давхацах тохиолдол бий. Цөөнхийн эрхтэй холбож үзвэл Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 27 дугаар зүйлийг тодорхой

²⁰ НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр, НҮБ-ын Хүний хүрээлэн буй орчны талаарх хурлын тунхаглал, 1 зарчим, <http://www.unep.org/Documents.Multilingual/Default.asp?Documentid=97&articleid=1503>

²¹ НҮБ-ын Хүрээлэн буй орчны хөтөлбөр, Хүрээлэн буй орчин, хөгжлийн тухай Риогийн тунхаглал, 1 зарчим, <http://www.unep.org/Documents.Multilingual/Default.asp?Documentid=78&articleid=1163>

²² Тогтвортой хөгжлийн талаарх дэлхийн дээд хэмжээний уулзалт, http://www.un.org/jsummit/html/basic_info/basicinfo.html

²³ Group Rights, <http://plato.stanford.edu/entries/rights-group/> Collective Rights, http://www.chrc-ccdp.ca/proactive_initiatives/section_67/page4-eng.aspx

Зураг 2. Монгол улсын уул уурхайн лиценз зураглал



Эх сурвалж: "Current Situation of Mongolia's Economic Development and Its Future Trend", NDIC, 2009

бүлэг эрхээ шаардах үндэслэл болгох боломжтой²⁴. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 169 дүгээр конвенц бол уугуул хүмүүсийн газар өмчлөх эрх болон хүрээлэн буй орчны хоорондын холбоосыг илэрхийлэх тод жишээ билээ. Эрүүл мэндээ хамгаалуулах эрхээс үүдэлтэйгээр түүний хэрэгжилтийг хянах байгууллага хүрээлэн буй орчны эрхийн зарим асуудлыг харгалзах боломжийг олгож байна.

Үүнтэй уялдан хөгжих эрхийг авч үзвэл, хөгжих эрх нь олон улсын тогтолцоонд шинээр хүлээн зөвшөөрсөн эрхийн нэг билээ. НҮБ-ын Ерөнхий Ассемблей болон Хүний эрхийн Комисс (хожим Хүний эрхийн зөвлөл болсон) зэрэг олон улсын цөөнгүй байгууллага олон жилийн турш анхаарч байсан. Хөгжлийн үндсийн талаар Нэгдсэн Үндсэн Байгууллагын Дүрмийн 55, 56 дугаар зүйлд амьжиргааны түвшинг

дээшлүүлэх, эдийн засаг, нийгмийн дэвшил, хөгжлийн нөхцлийг сайжруулахад ололт амжилт гаргахаар гишүүн Улсууд хамтрах гэж суулгасан. Эдгээр заалттай нийцүүлэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын мөн чанарыг илэрхийлсэн байдлаар Ерөнхий Ассемблей 1957 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан 1161 (XII) тогтоолдоо тэнцвэртэй, харилцан уялдаат эдийн засаг, нийгмийн хөгжил нь хүний эрхийг биелэлтэд хувь нэмэр оруулна гэжээ²⁵. Тегеран хотод болсон 1968 оны Хүний эрхийн талаарх дэлхийн хэмжээний хуралд эдийн засгийн талаасаа хөгжилтэй, хөгжингүй гэж тодорхойлсон орнуудын хоорондын зааг улам тэлж, олон улсын хамтын нийгэмлэгээс хүний эрхийг бодит биелэл болоход саад болж байгааг тэмдэглэсэн юм. Ерөнхий Ассемблейгаас жилийн дараа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэсэн Нийгмийн хөгжил, дэвшлийн тунхаглалыг (EA 2542 тогтоол (XXIV))

²⁴ Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, <http://www.mn-nhr.org/148-rs1srry0r-rrrr-srs-susryorr-ssrryorr-ssrr-rrr-srss-ryirryessr-rsrsrs-i-ryisriryerr.html>

²⁵ НҮБ, Ерөнхий Ассемблей, 1161 (XII) тогтоол, <http://www.un.org/documents/ga/res/12/ares12.htm>

баталсан.²⁶ Хүний эрхийн комиссын санал болгосноор НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга хүний эрхийн хувьд хөгжих эрх бусад эрхтэй хэрхэн харилцан холбоотойг судалсан судалгааг олон улсын хэмжээнд хийжээ. Судалгааны тайланг 1979 онд хэлэлцэж, дэлхий дахинд хөгжих эрхийн талаар анхаарал хандуулахад хүрсэн юм.

НҮБ-ын Хүний эрхийн комисс 1981 онд Хөгжих эрхийн тунхаглалын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулжээ. Үйл явц маш удаан байсан тул 1986 онд баталсан Ерөнхий Ассемблейн 41/128 дугаар тогтоолоор дахин чиглүүлж, тус тунхаглалыг баталсан. Тухайн тогтоолыг гишүүн улсуудын дийлэнх зөвшөөрч, АНУ эсэргүүцэж, Япон, Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс зэрэг улсууд түдгэлзсэн ажээ.²⁷ Дээрх тунхаглалаар “Хүн бүр хүний аливаа эрх, эрх чөлөөг бүрэн дүүрнээр биелүүлэхүйц эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн хөгжилд оролцох, хувь нэмрээ оруулах, түүнээс ашиг хүртэх эрхтэй учраас хүний салшгүй эрх” гэж хөгжих эрхийг ойлгохоор заасан. Нөгөө талаас хөгжих эрх нь өөртөө засан тохинох эрхтэй холбоотой. Тунхаглалд заасны дагуу гишүүн Улсууд хөгжих эрхийг бодит биелэл болгох үндэсний болон олон улсын түвшинд таатай нөхцөл үүсгэх олон улсын хөгжлийн бодлого боловсруулах арга хэмжээ авах үүрэг хүлээдэг. Мөн хөгжих эрхийн бүрэлдэхүүн хэсэг болсон ялгаварлан гадуурхахгүй байх, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хадгалах, сурч боловсрох, эрүүл

мэндийн үйлчилгээ авах, хоол хүнс, орон сууцаар хангагдах, ажил хийх тэгш боломж, адил цалин хөлс авах зэрэг багтана. Олон нийтийн оролцоог хөгжих эрхийг бодит биелэл болох гол үндэс гэж үзэх нь бий.

Вена хотод 1993 онд болсон Хүний эрхийн тухай дэлхийн хэмжээний хурлаар хэлэлцэх гол асуудлын нэгээр хөгжих эрхийг онцолсон байлаа. Дээрх тунхаглалд энэ эрхийг түгээмэл шинжтэй салшгүй эрхэд тооцон, хүний үндсэн эрхийн нэг гэсэн нь удаан үргэлжилсэн маргааныг эхлүүлсэн юм. Цөөн тооны хөгжилтэй улсын эдийн засгийн хөгжил, хорт болон аюултай хаягдлыг хууль бусаар хаях явдлыг арилгах, хөгжиж буй улсуудад оноосон өрийг хөнгөвчлөх нь хөгжих эрхийг хүлээн зөвшөөрөхөд саад болж байгаа хориг тээгийг арилгахыг зорьж байгаа үндэсний болон олон улсын тогтолцоонд маш чухал ажээ. НҮБ-ын Хүний эрхийн Комиссоос холбогдох асуудлыг судлах Ажлын хэсгийг байгуулсан. Гурав дахь удаагаа ажлын хэсгийг НҮБ-ын Хүний эрхийн комиссоос байгуулахдаа дараах бүрэн эрхийг олгосон байна. Үүнд:

- Хөгжих эрхийг хөхиүлэн дэмжих, хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшилд мониторинг хийх, хяналт тавих;
- НҮБ, түүний бусад байгууллагуудын илтгэлийг хянах;
- Хөгжих эрхийг хэрэгжүүлэхэд холбоотой асуудлаар НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын газарт зөвлөх;
- Холбогдох техникийн туслалцааг үзүүлэх.

Хүний эрхийн Комиссын 1998/72, Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн

²⁶ НҮБ, Ерөнхий Ассемблей, 2542 (XXIV) тогтоол, <http://www.un.org/documents/ga/res/24/ares24.htm>

²⁷ НҮБ, Ерөнхий Ассемблей, 41/128 тогтоол, <http://www.un.org/documents/ga/res/41/a41r128.htm>

1998/269 дугаар шийдвэрийн дагуу байгуулсан энэхүү ажлын хэсгийн анхны хурал 2000 оны 9 дүгээр сард болсон бол есдүгээр хурал 2008 оны 8 сард болжээ.²⁸

Хэдийгээр эрх зүйн үүднээс ахиц гаргах зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрөөс хөгжлийн үйл явцыг задлан шинжилсэн Хүний эрхийн хөгжлийн илтгэлийг боловсруулсан боловч энэхүү эрхийн биелэлт хангалтгүй байна. НҮБ-ын Хүний эрхийн комиссоос баталсан 2004/7 тогтоолын дагуу хөгжих эрхийн хэрэгжилт хариуцсан тусгай хэсэг байгуулж, 2005/4 тогтоолоор бүрэн эрхийг нь шинэчилсэн. Хүний эрхийн зөвлөлийн талаарх Ерөнхий Ассемблейн 60/251 тогтоолын дагуу татан буугдсан Хүний эрхийн комисст байсан бүх тусгай механизм хэвээр үлдсэн юм. НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс хөгжих эрхийг чухал холбогдолтойд тооцсон хэвээр байгаа билээ. Хөгжих эрх нь асар хурдан биш, харин урт удаан хугацааны өөрчлөлтийн үр дүнд бүрэн дүүрэн бодит биелэл болно. Зарим улсад үр дүн эерэг байгаа ч ахиц дэвшил удаан байна.

НҮБ-ын Ерөнхий Ассемблей 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсан цагаас эхлэн хувь хүмүүсийн эрх, эрх чөлөөг төрийн зүгээс зөрчих, хязгаарлахыг таслан зогсоох чиглэлээр олон чухал баримт бичгийг батлан гаргасан. Үүний зэрэгцээ төрийн бус оролцогчдын зүгээс хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа явдалд анхаарал хандуулах шаардлага тулгарсан бөгөөд төрийн бус оролцогчид буюу үндэстэн дамнасан корпораци, бизнесийн байгууллагууд нь эдийн засгийн хувьд

хүчирхэг болохын хэрээр төрийн бодлогод эерэг болон сөргөөр нөлөөлж, улмаар сая сая хүний эрхэд нөлөөлөх болоод байна. Олон улсын түвшинд төрийн бус оролцогчдын хүний эрхийн асуудлаар хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлох чиглэлээр олон санал, санаачлага өрнүүлэх болсон.

Энэ хүрээнд төрийн бус оролцогчдын хүний эрхийн асуудлаар баримталбал зохих зарчим, хэм хэмжээг тусгасан баримт бичгүүд (НҮБ-ын Даян дэлхийн тунхаг, НҮБ-ын Үндэстэн дамнасан корпораци болон бусад бизнес эрхлэгчдийн хүний эрхийн асуудлаар хүлээх үүрэг хариуцлагын зарчим, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Үндэстэн дамнасан бизнес эрхлэгчид болон нийгмийн хөтөлбөрт чиглэсэн зарчмуудын тухай гурван талт тунхаглал, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Үндэстэн дамнасан бизнес эрхлэгчдэд зориулсан удирдамж) ч гарч байна.²⁹

Нийгэм, хүрээлэн буй орчин, эдийн засагт шууд, хүчтэй нөлөөлдөг салбарын нэг уул уурхайн салбар билээ. Тодорхой байдлыг шалгах хэмжигдэхүүнийг ангилан үзвэл:³⁰

Хүрээлэн буй орчны нөлөө	<ul style="list-style-type: none"> • Биологийн төрөл зүйл, газар зохион байгуулалт • Уур амьсгалын өөрчлөлт • Усны удирдлага
Нийгмийн нөлөө	<ul style="list-style-type: none"> • Ажилтны болон хүй элгэний аюулгүй байдал • Сонирхогч талын идэвхтэй оролцоо • ДОХ/ХДХВ-ын бууралт • Уурхайн үйл ажиллагааны бодлого • Хүний эрх • Хүй элгэний хөгжил

²⁸ Хөгжих эрх хариуцсан ажлын хэсэг, <http://www2.ohchr.org/english/issues/development/groups/index.htm>

²⁹ НҮБХХ "Бизнес ба хүний эрх" хуралдаанд зориулан бэлтгэсэн мэдээллийн хуудсын төсөл
³⁰ Clarisa Lins, Elizabeth Horwitz Sustainability in the mining sector, 2007, 5 дахь тал.

Эдийн засгийн болон засаглалын нөлөө	<ul style="list-style-type: none"> • Нийлүүлэлтийн гинжин хэлхээний удирдлага • Ил тод, хариуцлагатай байдал • Гадаад гүйцэтгэлийн шалгуур • Тодорхой салбарын/дэлхий дахины санаачлага
--------------------------------------	---

Тогтвортой байдлын судалгааны “Хүний эрх” гэсэн дэд бүлэгт дараах дөрвөн шалгуураар байгууллагуудыг үнэлдэг байна. Үүнд:

- Уугуул хүмүүстэй мэдэгдэхүйц эерэгээр харилцах
- Ялгаварлан гадуурхахгүй байх бодлого
- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний талаарх бодлого
- Хүүхдийн хөдөлмөр/албадан хөдөлмөрийн эсрэг бодлого³¹

Гэсэн хэдий ч эдгээр шалгуурыг хангаснаар уул уурхайн тогтвортой байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг явуулах боломжтой гэж үзэх нь өрөөсгөл ойлголт юм. А. Сен “Хүний хөгжлийн зорилго бөгөөд арга хэрэгсэл нь хүний эрх чөлөө юм” гэж тэмдэглэсэн байдаг.³² Тогтвортой хүний хөгжлийн хандлага нь хөгжлийн эцсийн зорилго болох хүнд төвлөрдгөөрөө хөгжлийн бусад хандлага болох эдийн засгийн өсөлт, ханамжийг их байлгах, ядуурлыг бууруулах зэрэг хандлагаас давуу талтай юм.³³

Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн нэг онцлог нь байгалийн нөхөн сэргээгдэшгүй нөөцийг ашигладаг бөгөөд энэ нь хойч үеийнхэнд үлдээх байгалийн нөөцийн хэмжээг шууд бууруулж байгаа юм.

³¹ Clarisa Lins, Elizabeth Horwitz Sustainability in the mining sector, 2007, 40 дэх тал.

³² Amartya Sen (1999) "Development as Freedom, Anchor Books", New York.

³³ Anand, S. And Sen, A. (2000) "Human development and economic sustainability", World Development, 28(12), pp. 2029–2049.

Иймд уул уурхайн салбарын хувьд тогтвортой хүний хөгжлийн хандлага нь дараах хоёр нэн чухал хуваарилалтын асуудалд анхаардаг. Уул уурхайн салбарт хэрэгжүүлэх бодлого нь нэгд, ирээдүй үеийнхний хүний хөгжлийн боломжийг бууруулахгүй байх, хоёрт, энэхүү салбарын хөгжлийг өнөөгийн хүний хөгжлийг сайжруулах хүчин зүйл болгоход анхаарах ёстой юм.³⁴

Иймээс уул уурхайн салбар дахь хүний эрхийн өнөөгийн нөхцөл байдлыг зөрчигдсөн эрхийн хувьд тусгайлан авч үзвэл:

Уур амьсгалын өөрчлөлт

Уур амьсгалын өөрчлөлт Монголчуудад нийтэд нь нөлөөлөх боловч ядуу айл өрхийн амьжиргаа, амьдралын чанарт илүү аюул учруулах магадлалтай. Уур амьсгалын тогтворгүй байдал усны хомсдол үүсгэж, баталгаатай ус, ариун цэврийн байгууламж хязгаарлагдмалаас ядуучуудын халдварт өвчинд өртөх эрсдэл эрс нэмэгдэнэ. Алслагдмал хөдөө орон нутгийн хүн амын эрүүл мэндийн үйлчилгээ хязгаарлагдмалаас шалтгаалан төрөхийн өмнөх болон дараахь шатанд жирэмсэн эмэгтэйчүүд, эхчүүд, нярай хүүхдүүд болон ахмад настнууд зэрэг эмзэг бүлгийнхэн улам их эрсдэлд өртөж болзошгүй байна.

Монгол Улсын Засгийн газар уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, дасан зохицох чиглэлээр янз бүрийн стратеги боловсруулаад байна. Эрчим хүчний салбарт үр ашгийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах нь шийдвэрлэх алхам болно. Нэг

³⁴ Б.Алтанцэцэг, Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү: Уул уурхайн салбар ба тогтвортой хөгжил, Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэлд зориулсан эх материал (2011), 2010, УБ.

Хүснэгт 2. Монгол Улсын хүн амын ердийн хөдөлгөөний үзүүлэлтүүд

	1918	1935	1944	1956	1963	1969	1979	1989	2000	2006	2010
Хүн амын тоо (мян.)	647.5	738.2	759.1	845.5	1017.1	1197.6	1595.0	2044.0	2373.6	2594.8	2650.6
Төрөлт	-	-	26.1	32.3	43.2	40.2	39.2	36.5	20.5	19	-
Нас баралт	-	-	21.8	14.2	10.5	12.3	10.8	8.4	7.5	6.5	-
Ердийн цэвэр өсөлт	-	-	4.3	18.1	32.7	27.9	28.4	28.1	12.9	12.5	-

хүнд болон ДНБ-ий 1 ам. доллар тутамд ногдох нүүрсхүчлийн хийн ялгаруулалтын хэмжээг бууруулах талаарх Монгол Улсын үзүүлэлтийг сайжруулахад ой мод зэрэг нүүрстөрөгчийг шингээгчид чухал ач холбогдолтой. Монгол Улсын эдийн засаг нүүрстөрөгчийн ялгаруулалт өндөртэй тул эдийн засгийн өсөлт, нүүрстөрөгчийн ялгаруулалтыг зааглах, нүүрстөрөгч бага ялгаруулж хөгжих сонголтыг дэмжих шаардлагатай байна.³⁵

Шилжин суурьшилтын нөлөө

Шилжих хөдөлгөөний улмаас хүн амын нягтаршил нутаг дэвсгэрийн хэмжээнд жигд биш байна. Тухайлбал, Улаанбаатар хотод нэг хавтгай дөрвөлжин км-т 246.8 хүн ногдож байхад баруун бүсэд 0.9, зүүн бүсэд 0.7, төвийн бүсэд 1.0, хангайн бүсэд 1.4 байна.

Улаанбаатар хотын хүн амын өсөлт нийт хүн амын өсөлтөөс бараг 2 дахин их байгаа нь хөдөөнөөс шилжих хөдөлгөөн эрчимжиж, хотжих үйл явц түргэн хурдацтай явагдаж буйг харуулах боллоо.

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа шилжих хөдөлгөөний гол шалтгаан болж байна. Иймээс засаг захиргааны нэгжийн чанарыг сайжруулах, бүсийн нэмэгдлийг бий болгох, жижиг, дунд үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэлтийг хөдөөд

түлхүү дэмжих, бүс нутгийн хөгжлийн төв болон дагуул хотуудыг хөгжүүлэх замаар нийслэл дэх хүн амын төвлөрлийг сааруулах шаардлага гарч байна³⁶.

Үндэсний Статистикийн Хорооноос 2000 онд, НҮБ-ын Хүн амын сангаас 2010 онд хийсэн судалгаагаар 1989 онд хийгдсэн хүн амын тооллогоос хойш Монгол Улсад явагдсан хотжилтын үйл явц, дотоод шилжилт хөдөлгөөн, хүн ам зүйн өөрчлөлтүүдийн нэг том жишээ болох хүн амын өсөлтийн бууралт зэргийг дурьдсан байна. Тайланг хэвлэгдэж гарснаас хойш энэ асуудлууд олон нийтийн анхаарлыг ихээр татаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр хэлэлцэгдэж эхэлсэн бөгөөд хэд хэдэн судалгааны ажлыг дагуулжээ.

Тухайлбал, Улаанбаатар хот болон 21 аймагт гарсан шилжилт хөдөлгөөний судалгаа хийгдсэн байна. Эдгээрээс үндэслэн тус улсад хүн амын шилжилт хөдөлгөөний 3 урсгал байгааг хүн ам зүйчид санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд:

- Сумаас аймгийн төв рүү
- Захын аймгуудаас төв хэсэг рүү (ихэвчлэн Төв, Сэлэнгэ, Дорнод аймаг руу)
- Улаанбаатар хот руу зэрэг орж байна.

Хөдөө орон нутгийн суугчид эхлээд

³⁵ НҮБХХ, Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл 2011, Эмзэг байдлаас тогтвортой хагжил үрүү: Байгаль орчин, хүний хөгжил, УБ 2011, 42-43 тал.

³⁶ НҮБ-ын хүн амын сэнгийн 2010 онд хүн амын тооллогын талаарх мэдээлэл, http://mongolia.unfpa.org/2011/07/17/3540/mongolia_has_launched_the_main_findings_of_its_2010_population_and_housing_census/

“хагас хөдөө” буюу аймгийн төв рүү, дараа нь төвийн бүс рүү, ингээд эцэст нь Улаанбаатар хот руу тус тус шилжиж, төв хэсэг рүү шилжиж буй хүмүүсийн “замын төгсгөл” нь Улаанбаатар хот болж байна.

Төвлөрлийг сааруулж, нутгийн захиргааны байгууллагуудын эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтын зарим өөрчлөлт хийгдсэн. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүүний удирдлагын тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Төсвийн тухай хууль зэрэг хуулиудад энэ чиглэлээр зарим нэг нэмэлт өөрчлөлт оруулсан.

Гэхдээ эдгээр нь асуудлыг цогцоор нь шийдвэрлэх хэмжээнд биш, гагцхүү тулгамдсан зарим нэг асуудлыг шийдвэрлэх хэсэгчилсэн өөрчлөлт болсон гэж шинжээчид болон нутгийн удирдлагын мэргэжилтнүүд үзэж байна³⁷.

Нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд иргэдийн дийлэнх нь сэтгэл дундуур байдаг. Авлигатай тэмцэх газар, Нээлттэй нийгэм форум, Глоб интернэшнл ТББ-аас хамтран хийсэн “Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал” мониторингийн тайлангийн Төрийн байгууллагууд олон нийтийн санал бодлыг авдаг уу? гэсэн асуултад иргэдийн саналыг авдаг гэсэн мэдээлэл өгсөн 28 байгууллагын 23 хувь нь хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөгөө боловсруулахдаа, 5 хувь нь дотоод дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулахдаа, 18 хувь нь тухайн байгууллагад хандсан иргэдийн асуудлыг шийдвэрлэхдээ, 37

³⁷ ШУА, НҮБХХ, Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2007–2008, 75 тал.

хувь нь үйлчилгээнийхээ талаар, 18 хувь нь бусад асуудлаар иргэдийн санал бодлыг тус тус авч байжээ. Иргэдийн саналыг авдаг байгууллагуудын 72 хувь нь албан бичгээр, 63 хувь нь санал гомдол хүлээн авах ажилтнаар дамжуулж, мөн 63 хувь нь иргэдээс мэдээлэл авах утас ашиглах аргаар санал авдаг гэжээ³⁸.

Иргэдийн саналыг авдаггүй 35 байгууллага, байгууллагын онцлог, хууль тогтоомж, дээд шатны болон удирдлагын зүгээс зөвхөн хуульд заасны дагуу шийдвэр гаргадаг хатуу шаталсан тогтолцоотой байдаг зэргээс шалтгаалдаг гэсэн тайлбарыг хийсэн байна.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага буюу бүх шатны хурлууд жилд 1-2 удаа хуралдаж, төсөв батлах, тухайн шатныхаа Засаг даргын тайланг хэлэлцэх, зарим нэг хөтөлбөр төлөвлөгөө батлахаас төдийлэн хэтэрдэггүй. Хурлын тэргүүлэгчид нь төсөв багатайн улмаас хурлынхаа шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх талаар идэвхтэй ажиллах бололцоо хязгаарлагдмал байна. Шат шатны иргэдийн төлөөлөгчдөд санхүүгийн ямар нэг нөөц, түүнийг хэрэгжүүлэх эрх мэдэл дутмаг, үйл ажиллагааг нь үнэлэх, урамшуулах ямар нэг механизм байхгүй учраас хуралдаа оролцохоос өөр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй байна³⁹.

Үүнтэй уялдан орон нутгийн засаг захиргааны нэгжийг санхүүгийн эрх мэдэлтэй болгох, өөрөө төсвөө бүрдүүлэн, захиран зарцуулах эрх олгох асуудлыг эрчимтэйгээр шийдвэр гаргах түвшинд

³⁸ АТГ, ННФ, Глоб интернэшнл ТББ, Төрийн байгууллагын мэдээллийн нээлттэй, ил тод байдал. Мониторингийн тайлан. УБ., 2008. 41 дэх тал

³⁹ ШУА, НҮБХХ, Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт 2007–2008, 79 тал.

ярих болсон нь шилжилт хөдөлгөөнийг бууруулах нэг алхам гэж болно. Гэхдээ шилжилт хөдөлгөөнд дан ганц төрийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтаас гадна гаргасан шийдвэр үр нөлөөт байдлыг анхаарах нь зүйтэй. Тодруулбал, Монгол Улсын Засгийн газраас 1992 онд “Алт” хөтөлбөрийг батлан гаргаснаас хойш алт олборлох уурхайнуудын үйл ажиллагаа эрчимжиж, энэ салбарт оруулах гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэн, тус чиглэлийн үйлдвэр компаниудын тоо ч өссөөр байна.

Мөн 2006 онд гадаадын хөрөнгө оруулалтаар стратегийн орд газруудыг ашиглах тухай шийдвэр гарснаар уул уурхайн салбарыг түлхүү хөгжүүлэх бодлого баримталж, эдийн засгийн хөгжилд анхаарснаар мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлалын салбарт сөргөөр нөлөөлсөн билээ. Дээрх Зураг 2-т илэрхийлсэн байдлаар Монгол Улсын газар нутгийн дийлэнх хэсэгт үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгосноор мал аж ахуй эрхлэх бэлчээрийн хязгаарлагдмал болох, малын хөлийн даац орон нутагт хэтрэх, жуулчлалын үйл ажиллагааг улирлын чанартай явуулдаг аж ахуйн нэгжүүдийн санал болгох хөтөлбөрт өөрчлөлт орох, үзвэр үйлчилгээнд ашигладаг газрууд өөрчлөгдөх, нэвтрэх боломжгүй болох, цаашилбал тухайн орон нутгаас шилжин суурьших, өрхийн орлогоо нэмэгдүүлэх, чанартай үйлчилгээ, ялангуяа боловсролын төлөө нүүдэллэх үзэгдэл, ажилгүйдэл, ядуурлын тоо нэмэгдэх, хараа хяналтгүй хүүхэд олширч, сургууль завсардах, хүүхэд хөдөлмөр эрхлэх, ялангуяа тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх зэрэг

хүндрэлтэй нөхцөл байдал арилахгүй байна.

Зураг 3. Газрын доройтлын хандлага, Монгол Улс 2005-2010



Эх сурвалж: ҮСХ, 2009, 2011. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл 2008, 2010 он.⁴⁰

Уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн эрхийн төлөв байдал

Монгол Улс 1969 онд нэгдэн орсон “Ижил хөдөлмөрт адил хөлс олгох тухай” Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 100 дугаар Конвенцид ижил хөдөлмөрт адил хөлс олгох, ижил хөдөлмөр эрхэлж буй эрэгтэй, эмэгтэй ажилтанд адил тэнцүү шан олгох тухай тусгайлан заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулинд эдгээр асуудал тодорхой тусгагдсан байдаг. Гэтэл энэ зарчим тэр бүр, ялангуяа гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хэрэгждэггүй байна. Жишээлбэл, “Алтан Дорнод Монгол” ХХК-ны Ар аймганы алтны үйлдвэрийн ОХУ-ын иргэн гагнуурчинд 320 ам.доллар огч байхад Монгол Улсын иргэн гагнуурчинд 175 ам.долларын цалин олгож байв.

⁴⁰ НҮБХХ, Монгол Улсын Хүний хөгжлийн индгэл 2011, Эмзэг байдлаас тогтвортой хөгжил үрүү: Байгаль орчин, хүний хөгжил, УБ 2011, 48 тал.

Уул уурхайн үйлдвэр, байгууллагад ажлын онцлог гэдгээр голлон шалтгаалж Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтыг дордуулан ажилтны цалинг сард нэг удаа (тогтоосон өдөрт) өгөхөөр хөдөлмөрийн дотоод журам, бүр хамтын гэрээндээ тусган хууль зөрчдөг хэвшил тогтсон байна. Түүгээр ч зогсохгүй хугацаандаа цалин тавьж чадахгүй байх зөрчил цөөнгүй гардаг байна. Тухайлбал, “Селигдария Монголия” ХХК-ны Өлзийт тохой дахь уурхайн зарим монгол ажилтан 3 сар ажиллаад цалин аваагүй тохиолдол ч гарч байжээ.⁴¹

Илүү цагаар ажиллуулах, амрах хугацаагүй ээлжинд гаргах, боловсрол, үндэс угсаа, хүйсээр ялгаварлан гадуурхах явдал их, хоёр талын тэгш сонирхлыг илэрхийлэн гэрээ байгуулах нөхцөл бүрдүүлээгүй, Хөдөлмөрийн тухай хуульд заасан баталгаа, хангамж, боломжийг үл тоодог байдал нийтлэгээр гардаг байна.

Уул уурхайн салбар дахь хүүхдийн хөдөлмөр

Алтны ордуудад насанд хүрээгүй хүмүүс томчуудын нэгэн адил шороо зөөж ухах, ачиж буулгах, чулуу бутлах, мөнгөн ус зэрэг хорт бодистой харьцаж ажиллах нь түгээмэл болсон нь анхаарал татаж байгааг 2003 онд УИХ-д өргөн барьсан илтгэлдээ Комисс онцолж, алтны уурхайд албан бусаар хөдөлмөрлөж буй хүүхдүүд хүний эрүүл мэндэд хорт нөлөө үзүүлдэг мөнгөн устай харьцаж ажилладаг тухай дурдсан байна.

ОУХБ-ын “АЙПЕК” хөтөлбөрийн хүрээнд Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн нутагт байдаг үндсэн ба

⁴¹ ХЭҮК, Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэл, УБ, 2004 он, 52–55 тал.

шороон ордны 17 уурхайд хувиараа алт олборлодог 59 хүн, үүний дотор 11-18 насны 17 хүүхдийн дунд НЭМХ-ээс хор судлалын шинжилгээ хийхэд, судалгаанд хамрагдсан 17 хүүхдийн 8 нь мөнгөн усны архаг хордлоготой, тэдний 7 нь мэдрэлийн сульдааны хам шинж өвчтэй болсон байна. Эдгээр уурхайд ажилладаг 122 хүүхдийн дунд мөнгөн устай харьцаж ажилладаг хүүхэд 37,7 хувийг эзэлж байжээ. Тэнд ажилладаг эмэгтэйгээс мөнгөн усны хордлоготой, бие эрхтэний согогтой хүүхэд төрсөн талаар дээрх судалгааны тайланд тусгагджээ.

Хувиараа алт олборлогчдоос бэртэж, гэмтсэн осол аваарт орсон, эрүүл мэндээрээ хохирсон тохиолдол цөөнгүй гардаг байна. 2000-2002 онд Борнуурт 3 удаа, Баруунхараад 4 удаа осол гарсан. Хүүхдүүд осол аваарт өртөж болзошгүй газрын гүнд, нүх цооногт ажиллах, чулуу бутлах хүнд хүчир хөдөлмөрийг эрхэлж, хүүхдийн өргөх ачааны зөвшөөрөгдөх (эрэгтэй хүүхэд 8-16 кг, эмэгтэй хүүхэд 5-10 кг) хэмжээнээс 2-3 дахин хүнд шороо, чулуу байнга зөөх нь элбэг. Нийслэлийн Налайх дүүргийн нүүрсний уурхайд 200-300 хүүхэд тогтмол ажиллаж (тэднийг хүмүүс “болжмор”, “хэрээ” гэж нэрлэдэг), нүүрс чирж гаргах, шигших, түүх зэрэг хүнд хортой хөдөлмөр эрхэлдэг байжээ⁴².

Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2008 онд хийсэн судалгаагаар Өвөрхангай, Төв, Сэлэнгэ, Баянхонгор, Архангай, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Дорнод, Хэнтий зэрэг аймгуудад иргэд хувиараа алт, жонш олборлож, олон тооны хүүхдүүд хөдөлмөр эрхэлж байгаа боловч нарийвчилсан тоог гаргах боломжгүй байсан. 2006 онд МУИС-ийн Хүн ам

⁴² ХЭҮК, Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэл, УБ, 2003 он, 12–13 тал.

зүй, сургалт, судалгааны төвөөс хийсэн “Албан бусаар алт, жонш олборлож байгаа хүүхэд, насанд хүрэгчдийн суурь судалгаа”-гаар алт, жоншны ордод албан бусаар 45902 хүн ажиллаж байгаагийн 7996 нь 5-17 насны хүүхэд байгаа бөгөөд тэдгээр хүүхдийн 91,4 хувь нь алтны ордод ажиллаж, 2572 нь сургууль завсардсан тухай дурдсан байна.

Алт, жоншны уурхай дахь хүүхдийн хөдөлмөр нь хүүхдийн амь нас, эрүүл, мэнд, аюулгүй байдалд бодит эрсдэл учруулж, хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхэд сөргөөр нөлөөлж байгаа учраас тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр мөн.

Уул уурхай дахь биеэ үнэлэх явдал

Азийн сангаас 2008 онд хийсэн судалгаагаар уул уурхайд бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэг гарсан гэж дүгнэх боломжгүй ч бэлгийн үйлчилгээ үзүүлдэг хүмүүсийн хувьд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох магадлал өндөр ажээ. Уурхай дээр байгаа ихэнх бэлгийн үйлчилгээ үзүүлдэг эмэгтэйчүүд нь түр хугацааны ажил хайж, найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ ирсэн байна. Уурхайн хүнд хүчир ажил, өөр ажил сонгох боломжгүй учир биеэ үнэлэхэд хүрдэг бөгөөд гурван эмэгтэй нь зуучлагчийн хяналтан дор ажиллаж, оршин суух газраа чөлөөтэй сонгох зэрэг эрхээ хязгаарлуулдаг гэжээ. Хэрэв Монгол Улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хангаагүй бол эдгээр эмэгтэйчүүд хүн худалдаалах гэмт хэрэгт ортох эрсдэлтэй гэж үзэж болох юм.⁴³

⁴³ The Asia Foundation, Incidence of trafficking in persons and prostitution at mine sites in Mongolia, Ulaanbaatar, Mongolia, 2008, p. 36-37.

Нөгөө талаас уул уурхайн салбарын хөгжилтэй уялдан хүмүүсийн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэхийн зорихын зэрэгцээ хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хүлээн авах салбар болох гэдгээс урьдчилан сэргийлж байнгын хяналт, шалгалтыг хууль хяналтын байгууллагын зүгээс хийх шаардлагатай байна.

Олон нийтийн чиг хандлагаас харахад тухайн орон нутагт олборлолт нэмэгдэх тусам биеэ үнэлэх явдал ихэсдэг ажээ. Хэдийгээр хүүхэд биеэ үнэлсэн явдал бүртгэгдээгүй ч гэсэн албан бус болон гар аргаар олборлолт хийж байгаа газарт албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр гарах нөхцөл байдал, шинжийг урьдчилан анхаарах нь чухал.

Эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх

Монгол Улсын нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа болон хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж байгууллагууд 2006 оноос өмнө нөхөн сэргээлт хийдэггүй байсан учир Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн хяналт, шалгалтын үеэр нөхөн сэргээлт огт хийгээгүй, хагас хийсэн буюу нөхөн сэргээлт дөнгөж эхлэлийн байдалтай байгааг компаниудын үйл ажиллагаатай танилцсан байна. Үүний зэрэгцээ орон нуггийн Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн зүгээс хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах талаар зохион байгуулсан ажлуудад зарим эерэг

үр дүн байгаа боловч энэ талаар тооцоо судалгаа муутай, хэт ерөнхий хандсан тал ажиглагдаж байна. Нэн ялангуяа Иргэдийн төлөөлөгчдийн хурал, төрийн байгууллага, иргэний нийгмийн төлөөлөлтэй хамтран ажиллах шаардлагатай ажээ.

Хүн ам хэт төвлөрсөн суурин газруудын ойр орчимд ашигт малтмалын лиценз олгож байгаа нь хүн амын эрүүл мэнд, өмч, амьжиргааны эх үүсвэрт сөргөөр нөлөөлж, хүн амын өвчлөлийн түвшин нэмэгдэх, мөнгөн ус зэрэг бодисын нөлөөгөөр хордлогод орох, эхийн урагт өөрчлөлт орох, гаж төрөлт нэмэгдэх нөхцөл байдал үүсэхэд хүргэж байна.

ДЭМБ-аас уур амьсгалын өөрчлөлт, хүний эрүүл мэндийн чиглэлээр хийсэн олон судалгаагаар гурван төрлийн нөлөөллийг онцолсон байдаг. Нэгдүгээрт, зуны хэт халалт, дулаарлын шууд нөлөөлөл; хоёрдугаарт, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас өвчний халдвар тархах шинэ орон зай бий болж зарим төрлийн халдварт өвчин тархах эрсдэл нэмэгдэх шууд бус нөлөөлөл; гуравдугаарт, усны нөөц, усны хүрэлцээ өөрчлөгдсөнөөс гарах нөлөөлөл, хот болон хот орчмын газруудад ариун цэврийн байгууламж хангалтгүй байгаагаас шалтгаалж усаар дамжих халдварт өвчин тархах аюул зэрэг байна.

Эдгээр эрсдэлийн зарим нь Монгол Улсын хувьд төдийлөн ноцтой биш байж болох ч, уур амьсгалын өөрчлөлтийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг урьдчилан харж, багасгах асуудал тэргүүлэх ач холбогдолтой хэвээр байна. Одоогийн байдлаар нийт нас баралтын 2 хувийг “халдварт болон паразитын гаралтай өвчин” эзэлж байгаа бөгөөд энэ тоо цаашид өсч болзошгүй. Ялангуяа

хотын гэр хороололд, баталгаатай ундны ус, ариун цэврийн байгууламжгүй нөхцөлд амьдарч буй өрхүүд эрсдэлд өртөх магадлалтай⁴⁴.

Уул уурхайн үйлдвэрлэл, энэ салбар дахь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжсэн төрийн бодлогын үр дүнд ашигт малтмалын хайгуул, олборлолт нэмэгдэж, аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүс эрдэс баялгийн салбараас их хэмжээний ашиг орлого олсон боловч нөхөн сэргээлт хийлгүй орхигдуулсан байна. Тухайлбал, 2008 оны 1 дүгээр сард ашигт малтмалын нөхөн сэргээлтийн талаар 14 аймгаас ирүүлсэн мэдээгээр ашигт малтмалын олборлолт явуулж байгаа 251 аж ахуйн нэгж нийтдээ 1751,2 га. талбайд техникийн, 500,7 га. талбайд биологийн нөхөн сэргээлт хийсэн бөгөөд үлдсэн 143922,6 га. талбайд огт нөхөн сэргээлт хийгдээгүй байна. Үүний улмаас малын бэлчээр, хадлангийн талбай, малчдын үе дамжин нутагладаг газрын нь гол ус ширгэж, тэд идээшиж дассан нутгаа орхиоос аргагүй байдалд хүрсэн байна⁴⁵.

Иймээс байгаль орчны асуудлаарх нийтийн эрх ашгийн өмгөөлөл нь хүний эрхийн нөлөөллийн үр дүнтэй арга хэрэгслийн нэг юм. ХЭХТ 2005 оноос эхлэн уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны асуудлаарх нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийж байна. 2005-2009 оны хооронд нийт 10 хэрэг дээр ажилласан ба 2010 оноос шинээр 5 хэрэг дээр ажиллаж байна. Үүний зэрэгцээ нутгийн захиргааны байгууллагаас хөрөнгө оруулагч, уул

⁴⁴ НҮБХХ, Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл 2011, Эмзэг байдлаас тогтвортой хөгжил үрүү: Байгаль орчин, хүний хөгжил, УБ 2011, 34-35 тал.

⁴⁵ ХЭҮК, Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний төлөв байдлын илтгэл, УБ, 2008 он, 87 тал.

уурхай эрхлэгч байгууллагуудтай “Хамтын ажиллагааны гэрээ”, “Хамтран ажиллах хөгжлийн гэрээ” зэрэг баримт бичиг байгуулах замаар орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэд бүтэц сайжруулах, хөрөнгө оруулалт татах зэрэг арга хэмжээг санаачлан авч байгаа туршлага байгаа нь сайшаалтай боловч нийтлэг бус байна.

Монгол Улсад ТББ-ууд байгаль орчны хүний эрхийн хэрэгжилтийг сайжруулахын тулд Засгийн газрын хэрэгжүүлж байгаа уурхай, байгаль орчны хяналт, засаглалтай холбоотой бодлогод нөлөөлж, хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр ажиллан тодорхой дэвшил гаргаж байна. Гэхдээ ТББ-дын үйл ажиллагааны үр нөлөөг улам нэмэгдүүлэх, хууль, түүнийг хэрэгжүүлэх механизм, хяналтыг сайжруулах, түүнд иргэдийн тогтвортой оролцоог хангах өөрөөр хэлбэл тэдний орон даяар жигд хөгжин идэвхитэй үйл ажиллагаа эрхлэх эрх зүй, санхүүжилт, мэдээлэл, ёс зүй, үнэт зүйлсээ баримтлах орчныг бүрдүүлэх төрийн бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх цаг нь болсон гэж үзсэн байна⁴⁶.

Хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Тухайн нийгэмд гарч байгаа хүний эрхийн зөрчлийн эсрэг хариу арга хэмжээ авахын тулд хамрах хүрээ, хугацааг нарийвчлан тодорхойлох шаардлага тулгардаг. Үүний зэрэгцээ төрийн зүгээс хийсэн хууль ёсны хязгаарлалт уу, эсвэл бусдын эрх, эрх чөлөөнд халдсан зүй бус үйлдэл үү гэдгийг анхаарах хэрэгтэй.

⁴⁶ Г.Уранцоож, “Монголын төрийн бус байгууллагууд Засгийн газрын бодлогод нөлөөлж байгаа нь” Хүний хөгжлийн илтгэлд зориулсан материалаас

НҮБ-ын Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын заалтуудын хязгаарлалт болон татгалзах тухай Сиракусагийн зарчимд хуулийн дагуу төрийн зүгээс хийх хязгаарлалт нь дараах нөхцөлийг хангасан байна.

Үүнд:

- Хуульд тусгагдсан байх;
- Хязгаарлах болсон зорилго агуулах (хязгаарлах үндэслэл⁴⁷);
- Хязгаарлах хэр хэмжээ;
- Ардчилсан нийгмийн шаардлагад нийцсэн байх.⁴⁸

Тус зарчмын 21 дүгээр зүйлд “ардчилсан нийгэмд” гэсэн хэллэг нь хязгаарлалтын нөхцлүүдэд цаашид хязгаарласан хориг тогтоодог гэж тайлбарлаж болно; Хязгаарлалт тогтоосон улс нь хязгаарлалт тухайн нийгмийн ардчилсан чиг үүрэг гүйцэтгэхэд саад болохгүйг харуулсан байхыг шаардана; Хэдийгээр ардчилсан нийгмийн дан ганц загвар байхгүй ч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дүрэм, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний эрхийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэдэг нийгмийг энэ тодорхойлолттой нийцэж байна гэж үзэж болно гэж заажээ.

Харин уг зарчимд төрийн зүгээс тодорхой үндэслэлтэй байсан ч гэсэн дараахь эрхийг эдлүүлэхээс татгалзаж болохгүйг онцолжээ:

- Амьд явах;
- Эрүү шүүлтээс ангид байх;

⁴⁷ Үндэстний аюулгүй байдал, “нийтийн хэв журам”, “нийтийн эрүүл мэнд”, “нийтийн ёс суртахуун, бусдын эрх, эрх чөлөө” гэсэн үндэслэлийг Сиракусагийн зарчимд заасан байдаг.

⁴⁸ Сиракусагийн зарчим, E/CN.4/1985/4, <http://www.unhcr.org/refworld/docid/4672bc122.html>

- Сайн дурын зөвшөөрөлгүйгээр эмнэлгийн, эсвэл шинжлэх ухааны туршилтаас ангид байх;
- Боолчлол, сайн дурын бус боолын байдлаас ангид байх;
- Буцааж хэрэглэсэн эрүүгийн хууль тогтоомжийн улмаас илүү хүнд ял яллахгүй, эсвэл оноохгүй байх;
- Хуулийн өмнө эрх тэгш гэдгийг хүлээн зөвшөөрөх;
- Үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх.

Үүнтэй уялдан эдгээр эрхийг эдлэхдээ олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн зарчмуудыг удирдлага болгох ба хүний эрхэд суурилсан хандлагын суурь зарчим болдог. Хүний эрхийн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг уялдуулан хэрэгжүүлэх боломжтой хоёр арга зүйг санал болгож байна.

1. Эрхэд суурилсан хандлага ба хөгжил
2. Нийгмийн хариуцлагыг хөхиүлэн дэмжих

1. Эрхэд суурилсан хандлага ба хөгжил

2000 оны эхээр НҮБ-ын цөөнгүй агентлагууд хэдийнэ хөгжлийн төлөөх ХЭСХ-ыг баталсан боловч тус ойлголтыг ялгаатай ойлгож байсан. НҮБ-ын агентлаг хоорондын хамтын ажиллагааны улмаас НҮБ-ын агентлагууд, түншүүдийн ажил хэрэгт ХЭСХ гэж юу болох талаар “нийтлэг ойлголттой” болох нь чухал юм гэдэг илэрхий болсон. Үүний үр дүнд НҮБ-ын олон агентлагууд хүний эрхэд суурилсан хандлагын гол бүрэлдэхүүний талаарх нэгдсэн ойлголттой болсон. Энэхүү нэгдсэн ойлголтыг “НҮБ-ын нийтлэг ойлголт” гэдэг.⁴⁹

⁴⁹ НҮБ, Хөгжлийн хамтын ажиллагаанд чиглэсэн хүний эрхэд суурилсан хандлага: www.hreoc.gov.au/social_justice/conference/engaging_communities/un_common_understanding_rba.pdf.

Хүний эрхэд суурилсан хандлагын нийтлэг ойлголтын тухай НҮБ-ын мэдэгдэл

1. Аливаа хөгжлийн хамтын ажиллагааны хөтөлбөрүүд, бодлого, техник туслалцаа нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал, бусад хүний эрхийн олон улсын бусад гэрээнд заасан хүний эрхийн биелэлтэд ахиц гаргана.
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, бусад хүний эрхийн олон улсын бусад гэрээнд заасан хүний эрхийн стандартууд, дээрх баримт бичгээс үүдэлтэй зарчмууд нь бүх салбарын аливаа хөгжлийн хамтын ажиллагаа, төлөвлөлт болон төлөвлөлтийн үйл явцын бүх түвшинд удирдлага болно.
3. Хөгжлийн хамтын ажиллагаа “үүрэг хүлээгч” нарын өөрийн үүргийг биелүүлэх, “эрх эдлэгч” нарын өөрийн эрхийг шаардах чадавхийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулдаг.

Мөн энэхүү нийтлэг ойлголтод заасан ХЭСХ-ын тодорхойлолт нь хэлэхэд хэцүү урт тохиолдолд ХЭСХ-ын чухал мөн чанарыг товч байдлаар ийнхүү тодорхойлсон байна:

Хүний эрхэд суурилсан хандлага нь төлөвлөлтийн үйл ажиллагааны бүх аспектэд хүний эрх, түүний зарчмуудад хичээнгүйлэн, зохион байгуулалттайгаар анхаарал хандуулахад хүргэдэг. Хүний эрхэд суурилсан хандлага бол хэм хэмжээний хувьд олон улсын хүний эрхийн стандартуудад суурилсан, үйл ажиллагааны хувьд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад чиглэсэн хүний хөгжлийн үйл явцад зориулсан

оюун санааны хүрээ юм.⁵⁰

Дээрх тодорхойлолтуудаас харахад илэрхийлж буй үндсэн шинжүүдийг нэрлэвэл:

Шинж 1: Хөгжлийн хөтөлбөрүүдийн тэргүүний зорилго бол хүний эрхийн биелэлтэнд ахиц гаргах юм.

Анхаарлын төв нь хэрэгцээ биш, эрх болохыг сануулах замаар үндэсний төлөвлөлтийн зорилгыг дэмжих. Ялангуяа хэрэгцээг шууд хангахад арга хэмжээнээс илүүтэйгээр эрхийг баталгаажуулсан эрх зүйн эх сурвалжийн дагуу үйл ажиллагааг төлөвлөн, эдгээр эрхийг эдлүүлэх, баталгаажуулах, хөхиүлэн дэмжих, хангах нь чухал билээ.

Шинж 2: Хүний эрхийн зарчим, стандартууд нь бүх хөтөлбөрүүдийг чиглүүлдэг.

Хүний эрхийн зарчмууд нь нөхцөл байдлын үнэлгээ, задлан шинжилгээ, төлөвлөгөө, хэрэгжилт, мониторинг, үнэлгээний шат зэрэг хөтөлбөрийн бүх шатанд удирдлага болно. Энэ нь шийдвэр гаргагчаас төлөвлөгөөний шатанд тохирох шалгууруудыг тогтоох зэрэг төлөвлөлтийн шат бүрт шаардлагатай хүний эрхийн зарчмууд агуулсан байхыг баталгаажуулахын тулд ухамсарт хичээл зүтгэл шаарддаг. Төлөвлөлтийн бүх шатанд хүний эрхийг нэгтгэн оруулах нь дан ганц үр ашигт бус, үйл явцуудад анхаарахыг давхар шаарддаг.

Шинж 3: ХЭСХ нь эрх эдлэгч, үүрэг хүлээгчдийн чадавхийг бэхжүүлэхэд анхаарлаа төвлөрүүлдэг.

ХЭСХ эрх агуулагчийн тухай бодохдоо хамгийн ихээр гадуурхагдсан,

⁵⁰ ХЭДКГ, Хөгжлийн хамтын ажиллагаанд чиглэсэн хүний эрхэд суурилсан хандлагын тухай асуулт, хариулт, 2006.

үл зовшоорөгдсөн бүлэгт анхаарал хандуулахыг онцолдог. Тэгш эрх, оролцоо, татан оролцуулах зарчмууд нь энгийн иргэдтэй нэгэн адил торийн үйлчилгээг шууд хүртэж чадахгүй, эсвэл эрх мэдлийн хувьд гадуурхагдсан тухайн бүлэг этгээдэд тулгарах саад тээгийг анхаарч, бусдын адил тэгш боломжоор хангагдсан байх ёстой гэсэн санааг илэрхийлдэг.

Ядуу эмэгтэйчүүд, арьс өнгөний, угсаатны болон бусад цөөнх, таагүй нөхцөлд байх бусад бүлэг бол эрхийг нь хэрэгсэхгүй орхих өндөр эрсдэлд байдаг. Энэ шалтгааны улмаас ХЭСХ-ыг хэрэгжүүлэхдээ эдгээр бүлэгт анхаарал хандуулах төдийгүй тэдэнд тусгай давуу эрх олгох ёстой.

Хэрэгцээнд суурилсан хандлага ба хүний эрхэд суурилсан хандлага

Хөгжлийн хүй элгэн дотор өргөжсөн ХЭСХ-ын ойлголтын хувьд, хэрэгцээ болон эрхүүдийн хооронд дахь ялгааны талаар нэлээд маргаан өрнөсөн. Хамгийн гол ялгаа бол хэрэгцээ нь албан үүрэг, эсвэл үүрэг агуулаагүй ч амлалт огох, буяны хариу үйлдлийг санал болгох боломжтой. Эсрэгээрээ хүний эрх нь ямагт хүний эрхийн эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн, хөгжлийн хүчин чармайлтыг бэхжүүлсэн Төр, түүний нэгж хэсгийн харилцан хамаарах албан үүрэг болон үүргийг агуулдаг⁵¹.

Доорх хүс нэгтгэл тодорхойлсон ойлголтуудыг агуулан, НҮБ-ын Хүн амын сангийн Төлөвлөлтөд ХЭСХ-ыг хэрэгжүүлэх тухай 2004 оны Бодлогын тэмдэглэлдээ тайлбар хийсэн нь:

“Хэдийгээр хүний эрх хэрэгцээнд

⁵¹ UNFPA, Human Rights-Based Approach to Programming, Practical Implementation Manual and Training Materials, 2010, p. 90

Хэрэгцээнд суурилсан хандлага*	Хүний эрхэд суурилсан хандлага
Үр ашигт хүрэх зорилгод чиглэн ажилладаг	Үр ашиг, үйл явцад хүрэх зорилгод чиглэн ажилладаг
Хэрэгцээг хангахыг онцолдог	Эрхийн хэрэгжилтийг онцолдог
Хэрэгцээг үндэслэлтэй шаардлага гэж хүлээн зөвшөөрдөг	Эрх ямагт төрийн үүргийг агуулдаг гэдгийг хүлээн зөвшөөрдөг
Хэрэгцээ эрх мэдэл олгохгүйгээр хангагддаг	Эрх зөвхөн эрх мэдэл олгохыг хэрэгжүүлсэн тохиолдолд хангагдахыг хүлээн зөвшөөрдөг
Буяны үйлсийг хэрэгцээг хангахад зориулсан хүчтэй сэдэл гэж үздэг	Буяны үйлс бол хэрэгцээг хангах хангалттай бус сэдэл гэж тэмдэглэдэг
Үндэслэл нотолгоо, асуудлын шууд шалтгаануудад анхаардаг	Үндэслэл нотолгоо, асуудлын шууд шалтгаануудад анхаардаг
Хязгаарлагдмал салбарын төслүүдийг оруулдаг	Салбар хоорондын, нэгдмэл төсөл, хөтөлбөрүүдийг оруулдаг
Бодлогын талаарх бага зэрэг анхаарал бүхий нийгмийн нөхцөл байдалд анхаардаг	

суурилсан шаардлага ч гэлээ хэрэгцээнд суурилсан хандлагаас төлөвлөлтийн хүний эрхэд суурилсан хандлага тодоор ялгагдах ба хэрэгцээнд суурилсан хандлага нь “үүрэг хүлээгч”-ийн зарим хэлбэрийн оршихуйг агуулдаггүй. Хэрэгцээг хангах шаардлагад ямар нэгэн “зорилго” байхгүй бол хэрэгцээг хангуулахаар тодорхойлон заасан үүрэг бүхий томилогдсон этгээд, эсвэл механизм үгүй бөгөөд үүний улмаас эрхүүд нь одоогийн үл ойшоох, зөрчих явдлын өмнө эмзэг байна. Эрхэд суурилсан хандлага нь сонголт, боломжийг өргөжүүлэн, хүн бүр өөрийн эрх мэдлийг тодорхойлох, түүнийг чиглүүлэх явдалд дэмжлэг үзүүлдэг⁵².

2. Нийгмийн хариуцлагыг хөхүүлэн дэмжих

Сүүлийн 30 гаруй жилийн туршид дэлхийн эдийн засаг даяаршихын хэрээр үндэстэн дамнасан корпораци, бизнесийн байгууллагууд олноор үүсэн бий болж,

⁵² T. Obaid, Policy Note on Implementing a HRBA to Programming in UNFPA, 22 January 2004, UNFPA/CM/O4/7.

тэдгээрийн үйл ажиллагааны хамрах цар хүрээ улам өргөжин тэлсэн билээ. Эдгээр бизнесийн байгууллагуудын хүний нөөц нь зарим тохиолдолд жижиг улс орны хүн амтай тэнцэх хэмжээнд хүрсэн нь уг асуудалд олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс анхаарал тавин ажиллах цаг болсныг илтгэж байна. 2007 оны байдлаар дэлхий дахин дахь корпорациудын жилийн ашиг орлого нь дэлхийн дотоодын нийт бүтээгдэхүүний 11 хувийг эзэлж, цаашид өсөн нэмэгдэх хандлагатай байгаа нь уг байгууллагуудад их хэмжээний эрх мэдэл төвлөрч байгааг нотлож байна⁵³.

Ихэнх тохиолдолд хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих нь зөвхөн тухайн орны төр засгийн үүрэг хариуцлага гэж ойлгодог. Хэдийгээр аливаа орны төр засаг түүн дотор засгийн газар нь хүний эрхийг хангах нэн тэргүүний үүрэг хариуцлагыг үүрдэг

⁵³ Үндэстэн дамнасан корпораци дэлхийн эдийн засгийг хянаж байна <http://thesocietypages.org/socimages/2011/11/20/transnational-corporate-control-over-the-global-economy/>

боловч энэ нь хувийн хэвшлийг нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаас чөлөөлж байгаа хэрэг биш юм. Мөн хүний эрхэд суурилсан хөгжлийн хандлагын оролцогч субьектээр төрийн бус этгээдэд хувийн хэвшил, бизнесийн салбарыг тусгайлан авч үздэг.

Хувийн хэвшлийн хүлээх нийгмийн хариуцлагын асуудлыг ярилцахад юуны түүрүүнд тэдгээр байгууллагуудын хийж гүйцэтгэж болох зүйлс буюу тэдгээрийн нөлөөллийн хүрээг тодорхойлох нь маш чухал байдаг. Нөлөөллийн хүрээ гэсэн ойлголт аливаа олон улсын хэм хэмжээнд тэр болгон тусгагдаагүй байдаг хэдий ч энэ нь тухайн бизнесийн байгууллагын өөрийн бодлого, хамтын ажиллагаа, үйл явц, цар хүрээ, байрлал зэрэг олон хүчин зүйлүүдийг бодолцон хүний эрхийг хангах боломжийн хүрээ гэж ойлгож болох юм.

Иймд тухайн аж ахуйн нэгжийн том жижгээс үл хамааран түүнд тодорхой хэмжээний нөлөөллийн хүрээ байдаг. Нөлөөллийн хүрээг дараах үндсэн байдлаар тодорхойлж болно. Үүнд:

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанд нарийн хяналт тавьж ажиллах. Тодруулбал, өөрийн ажилтнуудад хөдөлмөрийн хэм хэмжээ, норм стандартыг мөрдүүлэхээр нягт нямбай хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагаа явуулж буй газрын уугуул иргэд, оршин суугчдын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчихгүй байх.
2. Хүний эрхийг бусадтай хамтран хамгаалах, хэрэгжүүлэх. Уг алхамыг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа хяналт тавин, хүний эрхийг хангасны дараа хийгдэх хоёр

дугаар шатны үйлдэл гэж ойлгож болох юм. Бусад оролцогчид, түнш, бараа бүтээгдэхүүн нийлүүлэгч, бизнесийн холбоод хүний эрхийг хамгаалахад хамтарч ажиллан, хүний эрхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах.

3. Бизнесийн байгууллагууд үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүнээ юунд хэрэглэгдэж буйд анхаарал тавих. Үүнд дарангуйлалт засаг бүхий газар ашиглагдаж буй зэр зэвсэг, тоног төхөөрөмж, түлш, эрчим хүч зэрэг зүйлс орж болох юм.
4. Хүний эрхийг хангах, хамгаалах болон хөхиүлэн дэмжихэд чиглэсэн таатай орчин бий болгох санхүүгийн туслалцаа үзүүлэх. Энэ үйл ажиллагаа нь нийгмийн болон нийгмийн анхаарал татсан бүлгийн ашиг тус, сайн сайхны төлөө өөрийн ашгийн тодорхой хэсгийн хувиарлахад чиглэнэ.

Мөн эдгээр үйлдлээс гадна бизнесийн байгууллагууд хүний эрхийн зөрчил гарахад шууд болон шууд бусаар нөлөөлдөг. Энэ нь хүний эрхийн зөрчил гаргаж буй этгээдэд шууд болон шууд бус байдлаар тусламж дэмжлэг үзүүлэх, итгэл үл даах, хүлээсэн үүргээ биелүүлэхдээ зөрчил гаргах хандлагатай этгээд, засгийн газар, компанитай гэрээ байгуулан ажиллахгүй байх, аливаа хүний эрхийн зөрчлөөс ашиг олохгүй байх, хүний эрхийн тогтмол зөрчилд хариу арга хэмжээ авахгүй байх зэрэг байдлаар хүний эрхийн зөрчил гарахад шууд болон шууд бусаар нөлөөлж болох юм.

Судалгаа, ажиглалтаас үзэхэд бизнесийн байгууллагууд болон засгийн газруудын үзэж байгаагаар хуулийн зүйл заалтаар албадсан зохицуулалтаас

илүү сайн дураар мөрдөх дүрэм журам бий болгон, түүнийг мөрдөх нь аж ахуй нэгжийн үйл ажиллагааны горим, хандлага болон хүний эрхийг хамгаалах ажилд үр дүн гарахад илүү нөлөө үзүүлдэг гэсэн дүгнэлтэнд хүрсэн байдаг⁵⁴.

Сүүлийн арван жилд ерөнхий болон үйлдвэрлэлд хамааралтай сайн дураар мөрдөх олон журам бий болжээ. Тэдгээрийн хамгийн өргөн цар хүрээг хамарсан нь НҮБ-ын Даян дэлхийн гэрээ (UN Global Compact) бөгөөд 2002 онд хариуцлагатай бизнесийн үйл ажиллагааг дэмжихээр үүсэн бий болсон сайн дурын санаачилга юм. Одоогоор уг гэрээнд 135 улсын 6000 гаруй бизнесийн байгууллагыг хамарсан 8000 гаруй оролцогч (гэрээний талууд буюу компаниуд) нэгдэн орсон байна. Даян дэлхийн гэрээнд хүний эрх хангах, сайн хөдөлмөрийн нөхцөлийг бий болгох, байгаль орчинг хамгаалах, авлигатай тэмцэхэд чиглэсэн 10 зарчмаас бүрддэг. Байгууллага бүр дээрх зарчмуудад чиглэсэн үйл ажиллагааны тайланг жил болгон хүргэн мэдээлэх журамтай байдаг⁵⁵.

Δ - Тухайн байгууллага нь ахиц дэвшлийн талаарх мэдээллийг заасан хугацаанд илгээж, харилцаа тогтоогүй үед энэ дүрсээр тэмдэглэдэг. (Монгол Улс)⁵⁶

Эцэст нь хэлэхэд, байгаль орчин, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагаанд илрэн гарах эрсдэл, давуу талыг удирдах, зохион байгуулах замаар хувийн хэвшилд дэмжлэг үзүүлэх, хүн бүрт үр ашигтай нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, үнэт зүйлсийг удирдлага болгон нийгэм, зах зээлийг зохистойгоор хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой хамтын ажиллагаа чухал ажээ. Үүнд дан ганц төр төдийгүй, нийгмийн харилцаанд оролцогч бүхий л этгээд нөлөөлөх хүрээндээ зүй зохистойгоор нөлөөлж, олон нийтэд эерэг хандлагыг бий болгох замаар хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ба зөрчил гарсан тохиолдолд өөрт олгосон боломжийн дагуу дангаар болон эвлэлдэн нэгдэж бүлэг болох замаар эрхээ шаардах, учирсан хохирлын нөхөн төлбөрийг хууль ёсны дагуу шаардах мэдлэгтэй, амьдралд ашиглах чадвартай, цаашдын амьдралд байнга илэрхийлэх хандлагатай байх нь эрх агуулагчдад чухал ач холбогдолтой.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

⁵⁴ ХЭДКГ, Тусгай илтгэгчийн мэдэгдэл, <http://www.ohchr.org/EN/NewsEvents/Pages/DisplayNews.aspx?NewsID=11567&LangID=E>

⁵⁵ НҮБ-ын Даян дэлхийн тунхаг, <http://www.unglobalcompact.org/AboutTheGC/index.html>

⁵⁶ Оролцогчдын нэрс (Монгол Улсын хувьд) http://www.unglobalcompact.org/participants/search?Business_type=all&commit=Search&cop_status=all&country%5B%5D=128&joined_after=&joined_before=&keyword=&listing_status_id=all&organization_type_id=&page=1&per_page=100§or_id=all

Хүснэгт 3. Даян дэлхийн
тунхагийг

Нэр	Төрөл	Салбар	Оролцож эхэлсэн огноо Харилцах хугацаа
Δ ХААН банк	Компани	Банк	2010/04/30 (2011/04/30)
Δ МТС ХХК	Компани	Ундаа	2009/07/30 (2011/07/30)
Алтай Кашмер ХХК	Компани	Нийтлэг үйлдвэрлэл	2009/04/09
Бишрэлт Холдинг ХК	Компани	Санхүүгийн үйлчилгээ	2009/04/02
Очир Ундраа ХХК	ЖДҮ	Аж үйлдвэрийн метал, уул уурхай	2009/03/12
Биокомбинат	Компани	Эмийн үйлдвэрлэл, биотехнологи	2009/03/10
Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбоо	Орон нутгийн хөдөлмөрийн байгууллага	Хамаарахгүй	2009/03/10
Δ Монкорд хадгаламж зээлийн хоршоо	ЖДҮ	Санхүүгийн үйлчилгээ	2009/02/27 (2011/03/23)
Монэнзим РП ХК	ЖДҮ	Химийн бодис	2009/02/27
Δ Classical Right ХК	ЖДҮ	Аялал, жуулчлал	2006/06/12 (2011/06/11)
Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим	Орон нутгийн бизнесийн холбоо	Хамаарахгүй	2006/06/06
Их Хүрээ JCI Монгол	Орон нутгийн ТББ	Хамаарахгүй	2006/03/23
Δ НИММ Аудит ХК	ЖДҮ	Дэмжих үйлчилгээ	2006/02/21 (2011/02/21)
Δ Мобиком Корпораци	Компани	Цахилгаан холбоо	2006/02/20 (2011/02/20)
Δ Монголросцветмет корпораци	Компани	Аж үйлдвэрийн метал, уул уурхай	2006/02/17 (2011/02/17)
Δ Монос групп ХК	Компани	Эмийн үйлдвэрлэл, биотехнологи	2006/02/17 (2011/02/17)
Δ Петровис	Компани	Газрын тос, хий үйлдвэрлэгч	2006/02/17 (2011/02/16)
Δ Эрдэнэт уул уурхайн компани	Компани	Аж үйлдвэрийн метал, уул уурхай	2006/02/16 (2011/02/16)
Δ MCS Холдинг ХХК	Компани	Барилга, материал	2006/02/15 (2011/02/18)
Δ Номин Холдинг ХК	Компани	Нийтлэг бараа	2006/02/15 (2011/02/15)
Δ Улаанбаатар төмөр замын олон улсын тээвэр зуучлалын төв	ЖДҮ	Аж үйлдвэрийн тээвэр	2006/02/03 (2011/02/03)
Улаанбаатар	Хот	Хамаарахгүй	2006/01/13

ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨ БА ХҮНИЙ ХӨГЖИЛ, ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ



Хуульч, хууль зүйн ухааны магистр
Данхүүгийн Баянбилэг

“Хүний хөгжил бол хүний өөрийнх нь дотоод нөөцийг хөгжүүлэх замаар чадавхижуулах, улмаар амьдралд нь ач холбогдол, үр дүнтэйгээр тусгалаа олох явдал бөгөөд хүний нийгмийн харилцаанд оролцох олон талт идэвхтэй үйл ажиллагааны цогц.

Мөн улс орны хөгжлийн “толь” гэж үзжээ. Харин хүний аюулгүй байдлыг “хүмүүний амьдралын гол утга учир болох үндсэн эрх чөлөөг хамгаалахыг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Хүний эрх, эрх чөлөөг дээрх 2 ухагдахуунтай нэгтгэн “Аливаа хүн эрх, эрх чөлөө болсон боломжоо эдлэхдээ аюулгүй баталгаат орчинд чөлөөтэйгээр өргөн сонголт хийх” гэсэн “цогц ойлголт”-ыг бүрдүүлж байна гэсэн байна.

Энэхүү өгүүлэл нь “Хүний эрх” сэтгүүлийн 2009 оны №02-т нийтлэгдэж байсан болно.

CORRELATION BETWEEN HUMAN RIGHTS AND FREEDOMS, HUMAN DEVELOPMENT, AND HUMAN SAFETY

D.Bayanbileg, Lawyer

This article argues that “human development is the improvement of a person’s capacity by effectively developing his or her own internal resources and realization in his or her life and is a set of multipartite activities of a person within society. Furthermore, it is a reflection of the development of a country.” Human safety is defined as “protection of basic freedom which constitutes the meaning of human life.” Along with human rights and freedoms, these three categories make up “a complex concept” which means, “every person can make a free choice in safe circumstances while enjoying the opportunity that his or her rights and freedoms provide.

“This article was published on the issue No 02 of “Human Rights” journal in 2009.

Америкийн Нэгдсэн Улсын 32 дахь Ерөнхийлөгч асан Франклин Делано Рузвельт /1882-1945/ 1941 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр “Бид аюулгүй, бат бэх байдлыг тогтоохоор хичээн зүтгэхдээ юуны өмнө дэлхий дахинд дөрвөн гол эрх чөлөөний суурийг тавьсан байх ёстой.

Энэ нь нэгдүгээрт үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх., хоёрдугаарт, бишрэн шүтэх, итгэл үнэмшилтэй байх., гуравдугаарт, гачигдах зовлонгоос ангид байх., 4 дүгээрт айх аюулгүй байх., эрх чөлөө дэлхийн газар сайгүй хангагдсан байх ёстой...” хэмээн Конгресст хандаж түүхт үгээ хэлсэн нь Нэгдсэн Үндэстний Байгууллагыг бий болгох, хүний эрх, эрх чөлөөг дэмжин дэлгэрүүлэх үйлсэд онцгой ач холбогдол өгсөн юм.

Энэхүү түүхт үг Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал /1948 он/-ын удирдтгал хэсэгт “Хүн ардын эрхэм дээд эрмэлзэл”, түүнчлэн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт /1966 он/, Нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн тухай олон улсын Пакт /1966 он/-ын оршил хэсэгт “Бие хүний эрхэм зорилго” болж тусгагдан, түүний агуулга, мөн чанар хүний эрхийн олон улсын болон бүс нутгийн байгууллагын эрх зүйн баримт бичигт, улс орон бүрийн Үндсэн хууль, хууль тогтоомжид илрэлээ олсоор байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын Дүрэм /1945 он/-д түүний зорилгыг “...Улс үндэстнүүдийн хооронд улс түмний тэгш эрх, өөрөө засан тохинох зарчмыг хүндэтгэсэн найрсаг харилцааг хөгжүүлэх, ...хүмүүнлэгийн шинжтэй олон

улсын асуудлыг шийдвэрлэх, ...хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжиж дэлгэрүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх...” гэж тодорхойлсон бөгөөд нөгөө талаар эдгээрийг НҮБ-ын олон улсын эдийн засаг, нийгмийн хамтын ажиллагааны үүрэг хэмээн тогтоосон байдаг⁵⁷.

Хүний эрх, эрх чөлөөний талаарх янз бүрийн тодорхойлолыг тухайлбал, “Хүн бол бүх эдийн хэмжүүр” хэмээсэн Эртний грекийн философич, гүн ухаантан Протагор /МЭӨ 490-420/-ын үеэс өнөөг хүртэл гадаадын болон дотоодын олон эрдэмтэн, судлаачийн хүний эрхийн талаарх бүтээлд олонтаа томъёолсон байдаг. Энэ удаад түүнийг манай зарим эрдэмтэн хэрхэн тодорхойлсныг үзье.

Хүний эрх гэдэг нь төрөлхөөс заяасан бөгөөд хамгийн эгэл утгаараа хүнд өөрт нь байдаг, нийгмийн дотор заавал эдлэх боломж мөн. Эрх чөлөө гэдэг нь хүний заавал эдлэх ёстой бөгөөд ямар нэгэн хязгаар тавьж үл болох боломжийг хэлнэ. Үүгээрээ эрх чөлөө нь хүний салшгүй эрх болж илэрдэг байна⁵⁸.

Хүний эрх нь хувь хүн, нийгэм, төр хоорондын харилцааны эрх зүйн хэм хэмжээний хэлбэр мөн. ...Үндсэн эрх, эрх чөлөө нь хувь хүний эрх зүйн байдлын гол суурь болж өгдөг ба тэдгээр нь хүний амьдралын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах бусад олон эрхийг бий болгох боломжийг олгодог⁵⁹.

⁵⁷ Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн IX бүлэг, 55-60 дугаар зүйл.

⁵⁸ Б.Чимид, “Үндсэн хуулийн тухай мэдлэг”, УБ., 2006 он.

⁵⁹ Ж.Амарсанаа, “Хүний эрхийн тухайд” илтгэл, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 50 жилийн ойд зориулсан олон улсын бага хуралд тавьсан илтгэл, УБ., 1997 он, 15, 17 дахь тал.

Олон улсын эрх зүйн баримт бичгээр баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө нь дор дурдсанаар ангилагдаж байна. Үүнд:

1. Хамрах хүрээ, салбараар нь хувийн, улс төрийн, эдийн засаг, нийгэм, соёлын;
2. Нийгмийн харилцаанд оролцох субъект болон тоогоор нь бие хүний, бүлгийн, хамтын /энэ нь зөвхөн тухай улсын дотроо/;
3. Мөн чанараар нь жам ёсны болон үүсмэл;
4. Хууль зүйн баталгааны хүрээгээр нь хууль тогтоомжид заасан үндэслэлээр хязгаарлаж болох, ямар ч тохиолдолд хязгаарлаж болохгүй;
5. Ард түмэн өөрөө засан тогтнох, хүүхэд, эмэгтэйчүүд, хөдөлмөрлөх, эвлэлдэн нэгдэх, тахир дутуу иргэд, цагаачлагч, дүрвэгсэд, геноцидын эсрэг, ялгаварлан гадуурхахын эсрэг, хүмүүнлэгийн гэх мэтээр 21 бүлэгт ангилагдсан 100 гаруй олон улсын эрх зүйн баримт бичгийн зорилго, зорилтоор;
6. Даяарчлагдаж буй дэлхий ертөнцийн өнөөгийн ерөнхий төлөв, агуулгын хувьд тэдгээрийг багцлаад олон улсын хэмжээнд ерөнхийдөө дараахь байдлаар авч үзэх хандлага гарч байна:
 - 1/ хувь хүний шууд эдлэх, угаасаа заяагдсан, салшгүй эрх; Энэ эрх бол иргэний ба улс төрийн зарим эрх юм.
 - 2/ төрөөс тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг шаарддаг эрх буюу эдийн засаг, нийгэм, соёлын эрх; Энэ эрх бол улс бүрийн санхүү, Эдийн засгийн нөөц, чадавхийн хүрээнд арга хэмжээ авахыг шаарддаг эрх юм.
 - 3/ Хамтын эрх. Энэ эрх нь дан ганц

улсаас хальсан өөрөөр хэлбэл, олон улсын хүчин чармайлтын хүрээнд хэрэгжих эрх /дайн, терроризм, цөмийн зэвсгийн аюулаас ангид байх, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, арилгахтай холбогдсон гэх мэт/ юм.

Хүний эрх, эрх чөлөөг төрөөс дээдлэх, хамгаалах, хангах, хөхиүлэн дэмжих асуудлын хувьд хөгжлийн янз бүрийн түвшинд байгаа тухайлбал, өндөр хөгжилтэй, хөгжиж байгаа, ядуу буурай улс орнуудын хандлагад ялгаа ажиглагддаг. Өндөр хөгжилтэй улс орнууд улс төрийн болон хувь хүний эрхийг, ядуу буурай улс орнууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг дээгүүр тавьж байхад, харин хөгжиж байгаа улс орнууд аль алийг нь анхаарах чиг баримталж байна. Энэ ялгаа нь 1948 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалд дурдагдсан хүний эрхүүд нь капиталист, социалист нийгмийн тогтолцооны бүлэг улсуудын ашиг сонирхол, үзэл бодлын зөрөлдөөнөөс улбаалан 1966 онд 2 тусдаа олон улсын гэрээ /Пакт/ болж батлагдахад ч нөлөөлсөн байдаг.

Хүний эрх, эрх чөлөөтэй холбогдож, тэдгээрийг тодотгож байгаа “хүний хөгжил”, “хүний аюулгүй байдал” гэсэн хоёр үндсэн ойлголтын талаар товч өгүүлье.

3.1. Хүний хөгжил гэж юу вэ?

Тодорхойлолт: Хүний хөгжил бол аливаа хүн эдийн засгийн, нийгмийн, улс төрийн, соёлын сонголтоо чөлөөтэй хийх боломжийг өргөжүүлэх үйл явц, нөгөө талаар үр дүн юм⁶⁰.

Хүний хөгжил нь хүний өөрийнх нь дотоод нөөцийг хөгжүүлэх замаар чадавхийг нь сайжруулах, ингэснээр

⁶⁰ НҮБХХ “Хүний хөгжлийн илтгэл: Хүний хөгжлийн үзэл баримтлал ба хэмжүүр”, Нью Йорк, 1990 он.

түүний амьдралд ач холбогдолтой, үр дүнтэйгээр тусгалаа олох явдал бөгөөд хүний нийгмийн харилцаанд оролцох олон талт идэвхтэй үйл ажиллагааны цогц юм. (зохиогч Д.Б.)

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд ... “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна...” гэж тунхагласан. Хүмүүс төрөх мөчлөө тэгш эрхтэй байдаг, тэдний цаашид нийгэмд эзлэх байр суурь, эрх тодорхой хэрэгжих нь өөрсдийнх нь зарцуулсан хөдөлмөр, чадавхиас хамаардаг⁶¹. Улс орны хөгжлийн “голь” бол хүний хөгжил билээ. Монгол ардын зүйр цэцэн үгст “Иргэн баян бол улс баян” гэдэг мэргэн санаа /зүйр цэцэн үг/ байдаг нь үүний илэрхийлэл болов уу. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр /НҮБХХ/-өөс дэлхийн эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд дүгнэлт хийж, улс орон бүрийг хүний хөгжлийн нэгдсэн хэмжүүр буюу хүний хөгжлийн индексээр нь байр эзлүүлэн, “Дэлхийн хүний хөгжлийн илтгэл”-ийг 1990 оноос эхлэн жил бүр гаргах болсон бөгөөд өнгөрсөн хугацаанд нийт 18 удаа “бичигджээ”.

Жил бүр өөр өөр сэдвээр, тухайн сэдэвтэй холбогдсон асуудлуудыг түлхүү хөндөж, дүн шинжилгээ хийж, үнэлэлт өгсөн илтгэлүүдийн анхных нь “Хүний хөгжлийн үзэл баримтлал ба хэмжүүр” нэртэйгээр гарсан ба “Ард түмэн бол аливаа үндэстний жинхэнэ баялаг мон.

Тийм ч учраас хөгжлийн зорилго нь хүн ардаа урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах таатай орчинг бүрдүүлэхэд оршино.” хэмээн эхэлдэг.

Хүний хөгжлийн индекс /ХХИ/-

⁶¹ Ж.Амарсанаа, “Хүний эрх (Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал)”, УБ, 2000 он, 69 дэх тал.

ийг иргэдийн наслалтын хэмжээ, боловсролын түвшин буюу насанд хүрэгсдийн бичиг үсэг тайлагдалт ба анхан, дунд, дээд шатны сургуульд хамрагдалт, нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ буюу амьжиргааны түвшин гэсэн үндсэн 3 суурь үзүүлэлтээр тодорхойлдог. Хэдийгээр ХХИ нь хүний хөгжлийн суурь, дундаж хэмжигдэхүүн боловч түүнийг бүрэн төгс тодорхойлодоггүй юм. Дэлхийн улс орнуудыг Африкийн улсуудын, Арабын улсуудын, Европ болон Европын холбооны улсуудын, Ази, Номхон далайн улсуудын, Латин Америк, Карибын тэнгисийн гэж газар зүйн байршлаар нь бүлэглэж, эдгээр 5 бүс нутгийн илтгэлийг 34 удаа эрхлэн бэлтгэж гаргасан байна.

Дэлхийн улсуудаас анхлан Бангладеш, Камерун, Пакистан, Филиппин улс 1992 онд НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр үндэсний хүний хөгжлийн илтгэлээ бэлтгэн гаргаж байсан бол 2001 он гэхэд 120 гаруй улс 260 гаруй үндэсний хүний хөгжлийн илтгэлийг, харин 2009 оны 5 дугаар сарын байдлаар 146 улс нийтдээ 629 ийм илтгэлийг боловсруулан гаргасан байна.

Монгол Улсын Засгийн газар “Монголын хүний хөгжлийн илтгэл”-ээ 1997 онд НҮБХХ-тэй хамтран анх удаа, түүнээс хойш 2000, 2003, 2007 онд гээд нийтдээ 4 удаа гаргаад байна. Манай улсын хүний хөгжлийн анхны илтгэл шилжлэгтийн үеийн Монгол Улсын иргэдийн амьжиргаа, аж байдлын түвшинд үнэлгээ өгсөн, хоёр дахь илтгэл нь Монгол Улсад төрийн үүрэг ямар байх ёстой, яаж ажиллах вэ? гэдэгт анхаарал хандуулсан, гурав дахь илтгэлд хот, хөдөөгийн ялгаатай байдалт үнэлэлт өгсөн байдаг. Харин 2007 онд гаргасан дөрөв дэх

Дэлхийн хүний хөгжлийн илтгэл

№	Он	Илтгэлд хамрагдсан улсын тоо	Монгол Улсын эрэмбэлэгдсэн байр	Илтгэлийн сэдэв
1	1990	130	61	“Хүний хөгжлийн үзэл баримтлал ба хэмжүүр”
2	1991	160	87	“Хүний хөгжлийг санхүүжүүлэх нь”
3	1992	160	88	“Нийтлэг чиг хандлага ба хүний хөгжил”
4	1993	173	100	“Ард түмний оролцоо”
5	1994	173	102	“Хүний аюулгүй байдлын шинэ чиг хандлага”
6	1995	174	110	“Жендер ба хүний хөгжил”
7	1996	174	113	“Эдийн засгийн өсөлт ба хүний хөгжил”
8	1997	175	101	“Ядуурлыг арилгахын төлөө хүний хөгжил”
9	1998	174	101	“Хүний хөгжлийн хэрэглээ”
10	1999	174	119	“Хүний төлөв байдлын даяарчлал ”
11	2000	174	117	“Хүний эрх ба хүний хөгжил”
12	2001	162	116	“Хүний хөгжилд зориулагдсан шинэ технологийн бүтээл бүтээх нь”
13	2002	177	114	“Задарч буй дэлхийд ардчиллыг гүнзгийрүүлэх нь”
14	2003	175	117	“Мянганы хөгжлийн зорилт: Хүн төрөлхтөний ядуурлыг эцэс болгохын тулд улс үндэстнүүд хоорондоо ойртон нягтрах нь”
15	2004	177	117	“Өнөөгийн олон талт дэлхий ертөнцийн соёлын эрх чөлөө”
16	2005	177	114	“Олон улсын хамтын ажиллагааны уулзвар: Тэнцвэргүй дэлхий дэх тусламж, худалдаа, аюулгүй байдал”
17	2006	177	116	“Хэт хомсдол: Эрх мэдэл, ядуурал ба усны гачаалын даяарчлал”
18	2007	177	114	“Цаг уурын өөрчлөлттэй тэмцэх нь: Хуваагдаж буй дэлхий дэх хүн төрөлхтөний эв санааны нэгдэл”

илтгэл нь хөдөлмөр эрхлэлт ба ядуурлын асуудлыг хөндсөн байна. Түүнчлэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, НҮБХХ, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, Удирдлагын академи, Монгол Улсын Их сургууль хамтран хүний хөгжлийн суурь мэдлэг, Монгол Улс дахь хүний хөгжлийн байдал, ирээдүйн чадавхи, боломж, төрийн бодлогын талаар өгүүлсэн “Хүний хөгжил” нэртэй сурах бичгийг 2006, 2007 онд эрхлэн гаргажээ.

Дэлхийн хэмжээнд 1990-2008 оны хооронд жил бүр Монгол Улс хэдэн улсаас хүний хөгжлийн индексээрээ хэддүгээр

байрт орж байгааг дараахь хүснэгтээр харьцуулан үзүүлж байна⁶².

Дэлхийн хүний хөгжлийн илтгэлийн 2007, 2008 оныхыг нэгтгэн 2008 онд гаргасан бөгөөд харин улс орнуудын хүний хөгжлийн индексийг нь дурдсан онуудад тус бүрт нь гаргасан байна.

Дэлхийн улс орнуудыг (2008 оны байдлаар) хүний хөгжлийн индекс тогтоосон түвшингөөр нь дээд /1-75 дугаарт/, дундаж /75-153 дугаарт/, доод /154-аас хойш/ гэж 3 ангилан эрэмбэлж байгаа бөгөөд манай Монгол Улсын хувьд

⁶² <http://www.hdr.undp.org/statistics>

дундаж түвшний ангилалд орж байна. Монгол Улс ХХИ-ээрээ нэлээд хойгуур эрэмбэлэгдсэн шалтгаан нь нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, иргэдийн дундаж наслалт доогуур үзүүлэлттэй байгаа явдал юм. Гэхдээ иргэдийн боловсролын түвшингөөрөө харьцангуй дээгүүр байр эзэлдэг.

3.2. Хүний аюулгүй байдал

Хүний аюулгүй байдал нь айх аюулгүй, гачигдах дутагдахаас ангид байх эрх чөлөө гэсэн хоёр бүлэг ухагдахууныг агуулж байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн тухай олон улсын пактын удиртгал тус бүрт айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх чөлөөт бие хүний зорилгыг тодорхойлж, энэ зорилгыг хэрэгжүүлэх үүргийг олон улсын гэрээний оролцогч улс бүр хүлээн зөвшөөрсөн байдаг.

1980-аад оны сүүлч хүртэл капиталист, социалист нийгмийн тогтолцооны ялгаанаас үүдэлтэйгээр жишээ нь 1949 онд байгуулагдсан Умард Атлантын цэргийн эвсэл-НАТО, 1956 онд байгуулагдсан Варшавын гэрээний улсуудын гэх мэтийн цэрэг-улс төрийн бүлэглэлийн аюулгүй байдал, улс орны үндэсний аюулгүй байдлын асуудал хурцаар хөндөгдөж байсан.

Харин “хүйтэн дайн” төгсгөл болсноор нийгмийн тогтолцооны ялгаа хоорондын дайсагналцах үзэл үндсэндээ арилж, 1990-ээд оны эхэн үеэс, тухайлбал 1994 онд анх удаа НҮБХХ-ийн Дэлхийн хүний хөгжлийн илтгэл нь “Хүний аюулгүй байдлын шинэ чиг хандлага” сэдэвтэйгээр бэлтгэгдэн гарсан нь дэлхийн хэмжээнд болон улс орны үндэсний аюулгүй

байдлын хүрээнд “хүний аюулгүй байдал” гэсэн ухагдахуун түгэн дэлгэрч, улмаар улс орнуудын гадаад, дотоод бодлогодоо баримтлах үзэл баримтлалын чиглэлийн нэг боллоо.

Тодорхойлолт:

НҮБ-ын Хүний аюулгүй байдлын зөвлөлөөс “Хүний амьдралын утга учрыг хүний эрх, эрх чөлөө, сэтгэл хангалуун байдлаар тодорхойлно.

Хүний аюулгүй байдал гэдэг нь хүмүүний амьдралын гол утга учир болох үндсэн эрх чөлөөг хамгаалахыг хэлнэ. Энэ нь хүнийг хямралт байдал, аюултай орчноос хамгаалахыг хэлнэ. Энэ нь улс төр, нийгэм, хүрээлэн буй орчин, эдийн засаг, батлан хамгаалах, соёлын системийг цогцлон бүтээж, улмаар нэр төртэй аж төрөх нөхцөл бий болгохыг хэлнэ.” гэж хүний аюулгүй байдлыг тодорхойлжээ⁶³.

Хүний аюулгүй байдал гэж юу вэ? Хамгийн энгийнээр хэлбэл энэ нь дэлхийд эрэгтэй, эмэгтэй хэн боловч мөрөөдөн хүсдэг зүйлс, тухайлбал, өрх гэрийнхнээ хүрэлцээтэй хоол хүнсээр хангах, боломжийн орон байртай байх, эрүүл энх байх, үр хүүхдээ эрдэм номд сургах, бусад хүмүүс болон байгалиас учруулж болох аюул заналаас хамгаалагдсан байх, төр засаг нь иргэд хүмүүсээ дарлан хавчдаггүй, харин тэднийхээ санал бодолд нийцүүлэн засаглалаа хэрэгжүүлдэг байхыг хэлнэ⁶⁴.

НҮБ-аас хүний аюулгүй байдал үндсэн 7 хэсгээс бүрэлдэн тогтохыг тодорхойлсон байдаг.

Үүнд:

⁶³ “Монгол Улсын эдийн засаг, экологийн эмзэг байдал ба хүний аюулгүй байдал” товхи.мол, 2005 он, 12 дахь тал.

⁶⁴ “Глобальчлалын эрин дэх хүний аюулгүй байдал” олон улсын бага хурлын илтгэлийн эмхтгэл, УБ., 2000 он, 270 дахь тал.

- Эдийн засгийн аюулгүй байдал;
- Хүнсний аюулгүй байдал;
- Эрүүл мэндийн аюулгүй байдал;
- Байгаль орчны аюулгүй байдал;
- Хувийн аюулгүй байдал;
- Хамт олны аюулгүй байдал;
- Улс төрийн аюулгүй байдал.

Тэгвэл Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.” хэмээн тодорхойлоод түүний бүрэлдэхүүн хэсгийг дараахь байдлаар тогтоож өгсөн байна:

- Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;
- нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;
- иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;
- эдийн засгийн аюулгүй байдал;
- шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;
- мэдээллийн аюулгүй байдал;
- монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;
- хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;
- экологийн аюулгүй байдал.

Эндээс үзвэл хүний аюулгүй байдал нь улс орны үндэсний аюулгүй байдалтай нягт уялдаатай нь харагдаж байна. Олон улсын түвшинд улс бүр үндэсний аюулгүй байдалд тусгаар тогтнол, оршин тогтнох газар нутгийн бүрэн бүтэн байдалтай холбогдсон аюулгүй байдлыг оруулдаг бөгөөд үүнд санал нэгтэй хандаж байдаг.

Харин хүний аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байх ёстой, эсхүл энэ хоёр зэрэгцэн байх ёстой гэсэн өөр өөр байр сууриас үзэж байна. Энэ нь улс орон бүрийн хөгжлийн, хүний хөгжлийн түвшин, хүний эрх, эрх чөлөө хэр хангагдаж байгаагаас шалтгаалж байна. 2000 оны 5 дугаар сард Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ, Шведийн олон улсын хөгжлийн агентлаг, “Очирбат сан” төрийн бус байгууллага хамтран “Глобальчлалын эрин дэх хүний аюулгүй байдал” сэдэвт олон улсын бага хурлыг зохион байгуулж, хүний аюулгүй байдлыг тойрсон 20 гаруй сэдвээр АНУ, БНСУ, Дани, Канад, ОХУ зэрэг гадаадын 8 улсын, түүнчлэн олон улсын байгууллагын болон дотоодын олон улсын хөгжил, аюулгүй байдлын судлаач мэргэжилтнүүд илтгэл тавьж хэлэлцүүлсэн юм. Энэхүү олон улсын бага хурлын төгсгөлд хүний аюулгүй байдлын ерөнхий ойлголт, үндсэн элемент, эдийн засаг, нийгэм, экологийн⁶⁵

асуудал, мэдээлэл, мэдээллийн технологи, Монгол Улсын хөгжлийн гадаад хүчин зүйлст хүний аюулгүй байдал ба үндэсний аюулгүй байдлын нөлөөллийн гэсэн 6 үндсэн чиглэлээр зөвлөмж гаргасан юм.

Олон улсын бага хурлын зөвлөмжийг Монгол Улсын Засгийн газар хүлээн авч, 2001 онд “Хүний аюулгүй байдлын төлөөх сайн засаглал хөтөлбөр”-ийг баталж, төрийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх, ард түмэндээ үр нөлөөтэй, шуурхай үйлчилж, тэдний үндсэн хэрэгцээг хангах, шударга ёсыг хэвшүүлэн сайн засаглалыг бүрдүүлэх

⁶⁵ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, 2001 он, 3.1, 3.4 дэх хэсэг, түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 1994 оны 56 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 2, 5 дахь хэсэгт тодорхойлсон байна.

зорилгыг дэвшүүлсэн. Энэ хөтөлбөрт Монгол Улсын хүний аюулгүй байдалд нөлөөлөх аюулыг харилцан уялдаатай цогц асуудлууд гэж тодорхойлоод үүнийг сайн засаглалаар дамжуулан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн. 2004 онд Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын шинжээчдийн тусламжтайгаар өөрийн улсынхаа эдийн засаг, экологийн эмзэг байдал хүний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгаа талаар 2 төрлийн судалгааг анх удаа явуулж, эдийн засгийн эмзэг байдлаараа хөгжиж байгаа 112 орны дотор 20 дугаар байрт оржээ.

4. Хүний эрх, эрх чөлөө, хүний хөгжил, хүний аюулгүй байдлын харилцан хамаарал

Эдгээр нэр томъёо - ухагдахууныг өмнө дурдсан тодорхойлолтыг нь үндэслэн маш товчоор илэрхийлбэл:

Хүний эрх, эрх чөлөө - боломж, чөлөөт бие хүний эрхэм зорилго;

Хүний хөгжил - үйл явц, үр дүн;

Хүний аюулгүй байдал – баталгаа буюу нөхцөл хангагдсан орчин.

Хүний эрх, эрх чөлөөг төр, шашин, хэн нэг этгээдээс олгодоггүй. Тэр нь хүнд өөрт нь байдаг, салшгүй боломж юм. Хүний эрх, эрх чөлөө, хүний хөгжил, хүний аюулгүй байдлыг хангах нь төрийн бодлогын нэн тэргүүнд тавигдах асуудал байх ёстой. Энэ 3 багц ухагдахууны нийтлэг шинж бол хүн рүү чиглэгдсэн, хүнд төвлөрсөн, нөгөө талаар тэдгээрийг хангахад ямар нэгэн хүрэх ёстой түвшин, хязгаар, тулж очих “хана, дээвэр” байхгүй. Учир нь “Хүний эрхийн билл” хэмээн нэрлэгдсэн олон улсын баримт бичгүүдийн оршил тус бүрт хүн бүр улс төр, иргэний, эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ адил эдлэх нөхцөлөөр хангагдаж байж, айх аюулгүй, гачигдах зовлонгүй байх чөлөөт бие хүний эрхэм зорилго биелэгдэхийг тодорхойлсон. Энэ өгүүлбэрээр л тэрхүү 3 ухагдахууны харилцан хамаарал, уялдаа холбоог илэрхийлж болж байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

АЖЛЫН БАЙРАН ДАХЬ БЭЛГИЙН ДАРАМТЛАЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ШААРДЛАГАТАЙ БАЙНА



Монголын Эмэгтэйчүүдийн сангийн захирал, хуульч Найдандоржийн Чинчулуун

Ажлын байран дахь бэлгийн дарамтлалд өртөж, хохирсон хохирогчийн эрхийг хамгаалах үр дүнтэй механизм бүрэлдэн тогтоогүй нийгэмд энэ нь далд, нуугдмал байдаг учраас хүний эрхийн ноцтой зөрчлийн нэг болж байна.

Монгол Улсын хувьд энэ зөрчлийг таслан зогсоох эрх зүйн зохицуулалт боловсронгуй биш, уг зөрчлийг шийдвэрлэх практик тогтоогүй, олон нийтийн мэдлэг, боловсрол хангалтгүй байна.

Цаашид уг асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчинг бий болгох олон талт ажил зайлшгүй шаардлагатай гэжээ.

“Хүний эрх” сэтгүүлийн 2006 оны №03-т нийтлэгдээс байсан болно.

THERE IS A NEED OF POLICY AND LEGISLATIONS TO SOLVE SEXUAL HARASSMENTS IN WORK PLACES

N.Chinchuluun, Director of Women's Foundation of Mongolia and Lawyer

Insufficient and ineffective mechanisms for protecting the rights of people who suffered sexual harassment in the workplace amount to serious, though often hidden, human rights violations. In Mongolia the laws concerning this issue are not sufficiently developed, and a practice for solving such cases has not yet been established. Additionally, there is no sufficient public awareness of the issue. Thus, it is essential to conduct activities involving multipartite efforts in order to create policy and legislations for the solutions to this problem.

This article was published on the issue No 03 of “Human Rights” journal in 2006

Бэлгийн дарамтлал нь ажлын байр, олон нийтийн газар бусдыг хүсээгүй байхад бэлгийн сэдэлттэйгээр хэл амаар доромжлон тохуурхахаас эхлээд шахалт дарамт үзүүлэх замаар бэлгийн харьцаанд оруулах хүртэл үйлдэгддэг гэмт хэрэг юм. Ажлын байран дахь бэлгийн дарамтлал (sexual harassment)-д өртөж хохирсон хохирогчид нь сэтгэл зүйн болон бие махбодийн хүнд дарамтад ордог. Хохирогчид нэр хүнд үнэлэмжээ алдахаас сэргийлж уг асуудлыг гаргаж тавихаас эмээдэг бөгөөд бэлгийн дарамтлалд өртөж хохирсон хохирогчийн эрхийг сэргээх үр дүнтэй механизм бүрэлдэж тогтоогүй нийгэмд энэ нь далд, нуугдмал байдаг хүний эрхийн ноцтой зөрчлийн нэг юм.

2003 онд ХЭҮК-оос хийсэн судалгаагаар хөдөлмөр эрхэлж байгаа хоёр эмэгтэй тутмын нэг нь ажлын байран дахь бэлгийн дарамтлал (АББД)-д өртдөг гэжээ. Хохирогчдын ихэнх нь эмэгтэйчүүд, охид байдаг хэдий ч эрчүүд ч бас үүнд тодорхой хэмжээгээр өртдөг. Хөдөлмөр эрхлэлтийн салбарт гарч байгаа бэлгийн дарамт байнга давтагдаж улам бүр хурцдаж, лавширч байдгаас хохирогчийн өөрийгөө үнэлэх үнэлэмж болоод бусад хүмүүсийн зүгээс тухайн хүнд хандах хандлагад сөргөөр нөлөөлж улмаар хохирогчийн хөдөлмөрийн бүтээмжийг бууруулаад зогсохгүй ажлаа орхих, үндэслэлгүйгээр халагдах, эсвэл тухайн саналыг хүлээн авахаас өөр аргагүй байдалд хүрэх зэргээр үүдэн гарч буй үр дагаврууд нь маш ноцтой байдаг.

Иймд АББД-ын илрэх хэлбэрийг дараах байдлаар та бүхэнд танилцуулахыг хүсэж байна.

1. Аман хэлбэрээр үйлдэгддэг. Жишээ нь: “тэрний хөх нь тийм, энэний өгзөг нь тийм, тэр лав бэлгийн ажилдаа тийм байгаа”, “Чи миний хэлснээр бэлгийн таашаал үзүүлэхгүй бол би чамайг ажлаас хална, цалинг чинь хасна эсвэл өгөхгүй” гэх мэтээр заналхийлэх, айлгах, сүрдүүлэх нь аман хэлбэрийн бэлгийн дарамтлал болно.

Мөн ажил олгогч нь ажилтныхаа бие галбирыг ил гаргаж үзүүлэхийг шаардах, биеийг нь шинжих, илт садар самуунд уруу татсан зурагт хуудас үзүүлэх, дур хүслийг нь өдөөх дуу хэллэг ашиглах, шөнийн цэнгээний газар явах, бэлгийн харьцаанд орохыг шахаж шаардах нь уриалах дарамт буюу аман хэлбэрийн дарамтанд орно. Австралийн Хүйсээр ялгаварлан гадуурхахын эсрэг Хуульд: “ажлын байранд бэлгийн шинжтэй хүлээж авашгүй зан авирыг амаар болон бичгээр гаргахыг АББД гэж хэлнэ” гэж хуульчилжээ.

2. Үйл хөдлөл, бие махбодийн хэлбэрээр үйлдэгддэг дарамт бий. Өлөн нүдээр ширтэх, бэлгийн шинжтэй дохио зангаа өгөх, биеийн эмзэг хэсгүүдэд хүрэх, базах, үнсэх, тэврэх, биеэр довтлох, хувцас эд зүйлсийг урж гэмтээх, хүчиндэх нь энэ төрлийн хүчирхийлэлд орно.

Хүчээр бэлгийн харьцаанд оруулснаас үүдэж эмэгтэй жирэмслэх тохиолдол их байдаг. ОХУ-ын Эрүүгийн хуульд: Бэлгийн шинжтэй үйлдлүүдэд хохирогчийг айлган сүрдүүлэх, албадан тулгах, эд зүйлийг гэмтээх, сүрдүүлбэл гэмт хэрэг үйлдсэнд тооцож хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 200-300 дахин нэмэгдүүлж торгох, түүнтэй тэнцэх хэмжээний хөдөлмөр хийлгэх, эсвэл

хоёр жил ЗХА хийлгэнэ гэж заасан байна. Мөн зайлшгүй хамаарах дараах 2 асуудал байна. Үүнд:

1. Бэлгийн дарамтлал “үйлдэгчид” гэж хэн бэ? Энэ нь ажил олгогчид, менежер, инженер техникийн ажилтнууд, дунд тушаалын албаны дарга нар, багш, дасгалжуулагчид гээд ер нь эрх мэдэл, нөлөө бүхий хүмүүс байж болзошгүй байдаг.

2. “Ажлын байр” гэж зөвхөн хөдөлмөр эрхэлдэг орон зайн тухай биш, ажлын байранд хамаарах орчин, хүмүүсийн харилцааг авч үздэг. Боловсрол, мэргэжил олгох салбар, бараагаар хангах үйлчилгээ үзүүлэх газар, олон нийтийн газар, нийтийн тээвэр, барилга байгууламж, орон байр, орон сууц, тариалангийн талбай, малын бэлчээрийн газар ч хамаарахаар заасан байдгийг олон орны эрх зүйн баримт бичгүүдээс харж болно.

Улс орнуудад АББД-ыг янз бүрийн механизмаар зохицуулдаг ч эцсийн шийдвэр нь адилхан байдаг. Жишээ нь:

1. Хохирогчийн гомдлыг хүлээн авах, шалгах, хариуцлага тооцох асуудлыг Австрали, Канад улсуудад Хүний эрхийн Комисс, АНУ-д Хөдөлмөрийн тэгш бололцооны комисс шийдвэрлэдэг байна. Ихэнх тохиолдолд эвлэрүүлэх арга хэмжээ авдаг. Үүний үр дүнд уучлалт гуйлгах, материаллаг хохирол төлүүлэх, ажилд нь эргүүлэн тогтоох, шилжүүлэх, байгууллагын дотоод дүрэм журманд өөрчлөлт оруулах, амлалт авахуулах, сургалтанд хамруулах зэрэг арга хэмжээ авдаг.

2. ӨАБНУ болон Малайзад “АББД-ын эсрэг дагаж мөрдөх ёс зүйн журам” (Меморандум) хэлбэрээр шийдвэрлэдэг

бол ихэнх нь Хүний эрхийн хуулиар зохицуулдаг.

Сүүлийн жилүүдэд улс орнуудад (Филлиппин, Малайз гэх мэт) бие даасан хууль гаргаж байгаа бөгөөд энэ нь ихээхэн үр дүнтэй байна гэж судлаачид үзэж байна.

Манай улсын хувьд энэ зөрчлийг таслан зогсоох эрх зүйн зохицуулалт боловсронгуй биш, уг зөрчлийг үр дүнтэйгээр шийдвэрлэх практик тогтоогүй, энэ асуудлаарх олон нийтийн мэдлэг боловсрол хангалтгүй байдаг зэрэг бусад олон сөрөг хүчин зүйлүүд байсаар байна.

Манай улсын тухайд АББД-ын хэлбэрийг тодорхойлоогүй, ажлын байранд бэлгийн дарамтлал үйлдэхийг хориглоогүй, АББД үйлдэгдсэн тохиолдолд ямар хариуцлага хүлээх, хэрхэн урьдчилан сэргийлэх талаар тодорхой заасан заалт байхгүй. Тиймээс энэ асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчинг бий болгох олон талт ажил зайлшгүй шаардлагатай.

Юуны түрүүнд:

1. Бие даасан хууль гаргах боломжийг судлах. Аль болох бие даасан хуультай болох,

2. Одоо мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах,

3. Дээрх хоёр заалт цаг хугацаа шаардагдана гэж үзвэл дор хаяж “АББД-ын эсрэг дагаж мөрдөх журам”-ыг зайлшгүй гаргах шаардлагатай байна. Эдгээр эрх зүйн орчинг сайжруулсны үр дүнд:

1. Ажлын байранд хамаарах орчинд бэлгийн дарамтлал үйлдэх нь “хууль бус” болох нь тодорхой болно.

2. Албан тушаалтан болон хамтран ажиллагсдын зүгээс албаны эрхээ хувийн ёс зүйгүй байдлаа илэрхийлэх зэвсэг болгож байгаа байдал таслан зогсоогдоно.

3. Үйлдвэрчний Эвлэл болон Оюутны зөвлөлийн гүйцэтгэх үүрэг функц сайжирч олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн дотоод журам үйлчилнэ. Ажил олгогч, ажилтнууд, багш сурагчдын мэдлэг дээшилж ажлын аюулгүй болон сэтгэл санааны хохирлоос чөлөөтэй ажлын орчин бүрдэнэ. Ажилтнуудаар дамжуулан нийгмийн ухамсар дээшилнэ.

4. Зөвлөгөө, туслалцаа үзүүлэх албад ажиллах боломж нээгдэнэ. (өмгөөллийн товчоод, эрүүл мэнд, бэлгийн халдлагад

ортогсдод зөвлөгөө өгөх газрууд гэж ойлгож болно.)

5. Гомдол барагдуулах механизм тодорхой болно. Хохирогчдын дунд хийсэн судалгаагаар байгууллагын дотор байдаг Хөдөлмөрийн маргаан таслах комисс болон Шүүхээр шийдвэрлүүлэхийг хүсдэггүй.

Харин Хүний эрхийн Үндэсний Комиссоор шийдвэрлүүлэхийг илүүд үздэг байна. Хөдөлмөрлөж, сурч байгаа хэн ч ямар нэгэн айдас түгшүүргүй орчинд сурлага, хөдөлмөрөө тэгш, шударгаар үнэлүүлэх ёстойг НҮБ-аас баталж гаргасан Хүний эрхийн Конвенциуд, Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын дүрэм журмуудад тодорхой заасан байдаг.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“МОНГОЛ УЛС ДАХЬ УУЛ УУРХАЙ БА ХҮНИЙ ЭРХ” СЭДЭВТ ҮНДЭСТНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БАРИМТ БИЧИГ

Хүний Эрх Хөгжлийн Төвөөс НҮБ-ын Суурин төлөөлөгчийн газар, НҮБ-ын Хүний Эрхийн Бүлгийн санаачлагаар “Монгол Улс дахь уул уурхай ба Хүний эрх” сэдэвт үндэстний хэлэлцүүлэгт зориулан энэхүү баримт бичгийг бэлтгэжээ.

Хэлэлцүүлгийн баримт бичигт уул уурхай ба хүний эрхтэй холбоотой зангилаа асуудлуудыг үндэстний хэмжээнд тодорхойлсон юм. Хэлэлцүүлгийн баримт бичигт энэ салбар дахь байгаль орчин ба хүний эрхийн асуудлыг амжилттай шийдвэрлэж байгаа бусад орны туршилагыг харуулах, мөн Монгол Улсад уул уурхайн хөгжлийг хэрхэн байгаль орчин, хүний эрхийн асуудалтай зохицуулж болох талаар зөвлөмж боловсруулан тусгасан байна.

Энэхүү баримт бичиг нь “Хүний эрх” сэтгүүлийн 2006 оны №02-т нийтлэгдэж байсан болно.

DISCUSSION PAPER FOR THE NATIONAL DIALOGUE “MINING AND HUMAN RIGHTS IN MONGOLIA”

This paper was prepared by the Center for Human Rights and Development for the national dialogue on the initiative by the United Nations Resident Representative's Office and the United Nations Human Rights Team Group. In the paper, the key issues related to mining and human rights in Mongolia were determined. The discussion paper includes recommendations on considering other countries' good practice in successfully solving environmental and human rights problems in the mining sector and on balancing development of the mining sector with environment and human rights concerns.

The discussion paper was published on the No 02 of “Human Rights” journal in 2006.

Оршил

Монгол Улс 2000 оны 9 дүгээр сард “Мянганы Тунхаглал”-ыг баталсан 189 улс үндэстний нэг болсон юм, Мянганы Тунхаглал нь Мянганы Хөгжлийн найман Зорилгыг агуулдаг. Монгол Улсын хувьд Мянганы Хөгжлийн 9 дэх шинэ зорилгыг Улсын Их Хурлын 2005 оны чуулганаар баталсан билээ. Мянганы Хөгжлийн 7 дахь зорилго нь “байгаль орчны тогтвортой байдлыг баталгаажуулах” ба 9 дэх зорилго нь “хүний эрхийг бэхжүүлж, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” гэж тодорхойлжээ. Энэ хоёр зорилго нь хамтдаа Монгол Улсад хүний эрх, ардчилал, уул уурхайг хөгжүүлэхтэй холбоотой.

Долоо дахь зорилгын, 10 дахь зорилт “тогтвортой хөгжлийн зарчмыг улсын бодлого, хөтөлбөрт тусган, байгалийн нөөцийн алдагдлыг нөхөн сэргээх”, 9 дэх зорилгын 20 дахь зорилт нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг хүндэтгэн бүрэн хэрэгжүүлж, хэвлэл мэдээллийн эрх чөлөө болон олон нийтийн мэдээлэл авах эрхийг хангах”, мөн зорилгын 21 дэх зорилт нь ардчиллын зарчмыг амьдралд нэвтрүүлэх”, 22 дахь зорилтод “нийгмийн бүх салбарт авилгалыг үл тэвчих орчинг бүрдүүлэх” гэж заажээ. НҮБ-ын Хүний Эрхийн Бүлэг (ХЭБ)-ийн сүүлийн (2005 оны 10 дугаар сарын 21) хуралд оролцогчид уул уурхайн

салбар сүүлийн арван жилд эрчимтэй хөгжиж, Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн боловч энэхүү эдийн засгийн өсөлт нь Монгол Улсад “байгаль орчны тогтвортой байдлыг хангах” гэсэн Мянганы Хөгжлийн 7 дахь зорилго, эсхүл “хүний эрхийг бэхжүүлэх” гэсэн Мянганы Хөгжлийн 9 дэх зорилготой нийцсэнгүй.

Оролцогчид байгаль орчинд учруулсан хохирол болон Монгол Улсын Мянганы Хөгжлийн Зорилгыг биелүүлэхэд улам их бэрхшээл үзүүлэх болсон уул уурхайн үйл ажиллагаанаас зөрчигдсөн орон нутгийн иргэдийн хүний эрхийн асуудлыг хэлэлцсэн. Эдгээр бэрхшээл, хүндрэлийг шууд, нээлтэй хэлэлцсэнээр Монгол Улс олон улсын норм, стандартын дагуу байгаль орчин болон иргэдээ хамгаалж, эдийн засгийн тогтвортой хөгжлөө хангах чадвартай болоход нэмэр болно гэж үзжээ.

Иймээс НҮБ-ын Хүний эрхийн байгууллага “Монгол Улс дахь Уул Уурхай ба Хүний Эрх” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийг зохион байгуулах шийдвэр гаргасан юм. Энэ хэлэлцүүлгийн гол зорилго нь Монгол Улсын уул уурхайн тогтвортой хөгжлийг хангах хүрээнд байгаль орчин, хүний эрхийг сахин хамгаалах чиглэлээр үр дүнтэй хамтын ажиллагаа, түншлэлийг бий болгох, уул уурхайн хөгжлийг цаашид тогтвортой хангахад тулгарч байгаа олон зангилаа асуудлаар уул уурхайн салбар, төр засаг, иргэний нийгмийн байгууллагууд мэдээлэл солилцох, ойлголцлыг бий болгоход оршино хэмээн тодорхойлсон билээ.

Энэхүү хурлын шийдвэрийн дагуу НҮБ-ын Суурин Төлөөлөгчийн Газар, НҮБ-ын ХЭБ хамтран уул уурхайн салбарт гарч байгаа хүний эрхийн асуудлыг судлах, үндэсний хэлэлцүүлэгт зориулсан баримт бичиг бэлтгэх ажлыг Хүний Эрх Хөгжил Төвөөр гүйцэтгүүлсэн юм. Хэлэлцүүлгийн баримт бичгийн гол зорилго нь уул уурхай ба хүний эрхтэй холбоотой зангилаа асуудлуудыг тодорхойлоход оршиж байв.

Энэ дагуу судалгаанд уул уурхайн компаниуд, хувиараа алт олзворлогчид, уул уурхайн сөрөг үр дагавраас нутаг усаа хамгаалах гэсэн иргэдийн хөдөлгөөнүүд, Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын болон нийтийн эрүүл мэнд, байгаль орчны асуудлаар ажилладаг шинжлэх ухааны байгууллагуудын төлөөлөгчид, Архангай аймгийн Цэнхэр сум, Дорнод аймгийн Баяндун сум, Өмнөговь аймгийн Мандал Овоо сум, Төв аймгийн Заамар сумын малчид, иргэд, баг, сум, аймгийн түвшний удирдлага, хувиараа алт олборлогч нартай ганцаарчлан уулзах, бүлгийн ярилцлага зохион байгуулах замаар мэдээлэл авч боловсруулав.

Аймгуудад өрнөж байгаа ашигт малтмал олзворлох үйл ажиллагааны тухай ерөнхий мэдээллийг НҮБ-ын хүний эрхийн сайн дурын ажилтнуудын тусламжтайгаар 13 аймгаас авав.

Хэлэлцүүлгийн баримт бичгийг гаргахдаа оролцогч бүх талуудын ашиг сонирхлыг хүндэтгэж, хүний эрх ба байгаль орчныг хамгаалах зарчмыг уул уурхайн салбарын хөгжилтэй хэрхэн зохистойгоор уялдуулах тухай тэдний санаа бодлыг тусгах зарчмаар

ажиллав. Түүнчлэн уул уурхайн салбарт байгаль орчин ба хүний эрхийн талаар гарч буй зөрчлүүд, түүнд холбогдох талууд хэрхэн хандаж, шийдвэрлэж байгаа мэдээллийг цуглуулж, кейс анализ хийлээ.

Хэлэлцүүлгийн баримт бичигт дээрх чиглэлээр цуглуулсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээнээс гадна уул уурхайн салбарт оролцогч олон талын бүтээлч хамтын ажиллагааг бий болгох замаар энэ салбар дахь байгаль орчин ба хүний эрхийн асуудлыг амжилттай шийдвэрлэж байгаа бусад орны туршлагыг харуулах, мөн Монгол Улсад уул уурхайн хөгжлийг хэрхэн байгаль орчин, хүний эрхийн асуудалтай зохицуулж болох талаар зөвлөмж боловсруулан тусгав.

Уул уурхайн салбараас байгаль орчинд үзүүлсэн сөрөг үр дагавар

Монгол орон өргөн дэлгэр нутагтай, цөөн хүн амтай, олон төрлийн ашигт малтмалын баялаг орд газруудтай. 1997 оноос ашигт малтмалын тухай хууль “Монгол улс дахь Уул Уурхай ба Хүний Эрх” сэдэвт үндэстний хэлэлцүүлгийн баримт бичиг батлагдан, Засгийн Газрын “Алт” хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн. Үүний дүнд уул уурхайн салбар өргөжин улсын эдийн засгийн тэргүүлэх секторын нэг болсон.

Улсын хэмжээгээр хүчин төгөлдөр байгаа лицензийн тоо 6171 бөгөөд нийт талбайн хэмжээ нь 71107888,66 га болж байгаа нь Монгол орны нутаг дэвсгэрийн 45-аас дээш хувийг эзэлж байна. Үүнээс 5172 хайгуулын лиценз 70901641,1 га, 999 ашиглалтын лиценз 206247.56 га газрыг хамарч байна.

Ашиглалтын лицензийг байгалийн үзэсгэлэнт газар, усны хагалбар газар, хамгаалбал зохих амьтан, ургамалтай газар зэргийг харгалзахгүй олгож байгаагаас Монгол орон өнөө үеийн болон хойч ирээдүйнхээ өмнө нөхөж барахгүй хохирлыг бий болгосоор байна.

Замбараагүй лиценз олголт, уурхайн, ялангуяа алтны уурхайн ядмаг, байгаль орчинд халтай технологи, байгаль орчны үнэлгээ, нөхөн сэргээлтийг хуулийн дагуу хийж хэрэгжүүлдэггүй, уурхайн үйл ажиллагаанд мэргэжлийн болон орон нутгийн иргэдийн хяналт сул, бараг байхгүй байгаагаас уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөө түүнээс үүссэн хүний эрхийн зөрчил нэн тулгамдсан асуудал болоод байна. Уул уурхайн салбарт гарч буй хүний эрхийн зөрчил нь гол төлөв энэ салбараас байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөтэй холбоотой байна.

Уул уурхайн үйл ажиллагаанаас монгол орны байгаль орчин ихээхэн бохирдож, эвдэрч сүйтгэж байна⁶⁶. Энэ чиглэлээр хийсэн судалгааны тайлан, мэргэжлийн хүмүүс, малчидтай уулзаж ярилцахад монгол орны уур амьсгал, байгаль орчин ихээхэн өөрчлөгдөж, эвдэрч сүйрч байгаа бөгөөд үүний нэг гол шалтгаан нь уул уурхайн үйл ажиллагаа гэж дүгнэж байна. Байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөө юуны түрүүнд ус, бэлчээрийн хорогдол, элэгдэл, сүйтгэлээр илэрч байна.

Гол ус: Төв азийн өндөрлөг газар орших эрс, тэс уур амьсгалтай Монгол орон усны нөөцөөр баялаг бус бөгөөд жилдээ орох

Хүснэгт 1. Монгол орны гадаргын усны тооллогын нэгдсэн дүн

Гол горхи		Булаг шанд		Рашаан		Нуур, тойром	
Нийт	Ширгэсэн	Нийт	Ширгэсэн	Нийт	Ширгэсэн	Нийт	Ширгэсэн
5565	683	9600	1484	374	10	4193	760

хур тунадасны хэмжээ түүний зарим нутагт ундны усны хэрэгцээ ч хангадаггүй байна. Нэгж талбайд ногдох усны нөөцөөр бусад орнуудтай харьцуулахад нэн бага, 1 км2 талбайд ойролцоогоор 22 орчим мян.м3 ус ногддог ба дэлхийн 145 орноос усны бага нөөцтэй 23 орны өмнөхөн ордог байна⁶⁶. Түүний зэрэгцээ нүүдлийн мал аж ахуйн амин чухал хэрэгцээ нь гол, ус түүнээс тэтгэгдэж байдаг бэлчээр юм.

Гэтэл Монгол оронд хэрэглэж байгаа уул уурхайн технологи нь ус их хэрэглэдэг онцлогтой. Уул уурхайнууд, ялангуяа алтны уурхайн үйл ажиллагаанаас олон гол мөрөн, булаг шанд, газрын гүний ус, нуур цөөрөм бохирдож, ус нь татарч, ширгэж үгүй болж байна. 2003 оны Улсын усны тооллогын дүнгээр гадаргын ус нэлээд хорогдож, ширгэсэн гол горхи, булаг шанд, рашаан, нуур тойрмын тоо 3000 дөхөж байна.

Ийнхүү ус хомсдож байгаагаас орон нутгийн иргэд хүндхэн асуудлуудтай тулгараад байна. Үүний цорын ганц шалтгаан нь уул уурхай биш боловч байгаль орчинг шаардлагын дагуу хамгаалдаггүй уул уурхай эрчимтэй хөгжсөн нь гол хүчин зүйл болсон.

⁶⁶Тус ярилцлагын баримт бичгийн хүрээнд 14 аймгаас уул уурхай хийгээд хүний эрхийн зөрчилтэй холбоотой асуудлаар мэдээлэл бэлтгэсэн юм. Үүний дэлгэрэнгүйг Хавсралт 2-оос үзнэ үү.

Бэлчээр. Монгол орон 1.3 сая орчим хавтгай дөрвөлжин км бэлчээрийн талбайтай бөгөөд энэ нь бүх газар нутгийн 82 хувьтай тэнцдэг. Гэвч алтны уурхайн үйл ажиллагаанаас нэлээд их сүйтгэгдэж байна. Алт олзворлох үйл ажиллагаа усны эх үүсвэр бараадаж явагддаг болохоор гол, худаг, гүний ус хорогдож бэлчээрийн болон хадлангийн талбайн нөхөн сэргээлтэд харшилж байна. Учир нь уул уурхайн аливаа үйл ажиллагааны дараах байгаль орчны нөхөн сэргээлтийг шаардлагын дагуу хэрэгжүүлэхгүй байна.

Мөн усны хомсдолтой холбоотой бэлчээрийн хорогдлоос гадна малчдын өвөлжөө, хаваржаа, бэлчээрийн хамт ашиглалтын лицензийн талбайтай давхцах, уурхайн том машин механизмын зам, замын шороонд дарагдаж бэлчээр талхлагдах нь түгээмэл байна.

Уул уурхайн салбар дахь хүний эрхийн зөрчил

Уул уурхайн салбарын хүрээнд гарч буй хүний эрхийн зөрчлүүдийг оролцогч талуудын үзэл бодлоор үзвэл дараах байдалтай байна.

Малчдын бүлэг. Монгол улсын хүн амын бараг 30 орчим хувь нь мал аж ахуй эрхэлж амьдардаг билээ.

Энэ бүлэг нь Монгол орны нүүдлийн мал аж ахуйд суурилсан соёл, амьдралын өвөрмөц

хэв маягийг хадгалж байгаа хүн амын бүлэг юм.

Гэвч тэд уул уурхайн үйл ажиллагаанаас хамгийн их хохирч байгаа нийгмийн бүлэг болсон. Орон нутгийн иргэд, малчид тэдний амьдарч байгаа орон нутагт өсөн хөгжиж байгаа уул уурхайн салбараас, ялангуяа тухайн нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагаанаас ямар ч ашиг тус байхгүй байна хэмээн санал нэгтэй дүгнэж байна.

Ийм учраас тэд орон нутагтаа алтны уурхайг ажиллуулах ямар ч сонирхолгүй ажээ.

Хайрцаг 1. Уул уурхайн үйл ажиллагаанд өртсөн нутгийн малчдын ярианаас⁶⁷

...Манай нутагт ажиллаж байгаа алтны компаниудаас бид ямар ч ашиг олж харахгүй байна ...нутаг орон, гол усыг маань сүйтгэж, биднийг амьдрах аргагүй болгох юм.

...Засаг даргадаа за манай суманд л алт гарвал битгий өгч үзээрэй гэж хэлдэг.

Гэтэл байдлаас харахад харин ч бидний хүсэлтийн эсрэг. Алт гарлаа бид авна гээд компанийнхан ирвэл тэг ээ, ав гээд л гарын үсгээ зурдаг юм байна. Тэгээд ингэдэг юм байх даа л гэж бодох юм байна шүү дээ. Дарга нар л мэддэг, өгдөг, шийддэг юм байлгүй гэж л боддог шүү дээ.

...Бэлчээрийн даац, мал маллагааны асуудал их хүнд байна даа. Манай Орхон багийн алтны уурхай орсон нутгаас 40 гаруй өрх, 20000 гаруй толгой мал нүүхээс өөр аргагүйд хүрсэн. Алтны уурхай нутгийн малчин бидэнд үнэхээр муу үр дагавартай

юм байна лээ л гэж хэлэх байна. Тэгээд байгаль орчин, бидний амьдрах орчны тухай ярих ч үг алга. Одоо би бодож байх нээ бидний тэмцэл хууль дүрмээ мэдэхгүйгээс л их алдаж гэж бодож байна.

Эхлээд алтны компанийнхан бидний нутагт ирээд алт ухаж авч байхдаа их л олон зүйл амлаж байсан. Эсгий, эсгий гутал, эсвэл мужааны үйлдвэр барьж өгч ажлын байраар хангана, эмнэлэг барьж өгнө гээд л гэтэл одоо бид нүүхээс л өөр замгүй болж хохирч байх шив дээ. ...Малчин бидэнд хамгийн гол зүйл бол ус л байдаг. Одоо нөхөн сэргээлт хийлээ ч гэсэн тэр булаг, ус дахин гарна гэж бодохгүй л байна. Миний мэдэхийн дээрхтэй нийлээд лав л 5 булаг ширгээд байгаа. ...Нэг л мэдэхэд ямар нэг компани манай лицензтэй газар гээд л ороод ирдэг. Нутгийн бид нар юу ч мэдээгүй байхад хүрч ирээд л ухаад унахаар нүүхээс өөр аргагүй болдог.

... Бид нар юу ч мэдэх боломжгүй. Бид ямар газраа өгөхгүй гэж хэлж болох юм биш. Хамгийн сайхан ус, бэлчээртэй газруудад алт ухаж байна шүү дэг. Бид нар алтныханд шахагдаж нүүсээр байгаад нүүх суух газаргүй болж байна.

...Манай сумыхан сүүлийн тав, зургаан жил отроор нүүдэллэж байна. Бид сумаасаа 200-500 км алс орших зэргэлдээх аймаг, сумын нутагт оторлодог. Үүнээс болж манай сумын нэлээд өрх өөр аймаг, сум руу шилжсэн. Шилжих хүсэлтэй өөр олон айл өрх байгаа боловч шилжүүлэхгүй байгаа. Хүүхдийн сургууль, эмнэлгийн үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмжээ авах зэрэгт их чирэгдэл гарах болсон.

⁶⁷ Архангай аймгийн Цэнхэр сум, Дорнод аймгийн Баяндун сум, Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын малчидтай хийсэн яриллагаас

...Одоо надад тэвчиж суух арга алга, нүүх ч газар алга, хэрвээ одоо энэ нутагт маань алтны компани орж ирвэл буу зэвсгээ бариад тэмцэнэ дээ...

Тэдэнд тохиолдож буй хүний эрхийн асуудлууд. Хэдийгээр иргэний, улс төрийн, эдийн засаг, нийгэм соёлын хүний эрхийн олон төрлийн зөрчлийг дурдаж болох боловч дээрх ярилцлагаас тод харагдаж байгаа дараах хэдэн төрлийг дурдъя.

- Бэлчээр, ус нь сүйтгэгдэж мал аж ахуйгаа эрхлэн амьжиргаагаа авч явах эрх нь зөрчигдөхөд хүрч байна.

- Иймээс тухайн орон нутгийн ард иргэдийн эдийн засгийн боломж хумигдаж байхад оронд нь өөр боломж бий болгож амьжиргаагаа зохистой түвшинд байлгаж улмаар сайжруулах эрхийг зөрчиж байна.

- Хөрс, ус нь бохирдох, газрын гадаргууг эвдсэнээс эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх

- Ашиглалтын лицензийн үйл ажиллагаа эхлэх гэж байгаа тухай мэдээлэл авах эрх,

- Ашиглалтын лицензийн үйл ажиллагааг эхлэх зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргахад оролцох эрх

- Алсын отор хийснээр сурч боловсрох, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ авах эрхийн хэрэгжилт хүндрэх,

- Уул уурхайн үйл ажиллагаанаас сүйрсэн газар, усаа нөхөн сэргээх, хянахад оролцох эрх,

- Уламжлалт мал аж ахуйн аргаа орхиход хүрч байгаа нь хөгжлийн замаа өөрөө сонгож хөгжих эрх зэргийг хэрэгжихгүй байгааг дурдаж болно.

Малчдын хүний эрх ийнхүү зөрчигдөж байгаа нь Монгол улсын хууль байгаль

орчин, орон нутгийн иргэд, малчдыг зохих ёсоор хамгаалж чадахгүй байгаагай холбоотой юм.

Албан бус алт олборлогчид⁶⁸. Албан бус алт олборлогчдын талаар олон жил ярьж, олон судалгааны тайлан бичигдсэн. 2003 оны байдлаар Монгол Улсад 100.00069 гаруй хүн гар аргаар алт олборлож байна. Гар аргаар алт олборлогчидтой холбоотой асуудлууд нь шийдвэрлэвэл зохих асуудал болоод байгааг ярилцлагад оролцогч бүх талууд өгүүлж байна.

• Гар аргаар алт олборлогчдын эрх зүйн орчин өнөөг хүртэл шийдэгдээгүй, энэ төрлийн үйл ажиллагааг албан ёсоор хүлээн зөвшөөрөөгүй гэж үзэж болно.

• Одоогоор зохицуулж байгаа “гал унтраах” буюу түр зуурын шинжтэй дүрэм журам энэ төрлийн үйл ажиллагааны бүх төрлийн харилцааг зохицуулахад хангалтгүй нь илэрхий юм. Хувиараа алт олборлогчид нь алтны уурхай, лиценз эзэмшигч, цагдаа, орон нутгийн захиргаа, нутгийн иргэдтэй тогтмол зөрчилтэй байдаг ба тэдний зүгээс үргэлж дарамттай тулгардаг байна. Нэгэнт хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдөөгүй болохоор тэдний эрхийг хамгаалах, баталгаажуулах ямар ч боломжгүй ажээ.

• Эрүүл мэнд болон аюулгүй байдлыг хангах ямар ч дүрэм байхгүй болохоор албан бус аргаар алт олборлох нь маш аюултай үйл ажиллагаа юм. Тэдний нэгний хэлснээр: “...Энэ бол амь өрсөн хөдөлмөр. Өглөө гарсан хүн амьд ирнэ гэсэн ямар ч баталгаа байхгүй...”

• Гар аргаар алт олборлогчдын ажиллаж

⁶⁸Төв аймгийн Заамарын Сов буюу Өгөөмөр / хуучнаар Хайлаастай/ баг, Гео, 26 гэдэг нэртэй 3 газрын гар аргаар алт олборлогчид болон тэнд амьдарч буй оршин суугчидтай ярилцлага хийж мэдээллийг цуглуулав.

⁶⁹Grayson Robin, Ninja Gold Miners of Mongolia 2003, p.23

Хүснэгт 2. Хайгуулын болон ашиглалтын лиценз, сүйтгэгдсэн бэлчээр, гол усны тоо / бүрэн бус мэдээ/¹

№	Аймгийн нэр	Олгогдсон лиценз			Сүйтгэгдсэн бэлчээр (га)	Бохирдсон, ширгэсэн гол, гөрхи, нуур цоором, рашаан, худаг (тоогоор)
		Х	А	Нийт		
1.	Архангай	-	19		1 ¹	10 гаруй
2.	Баян-Хонгор	550	66	616	436.800	40 гаруй
3.	Баян-Өлгий	7	4	12	1.6	-
4.	Булган	-	-	15	8000	10
5.	Говь-Сүмбэр	14	2	16	-	45
6.	Дорноговь	577	55	632	1 ²	-
7.	Дорнод	-	-	25 ³		
8.	Дундговь	420	20	440	-	-
9.	Завхан	61	-	-	-	-
10.	Хэнтий	525	53	571	-	44
11.	Өвөрхангай	87	16	103	-	2
12.	Өмнөговь	340	22	362	24156	3
13.	Увс	32	133	165	9437.8	4

байгаа орчинд хүний эрхийн бүх зөрчил оршиж байна. Эрүүл аюулгүй орчинд амьдрах, амьд явах, эрүүл хоол хүнсээр хангагдах, эрүүл мэндээ хамгаалах, сурч боловсрох, сонгох, сонгогдох эрх зэрэг. Гэхдээ тэдэнтэй хийсэн ярилцлагаас үзэхэд тэднийг эрхээ хэрхэн хамгаалах тухай мэдээллээр хангах нь хамгийн чухал байна. Учир нь ийм мэдээлэлгүйгээр тэд өөрсдийнхөө байдлыг сайжруулах юу ч хийж чадахгүй.

Хүүхдийн хөдөлмөр. “Сургууль завсардсан хүүхдүүд маш олон. Насанд хүрээгүй хүүхдүүд алтанд гарч энэ хүнд хүчир хөдөлмөрийг бусдын адил хийж, шороонд дарагдаж үхэж байна. Хэн энэ болгоныг хайхарч байгаа юм?” гэж тэд асууж байна.

Байгаль орчны сүйтгэл бохирдолт. Гар аргаар алт олборлогчид, алтны компани хоёрын хэн нь илүү байгаль орчныг сүйтгэж байна? гэж асуухад “аль аль нь” хэмээн хариулж байна. Тэдний хариултаар аль нь ч байгаль орчны нөхөн сэргээлт хийдэггүй байна.

Түүнээс гадна гар аргаар алт олборлогчдын дунд мөнгөн ус хэрэглэх үзэгдэл түгээмэл, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчид эрүүл шинэ газар үйл ажиллагаагаа өргөжүүлэх болсон нь анхаарал татсан асуудал болоод байна.

Эдийн засгийн зохицуулалтгүй байгаа нь энэ төрлийн үйл ажиллагаанаас орох эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах шаардлагатай болжээ. Тэд олборлосон алтаа улсад тушаан, зохих татвараа төлөн үйл ажиллагаагаа албан болгох хүсэлтэй байна.

¹НҮБ-ын орон нутагт ажилладаг хүний эрхийн сайн дурын ажилтнуудын бэлтгэн ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан бэлтгэв.

² Өвөлжөө 11, хаваржаа 12, зуслан 20, намаржаа 15 нэрвэгдсэн, 10 га ой мод сүйтгэгдсэн, 2500 га галбайн ургамал, амьтаг устаж үгүй болсон.

³ Дорноговь аймагт одоогоор энэ талаар мэдээлэл байхгүй байна.

⁴ Энэ тоо нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг компаниудын тоо юм. Одоогоор 350 аж ахуйн нэгж, иргэнд хайгуул, олборлолтын лицензийг олгожээ.

Гар аргаар алт олборлогчид:**Нийтлэг зөрчлүүд .****• Цагдаа нинжа нарын хоорондох зөрчил:**

“Алтны ордыг ашиглаж дуусаад компани болон газар түрээслэгчид нинжа нарыг оруулна. Учир нь зарим тохиолдолд том техникээр биш гар ажиллагаа шаардагддаг байна. Тийм үед нинжа нарыг зөвшөөрч оруулаад алт илрэнгүүт хэн нэг нь газрын зөвшөөрөл, лицензийг аваад нөгөө нинжа нарыгаа цагдаа нарын тусламжтайгаар хөөж гаргана.

Энэ бол хамгийн сонгодог арга. Цагдаагийн байгууллагын дарга нарт нь авилга өгдөг, цагдаа нар тушаал биелүүлдэг. Гэхдээ цагдаа нар бас зүгээр нэг хөөхгүй, баривчилна, зодно бороохойдно. Тийм байж болох уу?” гэж судалгаанд хамрагсад ярьж байна.

Компани, нинжа нар: байнга зөрчил тэмцэлтэй байдаг. Энэ ч ойлгомжтой. Алтны төлөө өрсөлдөж, хүч сорин тэмцэцгээж байна. Компаниуд хөрөнгө мөнгө, техник хэрэгсэл, эрх дархтай. Дээр нь хууль, засаг захиргаа бүгдийг өөрийн ашигт нийцүүлж чадаж байна. Иймээс хууль бусаар гэсэн нэрийн дор хувиараа алт олборлогчид байнга хохирол амсаж байдаг.

Гар аргаар алт олборлогчдын хэлснээр:

“Ашигласан газартаа гар аргаар алт олборлогчдыг оруулдаг учир нь гэвэл 1 цаг бульдозер ажиллуулахад 10000 төгрөг, экскаватор - 30000 төгрөгийн үнэтэй байдаг. Иймээс тэд өөрийн газар дээр зөвшөөрсөн болж алт олборлогчдыг ажиллуулж, ямар ч үнэ төлбөргүй алтаа нээлгэжээд дараа нь

цагдаагийн хүчээр хөөлгөдөг бас л хүний хөдөлмөрийг цэвэрхэн ашиглачихдаг сонгодог аргын нэг байгаа биз...”

• **Лиценз эзэмшигч нинжа нарын хоорондох зөрчил:** Мөн дээрхтэй адил. Хэрэв энэ асуудлыг шийдэх эрчимтэй арга хэмжээ авахгүй ба үр дагаврыг нь урьдчилж хэлэхэд хэцүү. Нэгэн нинжагийн хэлснээр “...Цагаан жилтэй Геологийн нэг дарга хүн ноднин 4 дүгээр сарын дундуур гар буу гаргаж нинжа руу буудсан. Тийм л юм дахин бүү болоосой...”

• **Нутгийн иргэд ба нинжа нар:** Малтай байсан нутгийн ардын амьдрал хэцүү болж байна. Олон газраас ирсэн хүмүүс мал хулгайлна. Өвөлжөө, бууц, түлээ түлш, малыг нь хулгайлна. Наад зах нь усны голдрил өөрчлөгдөөд нөгөө хүмүүс суурьшсан нутаг усаа орхиод шинэ газар нүүх болно. Өвөлжөө бууцных нь ойролцоо газар нүх ухна. Хажуугийнх нь хад чулуунаас хөдөө аймгуудаас ирээд бутлаад аваад явчихна. Бүх л бурууг нинжа нарт тохно.

• **Орон нутгийн засаг захиргаа ба нинжа нар:** Хувиараа алт олборлогчдыг хөөж туух үеэр л төр засгаас хэдэн хүн ирж харагддаг. Бусад цагт хүн ирдэггүй.

Алт олборлогчид ирж бидний ажлыг хүндрүүлж амьдралыг маань доройтуулж байна гэсэн үзлээр ханддаг. Компаниудаар татвар авна. Түүгээр барахгүй лиценз зөвшөөрлийг авахад ихээхэн хэмжээний авилгал авч л байгаа. Одоогоос 5 жилийн өмнө Цэнхэр, Улаан хад. Гурван гэр гэдэг газрууд ашиглагдчихсан газар байсан. Нинжа нар очоод дахиад алт илрүүлэхэд дахин Лиценз олгож түрээсэлсэн. “Хэн, яаж, ямар замаар авч өгч байгааг хэн мэдэж байгаа юм. Ядаж Заамараа хөгжүүлэх

хэрэгтэй, тийм ч юм байхгүй. Ядахдаа замаа засуулчхаж болно доо. Монголын хэдэн иргэдээ хамгаалж чадахгүй гадныханд ашиглуулаад байх юм”.

Гар аргаар алт олборлогчдын эрх зүйн орчныг боловсронгуй болгож эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж, гар аргаар алт олборлогчдын нийгмийн асуудлыг шийдэх, байгаль орчны нөхөн сэргээлт, хүний эрхийг зөрчлүүдийг арилгах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай болжээ. Учир нь энэ төрлийн үйл ажиллагааг зохицуулж байгаа түр зуурын дүрэм журам, улс төрчдийн сонгуулийн амлалт зэрэг нь гар аргаар алт олборлогчдын нөхцөл байдлыг улам бүр муутгаж байна.

Оролцогч талууд

Орон нутгийн удирдлага

2002 оны 1 дүгээр сард батлагдсан Тусгай Зөвшөөрлийн Хуулийн тодорхой заалтуудаар аж ахуйн нэгжүүд нь лицензийн бүртгэлийн эцсийн зөвшөөрлийг Засгийн газраас хүлээн авахаас өмнө бүс нутагт явуулах үйл ажиллагааныхаа талаар холбогдох орон нутгийн засаг даргатай зөвшилцөхийг шаардсан байдаг. Мөн Ашигт Малтмалын хуульд лиценз эзэмшигчийг уурхайн үйл ажиллагаагаа эхлүүлэхэд сумын засаг даргад хууль тогтоомжоор ашиг малтмал хайх, ашиглахыг хязгаарласан эсхүл хориглосноос бусад тохиолдолд лицензийн тухай мэдээлэл авч тухайн газрыг уг лицензэд заасан зориулалтаар ашиглуулах үүрэгтэйг хуульчилсан байна.

Бодит байдал: Орон нутагт уурхайн үйлдвэрлэл явуулахад орон нутгийн удирдлага ямар үүрэг, хариуцлагагай

байдаг тухай өгүүлэхэд дараахь зөрчилт байдал ажиглагдаж байна.

Хайрцаг 3. Аймгийн захиргааны албан тушаалтны яриа

Анх манай аймагт алтны компанийг үйл ажиллагаагаа явуулж эхлэхэд олон хүн аймаг орны маань хөгжилд их зүйл оруулна гэж хүлээж байсан. Харин одоо бодит байдал дээр орон нутгийн иргэдэд ямар ч ашиг шим хүртэхгүйгээр үл барам байгаль орчноо сүйтгүүлж амьдрах аргагүй болж нүүхээс өөр аргагүй байдалд орж байгааг л бид хараад сууж байна шүү дээ. Үүнд би их харамсдаг. Энэ үйлдвэрлэлээс улсад юу ордгийг нь би ч тодорхой мэдэхгүй.

Миний бодлоор орон нутгийн удирдлагад ямар ч эрх мэдэл байдаггүй юм. Тухайн аймагт алт олборлох үйл ажиллагааг дээгүүрээ том дарга нар шийддэг. Үүнийг бүүр хариуцдаг тусгай хүмүүс бий болчихсон, сүлжээ үүсчихсэн, тэгээд хэнийг хаана ажиллуулахаа тэд л шийддэг юм шүү дээ. Тэднээс ямар их дарамт ирдэг гэж бодож байна. Хэрвээ би аймаг орон нутагтаа ямар нэгэн юм гуйвал компанийн шаардлагатай баримт бичиг дээр гарын үсэг зурахаас өөр аргагүй болдог.

Би аймгийн даргаар ажиллаж байхдаа нэгэн алтны компани үйл ажиллагаа явуулж буй сумын тамгын газрын ажилтнуудын цалингийн 50%-ийг төлүүлдэг байсныг болиулсан. Тийм завхарсан байдлаар дур зоргоороо ажиллах нөхцөлөө хангаж байдаг юм, энэ алтны компаниуд. Манай аймагт ажиллаж байгаа алтны компанийн үйл ажиллагаанаас харахад Ашигт малтмалын тухай хуулийг өөрчлөхөөс өөр аргагүй юм байна гэж боддог.

Учир нь лицензээ авчихсан, зардал гаргачихсан алтны компаниуд ажлаа олборлолтоо хийнэ гээд ирчихдэг, энэ уурхайн төсөл нь нутаг оронд маань ямар ч ашиггүй байдаг, гэтэл одоо үйлчилж байгаа хуулиар орон нутгийн удирдлагад ямар ч эрх мэдэл байдаггүй их хэцүү л юм байна лээ.

...Намгүйгээр албан тушаалтан ажиллах боломжгүй байдаг юм. Намаас ямар үүрэг даалгавар өгнө түүнийг л бид хэрэгжүүлдэг бодит байдал нэгэнт тогтоод байна шүү дээ. ... Намын хурал дээр зарчмын санал чангахан хэлбэл, “Чамаас аяархан ярьдаг хүн байдаг юм шүү” гэж тухайн хүнд сануулдаг.

Үүнээс үзэхэд орон нутгийн түвшинд дээрээс лицензээ хуулийн дагуу аваад ирсэн компаниудад хориг саад тавих чадамжгүй бөгөөд харин ч тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулах боломжийг нь хангаж өгөх үүрэг хүлээдэг.

Бүх татвар нэгдсэн төсөвт ордгоос тухайн аймаг орон нутагт хэрэгжиж буй уул уурхайн төслүүдээс тус орон нутагт бодит үр ашиг байхгүй. Орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулах нь ихээхэн улс төржсөн, улс төрийн намын бүлгээс ихээхэн дарамттай учирдаг байна. Энэ нь орон нутгийн удирдлагын бие даасан байдлыг бүрэн алдагдуулж, орон нутгийн эрх ашгийг хамгаалах ажиллах зарчмыг хөсөрдүүлж байгаа юм.

Хуулийн хэрэгжилтийг хянах, эрчимжүүлэх чиглэлээр аймгийн удирдлага тодорхой ажил төлөвлөн ажилладаг боловч

түүний үр дүн тодорхой харагдахгүй байна. Уул уурхайгаас аймгийн газар нутгаа хамгаалах цорын ганц арга нь тодорхой нутаг дэвсгэрийг аймгийн болон сумын тусгай хэрэгцээнд авах арга хэмжээ болдог байна.

Тиймээс орон нутгийн удирдлагууд уул уурхайн салбартай холбоотой холбогдох хууль, дүрэм, журам заалтыг өөрчлөх, аймаг орон нутагт эдийн засгийн хувьд үр өгөөжтэй, нутгийн иргэдийн эрх ашгийг хөндөхөөс сэргийлсэн, улс төр, ашиг сонирхлын бүлгийн дарамтаас ангид байх байдлаар өөрчлөхийг хүсэж байна.

Хайрцаг 4: Сумын захиргааны албан тушаалтны ярианаас

Сумын Засаг даргын хувьд хамгийн хүндрэлтэй асуудал нь Геологи, Уул Уурхай, Кадастрын Алба (ГУУКА) орон нутагтай ямар ч харьцаагүй байдаг. Орон нутаг хууль зүйн хувьд ямар ч эрх мэдэлгүй.

Гэнэт л лиценз авсан, ордыг шилжүүлж авсан гээд л ороод ирдэг. Бидэнд мэдэгдэж байгаа юм гэвэл “Зууны мэдээ” сониноос тэрний лицензийг тэр шилжүүлж авжээ гэдгийг хайчилж авдаг. Аймаг сум, ерөөсөө мэдэхгүй, хотоос л шийдсэн байдаг. Улсын хөрөнгө оруулалтаар хайгуул хийсэн ордыг улс мэднэ, хувийн хөрөнгөөр асар олон хайгуул хийгдэж байна. Нэг мэдэхэд л ашиглалт хийх компанид худалдсан байдаг.

Орон нутагт юу үлддэг вэ гэхээр усны төлбөр л авна. Алтаа Монгол банканд тушаадаг хэдэн кг алт тушаасан нь ч мэдэгдэхгүй. Лицензийн наймаа малын наймаа шиг болж, өөр компани ороод ирдэг. Үүнээс болоод өмнөх компани нь

энэ жил хийх ёстой төлбөрөө хийхгүй явчихна. Тэгээд шүүхэд өгөх гэхээр нэрээ сольчихсон, хотод байдаг юм байна тэнд нь өг гэдэг тэгээд л өнгөрдөг.

Байгаль орчны хуулиар олгосон эрх хэмжээ байгаа боловч хөөцөлдөх гэхээр хууль тогтоомжийн талаар бидэнд туслах газар байдаггүй. Арга ядахдаа л аймгийн мэргэжлийн хяналтын газрыг дууддаг. Тэд нар ирээд акт бичээд битүүмжлээд явдаг. Дандаа сахиад зогсоод байх биш яваад өгсөн хойно нь ажиллаад эхэлдэг. Алтны компаниуд үүнийгээ их нууц хийнэ.

Засаг даргаар захирамж гаргуулахдаа хуулиар хориотой үйл ажиллагаа явуулахгүй гэж хэлдэг. Нүүснийх нь дараа очиход л мөнгөн ус үлдсэн байдаг. Хувиараа алт олборлож байгаа нинжа нар мөнгөн усыг нь тогоон дээрээ буцалгаад байж байдаг. Сум одоо яахав, сайндаа мөнгөн усны хорын тухай гарын авлага гаргаж ард иргэддээ тараасан. Гэтэл хүмүүс өнөөдрийн хэдэн төгрөгийг бодоод хор уршгийг нь ойлгохгүй байна. Бүх хуулиуд байгаа хэрнээ -ямар ч арга хэмжээ авах боломжгүй байна. Бидний шийдэх юмыг дээш нь яам агентлаг руу заасан байдаг. Орон нутгаас зөвшөөрөл авсны дараа лиценз олгооч гэсэн шаардлагыг хэд хэдэн удаа тавьсан. Одоогоор ур дүнгүй л сууж байна.

Бодит байдалд алтны компаниуд сумын захиргааны ажилчдын цалингийн тавин хувийг олгох нь тохиолддог байна. Энэ нь өөрийн компанийн үйл ажиллагааг засаг захиргааны зүгээс ямар нэгэн саад бэрхшээлгүй, зарим үед хууль бусаар явуулах нөхцөлөө бүрдүүлэхэд хэрэглэдэг арга хэмээн үзэж болох юм.

Тухайлбал, алтны компаниуд байгалийн нөхөн сэргээлт хийх мөнгөний 50 хувьтай тэнцэх мөнгийг сумын дансанд байрлуулахгүй байх, ашигт малтмал эрхлэх газар, усны зөвшөөрлийг нутгийн иргэдийн эсэргүүцлийг үл харгалзан гаргуулах зэргээр ашигладаг практик тогтжээ.

Дээрх байдлыг сумын удирдлагууд тайлбарлахдаа: “Дээрээс лицензээ аваад ирчихсэн компанийг яаж ч эсэргүүцэх, нутаг оронд ашигтай үйл ажиллагаа явуулах талаар хэлэлцээ хийх эрх зүйн боломж бидэнд байдаггүй юм шүү дээ” хэмээн тайлбарлаж байна. Энэ байдлаас үзэхэд сумын удирдлага нутгийн иргэдийн оролцоог хангах, нутгийн иргэдийн эрх ашгийг зохих ёсоор хамгаалахгүй байна.

Багийн удирдлага нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор багийн иргэдийн хурлаа зохион байгуулж асуудлыг авч хэлэлцэх, багийн нутгаа сумын тусгай хэрэгцээ, аймгийн тусгай хэрэгцээнд авахуулах арга хэмжээг зохион байгуулах, мөн сүүлийн үед нутаг ус, байгалиа хамгаалах зорилготой иргэдийн хөдөлгөөнийг зохион байгуулах, хамтран ажиллах зэрэг идэвхтэй ажиллах болсон байна.

Гэвч эдгээр хүмүүсийн хүний эрх, эрх зүйн мэдлэг хомс, хамгийн гол нь уул уурхайн үйл ажиллагаа, компаниуд, төрийн захиргааны дээд шатны байгууллагуудын бодлого, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах бололцоо, механизм байхгүй нь хамгийн том бэрхшээл болдог байна.

Уул уурхайн компаниуд. Тус ярилцлагын баримт бичгийг бэлтгэх хүрээнд Геологи Уул Уурхайн Кадастрын албанаас гаргасан компаниудын жагсаалтыг ашиглаж компаниудтай утсаар холбоо барьж мэдээлэл цуглуулах ажлыг зохион байгуулсан юм.

Ашиглалтын лицензтэй аж ахуйн жагсаалтад орсон нийт 588 нэгжид 1077 удаа утсаар залгахад, 506 нэгжээс ямар нэг шалтгаанаар мэдээлэл авч чадаагүй бөгөөд 82 аж ахуйн нэгжээс авсан мэдээллийг дор сийрүүлэв. Уул уурхайн ашиглалтын лиценз эзэмшиж буй компаниудын удирдлагуудаас дараах асуудлуудыг дэвшүүлэн гаргаж байна.

Байгаль орчны асуудал, үүнээс улбаалсан орон нутгийн иргэд, малчдын эсэргүүцэл ихээхэн тулгарах болсон нь бэрхшээл үүсгэж байна. Өөрсдөө ч Монгол орныхоо байгаль орчны эвдрэл сүйтгэл, гол усны хомсдолд санаа зовдог бөгөөд энэ асуудлыг уул уурхайн салбартай оновчтой уялдуулах шинэ зарчим, механизм хэрэгтэй байгааг юуны түрүүнд илэрхийлж байв.

Түүнээс гадна татварын дарамт их, төрийн байгууллагын хүнд суртал, орон нутгийн засаг захиргааны дэмжлэг байхгүй, технологи, хөрөнгө оруулалтын дутагдал голлох хүндрэлүүд юм. Дотоодын үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих бодлого сул: ашигт малтмалын хуульд оруулсан уурхайн ашиглалтын лицензийг дуудлагаар худалдах зарчим нь гадаадын компаниудад илүү боломжийг олгож байгаа, мон гадаад, дотоодын компаниудад ялгаатай оноосон татварыг эсэргүүцэж байгаагаа илэрхийлсэн байна.

Мөн гар аргаар алт олборлогчид алтны компаниудын үйл ажиллагаанд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байгааг өгүүлээд үүнийг зогсоох арга хэмжээ авахгүй бол олборлолт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг зүй зохистойгоор хийх нөхцөлийг алдагдуулж байна хэмээн үзэж байна.

Гэхдээ хамгийн гол тэмдэглэвэл зохих нэг асуудал нь алтны компаниудын удирдлагууд уул уурхайн салбарын үйл ажиллагаа хүний эрхийг зөрчинө гэж байхгүй, учир нь энэ салбар манай улсын эдийн засгийн өсөлтийг хангах хамгийн гол үйлдвэрлэл хэмээх үзэл нийтлэг байна /...Эдийн засгийн өсөлтийг хангаж байгаа гол салбарыг хүний эрх зөрчинө гэж юугаа яриад байгаа юм (компанийн захирал)/. Тэд байгаль орчны нөхөн сэргээлтийг хийлгүй, олон га газрыг эвдэн сүйтгэх, гол усыг бохирдуулах, ширгээх нь хүний эрхийн зөрчилд хүргэнэ гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байна.

Байгаль орчныг хамгаалах төрийн яам, албан тушаалтнуудын үзэл бодлоос. Уул уурхайн салбарын өмнө тулгамдаад байгаа олон асуудлууд, түүний дотор байгаль орчны нөхөн сэргээлтийг бодитой хэрэгжүүлэх, хүний эрхийн асуудлуудыг шийдвэрлэхэд төрийн холбогдох яамд, албад дараах саналыг боловсруулан холбогдох хууль тогтоомжид тусгах хэрэгтэй хэмээн үзэж байна.

Юуны түрүүнд ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лиценз олголтод дараах өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай ажээ. Үүнд:

- Хайгуулын лицензийн хувьд түүнийг

олгоход сумын засаг захиргааны эрх мэдэл, оролцоог нэмэгдүүлэх, хайгуулын явц дахь байгаль хамгаалах арга хэмжээг сайжруулах, сумын байгаль хамгаалагчийн үүрэг, статусыг нэмэгдүүлэх, хайгуулын лицензийг шинээр нэмж авах, сунгах, бусдад шилжүүлэх тохиолдолд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилтэд тулгуурладаг байх, Лиценз хүсэх өргөдөл, түүнийг олгох процессыг нийтэд мэдээлэх, тэдний саналыг авах, саналаа өгөх оролцоон хангах, байгаль орчны шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянахад оролцоог нэмэгдүүлэх;

• **Ашиглалтын лицензтэй холбоотойгоор** орон нутгийн засаг захиргааны эрх мэдлийг нэмэгдүүлэх, тухайлбал ашиглалтын лицензийг баг, сумын засаг даргын зөвшөөрөл дээр тулгуурлан олгодог байх, гэхдээ байгаль орчны нөхөн сэргээлтийг хийх эдийн засгийн чадавхийг харгалзах, эдийн засгийн хувьд ашиггүй буюу нөхөн сэргээлт, уурхайн ашиглалт зэрэгт зарцуулах өртгөөс ашиг нь илүү гарахгүй ордуудад лиценз олгохгүй байх, лиценз олгож болохгүй газруудыг хуульчлах.

Үүнд: экологийн эмзэг газар буюу гол мөрний эх, нуурын ай сав газар, нэн ховор амьтан, ургамлын байршил газар болон төв суурин, түүх соёлын дурсгалт газруудад г.м.

Ашиглалтын явц дахь байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа, хариуцлагын тогтолцоог сайжруулах. Тухайлбал, тухайн жилийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлын 50 хүртэл хувийг хэрэгжүүлээгүй тохиолдолд ашиглалтын лицензийг цуцлах, хохирлыг барагдуулах

хариуцлагаас чөлөөлөхгүй байх, ашиглалтын лицензийг сунгах, шинээр нэмж авах, шилжүүлэх тохиолдолд байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд заавал тулгуурладаг байх механизмыг чангатгах, байгаль орчныг нөхөн сэргээх болон түүнд хор хохирол учруулсан этгээдийн ашиглалтын лицензийг цуцлах, олгохгүй байх, эрүүгийн хариуцлагад татах зэргээр өөрчлөх.

Хөндлөнгийн хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлэх, нууцад холбоогүй бүх мэдээллийг ил тод болгох, авах боломжоор хангах. Тогтвортой байдлын гэрээ хийвэл түүнд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой тодорхой заалтууд болон өргөдөл гомдлыг хянах, арга хэмжээг хэрэгжүүлэх зохих ёсны санхүүжилттэй механизмыг тусгах.

Уул уурхайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, нөхөн сэргээлтийн чанарыг сайжруулах арга зам, техник технологийг хөгжүүлэх эсхүл бусад орны туршлагыг нэвтрүүлэх, байгаль орчинд уул уурхайн үйл ажиллагаанаас учирч буй сөрөг нөлөөний тухай мэдээлэл, судалгааг сайжруулах, экологийн хохирол, газрын болон эко системийн нөхөн сэргээлтийн үнийг тодорхойлох аргачлал боловсруулах эсхүл нэвтрүүлэх, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг усны ай сав газарт бүхэлд нь хуримтлагдах нөлөөллийг оролцуулан хийх.

Иргэдийн саналыг авдаг болох, үнэлгээг нийтэд ил тод болгох зарчмыг хуульчлах, энэ үйл ажиллагаанд гаргах зардлыг нэмэгдүүлэх зэргийг дурдаж болно.

Хүний эрхийн Үндэсний Комисс. Уул уурхайн салбар дахь хүний эрхийн асуудал, уурхайн хөдөлмөрийн нөхцөлд анхаарч ажилладаг ба энэ чиглэлд үйл ажиллагаагаа өргөтгөн уурхайн эргэн тойронд байгаа нутгийн иргэдийн хүний эрхийн асуудалд анхаарал хандуулан ажиллах зорилготой байна.

Шүүгчдийн бүлэг. Хүний эрх, эрх чөлөө нь Монгол улсын үндсэн хууль, Мянганы Хөгжлийн Зорилтын хамгийн чухал, суурь үнэлэмжүүд бөгөөд тэдгээрийг төр засаг хуулиар дамжуулан хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Төр засгийн энэ үүрэг амьдралд шүүхийн шийдвэрээр хэрэгждэг. Иймээс уул уурхайн салбарын хүрээнд гарч буй хууль бус үйл ажиллагаа, хүний эрхийн зөрчлүүдийг шийдэхэд шүүхийн байгууллага онцгой үүрэгтэй билээ. Иймд өнөөгийн шүүхийн систем нь дээрхтэй холбоотой асуудлыг хэрхэн шийдэж байгаа тухай шүүхийн байгууллагын ажилтнуудын саналыг тусгасан.

2005 оны байдлаар анхан шатны шүүхүүд иргэний нийт 24 492 хэргийг хянан шийдвэрлэжээ. Үүнээс Ашигт малтмал тухай хуулиар нийт 4 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Нийслэл, Төв аймгийн шүүхээр хайгуулын болон ашиглалтын лицензтэй холбоотой маргааныг Архангай, Хэнтий аймгуудад ашигт малтмалын тухай хуулийн бусад асуудлаар нийт 4 хэрэг маргаан шийдвэрлэсэн байна. Захиргааны хэргийн шүүхүүд 2005 онд 386 хэргийг хянан шийдвэрлэжээ. Үүнээс газрын тухай хуулиар 73, ашигт малтмалын тухай хуулиар 19 хэрэг тус тус хянан шийдвэрлэсэн байна.

Шүүгчидтэй хийсэн уулзалтаас гарч ирсэн асуудлыг доор сийрүүлбэл: Уул уурхайн салбарт лиценз олголт, татвар, хөдөлмөрийн нөхцөл, байгаль орчин, нутгийн иргэд, малчдын эрхийн зөрчил зэрэг хууль бус үйлдлүүд гарч байна. Үнэндээ орон нутгийн иргэд, малчдын хүний эрхийн зөрчил түгээмэл байгаа боловч түүнийг шүүхээр шийдвэрлэх нь ховор байна. Үүнд хэд хэдэн шалтгаан байна.

Энэ асуудал хөдөө орон нутагт их гарах бөгөөд нутгийн малчин иргэд компаниуд хууль зөрчиж байгааг мэддэггүй. Мэдсэн ч шүүхэд яаж хандахаа мэддэггүй. Мөн шүүхэд хандах процесс түвэгтэй байгаа тул иргэд шүүхээр шударга ёсыг тогтоож чадахгүйд хүрч байна. Хөдөөний хүмүүст шүүхээс болгоомжлох, шүүхэд итгэхгүй байх хандлага ажиглагдаж байна. Эдгээр нь дараах хүчин зүйлээс хамаарч байж болох юм.

- Шүүх байгууллагын ажиллагсдын цалин, хангамж муу, иймээс гадны нөлөөнд автах боломж өндөр.
- Шүүхийн байгууллагын ажилтнуудын хүний эрхийн мэдлэг сайн биш. Үндсэн хуулийн заалт болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенциудыг барин шийдвэр гаргах практик байхгүй.
- Амьдралд гардаг олон хэрэгт хуулийн зарчим, нотлох баримт зөрчилдөж байдаг бөгөөд шүүгч маш чухал үүрэг гүйцэтгэдгийг олон нийт ойлгохгүй байх.
- Удирдлагаар нь дамжуулан шүүгчид нөлөөлж болно, эсхүл шүүх шүүгч, түүний талын хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг гэсэн ойлголт тархсан
- Оролцогч аль нэг талтай холбоотой эсхүл

тухайн хэргээс гарах үр дүнтэй хувийн сонирхолтой шүүгчид хэргийг оноодог гэж хүмүүс боддог

• Шүүгчийн мэргэжлийн ёс зүйг дээшлүүлэх, тэдэнд нотлох баримтыг зөв шударгаар үнэлэх, шийдвэр гаргахдаа хуулийн зарчимд тулгуурлах, хувийн үзэл бодолдоо хөтлөгдөхгүй байх.

Ярилцлага өгсөн бүх шүүгчид Ашигт малтмалын тухай хуулийг бүхэлд нь өөрчлөх хэрэгтэй ба түүнийг сайжруулахаар өгч байгаа саналыг бүгдийг нь хэлэлцүүлж, хянуур шинжлэх шаардлагатай гэж үзэж байв. Тэдний үзэж байгаагаар уул уурхайн салбарт хамаатай олон хууль байгаа боловч тэдгээр нь бүрхэг, бие биетэйгээ уялдаагүй, зөрчилдөх нь элбэг байна. Мөн хуулийн зөрчилтэй асуудалд анализ хийн түүнийг шийдвэрлэх няхуур арга боловсруулах үүрэгтэй Хууль Хянах Зөвлөл гэдгийг байгуулах санал гаргаж байв.

Тэд мөн шүүхийн удирдах байгууллага сайн ажиллахгүй байна. Иймээс өөрчлөлт хийх хэрэгтэй. Одоогийн системээр шүүгчийн хариуцлага, үйл ажиллагааных нь гүйцэтгэлээр зөвхөн нэг л хүн бүх шийдвэр гаргадаг. Үүнд илүү олон хүн, олон хүний санаа бодол оролцох ёстой гэж хэлж байв.

НҮБ-ын суурин төлөөлөгчид

Байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлснээс болж иргэдийн хүний эрх зөрчигдөж байгаад НҮБ-ын Монгол салбар агентлагууд анхааран өөрсдийн үйл ажиллагааны чиглэлд тодорхой асуудлаар ажиллаж байна.

НҮБ-ын Хүн Амын Сан албан бус алт олборлогчдын нийгэм эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах чиглэлээр сургууль, эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх, хүчирхийлэл, хүйсийн тэгш бус байдлыг багасгах, нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх, тухайн орон нутагт эдгээр хүмүүст үзүүлэх үйлчилгээг сайжруулах чадавх бүрдүүлэх төслийг хэрэгжүүлнэ.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага Монгол дахь уул уурхайн практикийн хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөнд сэтгэл зовж, гурван чиглэлд төвлөрөн ажиллаж байна. Нэгдүгээрт, орон даяар сонгосон газарт усны чанарыг шалгах хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулсан. Хоёрдугаарт, уурхайн эргэн тойронд биеэ үнэлэх явдал дэлгэрч байгаад анхаарч эдгээр газарт бэлгэвчийг хэрэглэдэг дадлыг нэвтрүүлэх зорилго тавин ажиллаж байна. Гуравдугаарт уул уурхайн эргэн тойронд агаарын тоосжилт ихэссэнээс үүсдэг силикоз өвчний эсрэг хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. Эдгээрээс гадна мөнгөн усны хордлого болон албан бус алт олборлогчдын асуудлаар ЖАЙКА-тай хамтарч ажилласан ба олон уурхайд үйл ажиллагаагаа эхлэхээс нь өмнө эрүүл мэндийн эрсдэлийг бууруулах талаар зөвлөгөө өгчээ.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн хүний эрхийн зөрчил нь гол анхаарч ажилладаг асуудал. Уул уурхайн салбарт байдаг хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, уул уурхайн компани, албан бус алт олборлогчдын хоорондох хэлэлцээг

урагшлуулах, албан бус алт олборлогчдын асуудлаар хуулийн төсөл боловсруулах, тэдний хөдөлмөрийн аюулгүй байдал, тэргүүн туршлагаар гарын авлага тараах, хөдөлмөр эрхлэх өөр арга зам, мөнгөн усны хор уршгийн талаар сургалт хийх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлжээ.

Уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд үзүүлж байгаа сөрөг нөлөөнд ихэд санаа зовдог байна. Харин 2000 оноос хойш энэ чиглэлээрх хүмүүсийн мэдлэг мэдээлэл сайжирсныг тэмдэглэж байна. Энэ оны 6 дугаар сард Албан бус алт олборлогчдын талаар тайлан гаргах юм байна.

НҮБ-ын Хүүхдийн Сан

Уул уурхайн үйл ажиллагаанаас эмэгтэйчүүд хүүхдийн эрх зорчигдож, албан бус алт олборлогчдын хүүхдүүд сургуульд сурах, хөгжих боломжгүй байгаад их санаа зовнидог байна. Хэдийгээр энэ асуудлаар тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлээгүй байгаа боловч ОУХБ-ын энэ чиглэлийн хөтөлбөрт тэдний хүсэлтээр тусламж үзүүлдэг байна.

Уул уурхай, байгаль орчны салбар дахь олон улсын тэргүүний туршлагыг Монгол Улсын практиктай харьцуулсан нь

Доорх хүснэгтээр Монгол Улсын уул уурхайн хөгжлийн зохицуулалт олон улсын шилдэг туршлагатай хэрхэн нийцэхгүй байгааг үзүүлэв. Энэ нь мэдээллийн эрх чөлөө, шийдвэр гаргахад холбогдох орон нутгийн иргэдийн оролцоо, шүүхэд хандах боломж зэрэг олон салбарт ажиглагдаж байна. Мөн байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийх, лиценз эзэмшигчийн санхүү, техникийн чадвартай холбоотой процедур, хэрэглэж болох шилдэг технологи, агаар усны чанар, газрыг нөхөн сэргээх, барьцаа хөрөнгө, уурхайг хэрхэн хаах шаардлагуудтай ч нийцэхгүй байгаа ажээ.

Түүнчлэн лицензийг шилжүүлэх, хүчингүй болгох монгол улсын хууль дүрэм нь байгаль орчинд ээлтэй биш байна. Эцэст нь хамгийн гол асуудал бол Монгол орны одоогийн шаардлагууд нь тогтмол, шударгаар хэрэгжихгүй байгаа явдал юм.⁷⁷

⁷⁷ Уг харьцуулалтыг хийхэд ашигласан материалууд: "Human Rights in Natural Resource Development", Zillman et al., Oxford University Press, 2002; "Breaking New Ground: Mining, Minerals, and Sustainable Development", Report of the MMSD Project of World Business Council for Sustainable Development an International Institute for Mining and Development, Earthscan Publications Ltd., London an Sterling, VA; "Hard Rock Mining: State Approaches to Environmental Protection", J.McElfish Jr. et al., Environmental Law Institute, 1996; "Mineral Exploration, Mining and Aboriginal Community Engagement: A Guidebook Report of the Workshop on Indigenous Peoples and Mining Minerals and Sustainable Development", World Business Council for Sustainable Development and I.I.E.D., Perth, Australia

		Олон улсын шилдэг туршлага	Монгол Улсын оноогийн туршлага
1. Лицензтэй холбоотой шийдвэр гаргалт			
1.1	Мэдээллийн эрх чөлөө	Аливаа төрлийн лицензийн өргөдөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан, гарсан шийдвэр зэргийг вэб сафтуудад байрлуулж олон нийтэд ил тод байлгадаг, шалгах, хувиан авахад хямд үнээр албан ёсоор чөлөөтэй өгөх	Лицензийн өргөдлүүд, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, байгаль орчны төлөвлөгөө зэрэг холбогдох баримт бичгүүд нууц, харин эцсийн шийдвэр нь олон нийтийн мэдээлэл болдог
1.2	Олон нийтийн оролцоо	Лицензийн өргөдлийн талаар олон нийтэд зарлаж, олон нийтэд, иргэдэд уг өргөдөлтэй холбоотой саналаа өгөх боломжийг бүрдүүлж, олон нийтийн хэлэлцүүлгийг ихээхэн хэмжээний байгаль орчны нөлөөлөл үзүүлэх, шинэ боллого явуулах уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэхэд зохион байгуулах, олон нийтийн хэлэлцүүлгийн үед гарсан иргэдийн санал, шинжлэх ухааны үндэслэл зэргийг шийдвэр гаргахад заавал анхаарах	Өргөдөлтэй холбоотой олон нийтэд зарлах, мэдэгдэх, олон нийт, иргэд саналаа өгөх боломж, олон нийтийн хэлэлцүүлэг байхгүй. Лиценз олгох шийдвэрийг олон нийтийн оролцоогүйгээр гаргадаг.
1.3	Шүүхэд хандах боломж	Хохирсон иргэд, тухайн асуудлаар ажилладаг ТББ лиценз олгох үйл явцад оролцох, хэрвээ хууль зөрчсөн үйлдэл илэрвэл шүүхэд гомдол гаргах эрх зүйн боломжтой.	Хохирсон иргэд лицензтэй холбоотой шүүхэд гомдол гаргаж болно. Гэхдээ энэ нь маш ховор байна. Энэ боломж ТББ-уудад байхгүй.
1.4	Орон нутгийн иргэдийн оролцоо	Канад, Австрали зэрэг орнуудад уугуул иргэд уул уурхайн компаниудтай оролцооны /үр ашгийн/ гэрээг хийх замаар хэлэлцээ хийдэг. Уг гэрээнд тухайн уурхайд ажиллах орон нутгийн иргэдийн тоо, сурч боловсрох, хөгжих боломжууд, хамт олныг хөгжүүлэх, сан, байгаль орчны хяналт, уг гэрээг байгуулах хэлэлцээг хийх, мониторинг хийх, гэрээг хэрэгжүүлэх зардлыг компани хэрхэн гаргах зэргийг тусгадаг.	Орон нутгийн хамт олны оролцоо нь сумын Засаг даргын байгаль орчны төлөвлөгөөг хэлэлцэх, ус, газар ашиглах зөвшөөрлөөр хязгаарлагдана.
2.	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ (БОНУ)	БОНУ-г лиценз олгох процессын хэсэг болгон бэлтгэж, батлуулдаг. Энэ процесст иргэд оролцон саналаа хэлэх боломжтой. БОНУ-ийн үнэн зөвийг шүүхээр тогтоодог.	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг уул уурхайн компаниуд оорин сонгож авсан компанийг хөлсөн хийлгэх бөгөөд уг үнэлгээнд олон нийтийн санал, зөвлөмж, оролцоо байхгүй, үнэн зөв байдлыг шүүх хянан үздэггүй.
3. Холбогдох хууль, дүрэм			
3.1	Техник, санхүүгийн чадавч үзүүлэх	Лиценз авахаар өргөдөл гаргагчаас байгаль орчны хуулийг зөрчихгүй, нөхөн сэргээлтийг шаардлагын дагуу явуулах техник, санхүүгийн чадавч харуулахыг шаарддаг.	Уг асуудалтай холбоотойгоор өргөдөл гаргагч нь техник, санхүүгийн чадавч үзүүлэх шаардлагагүй.
3.2	Хамгийн шилдэг технологи хэрэглэх	Лицензийг олгохдоо уул уурхайн компаниудаас байгаль орчны нөлөөллийг хянах, хамгийн үр ашигтай практик, шилдэг технологийг шаарддаг.	Лиценз эзэмшигч нь шилдэг технологийг хэрэглэх шаардлагагүй.
3.3	Агаар усны чанарыг хадгалах	Уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орчны усны чанарыг хадгалах, бохирдлоос сэргийлэх зорилготой усны хүчиллэг, булингар, ууссан хүчлэг төрөгч гэх мэт үзүүлдэтийг хангах стандарт гарган уул уурхайн компаниудад мөрдүүлдэг. Мөн тухайн орчны агаарт үүнтэй ижил төрлийн стандарт мөрдүүлнэ.	Агаар, усны чанарын стандарт мөрдөггүй.
4.	Нөхөн сэргээх үйл ажиллагаа	Уурхайн үйл ажиллагаа явуулж байх үед, хар шороон хучлага, ургамалжуулалт зэрэг биологийн нөхөн сэргээлтийг зэрэг хийх, түүнчлэн ургамалжилт, биологийн нөхөн сэргээлтийг ургамлын ургах чадварт мониторинг хийх байдлаар хянахыг шаарддаг.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө шаарддаг боловч хэрэгжих нь ховор. Нөхөн сэргээлтийг хар шороон хорс, биологийн нөхөн сэргээлтгүй зовхон техникийн нөхөн сэргээлтээр хязгаарлаж байна.

5.	Барьцаа шаардах	Нөхөн сэргээлтийн нарийн тооцоолсон бүх зардлыг толох барьцаа болон бусад аюулгүй байдлыг хангахыг шаарддаг.	Нөхөн сэргээлтийн зардлын 50%-тай тэнцэх хөрөнгийг барьцаалахыг хуулиар шаардана. Гэвч амьдралд нөхөн сэргээлтийн зардлыг багаар тооцдог бөгөөд үүний 50%-аас бага хөрөнгийг холбогдох дансанд байршуулдаг ба зарим тохиолдолд хийгдэхгүй.
6.	Уурхайг хаах	Уурхайг түр болон бүрмөсөн хаахдаа бохирдсон хөрс, уснаас урсан гадаргын болон гүний усыг бохирдуулахаас урьдчилан сэргийлэхийг хатуу шаарддаг.	Түр зуурын болон улирлын шигжтэй уурхайг хаахад хэрэгжүүлэх хатуу шаардлага байхгүй, бүрмөсөн хаасан тохиолдолд ч хатуу мөрдөх шаардлага байхгүй.
7.	Лиценз хүчингүй болгох	Лиценз хүчингүй болгох нөхцөлд байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх хангалттай хамгаалалт хийгээгүй, байгаль орчны дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, шаардлагатай нөхөн сэргээлтийг хийгээгүй зэрэг орно.	Лиценз хүчингүй болгох нөхцөлд хангалттай хамгаалалт хийгээгүй, байгаль орчны дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, шаардлагатай нөхөн сэргээлтийг хийгээгүй зэрэг орохгүй.
8.	Лиценз шилжүүлэх	Лицензийг байгаль орчин, нөхөн сэргээлтийн шаардлагыг хангаагүй нөхцөлд шилжүүлж болохгүй.	Лицензийг байгаль орчин, нөхөн сэргээлтийн шаардлагыг хангаагүй нөхцөлд ч шилжүүлж болно.

Дүгнэлт, санал зөвлөмж

Орон нутгийн иргэд, малчид өөрсдийнх нь газар нутаг дахь уурхайн үйл ажиллагаанаас тодорхой үр шим хүртэхгүй байна. Монгол дахь алтны уурхайн үр ашиг муутай техник, технологи, байгаль орчны нөхөн сэргээлтийг шаардлагын дагуу хийхгүй байгаагаас бэлчээр сүйтгэх, гол мөрөн, горхи шандны ус бохирдох, ширгэх зэргээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна.

Байгаль орчинд учирсан сөрөг нөлөөнөөс малчдын иргэний, улс төрийн, эдийн засгийн, нийгэм, соёлын олон эрх зөрчигдөж байна. Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын лиценз авах, газар, усны зөвшөөрөл олгох, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг хянахад нутгийн иргэдийн оролцоо хангагдахгүй байна.

Монгол Улсын хууль тогтоомжоор малчдын эрхийг зохих ёсоор хамгаалаагүй бөгөөд Засгийн Газрын ашигт малтмалын салбарыг хөгжүүлэх бодлогод тэдний эрх ашгийг анхаарсангүй. Монгол улсад байгаль орчинд учирсан хохирлыг үнэлэх, хохирогчдод нөхөн төлбөр олгох туршлага алга. Түүнчлэн хүний эрхийн зөрчлийг шүүхээр шийдэх практик тогтоогүй бөгөөд хохирсон хүмүүс ихэнхдээ хууль эрх зүйн мэдлэггүй бөгөөд шүүхэд итгэх итгэлээр муу байна.

Малчид орон нутгийн иргэд эрхээ хамгаалахаар Монгол улсын янз бүрийн хэсэгт иргэний хөдөлгөөн байгуулжээ. Гэвч тэд зохион байгуулалтаар сул, хууль эрхийн мэдлэггүй, уул уурхайн компани, орон нутгийн удирдлагатай үр ашигтай ажиллах

туршлагагүй байна. Иймээс эдгээр төрийн бус байгууллагын хүний эрх, тогтвортой хөгжлийн зарчмыг хэрэгжүүлэх чадавхыг сайжруулахад нэн тэргүүнд анхаарах хэрэгтэй.

Гар аргаар алт олборлогчдын үйл ажиллагааг албан ёсны болгох эрх зүйн статустай болгоогүй учраас тэдний хүний эрх онцгой ихээр зөрчигдөж байна. Тэд алтны компани, цагдаа, орон нутгийн захиргаа, нутгийн иргэд зэрэг олон талын дарамтан доор, зөрчлөөр дүүрэн, хүний эрхэм чанараа хадгалж чадахгүй нөхцөлд амьжиргаагаа залгуулж байна.

Лицензийн асуудлаар шийдвэр гаргах, байгаль орчны шаардлагын биелүүлэлт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагааг хянах асуудлаар мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрхийг хамгаалах, эдгээр эрхийг зөрчсөн тохиолдолд шүүхээр шийдүүлэх эрхийг баталгаажуулахын тулд олон улсын тэргүүний туршлагыг нэвтрүүлэх хэрэгтэй.

Монгол Улсын уул уурхайн үйл ажиллагаанд хэрэглэж байгаа хуулийн доголдлыг арилгахын тулд байгаль орчны асуудлаар тавигддаг шаардлагыг чангаруулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх тухай өөрчлөлтийг Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуульд хийх. Ялангуяа, ил тод байдлыг нэмэгдүүлэх өөрчлөлт нь лицензийн өргөдөл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ болон холбогдох бусад материалд онцгой хамаатай юм.

Ач холбогдлоороо чухал лиценз олгох асуудлаар олон нийтийн хэлэлцүүлгийг

зохион байгуулан, санал сэтгэгдлээ хэлэх боломжоор хангах замаар олон нийтийн оролцоог зөвшөөрдөг, дэмждэг практикийг нэвтрүүлэх хэрэгтэй. Орон нутгийн удирдлага лицензийн үйл ажиллагаанд шаардлагатай зөвшөөрлийг иргэдийн нийтийн болон төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа олгодог, иргэд уурхайн компанийн хооронд оролцооны/үр ашгийн гэрээ хийх эрхийг олгодог байх шаардлагатай. Асуудлыг шүүхээр шийдвэрлэх боломжийг сайжруулахын тулд шинжлэх ухааны үнэлгээ, дүгнэлтийг нотлох баримтаар хэрэглэх, түүнийг шүүхийн шийдвэр гаргахдаа хэрэглэх явдлыг сайжруулах нь чухал байна.

Сонирхсон төрийн бус байгууллагууд, иргэдэд лиценз олгох шийдвэр гаргахад оролцох, эсрэг шийдвэр гаргуулахаар дээд байгууллага болон шүүхэд хандах эрх олгох хэрэгтэй. Байгаль орчныг хамгаалах, газар болон экосистемийг нөхөн сэргээх зориулалтын хуулийн хэрэгжилтийг сайжруулах. Уурхайн үйл ажиллагаа явуулах лицензийг гол мөрөн, булаг шандны эх, ховордсон ан амьтан, ургамалтай газар, түүх дурсгалын болон уугуул иргэд олноороо суурьшдаг газар эсхүл тахиж шүтдэг газар олгохгүй байх. Байгаль орчны шаардлагыг биелүүлээгүй, байгаль орчныг нөхөн сэргээх техникийн болон санхүүгийн чадавх байхгүй тохиолдолд лиценз олгодоггүй, хугацааг сунгадаггүй, хэн нэгэнд шилжүүлдэггүй байх. Түүнчлэн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг хангаагүй бол лицензийг цуцалдаг байх.

Энэхүү баримт бичгийн явцад Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хуулийг лицензийн асуудлаар гаргах шийдвэрт иргэдийн оролцоог хангах, байгаль хамгаалах зэрэг асуудлаарх олон улсын тэргүүний туршлагатай зохицуулан өөрчлөх саналыг боловсруулсан.

Энэ өөрчлөлтийн саналыг Улсын Их Хурлын Санхүү эдийн засгийн байнгын хороо, Улсын Их Хурлын бусад гишүүдэд гардуулна.

Монгол Улсын уул уурхайн салбарын урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахын


тулд бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид байгаль орчин болон хүний эрх хамгаалах зарчмыг Монгол Улсын уул уурхай, ашигт малтмалын хөгжилтэй холбоотой хууль, бодлого, хөтөлбөрт нэвтрүүлж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эс тэгвээс Монгол Улс Үндсэн хуулийн ардчиллыг хөгжүүлэх заалтыг хэрэгжүүлэх, Мянганы хөгжлийн зорилтыг биелүүлэх боломжгүй болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

МОНГОЛ ХЭЛЭЭР ЗӨВХӨН МАНАЙ ХУУДАСНАА

ХҮНИЙ ЭРХИЙН САЛБАРТ ГАРЧ БУЙ ХУВЬСАЛ ӨӨРЧЛӨЛТ



Харвардын хүний эрхийн сэтгүүл” дөнгөж үүсч, Харвардын Их сургуулийн Хүний эрхийн хөтөлбөр эхлээд удаа ч үгүй байсан тэр цагт миний бие Харвардын Их сургуулийн Хуулийн сургуулийн оюутан байлаа. Тэр үед Хуулийн сургуулийн хэмжээнд хүний эрхийн талаар сонирхдог, судалдаг хүмүүсийн тоо маш цөөхөн байсан нь одоо ч миний санаанд торж үлдсэн байдаг юм. Арьс өнгөөр ялгаварлах үзлийн эсрэг хөдөлгөөн, хүйтэн дайн, олон тооны хоморголон устгах явдлууд гээд хурц асуудлаар дүүрэн байсан тэр жилүүдэд “хүний эрх” гэдэг хэллэг Харвардын Хуулийн сургуульд өдрийн од шиг л цөөхөн сонсогддог байлаа. 20-иодхон жилийн дараа хүний эрх гэж хаа сайгүй ярьдаг болно гэдгийг тэгэхэд хаанаас мэдэх билээ дээ.

Ингээд хүний эрхийн салбарт гарсан хоёр чухал асуудлын талаар энэхүү

Нью-Йорк мужийн Их сургуулийн хүндэт профессор, тус их сургуулийн дэргэдэх Баффалогийн Хуулийн сургуулийн профессор Макау Мутуа, Хүний эрхийн Төвийн захирал бөгөөд Флойд Х. болон Хилда Херстийн нэрэмжит факультетийн эрдэмтэн юм. Тэрээр Хүний эрх: Улс төр, соёлын шүүмж (2002) зэрэг хүний эрхийн олон зохиол бүтээл туурвисан. Кени улсын Хүний эрхийн Комиссын гишүүнээр давхар ажилладаг.

нийтлэлдээ өгүүлэх гэсэн юм. Нэгдүгээрт, хүний эрхийн тухай сэдэв өнөөгийн эрх зүйн боловсролд голлох байр суурь эзэлдэг болжээ. Хоёрдугаарт, хүний эрхийн тухай ойлголт, үзэл санаа барууны чиг хандлагад суурилсан загвараасаа аажмаар өөрчлөгдөн холдож байна.

Харвардын Хуулийн сургуульд тэгэхэд анх удаагаа зааж байсан хүний эрхийн хичээлийг би 1985 онд сонгон суралцсан юм. Эдүгээ олон улсад нэр хүндтэйд тооцогдож буй Хүний эрхийн хөтөлбөрийг цоо шинээр боловсруулан зохиосон профессор Хенри Стайнер хичээлийг заалаа. Хүч тэнцвэргүй байдлын талаар маргалдаж, мэтгэлцэх дуртай оюутнууд бид шинэ сэдвийн хүрээнд зөрчилдөөнтэй олон асуудлуудыг профессорынхоо хамт судалсаар хичээлийн нэгэн хагас жилийг өнгөрөөв. Цоо шинэ, судлагдаагүй сэдэв

учраас 15 орчим оюутан л хүний эрхийн хичээлд ирсэн юм. Энэ сэдвийг жинхэнэ “хуулийн сургуулийн хичээл” шиг яаж заах юм бол доо гэж бид бүгдээрээ л гайхалзаж байлаа. Харин профессор Стайнер сократын аргыг хуулийн баримт бичиг, гэрээ, жишиг хуульд дүн шинжилгээ хийх, хэм хэмжээнд шүүмж хийх аргатай хослуулан энэ сэдвийг амьдралд ойртуулж чадсанд бид бүгд сэтгэл хангалуун үлдсэн.

Хүний эрхийн сэдэв эдүгээ хуулийн сургуулиудын жирийн бөгөөд өргөн хүрээтэй хичээл болсныг гайхахгүй байхын аргагүй. Хорин жилийн өмнө хүний эрхийн хичээлийг хэдхэн хуулийн сургуульд л заадаг байсан бол өнөөдөр АНУ-ын бараг бүхий л их дээд сургуулийн хөтөлбөрт багтсан байна. Дэлхийн ихэнх улс оронд мөн ийм л байгаа. Хүний эрх хуулийн сургуулийн хүрээнд ховорхон сэдэв байхаа больж, эрхзүйн боловсрол, хуулийн практикт нэвтэрлээ.

Харвардын Хуулийн сургуулиас эхлээд Нью Йорк Мужийн Их сургуулийн дэргэдэх Баффалогийн Хуулийн сургууль (миний багшилдаг) зэрэг олон их дээд сургуулийн хөтөлбөрийг одоо хүний эрхийн хичээлгүйгээр төсөөлөх ч боломжгүй болсон. Өөрөөр хэлбэл хүний эрхийн тухай сэдэв эрхзүйн боловсролын салшгүй чухал хэсэг болжээ.

Онолын талаасаа эрх зүйн боловсролын зорилгын тухай ойлголтод хүний эрхийн сэдэв хувьсгал гаргасан гэж хэлж болно.

Өмнө нь хуулийн пүүс, бизнес, төрийн болон орон нутгийн захиргааны үйл ажиллагааны хүрээнд буюу уламжлалт байдлаар үйлчилгээ үзүүлэх хэмжээнд эрхзүйн боловсролын зорилгыг ойлгодог байсан бол өнөө цагт хуулийн сургуулийн

оюутнууд өөрийн ирээдүйн ажил мэргэжилд өөр сонирхолтой сонголтууд байгааг олж хардаг болжээ. Тухайлбал, хуулийн сургууль төгсөгчид хүний эрхийн асуудлыг сонирхож төрийн бус байгууллага, олон улсын байгууллагад олноороо ажиллах болсон.

Түүнчлэн хувиараа хуулийн үйлчилгээ үзүүлэх, эрдэм шинжилгээний болон төрийн агентлагуудад ажиллах нь олширсон байна. Хүний эрхийн хөтөлбөрийг төгсөгчид хүний эрхийн хуульч, өмгөөлөгч, удирдах ажилтан, багш, олон улсын байгууллагын ажилтан, бодлого боловсруулагч болцгоож байгаа нь хүний эрхийн сургалтын хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэний нэг илрэл юм.

Хүний эрхийн салбарт гарч буй хамгийн чухал хувьсал бол хүний эрхийн тухай ойлголт, үзэл санаа, хүний эрхийн төлөө хөдөлгөөн, дискурст бий болж буй норматив шинжтэй өөрчлөлт гэж хэлж болох биз ээ. 20 орчим жилийн өмнө хүний эрхийг баруунаас дэлхийн бусад улсад түгээсэн “өглөг” хэмээн хардаг байлаа. Хүний эрхтэй холбоотой “олон улс”-ын асуудлуудад “тэд”, “бид” хэмээн талцаж ханддаг байв. Хүний эрх гээч нь хоцрогдсон буурай соёлтой улс орон, ард түмнүүдийг авран чөлөөлөх тухай зүйл гэж үздэг хүмүүс байлаа. Одоо ч зарим нь ингэж үзсээр байна. Тиймээс эхэн үеийн хүний эрхийн зүтгэлтнүүд европын соёл, онолыг дээдэлсэн барууны хандлага, итгэл үнэмшилдээ автсан байсан юм.

Харин сүүлийн арван таван жил орчим хүний эрхийн үзэл, хүний эрхийн үйл хэрэг, хүний эрхийн мэргэжилтнүүдийн үйл ажиллагааг эргэн харж, дүгнэлт хийх болсон

нь хүний эрхийн төлөө хөдөлгөөнд дотоод өөрчлөлт гарахад нөлөөллөө. Үүний үр дүнд хүний эрхийн үзэл санаа, үйл хэрэг, дискурст алгуур боловч эргэлтгүй шинэтгэл хийгдэж, хүний эрхийн асуудал соёл уламжлал бүрт хамаатай, түгээмэл үнэт зүйлс гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд энэ үйл явц цаашид тасралтгүй үргэлжлэх шинжтэй байна. Өөрөөр хэлбэл үнэхээрийн түгээмэл үзэл санаа бий болно гэсэн үг юм.

Дэлхий дахинаа жирийн иргэдийн дунд хүлээн зөвшөөрөгдөхийн тулд хүний эрхийн төлөө хөдөлгөөн аль ч соёл уламжлалаас эх ундаргаа олж авах зайлшгүй шаардлагатай билээ. Үзэл санааны хувьд ч гэсэн хүний эрхийн төлөө хөдөлгөөн илүү нарийн, төвөгтэй болж байна. Эхэн үедээ иргэний болон улс төрийн эрхэд онцгойлон анхаарч, хүйтэн дайны өрөөсгөл хандлагаас шалтгаалан хүний эрхийн судлаачид, эрдэмтэд, идэвхтнүүд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаар нүдээ аньж, чихээ дарж өнгөрдөг байв. Харин 90-ээд оны дунд үеэс эхлэн эдийн засгийн сул дорой байдал болон даяарчлалын сөрөг нөлөөний талаар анхаарал хандуулдаг болсон. Хөгжиж буй орнуудын хүний эрхийн идэвхтнүүд эдийн засгийн асуудалд анхаарах нь нэмэгдэж байна. Тэр ч бүү хэл барууны хүний эрхийн хоёр том байгууллага болох Эмнести Интернэйшнл, Хүний эрхийн харуул (Human Rights Watch) эдийн засгийн гачигдал, доройтлын асуудлыг сонирхон ажилладаг боллоо.

Гэхдээ томоохон төрийн бус байгууллагууд хошуу дүрэхээс хэтрэхгүй байгаа учраас энэ чиглэлээр шүүхийн практикт олигтой ахиц дэвшил гарахгүй байна. Хэдий тийм ч чамлах хэрэг үгүй юм. Хүний эрхийн төлөө үзэл санаа,

хөдөлгөөн өөрийгөө хүлээн зөвшөөрүүлэх гэвэл чөлөөт зах зээл, капитализмын сөрөг үзэгдлийг барьж авах эрмэлзэлтэй байх хэрэгтэй юм. Энэ тал дээр хөгжиж буй улс орнуудын сэтгэгчид, зүтгэлтнүүд голлох үүрэг гүйцэтгэж байгаа билээ.

Эцэст нь хэлэхэд улс төрийн ардчиллын асуудалтай хүзүү холбосон хэвээр яваа хүний эрхийн төлөө хөдөлгөөн дэлхий дахинаа хэн ч маргашгүй үйл хэрэг болж хүлээн зөвшөөрөгдөө гэвэл сул дорой, хүчин мөхөс, шударга бус явдалд сонор соргог хандах хэрэгтэй. Өнөөг хүртэл хүний эрхийн төлөө хөдөлгөөн барууны ардчилсан улс орнуудын эзэрхэг түрэмгий бодлогод хэт зөөлөн хандаж, хүний эрхийн асуудлыг гадаад бодлого, ашиг сонирхолдоо нийцүүлэн тодорхойлж байхад нь ч дуугүй байсаар ирсэн. Ийнхүү алагчилж хандсаар байх юм бол хүний эрхийн төлөө хөдөлгөөн мухардмал байдалд орно. Хүний эрхийн үзэл санааны суурь, аналитик төсөөлөл, стратегийн эвслийн талаар ч эргэн харж, дахин бодох шаардлагатай болно.

Зөвхөн хүчирхэг улс гүрэн, элитүүдтэй сүлбэлдсээр байх юм бол хүний эрхийн төлөө хөдөлгөөн жинхэнэ ёсоор хүлээн зөвшөөрөгдөж чадахгүй. Харин дорой буурайчуудын тэмцлийн хэрэгсэл болж чадаж гэмээнэ түүний хэрэг гарах юм. Хэрэв хүний эрхийн төлөө хөдөлгөөн барууныг дээдэлсэн, арьс үндсээр алагчилсан, чөлөөт зах зээлийг тахисан өрөөсгөл хандлагаасаа хагацахгүй бол энэхүү зорилгод хүрч чадахгүй билээ.

**Монгол хэлнээ орчуулсан Гантоморин
Золжаргал /ХЭҮК-ын Захиргаа, хамтын
ажиллагааны хэлтсийн дарга/**

Зочны яриа

**Д.ЭНХЖАРГАЛ: БИДНИЙ ЗОРЬЖ ЯВАА ЦЭГ ХОЛ,
ШИЙДВЭРЛЭХИЙГ ХҮСЧ БАЙГАА АСУУДАЛ ТОМ**



**Баруун гар талаас хатагтай Д.Энхжаргал,
З.Бадмаараг нар.**

Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төвийн захирал Д.Энхжаргалыг дугаарын зочноороо урьж ярилцлаа.

- Юуны өмнө “Хүний эрх” сэтгүүлийн урилгыг хүлээн авч, манай уншигчидтай уулзаж байгаа танд баярлалаа. Манай сэтгүүл хүний эрхийн онолын судалгааг Монголд хөгжүүлэх том зорилготой юм л даа?

- Хэдийгээр бид практик талбарт ажилладаг ч үйл ажиллагаагаа холбогдох салбарын онолын үндэслэл, олон улсын түвшинд нийтээр хүлээн зөвшөөрсөн үзэл баримтлал дээр тулгуурлахыг хичээдэг. Онол зөвхөн эрдэмтдэд хамаатай гэдэг ойлголт хэдийнэ ард хоцорч, онолыг хөгжүүлэхэд практик судлалыг чухалчилдаг болчихжээ. Тиймээс төвийнхөө хийсэн бүтээснийг танилцуулж, зорьж яваа үйл хэргийнхээ талаар хуваалцах боломж олдсоид би ч бас баяртай байна.

- Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ, энэ асуудлын онцлог шинж, нийгэмд болон гэр бүлд учруулах үр дагавар нь юу байдаг бол?

- Гэр бүлийн гишүүд, төрөл садан болон дотны харилцаатай хэн нэгний зүгээс нөгөөгөө хүч, эрх мэдлээр далайлгаж, хяналтаа тогтоон хамааралдаа оруулах харилцааг гэр бүлийн хүчирхийлэл гэж ойлгож болно.

Хүмүүс хайр, хүчирхийлэл хоёрыг заримдаа хольж ойлгоод байдаг. Хайртай болохоороо л ингэчихлээ гэх мэтчилэн. Үнэн хэрэгтээ хайр нь хүндэтгэл, зөвшилцөл, итгэлцэл дээр суурилдаг байхад хүчирхийлэл нь тэгш бус харилцаа байдаг. Гэр бүлийн харилцааг хүчирхийлэлтэй эсэхийг мэдэх гол

хэмжүүрийн нэг нь айдас юм. Иймээс үзэл бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргах зэрэг өдөр тутмын харилцаандаа хэн нь хэнээсээ айж байна, хэн нь хэнээсээ хамааралтай байна гэдгийг олж харах нь чухал.

Хүчирхийлэлтэй харилцаа нь хүний хувийн амьдрал, гэр бүлийн нэр төртэй холбоотой эмзэг асуудал. Иймээс далд оршдог, давтагддаг, давтагдах тусмаа аюул занал нь даамжирч байдаг онцлогтой. Ингэснээр гэр бүлийн итгэлцэл, хүндэтгэл, улмаар хайрыг аажмаар үгүй хийдэг. Өөрөөр хэлбэл, босгосон амьдралаа өөрийн гараар сүйтгэхэд хүргэдэг. Зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэх, дарамт үзүүлэх аргаар шийдэж болдог юм байна гэдгийг хүүхдэд сургаж байдгаараа хамгийн хорлонтой. Гэр бүл салалт, хараа хяналтгүй хүүхдүүд, хөдөлмөрийн бүтээмж бууралт, гэмтэл бэртэлд зориулж буй эрүүл мэндийн зардал өсөх зэрэг нийгэмд авчирч байгаа үр дагаврыг тоочиж, үнэлж баршгүй.

- Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Товийнхөн хуулийн “лобби” хийхдээ нэлээд туршлагатай санагддаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг санаачилж, нэлээд олон жил хөөцөлдөж байж батлуулсан. Одоо бас шинэчилсэн найруулгыг хийх сураг байсан. Хуулийн тосол боловсруулах, батлуулах нь хэн хүний зориглож, шүүрч аваад хийгээд байх хялбар ажил биш. Та нарыг хэн зоригжуулж, түлхүүрддэг юм бол?

- Лобби гэхээсээ илүү нөлөөлөл юм даа. Бид шууд үйлчилгээ үзүүлдэг болохоор хүмүүсийн харилцааны гүнд нэвтэрч, амьдралын халуун цэг дээр ажилладаг хүмүүс. Тийм болохоор тогтолцоо, бодлого, зохицуулалт, хуулийн бүх л цоорхой, хийдэл, давхардал, гажуудал илүү

тодорхой мэдрэгддэг. Нотолгоонд суурилж хийгддэг болохоор нөлөөллийн ажлын үр дүнд эерэгээр нөлөөлдөг.

- Хүчирхийллийн золиос болсон эмэгтэйчүүдийг зарим талаар буруутгах хандлага нийгэмд байдаг?

- Наад хандлага чинь л хүмүүсийг дуугүй байхад хүргэдэг, хүчирхийллийг далд бугшихад нөлөөлдөг гол хүчин зүйл юм. Тиймээс би хүчирхийлэлд өртдөг гээд өөрийгөө төлөөлөөд нийгэмд дуу хоолойгоо гаргах хүмүүс ховор.

- Та Хүний эрхийн салбарт харьцангуй олон жил ажиллалаа. Шантарч, замын дундаас буцахуйц хүндрэл бэрхшээлтэй тулгарч байв уу?

- Анх энэ байгууллагадаа хуулийн зөвлөхөөр ажилд орсноос хойш хүний эрхийн салбарт 14 жил ажиллаж байна. Мэдээж, шантрах юм захаас аваад л гарна шүү дээ. Бид чинь хүн бүхний хүлээн зөвшөөрдөг асуудлаар ажилладаггүй.

- Эрх зорчигдсон хүмүүст учирч буй сэтгэл, санаа бие махбодийн дарамтыг хамтдаа даван туулах асуудал танд тулгардаг байх. Энэ тохиолдолд та нарын аюулгүй байдлыг хамгаалах баталгаа бий юү?

- Ялангуяа манайх шиг халуун цэг дээр ажиллаж байгаа хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалахад онцгой хүчин чармайлт тавьдаг юм билээ, бусад орнуудад. Харамсалтай нь манайд алга даа.

- Хүний эрхийг хамгаалагчдын хамгааллын талаар хүний эрхийг хамгаалагчид нь хондох шаардлагатай болсон юм шиг ээ. Энэ салбарынхны олонх нь эмэгтэйчүүд байгаа цагт ялангуяа бүр илүү анхаарах ёстой гэдэгтэй та санал нийлэх үү?

- Та үнэхээр зөв асуудал хөндлөө. Эрэгтэй, эмэгтэйдээ ч гол нь биш, хамгийн эмзэг, хамгаалал, шийдэл шаардсан талбарт итгэл үнэмшил, хүсэл зоригоос өөр юу ч үгүй ажилладаг тэдгээр хүмүүсийн үйл ажиллагааг хамгаалахын тулд төрийн зүгээс онцгой хүчин чармайлт гаргах хэрэгтэй нь мэдээж. Нэг талаас энэ нь хүний эрхийг хамгаалахад илүү олон хүнийг татан оролцуулж, хүний эрхийг хамгаалагч болоход нь урам зориг өгөх сэдэл, түлхэц болдог. Нөгөө талаас үндэсний хууль тогтоомж, хуулийн байгууллага, төр засаг нь бүхэлдээ хүний эрхийг зөрчих явдлаас үр дүнтэй хамгаалж чадахгүй байгаа нөхцөлд хүний эрхийг хамгаалагчид хамгаалалтын хамгийн эцсийн хана хэрэм болдог гэж үздэгтэй холбоотой.

Хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүд бусадтай адил саад бэрхшээл бүгдийг туулж, амсдаг хэрнээ нийгэмд эзэлж буй байр суурь, дүр төрх, үүрэг ролиос шалтгаалан эрэгтэй хамгаалагчдаас ялгаатай дарамт, шахалтад өртдөг учраас онцгой анхаарал шаардагддаг гэж олон улсын түвшинд үздэг юм билээ.

1998 онд Хүний эрхийн Түгээмэл тунхаглалын 50 жилийн ойг тохиолдуулан Хүний эрхийг хамгаалагчдын тухай Тунхаглалыг баталсан. Зарим оронд уг Тунхаглалыг үндэсний хэмжээнд эрхзүйн хувьд заавал биелэгдэх шинжтэй болгон батлах явц өрнөж эхэлж байна. Бид ч гэсэн үүнд анхаарлаа хандуулж эхэлж байна.

-Жинхэнэ тэмцэгч нууцлаг хэрнээ ажил үйлсээ үргэлжлүүлсээр байдаг. Та тэдний нэг бололтой юм. Заримдаа өөрийн чинь хийсэн бүтээснийг өөр хүн өөрийнх мэтээр сурталчлах явдал тохиолдож байв уу?

- Бидний зорьж яваа цэг хол, шийдвэрлэхийг хүсч байгаа асуудал том. Тал талынх нь өнцөг, булангаас хэлтэлж, өөр өөрсдийн чадах хэмжээгээр хувь нэмрээ оруулж байж л бид хүсч байгаа өөрчлөлтөө бүтээнэ. Тийм учраас хүмүүсийг өөрчлөлт бий болгоход нь сэдэлжүүлэгч, өдөөгч, зоригжуулагч нь байхыг чармайдаг. Энэ асуудлаар олон хүн дуу хоолойгоо гаргаасай, энэ салбарт ажилладаг хүн олон байгаасай л гэж хүсдэг. Нэгэнт улаан туг болж онцгойрон дэргэдийг хүсдэггүй учраас өөрийн хийсэн, бүтээснээ өмчлөөд байхыг боддоггүй. Тэгээд ч ганцаараа бүгдийг бүтээнэ гэж юу байхав, хүмүүсийн дэмжлэг, түншлэл, хамтын ажиллагааны үр дүнд л амжилт, үр дүн гарч байдаг гэж боддог.

Хамгийн гол нь өөрийнхөө үнэт зүйл, итгэл үнэмшил, зорьж байгаа ажил үйлсдээ тууштай байж, алхам алхмаар, гэхдээ алсын хараа, стратегитайгаар, бас ганцаараа биш өргөн фронтоор дөтлөхийг чухалчилдаг.

- Хүчирхийлэлгүй, хүний эрхийг дээдлэгч нийгмийг бүтээн босгоход тулгуур суурь нь юу байх ёстой юм бол таны бодлоор?

- Хүмүүсийн хандлага, сэтгэлгээг тулгуур суурь нь гэж боддог. Хүн өөрчлөлтийнхөө түлхүүрийг өөрөө атгаж байдаг. Гаднаас нь онгойлгоно гэж байхгүй. Тиймээс хүний зүрх сэтгэлд хүрч, өөрийнхөө хандлага, зан үйлийг эргэн харж, эргэцүүлэн тунгаах, өөрчлөх сэдэл төрүүлэх нь хамгаас чухал гэж боддог. Тэгэхээр хүний эрхийн боловсролоор дамжуулан хүний эрхийн соёлыг бүтээхэд гол анхаарлаа хандуулах цаг болсон.

- Хүний эрхийн салбарт ажиллаж буй хүмүүст хандаж та юуг хэлэх вэ?

- Бид бол өөрсдөө өөрчлөлт гэж хэлэхийг хүсч байна. Хэрвээ бид ямар нэг зүйлийг өөрчлөхийг хүсч байгаа бол тэр өөрчлөлтийг өөрөөсөө, өөрийнхөө хамгийн ойр газраасаа эхлэх хэрэгтэй гэж үздэг.

- Цаг зав гарган ярилцсан танд баярлалаа.

Ярилцсан З.Бадмаараг /ХЭҮК-ын хэвлэл мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн/

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН